

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН
2026 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

| | |
|--|-----------|
| I БҮЛЭГ: МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ОНЦЛОГ, БАРИМТЛАХ БОДЛОГО, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ | 8 |
| II БҮЛЭГ: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА | 14 |
| 2.1. Дэлхийн эдийн засгийн төлөв байдал | 14 |
| 2.2. Түүхий эдийн зах зээлийн хандлага | 15 |
| 2.3. Монгол Улсын макро эдийн засгийн төлөв байдал..... | 17 |
| 2.3.1. Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал | 17 |
| 2.3.2. Макро эдийн засгийн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл..... | 22 |
| 2.3.3. Макро эдийн засгийн 2026 оны төсөөлөл | 23 |
| 2.4. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн таамаглал..... | 26 |
| III БҮЛЭГ: ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ | 27 |
| 3.1. Төсвийн орлого..... | 27 |
| 3.2. Төсвийн урсгал зардал..... | 27 |
| 3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон гадаад зээл, тусламж | 28 |
| 3.3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт | 28 |
| 3.3.2. Гадаад зээл, тусламж | 30 |
| 3.4. Засгийн газрын өр | 32 |
| IV БҮЛЭГ: МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ | 39 |
| 4.1. Төсвийн орлого..... | 39 |
| 4.1.1. Төсвийн орлогын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ | 39 |
| 4.1.2. Татварын орлого..... | 41 |
| 4.1.3. Татварын бус орлого | 44 |
| 4.1.4. Татварын зарлага..... | 45 |
| 4.2. Төсвийн урсгал зардал..... | 46 |
| 4.2.1. Урсгал зардлын төлөвлөлтөд баримтлах бодлого, зарчим..... | 46 |
| 4.2.2. Салбарын урсгал зардал..... | 46 |
| 4.2.3. Засгийн газрын тусгай сан | 58 |
| 4.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламж болон төр, хувийн хэвшлийн түншлэл | 64 |
| 4.3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт | 64 |

| | | |
|--|--|------------|
| 4.3.2. | Гадаад зээл, тусламж | 90 |
| 4.3.3. | Төр, хувийн хэвшлийн түншлэл..... | 116 |
| 4.4. | Орон нутгийн төсөв | 117 |
| 4.5. | Орон сууцны санхүүжилтийн банк | 118 |
| 4.6. | Засгийн газрын өр | 120 |
| V БҮЛЭГ: ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ | | 123 |
| 5.1. | Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд..... | 123 |
| 5.2. | Төсвийн тусгай шаардлага | 123 |
| 5.3. | Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр..... | 124 |
| VI БҮЛЭГ: ТӨСВИЙН ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ | | 125 |
| 6.1. | Товч агуулга | 125 |
| 6.2. | Макро эдийн засгийн эрсдэл..... | 128 |
| 6.2.1. | Макро эдийн засгийн орчин болон эрсдэлийн тойм | 128 |
| 6.2.2. | Гадаад эдийн засгийн орчны төлөв ба эрсдэл..... | 130 |
| 6.2.3. | Мэдрэмжийн шинжилгээ | 131 |
| 6.3. | Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд хийсэн эрсдэлийн шинжилгээ..... | 136 |
| 6.3.1. | ТӨААН-үүдийн санхүүгийн нөхцөл байдал..... | 136 |
| 6.3.2. | “ТӨААН-үүдийн санхүү, үйл ажиллагааны байдлын шинжилгээ” /SOE Health check tool/-ийн үр дүн | 137 |
| 6.4. | Засгийн газрын өрийн эрсдэл | 141 |
| 6.4.1. | Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн үзүүлэлтүүд | 141 |
| 6.4.2. | Өрийн тогтвортой байдлын шинжилгээ | 144 |
| 6.4.3. | Засгийн газрын болзошгүй өр төлбөр..... | 147 |
| 6.5. | Байгалийн гамшиг, зудын эрсдэл..... | 149 |
| VII БҮЛЭГ: ТӨСВИЙН ТӨСЛИЙН ХАВСРАЛТ | | 152 |
| 7.1. | Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн тайлбар..... | 152 |
| 7.2. | Хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл | 153 |
| 7.3. | Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний танилцуулга | 155 |
| 7.4. | Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт | 157 |
| 7.5. | Санхүүжилтийг нь зогсоох болон багасгах хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт, түүний төсөвт үзүүлэх нөлөөлөл, тайлбар | 161 |
| 7.5.1. | Урсгал зардал | 161 |

| | | |
|--------|--|-----|
| 7.5.2. | Улсын төсвийн хөрөнгө оруулалт | 162 |
| 7.6. | Сангийн үлдэгдлүүд..... | 163 |
| 7.7. | Олон нийтийн хэлэлцүүлэг | 163 |
| 7.7.1. | Е-Монголиа системээр авсан иргэдийн санал асуулгын үр дүн..... | 163 |
| 7.7.2. | Төсвийн Ерөнхийлөн захирагч нарын зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлэг | 165 |

ХҮСНЭГТ

| | |
|---|-----|
| Хүснэгт 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, салбаруудаар (хувь) | 18 |
| Хүснэгт 2. 2025 оны эхний 7 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл (тэрбум төгрөг) | 27 |
| Хүснэгт 3. 2025 оны эхний 7 сарын нэгдсэн төсвийн урсгал зарлагын гүйцэтгэл (тэрбум төгрөг) | 28 |
| Хүснэгт 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл эхлэх он (сая төгрөг) | 29 |
| Хүснэгт 5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, салбараар (сая төгрөг)..... | 29 |
| Хүснэгт 6. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт (тэрбум төгрөг) | 31 |
| Хүснэгт 7. Гадаад зээл, тусламжийн төсөл хөтөлбөр, хөгжлийн түншээр (тэрбум төгрөг) | 31 |
| Хүснэгт 8. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийн ашиглалт, төслөөр (тэрбум төгрөг) | 32 |
| Хүснэгт 9. Засгийн газрын гадаад тусламжийн ашиглалт, төсөл, арга хэмжээгээр (тэрбум төгрөг) | 32 |
| Хүснэгт 10. Засгийн газрын өрийн бүтэц (тэрбум төгрөг) | 32 |
| Хүснэгт 11. Засгийн газрын өрийн үйлчилгээ 2024-2026 (тэрбум төгрөг)..... | 33 |
| Хүснэгт 12. Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл, зээлдүүлэгчээр (тэрбум төгрөг) | 33 |
| Хүснэгт 13. Гадаад үнэт цаас, 2025.06.30 (тэрбум төгрөг) | 35 |
| Хүснэгт 14. 2026 оны нэгдсэн төсвийн нийт орлого (тэрбум төгрөг) | 40 |
| Хүснэгт 15. 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн (тэрбум төгрөг)..... | 41 |
| Хүснэгт 16. Татварын зарлагын хэмжээ (тэрбум төгрөг)..... | 45 |
| Хүснэгт 17. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал (сая төгрөг)..... | 51 |
| Хүснэгт 18. Засгийн газрын нөөц сангийн хөрөнгө (сая төгрөг)..... | 52 |
| Хүснэгт 19. Засаг даргын нөөц хөрөнгө (сая төгрөг)..... | 52 |
| Хүснэгт 20. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал (сая төгрөг) | 53 |
| Хүснэгт 21. Засгийн газрын тусгай сангийн зардлын төсөл (тэрбум төгрөг) | 58 |
| Хүснэгт 22. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, салбараар | 83 |
| Хүснэгт 23. Төслийн төрөл, ангилал (сая төгрөг) | 84 |
| Хүснэгт 24. Гадаад зээл, тусламжийн төсөл хөтөлбөр, хөгжлийн түншээр (тэрбум төгрөг) | 93 |
| Хүснэгт 25. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн мэдээлэл..... | 94 |
| Хүснэгт 26. Эрдэнэбүрэнгийн УЦС барих төслийн мэдээлэл | 95 |
| Хүснэгт 27. Чойр-сайншандын 220 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийн мэдээлэл | 96 |
| Хүснэгт 28. Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн мэдээлэл | 97 |
| Хүснэгт 29. Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн мэдээлэл | 98 |
| Хүснэгт 30. Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн мэдээлэл..... | 99 |
| Хүснэгт 31. Нүхэн гарч барих төслийн мэдээлэл..... | 100 |
| Хүснэгт 32. Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төслийн мэдээлэл | 101 |
| Хүснэгт 33. Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдааг дэмжих төслийн мэдээлэл | 102 |
| Хүснэгт 34. Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн мэдээлэл | 103 |
| Хүснэгт 35. Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн мэдээлэл | 104 |
| Хүснэгт 36. Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төслийн мэдээлэл | 106 |
| Хүснэгт 37. Солонго 1, 2 орон сууцны хороолол барих төслийн мэдээлэл..... | 107 |
| Хүснэгт 38. Баянголын амны 2007 айлын орлогод нийцсэн орон сууц барих төслийн мэдээлэл | 108 |
| Хүснэгт 39. Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн мэдээлэл | 109 |
| Хүснэгт 40. Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн мэдээлэл | 110 |
| Хүснэгт 41. Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн мэдээлэл | 111 |
| Хүснэгт 42. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн мэдээлэл..... | 112 |
| Хүснэгт 43. Зам тээврийн салбарын хөрөнгө оруулалт | 113 |
| Хүснэгт 44. Гадаад зээлийн хөрөнгөөр 2026 онд шинээр эхлэх төсөл, хөтөлбөрүүд, хэлэлцээрт | 114 |
| Хүснэгт 45. Аймгуудын санхүүгийн дэмжлэг (сая төгрөг)..... | 117 |
| Хүснэгт 46. Дээд шатны төсөвт төвлөрүүлэх дүн (сая төгрөг) | 117 |
| Хүснэгт 47. Орон нутгийн хөгжлийн сан (сая төгрөг)..... | 118 |
| Хүснэгт 48. Засгийн газрын өрийн багцын зорилтот бүтэц..... | 122 |

| | |
|---|-----|
| Хүснэгт 49. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)..... | 123 |
| Хүснэгт 50. Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн ДНБ-д эзлэх хувь..... | 124 |
| Хүснэгт 51. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын ДНБ-д эзлэх хувь..... | 124 |
| Хүснэгт 52. Засгийн газрын өрийн төсөөлөл, нэрлэсэн дүнгээр (ДНБ-д эзлэх хувь)..... | 124 |
| Хүснэгт 53. Төсвийн эрсдэлийн матриц..... | 126 |
| Хүснэгт 54. Төсвийн үндсэн үзүүлэлтийн мэдрэмжийн шинжилгээ..... | 131 |
| Хүснэгт 55. Нүүрсний биет хэмжээний бууралтын төсөвт үзүүлэх нөлөө..... | 132 |
| Хүснэгт 56. Нүүрсний үнийн бууралтын төсөвт үзүүлэх нөлөө..... | 134 |
| Хүснэгт 57. Зэсийн үнийн бууралтын төсөвт үзүүлэх нөлөө..... | 135 |
| Хүснэгт 58. Шинжилгээний үндсэн ангиллаар ангилсан ТӨААН-үүдийн санхүүгийн үзүүлэлт, их наяд төгрөгөөр..... | 137 |
| Хүснэгт 59. Сонгосон ТӨААН-үүдийн салбарын ангилал..... | 137 |
| Хүснэгт 60. Сонгосон ТӨААН-үүдийн ашигт ажиллагааны эрсдэлийн шинжилгээ..... | 138 |
| Хүснэгт 61. Сонгосон ТӨААН-үүдийн хөрвөх чадварын эрсдэлийн шинжилгээ..... | 139 |
| Хүснэгт 62. Сонгосон ТӨААН-үүдийн өр төлбөр төлөх чадварын эрсдэлийн шинжилгээ..... | 139 |
| Хүснэгт 63. Засгийн газрын өрийн зардал, эрсдэлийн үзүүлэлтүүд, 2024 он..... | 142 |
| Хүснэгт 64. Дунд хугацааны загварын үр дүн..... | 145 |
| Хүснэгт 65. Дунд хугацааны эрсдэлийн индекс..... | 146 |
| Хүснэгт 66. Өрийн тогтвортой байдлын шинжилгээний дүгнэлт..... | 146 |
| Хүснэгт 67. ТЕЗ-ийн хөтөлбөр, үр дүн, шалгуур үзүүлэлт, зорилтог түвшний тоо..... | 155 |
| Хүснэгт 68. Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт (сая төгрөг)..... | 157 |
| Хүснэгт 69. Санхүүжилтийг зогсоох болон багасгах хөтөлбөр, арга хэмжээний тайлбар (тэрбум төгрөг)..... | 161 |
| Хүснэгт 70. Санал асуулгын дүн..... | 164 |
| Хүснэгт 71. Санал асуулгын дүн..... | 164 |
| Хүснэгт 72. Санал асуулгын дүн..... | 164 |
| Хүснэгт 73. Санал асуулгын дүн..... | 165 |
| Хүснэгт 74. Санал асуулгын дүн..... | 165 |
| Хүснэгт 75. Олон нийтийн хэлэлцүүлэг (ТЕЗ нараар)..... | 166 |
| Хүснэгт 76. Төсөвт туссан саналын товчоо (тэрбум төгрөгөөр)..... | 167 |

ЗУРАГ

| | |
|--|-----|
| Зураг 1. Эдийн засгийн өсөлтийн хувь | 14 |
| Зураг 2. Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)..... | 16 |
| Зураг 3. Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/трой унц) | 16 |
| Зураг 4. Төмрийн хүдрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)..... | 16 |
| Зураг 5. Нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)..... | 16 |
| Зураг 6. Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/баррель) | 17 |
| Зураг 7. ДНБ-ий өсөлтийн бүтэц, эрэлт талаас (хувь) | 18 |
| Зураг 8. Жилийн инфляц ба зорилтот түвшин (хувь)..... | 19 |
| Зураг 9. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, пассив тал (хувь) | 20 |
| Зураг 10. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, актив тал (хувь) | 20 |
| Зураг 11. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбараар (мянган хүн)..... | 21 |
| Зураг 12. Ажиллагчид (мян.хүн), ажиллах хүчний оролцооны түвшин (хувь)..... | 21 |
| Зураг 13. Гадаад худалдааны нийт бараа эргэлт (тэрбум ам.доллар) | 21 |
| Зураг 14. Импорт, хэрэглээний зориулалтаар (тэрбум ам.доллар)..... | 22 |
| Зураг 15. Гадаад зээлийн үлдэгдэл, валютаар 2025.06.30 (тэрбум төгрөг)..... | 34 |
| Зураг 16. Засгийн газрын дотоод үнэт цаасны өгөөжийн муруй | 37 |
| Зураг 17. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого, салбараар (тэрбум төгрөг) | 42 |
| Зураг 18. Хувь хүний орлогын албан татварын орлого (тэрбум төгрөг) | 42 |
| Зураг 19. Импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын орлого (тэрбум төгрөг)..... | 43 |
| Зураг 20. Дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын орлого (тэрбум төгрөг)..... | 43 |
| Зураг 21. Уул уурхайн салбар болон бусад салбараас төсөвт төвлөрүүлэх орлого (эзлэх хувиар) | 44 |
| Зураг 22. Төлөвлөлтийн цаглавар | 64 |
| Зураг 23. УТХО-ын нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувь, ДНБ-д эзлэх хувь | 65 |
| Зураг 24. УТХО-аар хэрэгжүүлэхээр ирүүлсэн төсөл, арга хэмжээний санал, цаглавар | 66 |
| Зураг 25. Шалгуур үзүүлэлт, эрэмбэлэлт..... | 66 |
| Зураг 26. УХЖТ болон УТХО-ын уялдаа | 67 |
| Зураг 27. Төсвийн хөрөнгө оруулалтын зарчим | 69 |
| Зураг 28. Шинэ хөрөнгө оруулалт..... | 70 |
| Зураг 29. Онцлох хөрөнгө оруулалт, боловсрол | 71 |
| Зураг 30. Онцлох хөрөнгө оруулалт, боловсролын тоног төхөөрөмж | 72 |
| Зураг 31. Онцлох хөрөнгө оруулалт, Эрүүл мэндийн салбар | 74 |
| Зураг 32. Хавдар судлалын үндэсний төвийн бүтээн байгуулалт..... | 76 |
| Зураг 33. Онцлох хөрөнгө оруулалт, эрчим хүчний салбар | 77 |
| Зураг 34. Эрчим хүчний хөрөнгө оруулалт | 78 |
| Зураг 35. Онцлох хөрөнгө оруулалт, Онцгой байдлын салбар | 80 |
| Зураг 36. Онцлох хөрөнгө оруулалт, Цахим хөгжил | 81 |
| Зураг 37. СОП17 бүтээн байгуулалт..... | 81 |
| Зураг 38. Зам тээврийн салбарын хөрөнгө оруулалт..... | 82 |
| Зураг 39. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем | 89 |
| Зураг 40. Төсвийн хөрөнгө оруулалтын цахим системийн цар хүрээ | 90 |
| Зураг 41. Уул уурхайн экспортын нийт экспортод эзлэх хувь | 128 |
| Зураг 42. Уул уурхайн салбарын шууд болон шууд бус нөлөө дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь .. | 128 |
| Зураг 43. Уул уурхайн орлогын нийт төсвийн орлогод эзлэх хувь, дунджаар | 129 |
| Зураг 44. Уул уурхайн голлох бүтээгдэхүүнүүдийн нийт экспортод эзлэх хувь..... | 129 |
| Зураг 45. Гадаад орчны эрсдэлийн суваг | 130 |
| Зураг 46. Нүүрсний экспортын гүйцэтгэл | 133 |
| Зураг 47. Ганцмод боомтын коксжих нүүрсний үнийн хөдөлгөөн, тонн/юань | 133 |
| Зураг 48. Засгийн газрын өрийн динамик..... | 142 |
| Зураг 49. Богино хугацааны загварын үр дүн..... | 144 |
| Зураг 50. Өрийн төсөөллийн тархалт..... | 146 |
| Зураг 51. Санхүүжилтийн хэрэгцээ | 146 |
| Зураг 52. Дунд хугацааны эрсдэл..... | 146 |
| Зураг 53. Засгийн газрын үнэт цаас | 148 |

| | |
|--|-----|
| Зураг 54. Дотоод үнэт цаасны өгөөжийн муруй..... | 149 |
| Зураг 55. Зудтай жилүүдийн том малын зүй бус хорогдол, ХАА-ын салбарын агшилт..... | 149 |
| Зураг 56. Эрсдэл даах чадварын индекс, аймгаар | 150 |

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан төсвийн ерөнхийлөн захирагчдын 2026 оны төсвийн төсөл төсвийн хязгаарт нийцэж буй эсэх болон төсвийн төсөл боловсруулах үед олон нийтийн оролцоог хангаж ажилласан эсэх талаар дүн шинжилгээ



I БҮЛЭГ: МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ОНЦЛОГ, БАРИМТЛАХ БОДЛОГО, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор “Монгол Улсыг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг баталж, 9 зорилгын хүрээнд 47 зорилт, 243 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Энэ хүрээнд Засгийн газар өнгөрсөн таван жилд цар тахлын нөлөөгөөр унасан эдийн засгийг тогтворжуулах, хилийн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, эдийн засгийн суурийг тэлэх бодлогыг хэрэгжүүлсэн.

Харин Эдийн засаг, хөгжлийн яамнаас боловсруулж байгаа “Монгол Улсыг 2026–2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төсөл нь эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болсон уул уурхайн салбарт тулгуурлахын зэрэгцээ энэхүү хөгжлийн суурь дэд бүтцээ түшиглэн бусад салбараа бодлогоор дэмжиж, эдийн засгаа төрөлжүүлэхийг чухалчилж байна. Эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг эрчимжүүлэн гадаад хараат байдлыг бууруулахын сацуу засаглалын шинэчлэлийг үргэлжлүүлж, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог дэмжихэд чиглэсэн дунд хугацааны стратегийн зорилтыг баримтална.

Үүний зэрэгцээ иргэдийн амьдралын чанарыг сайжруулах нь төрийн бодлогын анхаарлын төвд байх ёстой тул Засгийн газрын хэрэгжүүлэх хамгийн том мега төсөл бол хүн төвтэй хөгжлийн бодлого байх болно. Түүнчлэн цахим шилжилтийг эрхэмлэгч Засгийн газрын хувьд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологид суурилсан өсөлтийг бий болгохыг зорьж байна.

Ирэх таван жил буюу 2030 он хүртэл Монгол Улсын эдийн засгийг хөгжүүлэх хөгжлийн үндсэн таван чиглэлийн төслийг задлан харуулбал,

- **Хүний хөгжлийг бодлогынхоо цөмд нь тавина.** Чадварлаг, бүтээмжтэй, эрүүл саруул, дэлхийд өрсөлдөх чадамжтай монгол хүний хөгжилд чиглэж, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын цогц реформыг эрчимжүүлнэ. Мөн бүтээмжтэй, гүйцэтгэл, үр дүнд суурилсан цалин хөлсний бодлогыг салбар бүрд нэвтрүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар иргэдийн амьдралын чанарыг сайжруулна;
- **Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эрчимжүүлнэ.** Уул уурхайн салбараас хэт хамаарлыг бууруулж, эдийн засгийг төрөлжүүлнэ. Түүнчлэн экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон инновацыг дэмжих замаар дотоод нөөц бололцоог өргөжүүлнэ;
- **Эрчим хүчний системийн найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг хангана.** Дотоодын эрчим хүчний үйлдвэрлэлийн бүх үе шатанд шинэ технологи, инновацыг нэвтрүүлж, үр ашгийг сайжруулан, импортын хараат байдлыг бууруулахад голлон анхаарч, экспортлогч орон болохыг зорино;
- **Цахим шилжилтийг эрхэмлэж, их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг зорилтоо болгоно.** Өндөр технологи шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулахаас гадна, төр хувийн хэвшил, иргэн, олон улсын хамтын ажиллагааг уялдуулна. Мөн их өгөгдөл, хиймэл оюунд суурилсан төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлнэ.

- **Цомхон, чадварлаг, бүтээмжтэй төрийн албыг бий болгож, засаглалыг сайжруулна.** Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн тоог цөөлж, хувьчлалыг эрчимжүүлэн, “ТООНООС ЧАНАРТ ШИЛЖИЖ”, төрийн албаны шинэчлэлийг үргэлжлүүлнэ. Үүний зэрэгцээ хувийн хэвшлийн хийх боломжтой ажлыг төр хийхгүй байх зарчмыг баримталж, төр зарим үйлчилгээний чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлж, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.

Эдгээр бодлогын үр дүнд ирэх таван жилд хүний хөгжлийг нэн тэргүүнд тавин боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тогтолцоог орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэ шатанд гаргаж, дэвшилтэт технологи, инновацыг бүх салбарт нэвтрүүлж, хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг таатай болгон эдийн засгийн багтаамжийг 2 дахин тэлж, нэг хүнд ногдох ДНБ-ийг 10,000 ам.долларт хүргэнэ.

Ирэх жил бол Эдийн засаг, хөгжлийн яамнаас боловсруулж буй дунд хугацааны хөгжлийн бодлогын эхний жил учраас 2026 ОНЫ ТӨСВИЙН БОДЛОГЫГ “Монгол Улсыг 2026–2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэхэд чиглүүлэхийн зэрэгцээ “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон “Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний хүрээнд боловсруулаад байна.

Гэвч 2026 оны төсвийн бодлогыг тодорхойлохдоо гадаад эдийн засгийн тодорхой бус байдал, үүнээс улбаалсан дотоод эдийн засгийн сорилтууд болон дараах онцлогуудыг харгалзаж үзлээ. Үүнд:

1. **Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал хэвээр хадгалагдана:** Томоохон гүрнүүдийн худалдааны дайн болон геополитикийн хурцадмал байдлаас үүссэн тодорхой бус байдал ирэх онд ч үргэлжлэх төлөвтэй байна.
2. **Түүхий эдийн үнэ тогтворгүй, хэлбэлзэл өндөр:** 2025 оны эхний хагаст БНХАУ-ын эрэлт суларснаас шалтгаалан нүүрсний хилийн үнэ 40 хувиар буурч, сүүлийн 15 жилийн хамгийн доод түвшинд хүрсэн. Энэхүү тренд хэвээр хадгалагдаж, 2026 онд экспортын голлох түүхий эдийн үнэ өмнөх онтой ижил түвшинд байхаар байна.
3. **Монгол Улсын эдийн засгийн идэвхжил сул:** Гадаад эдийн засгийн тодорхойгүй байдлаас шалтгаалан манай улсын голлох салбаруудын өсөлт удаашрах, бүтээмж өндөртэй салбаруудад хөдөлмөр эрхлэлт буурах, өрхийн бодит орлого, хэрэглээ болон худалдан авалтын өсөлт саарах зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр 2026 онд эдийн засгийн идэвхжил суларч болзошгүй.
4. **Төсвийн орон зай хязгаарлагдмал:** Түүхий эдийн үнэ буурч, эдийн засгийн идэвхжил сул байгаагаас шалтгаалан 2026 онд төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ ДНБ-ий 30.9 хувьд хүрэхээр байна. Энэ нь өмнөх оноос 2.7 хувиар буурсан үзүүлэлт юм.
5. **Төсвийн зарлагыг оновчтойгоор дахин хуваарилна:** Төсвийн урсгал зардлыг 2025 оны түвшинд буюу ДНБ-ий 24 хувьд хязгаарлаж, үр ашигтай, оновчтой байдлаар дахин хуваарилна.
6. **Иргэдийн санал дээр үндэслэсэн төсвийг боловсруулна:** 2026 оны төсвийн онцлог нь төсвийг боловсруулах явцад анх удаа олон нийтийн саналыг авсан ба

нийт 189 мянган иргэн саналаа хүргүүлсэн. Үүнээс давхардсан тоогоор 235 мянган иргэн эрүүл мэнд, боловсролын салбарт төсвийг түлхүү чиглүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна.

Иймд 2026 оны төсвийн бодлого нь **“макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, төсвийн зардлын өсөлтийг хязгаарлаж, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж хувийн хэвшлийг дэмжихийн зэрэгцээ олон нийтийн саналд үндэслэн эрүүл мэнд, боловсролын салбарт түлхүү анхаарна.”** Үүн дотроо:

1. Хүний хөгжил бол хамгийн том МЕГА төсөл байх болно.

Эрүүл мэнд:

- Эрүүл мэндийн даатгалын сангийн нөөцийг өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй өвчин эмгэг, амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээнд түлхүү зарцуулж, хүлээж болохуйц, амьдралын чанар сайжруулах тусламж, үйлчилгээнд **иргэний хариуцан төлөх хамтын төлбөрийн** хэмжээг нэмэгдүүлэх замаар шатлал хоорондын урсгалыг зохицуулж, санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлнэ.
- Эрүүл мэндийн салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 211.6 тэрбум төгрөг, гадаадын зээл тусламжаар 1,089.5 тэрбум төгрөг буюу нийт 1.3 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдэнэ. Тус хөрөнгө оруулалтаар салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх буюу Хавдрын эмнэлэг, Эс эд эрхтэн шилжүүлэх суулгах эмнэлэг, Зүрх судасны эмнэлгийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх бөгөөд гадаад зээлийн хөрөнгөөр 17 аймгийн эмнэлгийн барилгыг шинэчлэх, эрчимт эмчилгээ болон яаралтай тусламжийг сайжруулж, нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг санхүүжүүлнэ.

Боловсрол:

- Засгийн газраас 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд хамрагдалтыг 100 хувьд хүргэх, анги бүлгийн хүүхдийн тоог стандартын түвшинд хүргэж бууруулах зорилтыг дэвшүүлэн, 2028 он хүртэл 95 цэцэрлэг, 108 сургуулийг шинээр барьж, шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 448.0 тэрбум төгрөг, гадаадын зээл тусламжаар 593.6 тэрбум төгрөг буюу нийт 1.0 их наяд төгрөгийг 2026 оны төсвийн төсөлд тусгалаа.

Нийгмийн хамгаалал:

- Нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлнэ.
- Иргэдийн амьдралын чанар, орон сууцны санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орон сууцны санхүүжилтийн банкийг төр, хувийн хэвшил болон олон улсын санхүүгийн байгууллагын хамтын санхүүжилтээр байгуулж орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бэхжүүлнэ. Мөн олон улсын

сайн туршлагад тулгуурлан орон сууцны санхүүжилтийн банкны засаглал, үйл ажиллагааг улс төрөөс хараат бус, бие даасан байдлаар зохион байгуулж, олон улсын хөрөнгийн зах зээл болон Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын бодлоготой уялдуулах замаар санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

2. Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж, хувийн хэвшилд суурилсан өсөлтийг дэмжинэ.

Татварын шинэчлэл:

- Монгол Улсын Их хурлаас 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 үйл ажиллагааны хөтөлбөрт заасны дагуу улс орон даяар жил орчмын хугацаанд хэлэлцүүлж, олон нийтийн санал авч боловсруулсан татварын шинэчлэлийг 2026 оноос эхлэн үе шаттай хэрэгжүүлж эхэлнэ.
- Татварын шинэчлэлээр иргэд, аж ахуйн нэгжүүдийн татварын дэмжлэгийг оновчтой тогтоож, бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, жижиг, дунд бизнесүүдийн татварын хялбаршуулсан горимыг боловсронгуй болгож дэмжих, үйлдвэрлэгч нарт тулгардаг НӨАТ-ын хүндрэлийг шийдэх, бүх нийтээрээ НӨАТ-ыг жигд шударгаар төлдөг болж төлбөрийн баримт, татварын бүртгэл хамрагдалтыг сайжруулах, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих, татвар төлөх хугацааг сунгаж уян хатан болгох, зөвлөн туслах үйлчилгээнд төвлөрсөн татварын тогтолцоонд шилжих татварын ажлууд үе шаттай хэрэгжүүлж эхэлнэ.

Төр хувийн хэвшлийн түншлэл:

- Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг хялбаршуулж, өндөр үр ашиг бүхий дэд бүтцийн томоохон төслүүдийг хувийн хэвшил өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэн төрийн ачааллыг бууруулна.

3. Эрчим хүчний шинэчлэлийг эрчимжүүлж, найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг хангана.

- Эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх хүрээнд уг салбарт 2026 онд нийт 3.9 их наяд төгрөгийн бүтээн байгуулалт хийгдэнэ. Үүнд, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 347.4 тэрбум төгрөг, гадаад зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар 522.1 тэрбум төгрөг, төр хувийн хэвшлийн түншлэлээр 351.8 тэрбум төгрөг, бондын санхүүжилтээр 150 тэрбум төгрөг, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 2,566.3 тэрбум төгрөг буюу нийт 3.9 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдэнэ. Үүний үр дүнд, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг 3,515 мянган МВт.ц-аар, төвлөрсөн дулаан хангамжийн хүчин чадлыг 112 МВт-аар тус тус нэмэгдүүлнэ. Ингэснээр

цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын хувь 99.7 хувьд хүрч нэмэгдэх ба импортын цахилгаан эрчим хүчийг 663.4 мянган МВт.ц- аар бууруулна.

4. Цахим шинэчлэлийг хурдасгаж, их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг нэмэгдүүлнэ.

- Төрийн “Big data (их өгөгдөл)” суурилан зөвшөөрөл олгох үйл явцыг хялбаршуулна.
- Хиймэл оюунд суурилсан төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлнэ.
- Улсын төсөв болон гадаад зээлийн хөрөнгөөр үүрэн холбооны сүлжээ, шилэн кабель, 4G-ийн өргөтгөл хийж алслагдсан сум, багийн иргэдийг өндөр хурдны интернэт, мобайл сүлжээгээр хангана.
- Дэвшилтэт технологи, инновацад суурилсан гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх, эрт сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай авах, эрсдэлийг бууруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээр төлөвлөлөө.

5. Засаглалын шинэчлэлийг эрчимжүүлж, олон нийтийн хяналттай, цомхон, чадварлаг төрийн албыг бүрдүүлнэ.

- Чиг үүргийн давхардлыг арилган, төрийн албыг цомхон чадварлаг болгож хэмнэлт хийнэ.
- Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьцааг олон нийтэд санал болгож, бүтцийн өөрчлөлт хийнэ.
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг нэгтгэх, татан буулгах, бүтэц, орон тоо, түүний цалин хөлсний бодлогыг оновчтой тогтоож, удирдлагын багийг улс төрөөс ангид, нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулан томилно.
- Шүүхийн хараат бус байдлыг хангаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо бүрдүүлэх хүрээнд Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх, Хялбар ажиллагааны шүүхүүд байгуулна.

Ийнхүү, 2026 оны төсвийн төслийг “ТАНЫ ТӨЛСӨН ТАТВАРЫГ - ТАНЫ САНАЛААР - ХӨГЖИНГҮЙ МОНГОЛЫН ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ” зарчимд тулгуурлан боловсрууллаа.

ШИГТГЭЭ-1 ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХЖИЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

Эдийн засгийн мөчлөг гэдэг нь эдийн засгийн өсөлт, оргил, уналт, хямралын үе шатуудын дараалсан хэлбэлзэл юм. Эдийн засагт уналт, халалт зэрэг тогтворгүй байдал үүссэн нөхцөлд төрөөс төсөв, мөнгөний болон бусад бодлогын арга хэрэгслээр дамжуулан эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэхийг мөчлөг сөрсөн бодлого гэнэ.

Мөчлөг сөрсөн төсвийн бодлого – Эдийн засгийн уналтын үед төрөөс төсвийн зарлагыг нэмэгдүүлэх, татварын хэмжээг бууруулах болон зохицуулалтын бусад арга хэрэгсэл (жишээ нь төсвийн дүрэм, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах зэрэг)-ээр дамжуулан нийт эрэлтийг дэмжиж, эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлдэг. Харин эдийн засгийн халалтын үед төсвийн зарлагыг бууруулах, татварын хэмжээг нэмэгдүүлэх замаар эрэлтийг хязгаарлаж, эдийн засгийн тогтвортой байдлыг хангадаг.

Мөчлөг сөрсөн мөнгөний бодлого – Уналтын үед бодлогын хүүг бууруулах, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар хөрөнгө оруулалт, хэрэглээг дэмжинэ. Халалтын үед бодлогын хүүг нэмэгдүүлж, мөнгөний нийлүүлэлтийг бууруулах замаар эрэлтийг хязгаарлаж, эдийн засгийг тогтворжуулна.

Санхүүгийн зах зээлийн бусад арга хэрэгсэл: Макро зохистой бодлого, санхүүгийн зах зээлийн зохицуулалт зэрэг бодлогын арга хэрэгслээр дамжуулан санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангаж, эдийн засгийг тогтворжуулна.

2022-2023 онд Монгол Улсын Засгийн газар экспортыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлснээр эдийн засаг эрчимжиж 2023 оны сүүлийн хагаст үйлдвэрлэлийн зөрүү эерэг




болсон бол 2024 онд зудын нөхцөл байдлаас үүдэн хөдөө аж ахуйн салбар огцом агшиж үйлдвэрлэлийн сөрөг зөрүү нэмэгдсэн. 2025 он гарснаар АНУ-ын тарифын бодлого, БНХАУ-ын эдийн засгийн удаашрал зэрэг гадаад орчинд үүссэн нөхцөл байдлын улмаас нүүрсний үнэ 40 орчим хувиар буурч, уул уурхай, түүнийг дагасан тээвэр, худалдааны салбар удааширч 2025 оны II улирлын

байдлаар Монгол Улсын эдийн засаг потенциал үйлдвэрлэлийн түвшиндээ хүрээгүй байна. Бүтээмж өндөртэй салбаруудад хөдөлмөр эрхлэлт буурах, өрхийн хэрэглээ, худалдан авалтын өсөлт саарах, гадаад болон төсвийн хөрөнгө оруулалт хумигдах зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр 2026 онд манай улсын эдийн засгийн идэвхжил суларч болзошгүй. Иймээс бид 2026 онд татварын шинэчлэлийн хүрээнд иргэдийн бодит орлогыг хамгаалах, хувийн хэвшлийн бизнесийн орчныг сайжруулах, ТХХТ-ийн тухай хуулийн хүрээнд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг бодлогууд хэрэгжүүлж, эдийн засгийн идэвхжилийг дэмжин үйлдвэрлэлийг потенциал түвшинд хүргэнэ.

II БҮЛЭГ: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

2.1. Дэлхийн эдийн засгийн төлөв байдал

Худалдааны дайн намжсан ч дэлхийн эдийн засгийн төлөв байдал сул хэвээр байна. Сүүлийн саруудад АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп улс орнуудтай хэлэлцээр хийж тарифын бодлогоо сулруулж эхэлснээр худалдааны дайны эрсдэл намжиж эхэллээ. Үүнтэй зэрэгцэн олон улсын байгууллагууд дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөв байдлыг өмнөх төсөөллөөс сайжруулсан. Тухайлбал, Олон улсын валютын сан худалдааны эргэлт



Эх сурвалж: ОУВС-н төлөв байдлын 6-р сарын тайлан

тогтворжиж, хөрөнгө оруулалтын урсгал нэмэгдэхээр тооцож 2025-2026 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөв байдлыг өмнөх төсөөллөөс 0.1-0.2 нэгж хувиар нэмэгдүүлэв.

Худалдааны хэлэлцээрүүд богино хугацаанд зах зээлд эерэг дохио өгч байгаа ч дунд, урт хугацаанд тогтворжих эсэх нь тодорхой бус хэвээр байна. Иймд,

2025–2026 оны дэлхийн эдийн засгийн өсөлт сүүлийн арван жилийн дунджаас доогуур түвшинд хадгалагдах хүлээлттэй байна. Энэ нөхцөлд улс орнууд эрсдэлд тэсвэртэй байдлаа нэмэгдүүлж, худалдааны шинэ түншлэлийг өргөжүүлэх, мөн дотоодын эрэлт ба хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх төлөвтэй байна. Зүүн Азийн хөгжиж буй орнууд худалдааны шинэ түншлэлийг эрэлхийлж, гадаад худалдааг нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа бол Латин Америкийн орнууд уул уурхайн салбараас өндөр хамааралтай байдлыг бууруулж, эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэх чиглэлд голлон анхаарч байна.

БНХАУ-ын эдийн засаг 2025 оны эхний хагас жилд 5.3 хувиар өсөж, хүлээлтийг давлаа. Өсөлтөд АНУ-аас гадна бусад улс орнууд руу чиглэсэн экспорт нэмэгдсэн нь голлон нөлөөлж, нийт экспортын хэмжээ 7.2 хувиар өсөв. Харин импорт 2.7 хувиар буурсан нь зарим төрлийн түүхий эдийн эрэлт буурч, дотоодын хөрөнгө оруулалтын идэвх суларсныг илтгэнэ. Салбарын хувьд аялал жуулчлал, цахим худалдаа зэрэг үйлчилгээний салбар эерэг өсөлт үзүүлсэн бол үл хөдлөх хөрөнгийн салбарын хөрөнгө оруулалт 11.0 хувиар буурч, уналт үргэлжилсэн хэвээр байна. Мөн инфляц 0 орчим хувь байгаа нь дотоодын хэрэглээ бүрэн сэргээгүйг харуулж байна.

Fitch Rating агентлагийн үзэж байгаагаар, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт нь төсвийн тэлэлт зэрэг Засгийн газрын бодлогын дэмжлэг болон тариф хэрэгжихээс өмнөх экспортын захиалгыг түрүүлж гүйцэтгэсэн "front-loading" үйл явцад тулгуурласан, түр зуурын шинжтэй өсөлт байх магадлалтай гэж үзэж байна.¹ Мөн сүүлийн саруудад АНУ-ын гадаад худалдааны тарифын бодлого харьцангуй зөөлөрснөөс шалтгаалан Олон улсын валютын сан БНХАУ-ын 2025 оны өсөлтийн төлөвийг 4.8 хувь, Дэлхийн банк 4.6 хувь

¹ China's Port Throughput Slows Further, but Offset by Front-Loading Containers

болгон өсгөсөн ч, 2026 онд уг үзүүлэлт ОУВС-ын тооцоогоор 4.2 хувь, Дэлхийн банкны таамгаар 4.0 хувь болж буурахаар тооцоолжээ. Энэ нь үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн удаашрал, дотоодын хөрөнгө оруулалтын идэвх сул, мөн гадаад худалдааны орчны тодорхойгүй байдалтай холбоотой гэж үзэж байна.

БНХАУ-ын 2021–2025 оны 14 дэх “Таван жилийн төлөвлөгөө”-ний хүрээнд үл хөдлөх хөрөнгө, барилга байгууламж болон хүнд үйлдвэрлэлд тулгуурласан, хурдтай өсөлтийн загварыг баримталж ирсэн бол 2026–2030 оны 15 дахь “Таван жилийн төлөвлөгөө”-нд шинжлэх ухаан, дэвшилтэт техник, технологид суурилсан шинэ бүтцийг төлөвшүүлж, эдийн засгийн чанартай өсөлтөд чиглэсэн бодлого давамгайлах төлөвтэй байна. Үүнтэй уялдуулан өндөр технологийн үйлдвэрлэл, ногоон эрчим хүч, дижитал эдийн засаг, хиймэл оюун ухаан, биотехнологи зэрэг стратегийн ач холбогдол бүхий салбаруудыг эрчимтэй хөгжүүлж, инновацын экосистемийг өргөжүүлэх зорилтыг тэргүүлэх чиглэл болгохыг Шанхай хотноо болсон уулзалтын үеэр БНХАУ-ын Ерөнхийлөгч Ши Жиньпин онцлон тэмдэглэсэн байна.²

Мөн гадаад бодлогын хүрээнд АНУ болон хөгжингүй орнуудаас эдийн засгийн хараат байдлаа бууруулахын зэрэгцээ “Дэлхийн Өмнөд”-ийн орнуудтай дэд бүтэц, аж үйлдвэржилтийн салбарт хамтын ажиллагааг идэвхжүүлэх бодлого баримталж байна. Сингапурын Үндэсний их сургуулийн дэд профессор Гү Чиньянгийн тайлбарласнаар, Дэлхийн Өмнөдийн дэд бүтэц, аж үйлдвэржилтийн эрэлт хэрэгцээг хангаж, эцсийн хэрэглээний барааны оронд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлийн гинжин хэлхээ бүхий барааг экспортлох нь дотоодын эрэлтийн дутагдлыг нөхөх, илүүдэл хүчин чадлыг ашиглах, ажил эрхлэлт ба орлогыг өсгөхөөс гадна хөгжингүй орнуудаас хараат байдлыг бууруулж, худалдааны маргааны эрсдэлийг сааруулах боломжтой гэж үзэж байна.³

2.2. Түүхий эдийн зах зээлийн хандлага

Зэс: Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн дундаж үнэ 2024 онд 9,145 ам.доллар болж, өмнөх оноос 7.9 хувиар өссөн байна. Харин 2025 оны эхний 7 сарын байдлаар 9,475 ам.доллар болж, өмнөх оноос 3.6 хувиар өссөн байна. АНУ-ын тарифын бодлогын шийдвэрүүдээс үүдэлтэй томоохон үйлдвэрүүдийн зэсийн нөөцийн хэлбэлзэл дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэд нөлөөлж байна. Дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдэж байгаа хэдий ч цахилгаан автомашин, сэргээгдэх эрчим хүч, тоон өгөгдөл боловсруулах төвүүд, технологийн салбарын хурдацтай хөгжлөөс шалтгаалан зэсийн эрэлт нэмэгдэж үнэ өсөхөөр байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар зэсийн дундаж үнэ 2025 онд 9,200 ам.доллар, 2026 онд 9,700 ам.долларт хүрэхээр байна.

² "Ерөнхийлөгч Ши Жиньпин БНХАУ-ын 15 дахь таван жилийн төлөвлөгөөний чиглэл, зорилтыг тодорхойлов"

³ "Өмнө чиглэсэн хөгжил: Барууны зах зээлээс цааш чиглэсэн БНХАУ-ын эдийн засгийн шинэ өсөлтийн стратеги"

Зураг 2. Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл
(ам.доллар/тонн)



Зураг 3. Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл
(ам.доллар/трой унц)



Эх сурвалж: Блүүмберг терминал

Алт: Лондоны металлын бирж дэх алтны дундаж үнэ 2024 онд 2,389 ам.доллар болж, өмнөх оноос 22.9 хувиар өссөн байна. Харин 2025 оны эхний 7 сарын байдлаар 3,115 ам.доллар болж, өмнөх оноос 30.4 хувиар өссөн байна. АНУ-ын Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ 2024 онд бууруулсан нь алтны эрэлтийг нэмэгдүүлж, үнэ өсөхөд нөлөөллөө. Дэлхийн тодорхой бус байдал нэмэгдэж байгаатай холбоотойгоор алтны үнэ үргэлжлэн өсөх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар алтны дундаж үнэ 2025 онд 2,900 ам.доллар, 2026 онд 2,800 ам.долларт хүрэхээр байна.

Төмрийн хүдэр: Төмрийн хүдрийн (62 хувийн агууламжтай) үнэ 2024 онд 110 ам.доллар болж, өмнөх оноос 8.0 хувиар буурсан байна. Харин 2025 оны эхний 7 сарын байдлаар 100 ам.доллар болж, өмнөх оноос 9.3 хувиар буурлаа. Австрали, Бразил зэрэг улсуудын нийлүүлэлтийн өсөлт, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт төмрийн хүдрийн үнэ буурахад голлон нөлөөллөө. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар богино хугацаанд сэргэх төлөвгүй байгаагаас гадна Австрали, Бразил зэрэг улсуудын олборлолт тогтвортой өсөхөөр байгаа тул төмрийн хүдрийн үнэ буурах төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар төмрийн хүдрийн дундаж үнэ 2025 онд 95 ам.доллар, 2026 онд 90 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 4. Төмрийн хүдрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл
(ам.доллар/тонн)



Зураг 5. Нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл
(ам.доллар/тонн)



Эх сурвалж: Блүүмберг терминал

Коксжих нүүрс: Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний дундаж үнэ 2024 онд 243 ам.доллар болж, өмнөх оноос 17.9 хувиар буурсан

байна. Харин 2025 оны эхний 7 сарын байдлаар 184 ам.доллар болж, өмнөх оноос 24.2 хувиар буурлаа. Дэлхийн коксжих нүүрсний хэрэглээний хоёрдогч том хэрэглэгч болох Энэтхэг улс руу чиглэсэн гангийн нийлүүлэлт нэмэгдсэн, БНХАУ-ын ган хайлуулах томоохон үйлдвэрүүд коксжих нүүрсний татан авалтаа удаашруулсан зэрэг нь коксжих нүүрсний үнэ буурахад голлон нөлөөллөө. Дэлхийн тодорхой бус байдал, худалдааны дайнаас шалтгаалан нүүрсний үнэ буурах дарамт нэмэгдэж байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар коксжих нүүрсний дундаж үнэ 2025-2026 онд 175 ам.долларт хүрч буурахаар байна.

Газрын тос: Brent төрлийн газрын тосны дундаж үнэ 2024 онд 80 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 2.8 хувиар буурсан байна. Харин 2025 оны эхний 7 сарын байдлаар 68 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 9.3 хувиар буурлаа. АНУ болон Канад, Бразил зэрэг улсуудын газрын тосны олборлолт нэмэгдсэнээс гадна БНХАУ-ын эрэлт бага байсан нь газрын тосны үнэ буурахад голлон нөлөөллөө. Геополитикийн тодорхой бус байдал, худалдааны дайнаас үүдэлтэй дэлхийн эдийн засгийн идэвхжилийн удаашралаас шалтгаалан газрын тосны үнэ буурах төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар Brent төрлийн газрын тосны дундаж үнэ 2025 онд 75 ам.доллар, 2026 онд 72 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 6. Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/баррель)



Эх сурвалж: Блуумберг терминал

2.3. Монгол Улсын макро эдийн засгийн төлөв байдал


2.3.1. Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2025 оны эхний хагас жилд 40.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 15.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар тус тус өслөө.

Хүснэгт 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, салбаруудаар
(хувь)

| Салбар | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025.II |
|---------------|------|------|------|------|---------|
| ДНБ | 1.6 | 5.0 | 7.4 | 5.1 | 5.6 |
| ХАА | -0.8 | 1.7 | -1.3 | -3.6 | 3.6 |
| Үйлдвэрлэл | -0.6 | -1.2 | 3.2 | 1.6 | 1.2 |
| Уул уурхай | 0.1 | -2.1 | 2.6 | 1.4 | 0.1 |
| Боловсруулах | -0.1 | 0.5 | 0.4 | -0.3 | 0.3 |
| Цахилгаан, ус | 0.2 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.3 |
| Барилга | -0.9 | 0.2 | 0.1 | 0.4 | 0.4 |
| Үйлчилгээ | 1.8 | 3.2 | 4.7 | 5.4 | 0.7 |
| Худалдаа | 0.6 | 1.1 | 0.8 | 1.4 | -0.7 |
| Тээвэр | -0.3 | 0.4 | 1.8 | 1.0 | -0.6 |
| Бусад | 1.5 | 1.7 | 2.1 | 2.5 | 1.4 |
| Цэвэр татвар | 1.3 | 1.4 | 0.8 | 1.8 | 0.2 |

Зураг 7. ДНБ-ий өсөлтийн бүтэц, эрэлт талаас (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөө аж ахуйн салбарын сэргэлт эдийн засгийн өсөлтийг дэмжиж байгаа бол уул уурхайн салбарын өсөлт удааширч, тээвэр, худалдааны салбарууд агшиж, өсөлтийг сааруулав.

Уул уурхайн салбар дах зэсийн баяжмалаас бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурснаар өсөлтийн эрчим өнгөрсөн оноос саарч, 1.1 хувьд хязгаарлагдлаа. Тухайлбал, нүүрс олборлолт 43.8 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 11 хувиар, төмрийн хүдэр, баяжмал үйлдвэрлэл 4.8 сая тонн болж, өмнөх оны мөн үеэс 5 хувиар тус тус буурлаа. Түүнчлэн 2025 оны эхний хагас жилд газрын тос олборлолт 1.9 сая баррель, алтны олборлолт 4.5 тонн болж буурсан байна. Харин Оюу толгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэнээр нийт зэсийн баяжмал үйлдвэрлэл 29 хувиар өсөж 970 мянган тоннд хүрч, уул уурхайн салбарын өсөлтийг дэмжлээ.

Уул уурхайн бус салбарын өсөлт 2025 оны эхний хагас жилд хөдөө аж ахуйн салбарын сэргэлтийн голлох нөлөөгөөр эрчимжиж, 6.3 хувьд хүрлээ. Хаваржилт тогтуун байж, мал төллөлт, бойжилт хэвийн үргэлжилсний үр дүнд бойжсон төлийн тоо толгой 20.8 саяд хүрч (төл бойжилт 98.5 хувь) өмнөх оны мөн үеэс 5.4 сая толгой малаар нэмэгдэн, том малын зүй бус хорогдол 189 мянга болж, өмнөх оны мөн үеэс 7.9 сая толгой малаар буурсан голлох нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбар 36 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 3.6 нэгж хувийг бүрдүүллээ. Барилгын салбар 2025 оны эхний хагас жилд орон сууц, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламж болон Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын голлох нөлөөгөөр 25 хувиар өсөж, өсөлтийг 0.4 нэгж хувиар дэмжлээ. Мөн шинээр ашиглалтад орсон Тосон, Бөөрөлжүүт зэрэг ДЦС-уудын үйлдвэрлэлийн нөлөөгөөр цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл 4.8 тэрбум кВт цагт хүрч өмнөх оны мөн үеэс 9 хувиар, дулааны эрчим хүч үйлдвэрлэл 9.5 сая.Гкалд хүрч 7.7 хувиар өссөнөөр эрчим хүчний салбар үйлдвэрлэл 8.4 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийг 0.3 хувиар дэмжлээ. Харин авто тээврийн орлогын бууралтын голлох нөлөөгөөр тээврийн салбар 2025 оны эхний хагас жилд 12.5 хувиар агшиж, эдийн засгийн өсөлтийг

0.6 нэгж хувиар сааруулав. Мөн бөөний болон жижиглэн худалдааны салбар 5.7 хувиар агшлаа.


Нийт эрэлтийн талаас авч үзвэл эдийн засгийн өсөлт 2025 оны эхний хагас жилд үндсэн хөрөнгийн хуримтлал, өрхийн хэрэглээний өсөлтийн голлох нөлөөгөөр 5.7 хувьд хүрч, өмнөх оны мөн үеийн орчимд хадгалагдлаа. Хаврын цаг агаар таатай байж том малын зүй бус хорогдол бага, төл бойжилт өндөр байсны үр дүнд биологийн өсөж үрждэг хөрөнгө нэмэгдсэний голлох нөлөөгөөр үндсэн хөрөнгийн хуримтлал өмнөх оны мөн үеэс 18.6 хувиар өсөж, нийт эрэлтийн өсөлтийг 6.5 нэгж хувиар дэмжлээ. Мөн орон сууц, эмнэлэг, сургууль, цэцэрлэг зэрэг орон сууцны бус барилгын бүтээн байгуулалтын ажил үндсэн хөрөнгийн хуримтлалыг дэмжсэн байна. Өрхийн хэрэглээ 2025 оны эхний хагас жилд 9.9 хувиар өсөж, нийт өсөлтийг 7.8 нэгж хувиар дэмжээ. Өрхийн бодит орлого өмнөх оны мөн үеэс 8.0 хувиар, хэрэглээний зээл 19.6 хувиар тус тус өссөн нь өрхийн хэрэглээний өсөлтийг голлон дэмжсэн байна. Харин зэсээс бусад уул уурхайн бүтээгдэхүүний экспорт буурсан хэдий ч барааны импортын өсөлт саарсан нь нийт эдийн засгийн өсөлтөд үзүүлэх цэвэр экспортын сөрөг нөлөөг бууруулсан байна.

Инфляц: Улсын жилийн инфляц 2025 оны 7 дугаар сард 8.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.0 нэгж хувиар өсөж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурлаа. Инфляц өмнөх оны мөн үеэс өсөхөд мах, цахилгааны төлбөр, орон сууцны түрээс, машин болон нийтийн тээврийн үйлчилгээ, хувцасны бүлгийн үнийн өсөлт голчлон нөлөөлжээ.

Импортын барааны үнэ 2025 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өсөж, нийт инфляцын 2.1 нэгж хувь буюу 26.1 хувийг бүрдүүлсэн байна. Импортын барааны үнийн өсөлтийн дийлэнхийг хүнсний бус бараа бүрдүүлж байна.

Дотоодын бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 11.5 хувиар өсөж, нийт инфляцын 6.0 нэгж хувь буюу 73.9 хувийг бүрдүүллээ. Хүнсний барааны үнэ 2025 оны 7 дугаар сард 6.4 хувиар өссөн нь нийт инфляцын 1.8 нэгж хувийг бүрдүүлэв. Үүний 1.5 нэгж хувийг дотоодын хүнсний бүтээгдэхүүн бүрдүүллээ. Хүнсний үнийн өсөлтийн дийлэнх буюу 80 орчим хувийг талх, нарийн боов, сүү, мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт тайлбарлаж байна.

Зураг 8. Жилийн инфляц ба зорилтот түвшин (хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүнсний бус бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар өсөж, нийт инфляцын 6.3 нэгж хувийг эзэлж байна. Үүнд хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар, өрхийн цахилгааны төлбөр 65 хувиар, автобусны билетийн үнэ 100 хувиар, орон сууцны түрээс 40.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлөв.

Хүнс, шатахуун, хатуу түлш, болон эрчим хүчний нөлөөг хасаж тооцсон эрэлтийн гаралтай (суурь) инфляц 2025 оны 7 дугаар сард 8.2 хувь гарч, өмнөх оны мөн үеэс 2.8 нэгж хувиар эрчимжсэн хэдий ч сүүлийн 4 сар дараалан буурч байна. Эрэлтийн инфляц саарахад эдийн засгийн дотоод идэвхжил суларсан нь нөлөөллөө. Эрэлтийн шалтгаантай инфляц нийт инфляцын дийлэнх буюу 62 орчим хувийг тайлбарлаж байна. Нийлүүлэлтийн гаралтай инфляц 2025 оны 7 дугаар сард 7.9 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.5 нэгж хувиар эрчимжив. Үүнд цахилгааны тариф нэмэгдсэн болон малын зүй бус хорогдолтой холбоотойгоор махны үнэ өссөн нь нөлөөллөө.

Мөнгөний нийлүүлэлт: Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 43.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар өслөө. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд эх үүсвэр (пассив) талаас төгрөг ба гадаад валютын хадгаламж нийлбэр дүнгээр 15.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн бол төгрөг ба гадаад валютын харилцах нийлбэр дүнгээр өмнөх оны мөн үеэс 12.9 хувиар буурч, өсөлтийг сааруулжээ. Харин мөнгөний нийлүүлэлтийн байршуулалт (актив) талаас гадаад цэвэр актив жилийн өсөлтийн -14.3 нэгж хувийг, дотоод цэвэр актив 18.0 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна. Зээлийн өсөлт өндөр хэвээр хадгалагдсан нь дотоод цэвэр активыг нэмэгдүүлсэн байна.


Зураг 9. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, пассив тал (хувь)



Эх сурвалж: Монголбанк

Тэмдэглэл: ЗГЦЗ- Засгийн газрын цэвэр зээл, ГЦА-Гадаад цэвэр актив

Зураг 10. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, актив тал (хувь)



Эх сурвалж: Монголбанк, тооцоолол


Ажил эрхлэлт, ажилгүйдэл: Ажиллагчдын тоо 2025 оны эхний хагасын байдлаар өмнөх оны мөн үеэс 43 мянгаар нэмэгдэж 1 сая 390 мянгад хүрсэн байна. Энэхүү өсөлтөд нийт ажиллагчдын дөрөвний нэгийг бүрдүүлдэг хөдөө аж ахуйн салбарын ажиллагчдын тоо сэргэж, өмнөх оны мөн үеэс 45 мянгаар буюу 14 хувиар өссөн нь голчлон нөлөөллөө. Мөн барилгын салбарт 15 мянга, уул уурхай, боловсруулах салбарт тус бүр 11 мянган ажилчид нэмэгдсэн нь өсөлтийг дэмжлээ. Харин үйлчилгээний салбарын ажилчид 27 мянгаар, худалдааны салбар 19 мянгаар буурсан нь өсөлтийн хурдыг сааруулсан байна.

Зураг 11. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбараар (мянган хүн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 12. Ажиллагчид (мян.хүн), ажиллах хүчний оролцооны түвшин (хувь)




Харин ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 16 мянган хүнээр буюу 20 хувиар буурч 66 мянгад хүрлээ. Ингэснээр ажилгүйдлийн түвшин 1.2 нэгж хувиар буурч 4.5 хувьд хүрэв. Энэхүү бууралт нь ажиллах хүчний өсөлтийг сааруулснаар ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар буурч 61.9 хувь болсон байна.

Төлбөрийн тэнцэл: Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оны мөн үеэс 12 хувиар буюу 1.0 тэрбум ам.доллаар буурснаар төлбөрийн тэнцэл 2025 оны эхний 6 сард 462 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Мөн бараа, үйлчилгээний импорт өмнөх оны мөн үеэс 1 хувиар буюу 91 сая ам.доллаар, шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал 41 хувиар буюу 0.6 тэрбум ам.доллаар тус тус бага байна. Гадаад валютын улсын нөөц 2025 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар 5,380 сая ам.доллар байна.

Гадаад худалдаа: Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2025 оны эхний 7 сард 14.2 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Экспорт 2025 оны эхний 7 сард 7.8 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар буурлаа. Экспортын бууралтад нүүрсний экспортын биет хэмжээ 44.4 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар, нүүрсний хилийн үнэ тонн тутамдаа 70 ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 40.1 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөллөө.

Зураг 13. Гадаад худалдааны нийт бараа эргэлт (тэрбум ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

БНХАУ-ын нүүрсний уурхайнуудын олборлолт нэмэгдсэнтэй холбоотойгоор нүүрсний нийлүүлэлт нэмэгдэж, үнэ буурсан байна. Харин Оюу толгойн далд уурхайн олборлолтын үйл ажиллагаа тогтворжсон, дэлхийн зах зээлд цэвэр зэсийн эрэлт өндөр түвшинд хадгалагдсан зэргээс шалтгаалан зэсийн баяжмалын экспорт 1,243 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 34.0 хувиар өсжээ. Мөн төмрийн хүдрийн экспорт 4,681 мянган тоннд хүрч, 10.0 хувиар нэмэгдсэн байна.


Уул уурхайн бус экспортын хувьд 2025 оны эхний 7 сард ноолуурын экспорт 78 хувиар буурсан байна. Түүнчлэн, боловсруулах үйлдвэрлэлийн идэвх сул байсан нь мах болон арьс, ширний экспорт буурахад нөлөөлсөн байна.

Нийт импорт 2025 оны эхний 7 сарын байдлаар 6.5 тэрбум ам.долларт хүрч, жилийн өсөлтийн хурд 1.1 хувьд хүрч саарлаа. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өмнөх оны мөн үеэс 14 хувиар өссөн бол аж үйлдвэрийн орцын импорт 10 хувиар, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 3 хувиар тус тус буурсан байна. Хэрэглээний бүтээгдэхүүний импортын өсөлтөд суудлын автомашин болон хүнсний бүтээгдэхүүний импорт голлох нөлөөг үзүүлээ. Тухайлбал, суудлын автомашины импорт 2025 оны эхний 7 сард 753 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 33 хувь буюу 187 сая ам.доллараар, хүнсний бүтээгдэхүүний импорт 682 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9 хувь буюу 55 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн байна.

2.3.2. Макро эдийн засгийн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

Эдийн засгийн өсөлтийг 2025 оны эцэст 5.5 хувь байхаар төсөөлж байна. Салбаруудаар авч үзвэл, байгаль цаг уурын таатай байдлын нөлөөгөөр төл бойжилт өндөр, том малын зүй бус хорогдол бага байж, хөдөө аж ахуйн салбар эдийн засгийн өсөлтийг голлон тэтгэх төлөвтэй байна. Нүүрс олборлолтын эрчим удааширч, уул уурхай салбарын өсөлтийн хурд саарах хандлагатай байгаа ч Оюу толгойн гүний уурхайн олборлолтын нөлөөгөөр баяжмал дахь зэс болон алтны агуулга нэмэгдэж, уул уурхайн салбарын өсөлтийг дэмжих хүлээлттэй байна. Барилгын салбарын өсөлт нь Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн төмөр зам, орон сууц, орон сууцны бус барилгын бүтээн байгуулалтын нөлөөгөөр эрчимжиж, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ. Хөдөө аж ахуй болон уул уурхайн салбарын үйл ажиллагааны идэвхжилийн нөлөөгөөр боловсруулах салбарын өсөлт эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэх төлөвтэй байна.

Зураг 14. Импорт, хэрэглээний зориулалтаар (тэрбум ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Нийт эрэлтийн талаас дотоод эрэлтийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө хадгалагдах хэдий ч 2024 оны түвшнээс сулрах хүлээлтэй байна. Дотоод эрэлтийг үндсэн хөрөнгийн хуримтлал голлон дэмжинэ. Харин цалингийн өсөлт саарч, хэрэглээний зээлийн нөхцөл чангарснаар өрхийн хэрэглээний өсөлт аажмаар хумигдах төлөвтэй байна. Нүүрс, газрын тосны экспорт буурсан ч, импортын өсөлт нам түвшинд хадгалагдсанаар цэвэр экспортын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх сөрөг нөлөөг буурахаар хүлээж байна.

Инфляц 2025 онд дунджаар төв банкны зорилтот түвшин орчимд байх төлөвтэй байна. Цахилгааны тарифын нэмэгдлийн нөлөөгөөр дотоодын бараа, үйлчилгээний үнэ өсөх хандлагатай байсны зэрэгцээ эрэлтийн гаралтай инфляц өндөр байсан бол 2025 оны сүүлээс саарч, тогтворжих хүлээлтэй байна. Цаашид геополитикийн хурцадмал байдал, уур амьсгалын өөрчлөлт, тээвэр логистикийн саатлаас үүдэн инфляц өдөөгдөх эрсдэлүүд хадгалагдаж байна.

Нийт экспорт 2025 онд 15.8 тэрбум ам.долларт хүрэхээр төсөөлж байна. Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспорт 14.5 тэрбум ам.долларт, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт 1.3 тэрбум ам.доллар, тэр дундаа хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт 717 сая ам.долларт тус тус хүрэхээр байна. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсноор хилийн Гашуунсухайт боомтын нүүрс тээврийн эргэлт сайжрах, Тавантолгой-Ханги чиглэлийн төмөр замын тээвэр зохион байгуулалтыг сайжруулснаар хилийн Ханги боомтын нүүрс тээвэр нэмэгдэж, нүүрсний экспорт 2025 онд 80 сая тоннд хүрэхээр байна. Түүнчлэн, Оюу толгойн гүний уурхайн зэсийн баяжмал дахь цэвэр зэс, алтны агуулга нэмэгдэж зэсийн баяжмалын экспорт 2,024 мянган тонн, олборлолт нэмэгдсэнтэй холбоотойгоор төмрийн хүдрийн экспорт 8,110 мянган тоннд хүрэхээр төсөөлж байна.

Харин нийт импорт 2025 онд 12.5 тэрбум ам.долларт хүрэхээр тооцоолж байна. Эдийн засгийн өсөлт хадгалагдаж, хэрэглээний бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлийн завсрын хэрэглээнд ашиглагдах бүтээгдэхүүний импорт нэмэгдэх төлөвтэй байгаа бол томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын нөлөөгөөр барилгын материалын импорт өсөхөөр байна.

2.3.3. Макро эдийн засгийн 2026 оны төсөөлөл

Эдийн засгийн өсөлт 2026 онд 5.7 хувь орчимд байна. Уул уурхайн салбарын өсөлт Оюутолгойн зэсийн баяжмал дахь алтны агуулга өмнөх оноос буурах хандлагатай байгаа ч зэсийн баяжмал олборлолт, баяжмал дах цэвэр зэсийн агуулга нэмэгдэх, нүүрс, төмрийн хүдэр, алтны олборлолтын өсөлтийн нөлөөгөөр 12 орчим хувьд байна. Уул уурхайн бус салбаруудын үйлдвэрлэл 2026 онд 4.8 хувь байна. Үүнд, тээврийн салбарт боомтуудын хил холболтын бүтээн байгуулалт хийгдэж, тээврийн дэд бүтэц сайжирснаар уул уурхайн болон уул уурхайн бус бүтээгдэхүүний ачаа тээвэр нэмэгдэж салбарын өсөлтийг дэмжинэ. “Хүнсний хувьсгал” хөдөлгөөн, “Цагаан алт” хөтөлбөр, “Атар-4” аянууд хөдөө аж ахуй, боловсруулах салбаруудын өсөлтийг дэмжинэ. Түүнчлэн, ирэх онуудад хэрэгжих томоохон төслүүд эдийн засгийн өсөлтийг дунд хугацаанд тогтвортой хадгалах хөшүүрэг

болно. Тухайлбал, Эрдэнэбүрэнгийн УЦС, Газрын тос боловсруулах үйлдвэр, Дулааны III цахилгаан станцын өргөтгөл, Улаанбаатар-Шинэ Хархорум хот чиглэлийн автозамын өргөтгөл шинэчлэл, Зэс хайлуулах үйлдвэр, Гангийн үйлдвэр, Нүүрс-химийн цогцолбор, Туулын хурдны зам, Сэлбэ дэд төв зэрэг бүтээн байгуулалтын төслүүд барилга, эрчим хүч, боловсруулах салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, өсөлтийг дэмжинэ. Мөн өрхийн хэрэглээний өсөлт 2026 онд тогтвортой хадгалагдсанаар худалдаа, үйлчилгээний салбарын үйл ажиллагаа тэлэн нийт өсөлтөд эерэг хувь нэмэр оруулахаар байна.

Инфляц 2026 онд дунджаар 7 хувь байхаар төсөөлж байна. Тодруулбал, 2026 онд цахилгааны тариф болон автобусны билетийн үнийн өсөлтийн суурь үеийн нөлөө арилж, эрэлтийн шинжтэй инфляцын дарамт буурснаар инфляц төв банкны зорилтот 6 ± 2 интервалд орж тогтворжихоор байна. Мөн “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний нөлөөгөөр дотоодын хүнсний нийлүүлэлт нэмэгдэж, үнийн өсөлт саарах хүлээлттэй байна. Түүнчлэн, импортын гол боомт болох Замын-Үүд-Эрээн боомтод хийгдэж буй нарийн царигийн хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтын үр дүнд тус боомтын нэвтрүүлэлтийн хүчин чадал нэмэгдэж, барааны эргэлт сайжрах, нийлүүлэлтийн саатлаас үүдэлтэй үнийн өсөлт үүсэх эрсдэлийг бууруулахаар байна.

Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2026 онд 3.2 орчим тэрбум ам.долларын ашигтай байх төлөвтэй байна. Эдийн засгийн идэвхжил хадгалагдаж, нийт импорт 13.4 тэрбум ам.доллар, нийт экспорт 2026 онд 16.6 тэрбум ам.долларт хүрэхээр тооцоолж байна. Төмөр замын суурь дэд бүтцийг сайжруулж, Гашуунсухайт, Шивээхүрэн болон Ханги боомтын тээвэр зохион байгуулалтыг сайжруулснаар 2026 онд нүүрсний экспорт 90 сая тонн, төмрийн хүдрийн экспорт 9.4 сая тоннд хүрч тус тус нэмэгдэхээр байна. Мөн Оюу толгойн зэсийн баяжмал дахь цэвэр зэсийн агуулга нэмэгдэж, экспортын орлого нэмэгдэх бол алтны олборлолтыг дэмжих арга хэмжээнүүдийн нөлөөгөөр алтны экспорт 2026 онд 20 тоннд хүрч нэмэгдэхээр байна.

ШИГТГЭЭ-2 ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ӨРХИЙН ОРЛОГОД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Эдийн засгийн өсөлт өрхийн орлогод үзүүлэх нөлөөлөхийг өнгөрсөн жилүүдийн түүхэн өгөгдөл дээр олон улсад өргөнөөр ашиглагддаг бүтцийн вектор авторегрессив загвар ашиглан тооцлоо. 2026 онд эдийн засаг 5.7 хувийн бодит өсөлттэй байхын зэрэгцээ Засгийн газар Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэвэр, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэврийн хэмжээг 6.0 хувиар нэмэгдүүлснээр өрхийн бодит орлого **7 орчим хувиар өсөхөөр** байна⁴. Өрхийн бодит орлогын өсөлтийг нөлөөллийн сувгуудаар задалж үзвэл,



орлогыг 9 орчим хувиар нэмэгдүүлж, энэ нь өрхийн бодит орлогын өсөлтийн **4.5 нэгж хувийг** тайлбарлаж байна.

- 1. Хөдөлмөр эрхлэлт болон цалингийн орлогоор дамжих нөлөөлөл:** Эдийн засгийн идэвхжил нэмэгдэхийн хэрээр бизнесийн салбаруудын ашигт ажиллагаа нэмэгдэн, хөдөлмөрийн эрэлт нэмэгддэг. Ингэснээр хөдөлмөр эрхлэх хүмүүсийн тоо нэмэгдэж, цалин хөлсөөр дамжин өрхийн орлого өсдөг. Өрхийн орлогын дунджаар 50 орчим хувийг цалингийн орлого бүрдүүлдэг ба эдийн засаг ирэх онд 5.7 хувиар өссөнөөр бодит цалингийн орлогыг 9 орчим хувиар нэмэгдүүлж, энэ нь өрхийн бодит орлогын өсөлтийн **4.5 нэгж хувийг** тайлбарлаж байна.
- 2. Бизнес, хөрөнгө оруулалт болон өрхийн үйлдвэрлэлээр дамжих нөлөөлөл:** Өрхийн орлогын 30 орчим хувийг бизнесийн орлого, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын өгөөж, үл хөдлөх хөрөнгийн түрээс зэрэг эх үүсвэрүүд эзэлдэг. Эдийн засгийн өсөлт нь бизнесийн идэвхжил, хэрэглээ болон хөрөнгө оруулалтын өсөлтөөр дамжуулан эдгээр орлогын өсөлтөд эерэг нөлөө үзүүлдэг. Тодруулбал, эдийн засаг 5.7 хувь өссөнөөр өрхийн нийт орлогыг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн өсөлтөөр дамжуулан **0.9 нэгж хувиар**, хөдөө аж ахуйн бус орлогоор дамжуулан **0.4 нэгж хувиар**, бусад мөнгөн болон мөнгөн бус орлогоор дамжин **0.9 нэгж хувиар** тус тус нэмэгдүүлэхээр байна.
- 3. Тэтгэвэр, тэтгэмжийн орлого:** Манай улс орлогын дахин хуваарилалтын түвшингээр дундаж орлоготой орнуудаас дээгүүр жагсаж, төсвөөс олгож буй мөнгөн болон мөнгөн бус шилжүүлгүүд нь ядуурлыг бууруулахад үр дүнтэй байдаг (Дэлхийн Банк, 2025⁵). Эдгээр төсвийн шилжүүлэг нь өрхийн орлогын дунджаар 20 орчим хувийг бүрдүүлдэг. Эдийн засгийн тогтвортой өсөлт нь татварын орлогыг нэмэгдүүлж, Засгийн газраас хэрэгжүүлэх тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамжийн зардал болон дэд бүтэц, хүний хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх санхүүгийн бололцоог бүрдүүлдэг. 2026 оны төсвийн төсөлд Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэвэр, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэврийн хэмжээг 6.0 хувиар нэмэгдүүлэхээр тусгасны дагуу тэтгэвэр, тэтгэмжийн бодит орлого тогтвортой хадгалагдахаар байна.

⁴Дунджаар эдийн засгийн 1 хувийн бодит өсөлт нь өрхийн бодит орлогыг 1.2 хувиар өсгөдөг гэсэн Сангийн яамны дотоод тооцоололд үндэслэв.

⁵World Bank, (2025). *Building resilience: Fiscal policies for poverty reduction and equity in Mongolia*.

2.4. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн таамаглал

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад баримтлах макро эдийн засгийн төлөв байдлын таамаглалыг⁶ 2025 оны 3 дугаар сард боловсруулсан. Тус таамаглалд эдийн засгийн голлох үзүүлэлтийг доорх байдлаар тусгажээ.

Эдийн засгийн өсөлт

Эдийн засгийн бодит өсөлт 2026-2028 оны хооронд дунджаар 5.4-5.7 хувьд хүрэх төлөвтэй байна. Тус өсөлтийн гол хөдөлгүүр нь уул уурхайн салбар, тэр дундаа нүүрс, зэсийн экспорт юм. Гэвч нүүрсний зах зээлийн үнэ ханш болон БНХАУ-ын зах зээлийн тодорхойгүй байдал зэрэг хүчин зүйлс эдийн засгийн өсөлтийг тодорхойгүй нөхцөл байдалд оруулж байна.

Инфляц

Инфляцын түвшин 2026 оноос эхлэн аажмаар буурах хандлагатай ба 2026 онд 8.2 хувь, 2027 онд 7.2 хувь, 2028 онд 6.8 хувь болж буурна гэж үзэж байна. Гэсэн ч 2025 онд инфляц өндөр байх төлөвтэй бөгөөд эрчим хүчний үнэ нэмэгдэх, цалин хөлсний өсөлт, төсвийн зарлагын өсөлт зэрэг нь инфляцыг нэмэгдүүлэх гол эрсдэл болж байна.

Төсвийн орлого, зарлага

Төсвийн орлогын хэмжээ ДНБ-д эзлэх хувиар тогтвортой буюу 35.8 хувь орчимд байна гэж таамаглаж байгаа ч уул уурхайн орлого 2026 онд ДНБ-ий 16.7 хувийг эзэлж байсан бол 2028 он гэхэд 14.5 хувь болж буурах төлөвтэй байна. Харин төсвийн зарлагын хэмжээ өндөр хэвээр, ДНБ-д эзлэх хувь нь 36.8 хувиас 37.7 хувь хүртэл өсөх хандлагатай байна. Энэ нь төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх эрсдэлийг дагуулж байгаа тул төсвийн сахилга батыг баримтлан зарлагаа хянахыг зөвлөж байна.

Өрийн төлөв байдал

Засгийн газрын нийт өрийн түвшин 2026 онд ДНБ-ий 37.5 хувь, 2028 онд 36.3 хувь болж аажмаар буурахаар байна. Гэсэн хэдий ч өндөр өрийн түвшин төсөвт дарамт учруулах эрсдэлтэй тул анхааралтай хандах шаардлагатай.

Гадаад худалдаа, төлбөрийн тэнцлийн төлөв

Гадаад худалдаа, төлбөрийн тэнцлийн хувьд нүүрсний экспортын үнэ 2026-2028 онд 88-95 ам.долларын хооронд хэлбэлзэх төлөвтэй гэж таамагласан боловч бодит байдал дээр энэхүү үнэ ханш доогуур гарах эрсдэл өндөр байна. Түүнчлэн 2025 оноос эхлэн БНХАУ-ын зах зээлд нүүрсний эрэлт буурах, үнийн дарамт нэмэгдэх, ОХУ-ын нүүрсний экспорт нэмэгдэх зэрэг нь Монгол Улсын нүүрсний экспортод сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

⁶ <https://www.parliament.mn/nn/74278/>

III БҮЛЭГ: ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

3.1. Төсвийн орлого

Олон улсын худалдаа, эдийн засгийн нөхцөл байдал тодорхойгүй болсноос шалтгаалж улс орнуудын эдийн засгийн төлөв байдалд хүндрэл үүсэж байна. Үүнээс үүдэн БНХАУ-ын аж үйлдвэрлэлийн өсөлт саарч, манай экспортын гол нэр төрлийн ашигт малтмал болох нүүрсний үнэ огцом буурлаа. Тодруулбал, нүүрсний үнэ тонн тутамд эхний 7 сарын байдлаар 68.0 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40 орчим хувиар буурсан байна.

Нүүрсний үнийн уналттай холбоотойгоор экспортын орлого буурч, эдийн засгийн идэвхжил удааширсан нөхцөл байдал үүсэж байна. Үүнээс улбаалан нэгдсэн төсвийн нийт орлого 2025 оны эхний 7 сарын байдлаар 16,578.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1,071.2 тэрбум төгрөг буюу 6.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2. 2025 оны эхний 7 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл (тэрбум төгрөг)

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.07 ГҮЙЦ | 2025 ТОД | 2025.07 ГҮЙЦ | Өмнөх оны мөн үеэс зөрүү |
|------------------------------|-----------------|-----------------|-----------------|-----------------------------|
| Нийт орлого | 17,649.5 | 32,540.2 | 16,578.3 | -1,071.2 |
| Тогтворжуулалтын сан | 245.3 | 429.1 | 257.7 | 12.4 |
| Ирээдүйн өв сан | 569.1 | 1,394.1 | 592.3 | 23.2 |
| Хуримтлалын сан | 0.0 | 507.1 | 140.1 | 140.1 |
| Тэнцвэржүүлсэн орлого | 16,835.1 | 30,209.9 | 15,588.2 | -1,246.9 |
| Татварын орлого | 15,800.7 | 28,346.7 | 14,418.6 | -1,382.1 |
| Татварын бус орлого | 1,034.4 | 1,863.2 | 1,169.6 | 135.2 |

Ийнхүү төсвийн орлого буурахад нүүрсний үнийн бууралттай холбоотойгоор аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 3,114.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 26.7 хувиар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 1,833.0 тэрбум төгрөг болж, 39.4 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Иймд дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр 2025 оны төсөвт тодотгол хийж, нэгдсэн төсвийн орлогыг 32,540.2 тэрбум төгрөгт, тэнцвэржүүлсэн орлогыг 30,209.9 тэрбум төгрөгт тус тус хүрэхээр тооцоолсон. Энэ хүрээнд нүүрсний экспортыг эрчимжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, нүүрсний экспортын тоо хэмжээг өмнөх оны түвшнээс бууруулахгүй байх, 85.0 сая тоннд хүргэх зорилт тавин ажиллаж байна.

3.2. Төсвийн урсгал зардал

Төсвийн нийт урсгал зардал 2025 онд 23.9 их наяд төгрөгт хүрэхээр байгаа бөгөөд үүний 60.7 хувийг төрөөс иргэдэд олгодог тэтгэвэр, тэтгэмж, халамж, хүүхдийн мөнгө, болон хуульд заасны дагуу тарифаар гүйцэтгэлд үндэслэн санхүүждэг эрүүл мэнд, боловсролын салбарын цалин хөлс, 14.2 хувийг төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагаатай холбоотой зардал, 16.3 хувийг бусад салбарын цалин хөлс нэмэгдэл,

урамшууллын зардал, 5.3 хувийг гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөр 3.5 хувийг төрөөс иргэн, аж ахуй нэгжид олгох хөнгөлөлт татаас тус тус эзэлж байна.

Хүснэгт 3. 2025 оны эхний 7 сарын нэгдсэн төсвийн урсгал зарлагын гүйцэтгэл (тэрбум төгрөг)

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.7 ГҮЙЦ | 2025 ТОД | 2025.7 ГҮЙЦ | Өмнөх оны мөн үеэс зөрүү |
|---------------------------------|-----------------|-----------------|-----------------|--------------------------------|
| Нийт урсгал зарлага | 12,124.5 | 23,964.1 | 14,133.3 | 2,008.8 |
| Бараа, ажил үйлчилгээний зардал | 4,838.3 | 9,939.4 | 5,765.6 | 927.3 |
| <i>Үүнээс Цалин хөлс</i> | <i>2,941.9</i> | <i>6,354.4</i> | <i>3,741.6</i> | <i>799.7</i> |
| Хүү | 808.1 | 1,292.9 | 931.8 | 123.7 |
| Татаас | 439.9 | 862.0 | 515.3 | 75.4 |
| Урсгал шилжүүлэг | 6,038.2 | 11,869.7 | 6,920.6 | 882.4 |

Нэгдсэн төсвийн урсгал зарлага 2025 оны 7 сарын байдлаар 14,133.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 2,008.8 тэрбум төгрөгөөр буюу 16.6 хувиар өссөн байна. Үүнд, Монгол Улсын Засгийн газраас нийт төрийн албан хаагчдын цалинг 2025 оны 1 дугаар сарын 1-ээс дунджаар 6.0 хувиар, нэмэгдүүлсэн, мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тогтооход баримтлах итгэлцүүрийг 2025 онд шинэчилснээр тэтгэврийн зөрүүг бууруулж, тэтгэврийн зөрүүг бууруулсан сууриас тэтгэврийг 2025 оны 1 дүгээр сараас 6 хувь тус тус нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлжээ.

3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон гадаад зээл, тусламж

3.3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд өмнөх онуудад эхлүүлсэн төслүүдээ дуусгах, бүсчилсэн хөгжлийг дэмжих томоохон дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх бодлогыг баримталсан. Тухайлбал, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр 621 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 3,124.1 тэрбум төгрөг, концессын “Барих-шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулсан төслийн эргэн төлөлтөд 2 төсөл, арга хэмжээнд 107.1 тэрбум төгрөг тус тус батлагдсан бөгөөд үүнээс 29.4 хувь буюу 951.2 тэрбум төгрөгийг зам тээврийн салбарт, 6.1 хувь буюу 196.2 тэрбум төгрөгийг эрчим хүчний салбарт, 11.0 хувь буюу 354.1 тэрбум төгрөгийг инженерийн дэд бүтцийн чиглэлээр, 15.0 хувь буюу 472.7 тэрбум төгрөгийг боловсролын салбарт, үлдсэн санхүүжилтийг бусад салбарт хэрэгжүүлэхээр батлагдсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим заалтууд 2025 оноос бүрэн хэрэгжиж эхэллээ. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.1.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу 2025 оны 05 дугаар сарын 31-ний дотор худалдан авах ажиллагааг бүрэн дуусгах, гэрээ байгуулаагүй төслүүдийн санхүүжилтийг хэмнэлтэд тооцох, зарцуулахгүй байх зохицуулалтын хүрээнд “Төсвийн хэмнэлтэд тооцох тухай” тогтоолыг Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж баталсан. Уг тогтоолын хүрээнд нийт 535.9 тэрбум төгрөгийг төсвийн хэмнэлтэд тооцсон.

Түүнчлэн Улсын Их Хурлаас 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан бөгөөд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9,033.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 613 төсөл, арга хэмжээнд 3,022.1 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдсан бөгөөд 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 941.2 тэрбум төгрөгийг олгож гүйцэтгэл 31 хувьтай байна.

Хүснэгт 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл эхлэх он (сая төгрөг)

| АНГИЛАЛ | ТӨСЛИЙН ТОО | БАТЛАГДСАН | ГҮЙЦЭТГЭЛ | ҮЛДЭГДЭЛ | ХУВЬ |
|--------------------------|-------------|----------------|--------------|----------------|------------|
| ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ | 505 | 1,929.3 | 743.6 | 1,185.7 | 39% |
| ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ | 106 | 985.6 | 187.4 | 798.3 | 19% |
| КОНЦЕСС | 2 | 107.1 | 11.0 | 96.1 | 10% |
| Нийт дүн | 613 | 3,022.1 | 942.0 | 2,080.1 | 31% |

Өмнөх онуудад эхлүүлсэн 2025 онд үргэлжлэн хэрэгжиж буй төслүүдийн хувьд санхүүжилтийн гүйцэтгэл 39 хувь буюу 743.6 тэрбум төгрөг, шинээр хэрэгжиж байгаа төслүүдийн санхүүжилтийн гүйцэтгэл 19 хувь буюу 187.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол концессын эргэн төлөлтөд 10 хувь буюу 11.0 тэрбум төгрөгийг тус тус олгоод байна.

Хүснэгт 5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, салбараар (сая төгрөг)

| ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ | ТӨСЛИЙН ТОО | БАТЛАГДСАН | ГҮЙЦЭТГЭЛ | ХУВЬ | ҮЛДЭГДЭЛ |
|---|-------------|------------|-----------|------|-----------|
| МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ | 2 | 694.1 | 694.0 | 100% | 0.1 |
| МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА | 1 | 8,560.0 | 4,350.8 | 51% | 4,209.2 |
| МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД | 1 | 1,433.5 | - | 0% | 1,433.5 |
| МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД | 5 | 39,383.0 | 10,658.9 | 27% | 28,724.1 |
| МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД | 7 | 41,553.1 | 10,263.2 | 25% | 31,289.9 |
| МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА | 17 | 23,167.0 | 13,148.2 | 57% | 10,018.8 |
| ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД | 2 | 9,569.6 | 8,267.5 | 86% | 1,302.1 |
| САНГИЙН САЙД | 10 | 127,720.2 | 33,454.2 | 26% | 94,266.0 |
| ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД | 18 | 104,720.7 | 31,621.7 | 30% | 73,099.0 |
| АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД | 1 | 779.5 | 779.5 | 100% | 0.0 |
| БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД | 4 | 65,803.9 | 32,970.2 | 50% | 32,833.7 |
| БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД | 13 | 69,502.5 | 4,360.2 | 6% | 65,142.3 |
| БОЛОВСРОЛЫН САЙД | 184 | 446,352.9 | 189,659.8 | 42% | 256,693.1 |
| ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД | 24 | 48,728.1 | 27,366.5 | 56% | 21,361.6 |
| ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД | 95 | 918,076.2 | 245,606.9 | 27% | 672,469.3 |
| СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД | 48 | 125,564.5 | 60,089.7 | 48% | 65,474.8 |
| ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД | 56 | 334,772.4 | 93,809.3 | 28% | 240,963.1 |
| ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД | 17 | 56,284.2 | 14,746.6 | 26% | 41,537.6 |

| | | | | | |
|--|------------|--------------------|------------------|------------|--------------------|
| ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД | 5 | 23,362.8 | - | 0% | 23,362.8 |
| ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД | 42 | 229,421.9 | 55,055.4 | 24% | 174,366.5 |
| ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД | 38 | 145,907.2 | 52,015.2 | 36% | 93,892.0 |
| АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА | 2 | 2,285.1 | 1,629.2 | 71% | 655.9 |
| УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ | 3 | 4,089.7 | 1,544.5 | 38% | 2,545.2 |
| ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА | 7 | 52,748.6 | 14,149.2 | 27% | 38,599.4 |
| УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР | 5 | 29,838.3 | 22,600.0 | 76% | 7,238.3 |
| САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА | 1 | 243.4 | 48.7 | 20% | 194.7 |
| ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДАРГА | 1 | 300.0 | 300.0 | 100% | - |
| ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА | 1 | 2,271.6 | - | 0% | 2,271.6 |
| ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА | 1 | 1,804.2 | 1,797.2 | 100% | 7.0 |
| УЛСЫН ТӨСВИЙН ДҮН | 611 | 2,914,938.2 | 930,986.4 | 32% | 1,983,951.8 |
| КОНЦЕСС | 2 | 107,132.1 | 10,983.4 | 10% | 96,148.7 |
| НИЙТ | 613 | 3,022,070.3 | 941,969.8 | 31% | 2,080,100.5 |

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолоор **төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар** солих ажлыг “Эрдэнэт” ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн, хэрэгжүүлэхийг даалгасан.

Энэ хүрээнд нийт 160 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, 17 аймгийн 294 суманд байрлах 218 цэцэрлэг, 332 ерөнхий боловсролын сургууль, 245 дотуур байрыг орчин үеийн стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжид холбох бүтээн байгуулалтын ажлыг 4 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Тухайлбал, 1 дүгээр ээлжийн хүрээнд 14 аймгийн 50 сумын 164 байгууламж хамрагдаж, хэрэгжилт 85 хувь, 2 дугаар ээлжид 14 аймгийн 42 сумын нийт 134 байгууламж хамрагдаж, хэрэгжилт 100 хувь, 3 дугаар ээлжид 17 аймгийн 127 сумын нийт 329 байгууламж хамрагдаж, хэрэгжилт 68 хувь, 4 дүгээр ээлжид 17 аймгийн 75 сумын нийт 168 байгууламж хамрагдаж, хэрэгжилт 52 хувьтай үргэлжилж байна.

2025 оны 08 сарын 31-ний өдрийн байдлаар 157 цэцэрлэг, 232 сургууль, 187 дотуур байрын ариун цэврийн байгууламж ашиглалтад орж 104.4 тэрбум төгрөгийг санхүүжүүлснээр гүйцэтгэл 65 хувьтай байна.

Эхний хагас жилийн байдлаар нийгмийн салбарт 6060 суудал бүхий 13 сургууль, 720 ор бүхий 8 цэцэрлэг, 220 суудал бүхий 2 дотуур байр, 75 ор бүхий 5 эмнэлэг, 1600 суудал бүхий 7 соёлын төв, 4 спорт заал ашиглалтад орсон.

Харин дэд бүтцийн салбарын хувьд 166.6 км авто зам, 17 инженерийн байгууламж, цахилгаан, дулаан хангамжийн 6 төсөл, арга хэмжээ ашиглалтад орсон байна.

3.3.2. Гадаад зээл, тусламж

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад нийт 1,959.4 тэрбум

төгрөг батлагдсанаас 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар гүйцэтгэл 53.7 хувь буюу гадаад зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт 1,051.97 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 6. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт (тэрбум төгрөг)

| Ангилал | Төслийн тоо | 2025 оны батлагдсан төсөв | Ашиглалт /2025.09.01/ | Хувь | Үлдэгдэл |
|----------------|-------------|---------------------------|-----------------------|------------|--------------|
| Гадаад зээл | 99 | 1,542.4 | 916.5 | 59% | 625.9 |
| Гадаад тусламж | 32 | 417.0 | 135.5 | 32% | 281.5 |
| НИЙТ | 131 | 1,959.4 | 1,052.0 | 54% | 907.4 |

Засгийн газрын зүгээс 2025 онд нийт 20 хөгжлийн түнш орон болон олон улсын байгууллагатай хамтран, гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 131 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Үүнд:

Хүснэгт 7. Гадаад зээл, тусламжийн төсөл хөтөлбөр, хөгжлийн түншээр (тэрбум төгрөг)

| Д/д | Хөгжлийн түнш | Төслийн тоо | 2025 онд батлагдсан ашиглалт | 2025 оны батлагдсан ашиглалтад эзлэх хувь | Ашиглалт /2025.09.01/ |
|-----|--|-------------|------------------------------|---|-----------------------|
| 1 | Бүгд Найрамдах Хятад Ард Улс | 9 | 431.6 | 22% | 314.0 |
| 2 | Бүгд Найрамдах Энэтхэг Улс | 2 | 334.7 | 17% | 192.2 |
| 3 | Азийн хөгжлийн банк | 57 | 346.1 | 18% | 156.0 |
| 4 | Бүгд Найрамдах Солонгос Улс | 7 | 202.7 | 10% | 90.1 |
| 5 | Америкийн Нэгдсэн Улс | 2 | 200.6 | 10% | 89.3 |
| 6 | Дэлхийн банк | 17 | 130.3 | 7% | 69.1 |
| 7 | Европын сэргээн босголт хөгжлийн банк | 15 | 126.5 | 6% | 26.7 |
| 8 | Холбооны Бүгд Найрамдах Герман Улс | 4 | 46.1 | 2% | 7.9 |
| 9 | Бүгд Найрамдах Франц Улс | 3 | 44.0 | 2% | 55.6 |
| 10 | Бүгд Найрамдах Австри Улс | 2 | 29.2 | 1% | 23.3 |
| 11 | Бүгд Найрамдах Польш Улс | 2 | 21.0 | 1% | 6.9 |
| 12 | Япон Улс | 1 | 16.4 | 1% | 9.2 |
| 13 | Европын хөрөнгө оруулалтын банк | 2 | 14.1 | 1% | 7.8 |
| 14 | Боловсролын Дэлхийн түншлэл | 1 | 8.7 | 0% | 2.5 |
| 15 | Люксембургийн Их Гүнт Улс | 1 | 4.5 | 0% | - |
| 16 | Кувейт Улс | 2 | 2.8 | 0% | 1.3 |
| 17 | Азийн дэд бүтэц хөрөнгө оруулалтын банк | 1 | 0.02 | 0% | 0.02 |
| 18 | Оросын Холбооны Улс | 1 | 0.01 | 0% | - |
| 19 | Унгар Улс | 1 | 0.01 | 0% | - |
| 20 | Хөдөө, аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан | 1 | 0.01 | 0% | - |
| | НИЙТ | 131 | 1,959.4 | | 1,052.0 |

“Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөр нь нийгэм, эдийн засгийн ач холбогдол өндөртэй томоохон бүтээн байгуулалтад чиглэж 2025 онд авч ашиглах нийт зээл, тусламжийн 67 хувийг 4 том хөгжлийн түнш байгууллага, улс орнууд бүрдүүлж байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зээл, тусламж 22 хувьд хүрч, энэ хүрээнд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл, Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл хэрэгжиж байгаа бол 17 хувь нь болох Бүгд Найрамдах Энэтхэг Улсын зээлээр Газрын тосны үйлдвэр барих төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөдөг байна. Үүнээс

гадна, олон улсын хөгжлийн гол түнш байгууллагууд болох Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банкны санхүүжилт өмнөх жилүүдийн адил өндөр түвшинд хадгалагдаж байгаа бөгөөд тус тус 18 болон 7 хувийг эзэлж байна.”

Гадаад зээл, тусламжийн эх үүсвэр нь улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилтыг хангах болон эдийн засаг, нийгмийн хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэсээр ирсэн бөгөөд цаашид ч бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, урт хугацааны тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, дэд бүтцийн томоохон төслүүд хэрэгжиж байна.

Хүснэгт 8. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийн ашиглалт, төслөөр (тэрбум төгрөг)

| Ангилал | Төслийн нэр | Амлалтын дүн | Ашиглах үлдэгдэл | 2025 Батлагдсан | Үлдэгдэл |
|--|--|-----------------|------------------|-----------------|-----------------|
| 500.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй | Газрын тос боловсруулах үйлдвэр | 5,808.6 | 4,889.5 | 346.5 | 4,543.0 |
| | Эрдэнэбүрэн УЦС | 865.8 | 865.8 | 271.6 | 594.2 |
| | Солонго 1, 2 хороолол | 912.9 | 550.4 | 135.0 | 415.4 |
| | Төв цэвэрлэх байгууламж | 853.7 | 129.3 | 80.0 | 49.3 |
| | Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл - 3 | 513.1 | 501.5 | 49.7 | 451.8 |
| Бусад 92 төсөл | | 8,898.5 | 5,665.1 | 659.6 | 5,005.5 |
| НИЙТ | | 17,876.5 | 12,601.6 | 1,542.4 | 11,059.2 |

“Дээрх хүснэгтэд харуулснаар гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй 500.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 7 төсөл нь 2025 онд батлагдсан нийт гадаад зээлийн ашиглалтын 55 хувийг эзэлж байна.”

Хүснэгт 9. Засгийн газрын гадаад тусламжийн ашиглалт, төсөл, арга хэмжээгээр (тэрбум төгрөг)

| Ангилал | Төслийн нэр | Амлалтын дүн | Ашиглах үлдэгдэл | 2025 Батлагдсан | Үлдэгдэл |
|-------------------------------|---|----------------|------------------|-----------------|----------------|
| Нийт тусламжийн 38% - 1 төсөл | УБ хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл /МСС/ | 1,255.5 | 410.9 | 200.6 | 210.3 |
| Бусад 31 төсөл | | 2,040.9 | 1,697.0 | 216.4 | 1,480.6 |
| НИЙТ | | 3,296.4 | 2,107.9 | 417.0 | 1,690.9 |

“Гадаад тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн нийт амлалтын дүнгийн 38 хувийг АНУ-ын Мянганы Сорилтын Сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл дангаар эзэлж байна.”

3.4. Засгийн газрын өр

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2025 оны эхний хагас жилийн байдлаар нэрлэсэн дүнгээр 35.5 их наяд төгрөг, ДНБ-ний 39.5 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 10. Засгийн газрын өрийн бүтэц (тэрбум төгрөг)

| ӨРИЙН ХЭРЭГСЭЛ | 2025.06.30 | 2025 ХБГ | 2026 Төсөв |
|--------------------------|------------|----------|------------|
| Засгийн газрын дотоод өр | 562.8 | 610.2 | 1,040.6 |
| Дотоод үнэт цаас | 562.8 | 610.2 | 1,040.6 |

| | | | |
|---|-----------------|-----------------|-----------------|
| Засгийн газрын гадаад өр | 32,219.4 | 33,032.5 | 33,474.7 |
| Гадаад үнэт цаас | 9,053.9 | 9,340.7 | 9,022.9 |
| Гадаад зээл | 23,165.4 | 23,691.7 | 24,452.3 |
| Засгийн газрын бусад өр | 2,751.4 | 6,420.1 | 10,349.7 |
| Засгийн газрын өрийн баталгаа | 176.2 | 3,821.9 | 7,711.7 |
| Орон нутгийн өр | 2,575.2 | 2,598.2 | 2,638.1 |
| ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР | 35,533.6 | 40,062.7 | 44,865.5 |
| Засгийн газрын өр / ДНБ (Хуулийн хязгаар 60%) | 39.5% | 44.5% | 43.8% |

Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хэмжээ 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 44.5 хувь, 2026 оны төсөөллөөр 43.8 хувьтай тэнцэхээр байна. Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт 2026 онд нийт 3,748.8 тэрбум төгрөг төлөхөөс үндсэн төлбөрт 2,449.6 тэрбум төгрөгийг, хүүгийн төлбөрт 1,299.2 тэрбум төгрөгийг тус тус төлөхөөр байна.

Хүснэгт 11. Засгийн газрын өрийн үйлчилгээ 2024-2026 (тэрбум төгрөг)

| Засгийн газрын өрийн үйлчилгээ | 2024 Гүйц. | 2025 ХБГ | 2026 Төсөв |
|--------------------------------|----------------|----------------|----------------|
| Үндсэн төлбөр* | 1,548.9 | 1,576.9 | 2,449.6 |
| Гадаад бонд | 178.5 | - | 656.6 |
| Гадаад зээл | 1,232.9 | 1,476.9 | 1,647.0 |
| Дотоод бонд | 137.5 | 100.0 | 146.0 |
| Хүүгийн төлбөр | 1,165.9 | 1,292.9 | 1,299.2 |
| Гадаад бонд | 599.4 | 576.8 | 560.2 |
| Гадаад зээл | 559.1 | 681.4 | 671.8 |
| Дотоод бонд | 7.5 | 34.7 | 67.3 |
| НИЙТ | 2,719.5 | 2,869.8 | 3,748.8 |

*-Дахин санхүүжилт, орон нутгийн үнэт цаасны өрийн үйлчилгээний дүн ороогүй

Засгийн газрын гадаад зээл

Засгийн газрын зүгээс 1991 оноос 2025 оны 2 дугаар улирал хүртэл хугацаанд нийт 9,187.9 сая ам.доллартой тэнцэх хэмжээний гадаад зээлийг авч ашигласнаас 2025 оны 2 дугаар улирлын байдлаар нэрлэсэн дүнгээр зээлийн үлдэгдэл 6,469.5 сая ам.доллар буюу 23,165.4 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Хүснэгт 12. Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл, зээлдүүлэгчээр (тэрбум төгрөг)

| Зээлдэгчээр | 2024.12.31 | 2025.06.30 |
|---|-----------------|-----------------|
| Олон талт | 11,903.6 | 12,486.8 |
| Азийн хөгжлийн банк | 7,650.5 | 7,872.3 |
| Дэлхийн банк | 2,758.6 | 3,058.2 |
| Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк | 714.6 | 737.6 |
| Европын сэргээн босголт, хөгжлийн банк | 379.6 | 432.5 |
| Европын хөрөнгө оруулалтын банк | 137.1 | 192.8 |

| | | |
|---|-----------------|-----------------|
| Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сан | 86.7 | 93.1 |
| Нордикийн хөгжлийн сан | 57.4 | 63.3 |
| Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сан | 37.8 | 36.8 |
| Олон улсын валютын сан | 81.3 | 0.2 |
| Хоёр талт | 9,739.1 | 10,678.5 |
| Бүгд Найрамдах Хятад Ард улс | 3,660.2 | 3,722.3 |
| Япон улс | 2,878.6 | 3,196.5 |
| Бүгд Найрамдах Солонгос улс | 1,143.1 | 1,338.6 |
| Бүгд Найрамдах Энэтхэг улс | 934.3 | 1,071.3 |
| Бүгд Найрамдах Австри улс | 358.0 | 424.8 |
| Бүгд Найрамдах Франц улс | 339.0 | 433.3 |
| Холбооны Бүгд Найрамдах Герман улс | 282.0 | 324.3 |
| Бүгд Найрамдах Польш улс | 116.9 | 136.3 |
| Бельгийн Вант улс | 24.7 | 29.1 |
| Испанийн Вант улс | 2.3 | 2.0 |
| Нийт | 21,641.6 | 23,165.4 |

Зураг 15. Гадаад зээлийн үлдэгдэл, валютаар 2025.06.30
(тэрбум төгрөг)



Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдлийг зээлдүүлэгчээр ангилбал олон талт зээлдүүлэгчийн зээлийн үлдэгдэл 2025 оны эхний хагас жилийн байдлаар 12,486.8 тэрбум төгрөг, үүнээс Азийн хөгжлийн банк 63.0 хувийг, Дэлхийн банк 24.5 хувийг тус тус эзэлж байгаа бол хоёр талт зээлдүүлэгч улсаас авсан зээлийн үлдэгдэл 10,678.4 тэрбум төгрөг, үүнээс БНХАУ 34.9 хувийг, Япон улс 29.9 хувийг эзэлж байна.

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдлийг валютаар задалбал ам.доллар 53.7 хувийг, зээлжих тусгай эрх 20.9 хувийг, иен 13.7 хувийг, евро 6.8 хувийг, вон 4.8 хувийг, Арабын дирхам, Кувейт динар үлдсэн 0.1 хувийг эзэлж байна.

Олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авч буй гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрөөс эдийн засгийн үр ашигтай төсөл хөтөлбөрийн эх үүсвэрийг улсын төсөвт эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгодог. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтөөр 2026 оны төсвийн жилд нийт 564.3 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөөд байна.

Засгийн газрын гадаад үнэт цаас

Засгийн газраас олон улсын зах зээлд арилжаалсан гадаад үнэт цаасны нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2025 оны эхний хагас жилийн байдлаар 2,528.5 сая ам.доллар буюу 9,053.9 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Хүснэгт 13. Гадаад үнэт цаас, 2025.06.30 (тэрбум төгрөг)

| № | Гадаад үнэт цаас | Хүү | Эргэн төлөгдөх огноо | Хугацаа | Нэрлэсэн үлдэгдэл | |
|-------------|------------------|--------|----------------------|---------|-------------------|----------------|
| | | | | | сая \$ | тб ₮ |
| 1 | Номад | 5.125% | 2026.04.07 | 5.5 жил | 176.3 | 631.4 |
| 2 | Сенчири-1 27' | 3.500% | 2027.07.07 | 6 жил | 420.1 | 1,504.2 |
| 3 | Сенчири-2 | 8.650% | 2028.01.19 | 5 жил | 558.0 | 1,998.0 |
| 4 | Сенчири-3 | 7.785% | 2029.06.05 | 5.5 жил | 351.9 | 1,260.1 |
| 5 | Сенчири-4 | 6.625% | 2030.02.25 | 5 жил | 511.5 | 1,831.5 |
| 6 | Сенчири-1 31' | 4.450% | 2031.07.07 | 10 жил | 510.7 | 1,828.6 |
| НИЙТ | | | | | 2,528.5 | 9,053.9 |

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 он болон 2026-2028 оны стратегийн баримт бичигт шинээр гадаад үнэт цаас гаргасан тохиолдолд зөвхөн дахин санхүүжилт буюу өрийн зохицуулалтын хүрээнд гаргах бөгөөд төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх, төсвийн алдагдал санхүүжүүлэх зорилгоор гадаад үнэт цаас гаргахгүй байхаар заасан.

Засгийн газраас 2021 онд авч хэрэгжүүлсэн Сенчири-1 төслийн хүрээнд Монгол Улс түүхэндээ хамгийн бага хүүтэйгээр өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бол 2023 оны 1 дүгээр сард авч хэрэгжүүлсэн Сенчири-2 төслийн хүрээнд Ковид-19 цар тахлын дараах олон улсын санхүүгийн зах зээлийн хямралын үед хөгжиж буй орнуудаас өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн анхдагч орнуудын нэг болсон.

Мөн Сенчири-3 төслийн хүрээнд хугацаа нь тулаад байсан Хуралдай бондын үлдэгдэл төлбөрийг дахин санхүүжилт хийж өрийн зохицуулалтын арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлсэн. Уг арга хэмжээний дагуу 350.0 сая ам.долларын хэмжээтэй, 7.875 хувийн хүүтэй, 5.5 жилийн хугацаатай бондыг 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр олон улсын санхүүгийн зах зээл дээр арилжаалж, 2024 оны 3 дугаар сард эргэн төлөгдөх хуваарьтай Хуралдай бондын үлдэгдэл 339.5 сая ам.долларыг дахин санхүүжүүлж, үлдсэн хэсгийг төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс төлж барагдуулсан.

Түүнчлэн, Сенчири-4 төслийг олон улсын зах зээлийн тохиромжтой үед буюу АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн дараах тодорхойгүй нөхцөл байдал үүсэхээс өмнө 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр авч хэрэгжүүлж, 2026 онд төлөгдөх хуваарьтай Номад бонд болон 2028 онд төлөгдөх хуваарьтай Сенчири-2 бондуудаас нийт 500 сая ам.долларын төлбөрийг дахин санхүүжүүлсэн.

Сенчири-4 бондын хувьд Монгол Улсын Засгийн газрын эрсдэлийн түвшин түүхэндээ хамгийн бага буюу 2.3 хувьтай гарсан нь Засгийн газрын өмнө гарган

арилжаалж байсан гадаад бондуудын эрсдэлийн дундаж түвшин болох 5.5 хувиас 3.2 нэгж хувиар бага үзүүлэлт юм.

Дээрх Сенчири-1, 2, 3, 4 өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2022-2028 онд төлөгдөх хуваарьтай байсан Чингис, Гэрэгэ, Хуралдай, Номад, Сенчири-2 бондуудын нийт 2.9 тэрбум ам.долларын төлбөрийг шийдвэрлэсэн бөгөөд үүнээс 414.0 сая ам.долларын төлбөрийг төрийн сангийн мөнгөн хөрөнгөөс төлж барагдуулсан. Үүний үр дүнд 2027 он хүртэл томоохон гадаад үнэт цаасны эргэн төлөлтүүдийг гадаад валютын албан нөөц, төлбөрийн тэнцэл, улсын төсөвт дарамт үүсгэхгүйгээр шийдвэрлээд байна.


Засгийн газрын дотоод үнэт цаас

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2025 оны эхний хагас жилийн байдлаар 562.8 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүнээс 97.1 тэрбум төгрөг нь Сайн хувьцаа хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор 2016 онд арилжаалсан үнэт цаас, 60.3 тэрбум төгрөгийн үнэт цаас нь зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор 2025 онд нээлттэй арилжаалсан үнэт цаас, 405.4 тэрбум төгрөгийн үнэт цаас нь улирлын чанартай мөнгөн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор 2024 оноос 2025 оны хооронд арилжаалсан үнэт цаас байна.

Улсын Их Хурлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 26 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг”-ийн 4 дүгээр зорилтод “Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна” гэж заасан. Мөн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг дагаж батлагдсан Улсын Их Хурлын 2024 оны 51 дүгээр тогтоолд Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.2, 12.1.3 дэх зориулалтаар 2025 онд арилжаалах дотоод үнэт цаасны хэмжээг 300.0 тэрбум төгрөг байхаар баталсан.

Үүний дагуу Засгийн газар 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн Монголын хөрөнгийн биржийн Засгийн газрын дотоод үнэт цаас (ЗГДҮЦ)-ны арилжааны цахим систем (bonds.mse.mn)-ээр дамжуулан ЗГДҮЦ-ны нээлттэй арилжааг эхлүүлээд байна. Нээлттэй арилжаагаар 2025 оны 8 дугаар сарын байдлаар нийт 87 тэрбум төгрөгийн үнэт цаасыг арилжаалаад байгаа бөгөөд 1 жил буюу түүнээс доош богино хугацаатай үнэт цаасны хүү дунджаар 9.3 хувь, 2-5 жилийн дунд хугацаатай үнэт цаасны хүү дунджаар 10.5 хувь буюу бодлогын хүүнээс 1.5-2.7 хувиар доогуур арилжаалагдсан.

Зураг 16. Засгийн газрын дотоод үнэт цаасны өгөөжийн муруй



ЗГДҮЦ-ны нээлттэй арилжааг эхлүүлснээр дотоодын зах зээлд төгрөгийн эрсдэлгүй өгөөжийн муруйг тогтоон, аж ахуйн нэгжүүдийн дотоодын зах зээлээс төвлөрүүлэх эх үүсвэрийн үнэлгээ бодитоор буюу харьцангуй бага хэмжээнд хүү тогтох, хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын бааз суурийг нэмэгдүүлэх ач холбогдолтой байна.

Орон нутгийн өр

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8.а-д зааснаар өрийн хэрэгслээр үүсгэж, аймаг, нийслэлээс бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүрэг нь Засгийн газрын өрд тооцогддог. Нийслэлийн үнэт цаасны үлдэгдэл 2025 оны эхний хагас жилийн байдлаар 2,575.2 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бөгөөд энэ нь дараах зээллэгүүдээс бүрдэж байна. Үүнд:

- 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдөр арилжаалсан 500.0 тэрбум төгрөгийн үнэт цаас, 12-14 хувийн хүүтэй, 1-3 жилийн хугацаатай;
- 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр арилжаалсан 298.0 тэрбум төгрөгийн үнэт цаас, 13.8 (ам.долларын 8.3 хувь) хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай;
- 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр олон улсын зах зээлд Засгийн газрын өрийн баталгаатайгаар арилжаалсан 500.0 сая ам.долларын үнэт цаас, 7.75 хувийн хүүтэй, 2.75 жилийн хугацаатай.

Нийслэлийн үнэт цаасны өрийн үйлчилгээний хувьд 2026 онд үндсэн төлбөрт 159.7 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 246.8 тэрбум төгрөг төлөгдөх хуваарьтай байгаа бөгөөд Өрийн удирдлагын тухай хуулийн 19.12 дахь хэсэгт заасны дагуу өрийн үйлчилгээний төлбөрийг тухайн орон нутгийн төсвөөс гүйцэтгэнэ.

Түүнчлэн, Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газраас Даланзадгадад 50 МВт-ын дулааны цахилгаан станц барих төслийг санхүүжүүлэх зорилгоор 2026-2028 онд дотоодын зах зээлд 500.0 тэрбум төгрөг хүртэлх үнэт цаасыг үе шаттайгаар арилжаалах хүсэлт ирүүлснийг Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газраас 2026 онд

150.0 тэрбум төгрөгийн үнэт цаас гаргахаар төлөвлөж Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд тусгаад байна.

Даланзадгадад 50 МВт-ын дулааны цахилгаан станц барих төсөл нь Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан эдийн засгийн өндөр ач холбогдолтой төсөл бөгөөд төслийн бүтээн байгуулалтын үе шат 2026 онд эхэлж, 2028 онд бүрэн ашиглалтад орно. Төслийн нийт хөрөнгө оруулалт 130.0 сая ам.доллар бөгөөд аймгийн үнэт цаасаар 100 хувь санхүүжүүлнэ.

Засгийн газрын өрийн баталгаа

Засгийн газрын өрийн баталгааны нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 376.5 сая юань буюу 176.2 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бөгөөд энэ нь Чойбалсан ДЦС-ыг өргөтгөх төсөлд зориулан Монгол Улсын Хөгжлийн банканд гаргасан Засгийн газрын өрийн баталгаанд хамаарах зээлийн үлдэгдэл юм.

Тодруулбал, Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 90 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 133 дугаар тогтоолын дагуу БНХАУ-ын Хөгжлийн банкны 420 сая юанийн зээлийн эх үүсвэрээр хэрэгжиж буй “Чойбалсан ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төсөл”-ийн санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банканд 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Засгийн газрын өрийн баталгааг гаргасан бөгөөд тус дулааны цахилгаан станцын өргөтгөл нь 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр ашиглалтад орсон. Уг зээлийн эргэн төлөлт 2031 онд төлөгдөж дуусах хуваарьтай, үүнээс 2026 онд 28.4 тэрбум төгрөгийг төлөхөөр байна.

Түүнчлэн, Улсын Их Хурлаас Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын авч ашиглах зээллэгт 2025 онд Засгийн газрын өрийн баталгаа гаргахыг зөвшөөрсөн. Тодруулбал, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах зорилтын хүрээнд “Нэгдүгээр тойрог зам” төслийн эх үүсвэрийг татан төвлөрүүлэх зорилгоор авах зээллэгийн 2025 онд ашиглах 260.3 сая ам.долларын үндсэн болон хүүгийн төлбөрийн 85 хувь хүртэлх хэмжээнд “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-т 2025 оны төсвийн жилд багтаан Засгийн газрын өрийн баталгаа гаргахыг зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 86 дугаар тогтоол гарсан. Үүний дагуу Нийслэлийн Засаг даргын тамгын газраас зээлдүүлэгч байгууллагыг тодорхойлон санхүүжилтийн хэлэлцээрийг хийж, гэрээ байгуулахаар тогтсон тохиолдолд Засгийн газрын өрийн баталгаа гаргах асуудлыг эцэслэн шийдвэрлэхээр байна.

IV БҮЛЭГ: МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ

4.1. Төсвийн орлого

4.1.1. Төсвийн орлогын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн орлогын төсөөллийг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль болон ирэх оны макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгод түвшинд үндэслэн боловсрууллаа. Ирэх 2026 оны төсвийн орлогын төсөөллийг боловсруулахад доор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө. Үүнд:

- Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, тус сангийн хөрөнгийг арвижуулна. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос Төсвийн тогтворжуулалтын сан болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувь буюу 2,186.9 тэрбум төгрөгийг Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагуу санд хуримтлуулна. Үндэсний баялгийн сангийн хөрөнгийг Засгийн газраас баталсан хөрөнгийн удирдлагын бодлогын хүрээнд оновчтой удирдаж, сангийн хөрөнгийн орлого, өгөөжийг нэмэгдүүлнэ.
- Экспортын орлогыг нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдол өгч ажиллан, нүүрсний экспортын хэмжээг 90 саяд хүргэнэ. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын хэмжээг өмнөх онуудын түвшнээс бууруулахгүй байх, нэмэгдүүлэх үйл ажиллагааг бүх талаар дэмжинэ. Энэ хүрээнд гол худалдааны боомтуудын дэд бүтцийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлж, хилийн нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, экспортын тээврийг оновчтой зохион байгуулах, тасралтгүй байдлыг хангах, төмөр замын тээврийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Иргэдийн хэрэглээндээ төлдөг татварын ачааллыг багасгах, бодит орлогыг хамгаалах, орлогын тэгш бус байдлыг бууруулах, татварын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор иргэн бүрийн сарын 1 сая төгрөг хүртэлх худалдан авалтад төлсөн НӨАТ-ын буцаан олголтыг нэмэгдүүлэн 50 хувьд хүргэнэ.
- Төлбөрийн баримтыг бүрэн цахимжуулах ажлыг эхлүүлж, холбогдох системийн хөгжүүлэлтийг хийнэ. Иргэдийн банкны картаар нь дамжуулж худалдан авалт хийх бүрд нь автоматаар төлбөрийн баримт бүртгэгдэх боломжтой болно. Түүнчлэн зах, худалдааны төвүүд, цахим худалдаа эрхлэгчдийн төлбөрийн баримт олголтыг идэвхжүүлэх, хялбаршуулах, бүртгэлийг сайжруулах замаар НӨАТ-ын хамрагдалтын түвшнийг нэмэгдүүлж, татварын суурийг өргөжүүлнэ.
- Инфляцыг тогтворжуулах, үнийн өсөлтөөс сэргийлэх зорилгоор газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн болон онцгой албан татварыг “0” хувиар тогтоосон арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

- Гааль, татварын бүртгэл, мэдээллийн системийг боловсронгуй болгох үйл ажиллагааг үргэлжлүүлэн хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан системийг хөгжүүлнэ. Ингэснээр гааль, татварын хяналт, шалгалтын цар хүрээг оновчтой тодорхойлох, давхардлыг арилгах, гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацааг багасгах, татвар төлөгчдөд учруулах чирэгдэл, хүнд суртлыг бууруулахад дэвшил гарч, татвар ногдуулах, хураах, хяналт шалгалт хийх үйл ажиллагаанд зарцуулах цаг, зардал буурна.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн нийт орлогыг 34,923.8 тэрбум төгрөгт хүрнэ гэж тооцлоо. Энэ нь 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулахад 2,383.6 тэрбум төгрөг буюу 7.3 хувиар өсөхөөр байна. Ирэх онд Төсвийн тогтворжуулалтын санд 367.7 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 2,427.2 тэрбум төгрөг, Хуримтлалын санд 528.9 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлнэ.

Хүснэгт 14. 2026 оны нэгдсэн төсвийн нийт орлого (тэрбум төгрөг)

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024 ГҮЙЦ | 2025 ТОД | 2026 ТӨС | ЗӨРҮҮ |
|--|-----------------|-----------------|-----------------|----------------|
| Нийт орлого ба тусламжийн дүн | 31,456.6 | 32,540.2 | 34,923.8 | 2,383.6 |
| Тогтворжуулалтын сан | 443.9 | 429.1 | 367.7 | -61.5 |
| Ирээдүйн өв сан | 841.4 | 1,394.1 | 2,427.2 | 1,033.1 |
| Хуримтлалын сан | 500.6 | 507.1 | 528.9 | 21.8 |
| Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн | 29,670.8 | 30,209.9 | 31,600.0 | 1,390.1 |

Төсвийн тогтворжуулалтын сангийн орлого

Ирэх онд зэс, нүүрсний экспортоос төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэгдсэн төсвийн нийт орлогын гурваас дээш хувийг бүрдүүлэхээр байгаа тул Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасны дагуу эдгээр бүтээгдэхүүнийг “гол нэр төрлийн эрдэс баялаг” гэж тодорхойлж, тэдгээрийн тэнцвэржүүлсэн үнийг тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасны дагуу тооцож, төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлогыг тооцов. Зэсийн тэнцвэржүүлсэн үнэ тонн тутамд 8,341.8 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ тонн тутамд 133.7 ам.доллар байхаар байна. Уг тооцооллын дагуу 2026 онд Төсвийн тогтворжуулалтын санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 292.1 тэрбум төгрөгийг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоос 75.6 тэрбум төгрөгийг, нийт 367.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр байна. Нүүрсний зах зээлийн үнэ тэнцвэржүүлсэн үнээс бага байхаар байгаа тул зөвхөн зэсийн орлогоос тогтворжуулалтын санд хөрөнгө төвлөрөхөөр байгаа болно.

Үндэсний баялгийн сангийн орлого

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос Төсвийн тогтворжуулалтын сан болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувь буюу 2,186.9 тэрбум төгрөгийг Ирээдүйн өв санд, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т заасны дагуу уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогоос 372.9 тэрбум төгрөгийг Хуримтлалын

санд тус тус төвлөрүүлнэ. Түүнчлэн, сангийн хөрөнгө оруулалтын орлогоос 240.3 тэрбум төгрөгийг Ирээдүйн өв санд, 156.0 тэрбум төгрөгийг Хуримтлалын санд хуримтлуулна. Ингэснээр нийт 2,956.1 тэрбум төгрөг Үндэсний баялгийн санд төвлөрөхөөр байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагын дагуу нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 2026 онд 31,600.0 тэрбум төгрөгт хүрэхээр тооцлоо.

Хүснэгт 15. 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн (тэрбум төгрөг)

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024 ГҮЙЦ | 2025 ТОД | 2026 ТӨС | ЗӨРҮҮ |
|--|-----------------|-----------------|-----------------|----------------|
| Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн | 29,670.8 | 30,209.9 | 31,600.0 | 1,390.1 |
| 1. Татварын орлого | 27,310.7 | 28,346.7 | 29,710.8 | 1,364.1 |
| 1.1 Орлогын албан татвар | 8,970.6 | 8,622.2 | 9,248.7 | 626.4 |
| 1.2 Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого | 4,731.8 | 6,001.4 | 6,707.0 | 705.5 |
| 1.3 Хөрөнгийн албан татвар | 459.5 | 620.7 | 626.9 | 6.2 |
| 1.4 Нэмэгдсэн өртгийн албан татвар | 5,866.8 | 6,646.8 | 7,033.2 | 386.4 |
| 1.5 Онцгой албан татвар | 1,107.4 | 1,254.5 | 1,331.5 | 77.0 |
| 1.6 Тусгай зориулалтын орлого | 26.4 | 31.5 | 33.0 | 1.5 |
| 1.7 Гадаад үйл ажиллагааны орлого | 1,792.4 | 2,114.0 | 2,255.0 | 141.0 |
| 1.8 Бусад татвар | 4,355.9 | 3,055.5 | 2,475.5 | -580.0 |
| 2. Татварын бус орлого | 2,360.1 | 1,863.2 | 1,889.2 | 26.0 |
| 2.1 Нийтлэг татварын бус орлого | 1,885.2 | 1,440.0 | 1,523.2 | 83.1 |
| 2.2 Хөрөнгийн орлого | 6.3 | 6.2 | 1.0 | -5.2 |
| 2.3 Тусламжийн орлого | 468.6 | 417.0 | 365.0 | -52.0 |

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого нь 2025 оны батлагдсан дүнтэй харьцуулахад 1,390.1 тэрбум төгрөгөөр өсөхөөр байна. Энэхүү өсөлтийн 626.4 тэрбум төгрөгийг орлогын албан татварын орлого, 386.4 тэрбум төгрөгийг нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын өсөлт тус тус эзэлж байна.

4.1.2. Татварын орлого

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын төсөөллийг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээ, аж ахуйн нэгжүүдийн тайлангийн мэдээлэл болон ашигт ажиллагааны түвшин зэрэгт үндэслэн тооцлоо. Ирэх онд эдийн засгийн өсөлт 5.7 хувь байж, нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 102,400.0 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна.

Зураг 17. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого, салбараар (тэрбум төгрөг)



Ирэх онд Засгийн газар гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэх, борлуулалтыг эрчимжүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийг тэлэх, уул уурхайн биржийн арилжааг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Улмаар, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 2026 онд 6,580.4 тэрбум төгрөгт хүрэхээр байгаа бөгөөд үүний 75.6 тэрбум төгрөгийг Төсвийн тогтворжуулалтын санд, үлдэх 6,504.8

тэрбум төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт тус тус төвлөрүүлэхээр тооцлоо.

Хувь хүний орлогын албан татварын орлого

Энэ онд Засгийн газар төсвийн хэмнэлтийн цогц арга хэмжээг хэрэгжүүлж байна. Төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгаж оновчтой болгох, төрийн үйлчилгээг цахимжуулах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийн орон тоог 9 хувиар бууруулан ажиллаж байна.


Энэхүү арга хэмжээний нөлөөллийг хувь хүний орлогын албан татварын орлогын тооцоололд тусгасан болно. Мөн 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг өмнөх оноос 20.0 хувиар нэмэгдүүлэн 792.0 мянган төгрөг байхаар тогтоосныг харгалзан үзсэн.

Ингэснээр 2026 онд төсөвт төвлөрүүлэх хувь хүний орлогын албан татварын орлого энэ оны батлагдсан дүнгээс 189.3 тэрбум төгрөгөөр буюу 6.8 хувиар өсөж, 2,975.8 тэрбум төгрөгт хүрэхээр тооцлоо.

Импортын татварын орлого

Манай улсын нийт импорт энэ оны эхний 7 сарын байдлаар 6,480.8 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 68.9 сая ам доллароор өссөн байна. Дээрх өсөлтөд суудлын автомашины импорт нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлжээ. Импортын энэхүү өсөлтөөс үүдэн гаалийн албан татварын орлого энэ оны эхний 7 сарын байдлаар 1,056.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 8.2 хувь, импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар 2,292.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар тус тус өссөн байна.

Зураг 18. Хувь хүний орлогын албан татварын орлого (тэрбум төгрөг)



Ирэх онд гаалийн байгууллагын үйлчилгээг түргэн, шуурхай, ил тод болгож, гаалийн хяналт бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацааг бууруулж, гадаад худалдааны урсгалыг нэмэгдүүлэх тал дээр онцгой анхаарч ажиллана. Гадаад худалдаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж өөрийн бараанд тохирох “барааны ангиллын код”-ыг хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан системээр тодорхойлуулснаар төсвийн орлого нэмэгдэх боломжтой гэж үзэж байна.

Гаалийн байгууллагын цахим шилжилтийг эрчимжүүлж, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлсний үр дүнд гаалийн албан татварын орлого 2,267.0 тэрбум төгрөг, импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 4,930.0 тэрбум төгрөгт тус тус хүрнэ гэж тооцлоо.

Онцгой албан татвар

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн нийт орлогын 3.8 хувь буюу 1,331.5 тэрбум төгрөгийг онцгой албан татвараас төвлөрүүлэхээр тооцлоо. Үүнээс суудлын автомашины онцгой албан татварын орлогоор 640.0 тэрбум төгрөг, дотоодын архи, тамхи, пивоны онцгой албан татварын орлогоор 420.0 тэрбум төгрөг, импортын архи, дарс, тамхи, пивоны онцгой албан татварын орлогоор 263.0 тэрбум төгрөгийг тус тус төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

Түүнчлэн автобензин, дизель түлшний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, инфляцыг тогтворжуулах, үнийн өсөлтөөс сэргийлэх зорилгоор газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн болон онцгой албан татварыг “0” хувиар тогтоосон арга хэмжээг ирэх онд үргэлжлүүлэхээр төлөвлөлөө.


Дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар

Ирэх 2026 онд дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлого энэ оны хүлээгдэж буй түвшнээс 15.5 хувиар өсөж, 3,188.2 тэрбум төгрөгт хүрэхээр тооцлоо.

Зураг 20. Дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын орлого (тэрбум төгрөг)



Зураг 19. Импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын орлого (тэрбум төгрөг)



бүтээгдэхүүний бүртгэлийг боловсронгуй болгох, сайжруулах ажлыг шат дараатайгаар авч хэрэгжүүлнэ.

Түүнчлэн иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалах, орлогын тэгш бус байдлыг бууруулах зорилгоор иргэдийн төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг нэмэгдүүлэхээр тооцлоо.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Засгийн газар 2026 онд уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд ач холбогдол өгч ажиллана. Уг ажлын хүрээнд хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, боомтуудын дэд бүтцийн ажлыг үргэлжлүүлэх, боомтын үйл ажиллагааг сайжруулах замаар хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлнэ.

Ингэснээр ирэх онд нүүрсний экспорт 90 сая тоннд, зэсийн баяжмалын экспорт 1.9 сая тоннд хүрэхээр тооцлоо. Түүнчлэн нүүрсний зах зээлийн үнийг энэ оны түвшинд буюу тонн тутамд 70 ам.доллаар, зэсийн зах зээлийн үнийг тонн тутамд 9,700 ам.доллар байхаар тус тус тооцсон болно. Нүүрс, зэсийн зах зээлийн үнийг тооцоход бодитой байх, учирч болох үнийн эрсдэлийг харгалзан үзсэн болно.

Зураг 21. Уул уурхайн салбар болон бусад салбараас төсөвт төвлөрүүлэх орлого (эзлэх хувиар)



Ирэх 2026 онд экспортлох ашигт малтмалын биет хэмжээ болон зах зээлийн үнэд үндэслэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоор 4,062.2 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

Үүнээс Төсвийн тогтворжуулалтын санд нийт 292.1 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд нийт 2,186.9 тэрбум төгрөг, үлдэх 1,583.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр байна.

Ийнхүү нүүрс, зэсийн баяжмалын экспортын нөлөөгөөр уул уурхайн салбараас 9,327.7 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцсон бөгөөд энэ нь нэгдсэн төсвийн нийт орлогын 27 орчим хувийг бүрдүүлэхээр байна.

4.1.3. Татварын бус орлого

Хувьцааны ногдол ашиг

Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглал, ил тод байдлыг сайжруулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг ирэх жил үргэлжлүүлэн авч хэрэгжүүлнэ. Ингэснээр нийт 548.3 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлогыг төсөвт төвлөрүүлэх бөгөөд үүнээс 372.9 тэрбум төгрөгийг Хуримтлалын санд, 95.4 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт, 80.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлэхээр байна.

Навигацийн орлого

Өнгөрсөн 2024 оны гүйцэтгэл болон 2025 оны батлагдсан дүнд үндэслэн навигацийн орлогыг ирэх онд 80.0 тэрбум төгрөг байхаар тооцлоо. Ирэх 2026 онд Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэх дамжин өнгөрөх олон улсын нислэгийн тоо, зорчигчийн урсгал энэ оны түвшинд хадгалагдахаар байгаа тул навигацийн орлогын хэмжээг энэ оноос бууруулахгүй байх, хэвээр нь хадгалах зарчим баримтлан тооцлоо.

Газрын тосны орлого

Газрын тосны орлого энэ оны эхний 7 сарын байдлаар 138.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Ирэх онд экспортлох газрын тосны биет хэмжээ 3,770.0 мянган баррель, нэгж баррелийн үнэ 72.0 доллартой байхаар төсөөлөв. Энэ хүрээнд газрын тосны орлогоор 2026 онд нийт 232.0 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлнэ гэж тооцлоо.

4.1.4. Татварын зарлага

Татварын хууль тогтоомжийн дагуу татвар төлөгчдөд эдлүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлт энэ онд 1,650.9 тэрбум төгрөгт хүрч, нийт орлогын 5.2 хувьтай тэнцэхээр байна. 2026 онд 1,414.0 тэрбум төгрөгт буюу нийт орлогын 4.3 хувь, 2027 онд 1,506.3 тэрбум төгрөг буюу нийт орлогын 4.3 хувьд тус тус хүрэхээр байна. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээг хүснэгтлэн харуулбал:

Хүснэгт 16. Татварын зарлагын хэмжээ (тэрбум төгрөг)

| Үзүүлэлт | 2023 | 2024 | 2025 ХБГ | 2026 ТӨС | 2027 ТӨС |
|-------------------------------|---------|---------|-------------|-------------|-------------|
| Нийт орлогод эзлэх хувь | 4.3 | 4.3 | 5.2 | 4.3 | 4.3 |
| Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт | 1,053.4 | 1,587.2 | 1,650.9 | 1,414.0 | 1,506.3 |
| ААНОАТ | 424.6 | 946.5 | 1,017.5 | 742.8 | 845.4 |
| НӨАТ | 385.4 | 393.1 | 377.0 | 392.5 | 382.3 |
| Гааль | 38.6 | 38.4 | 31.6 | 39.4 | 41.3 |
| ХХОАТ | 204.8 | 209.1 | 224.7 | 239.3 | 237.3 |

4.2. Төсвийн урсгал зардал

4.2.1. Урсгал зардлын төлөвлөлтөд баримтлах бодлого, зарчим

Удирдах албан тушаалтны орон тоог бууруулж, төрийн албан хаагчдын нийт орон тооны тэлэлтийг хязгаарлана. 2025 оны төсвийн тодотголоор Засгийн газраас төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. 2026 онд орон тооны тэлэлтийг хязгаарлаж, 2025 оны түвшинд хадгална. Мөн төсвийн тодотголоор яам, агентлагийн 135 удирдах албан тушаалтны орон тоог бууруулсан ба 2026 оны төсвийн төсөлд эдгээр орон тоотой холбоотой зардлыг хэмнэхээр тооцлоо.

Төрийн хэмнэлтийн бодлогыг үргэлжлүүлнэ. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хангаж, төсвийн байгууллагын үр ашиггүй зардлыг 5.7 хувиар бууруулан, хэмнэгдсэн хөрөнгийг нийгмийн салбарт зарцуулахаар тооцлоо.

Экспортыг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн арга хэмжээний зардлыг нэмж хуваарилна. Энэ хүрээнд геологийн судалгаа, эрлийн ажлын зардал, хүн амын хүнсний хэрэглээний улаан буудайн нөөц бүрдүүлэх зардал, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал, гамшиг ослын үеийн бэлэн байдлыг хангах, алба хаагчдын орлогын баталгааг сайжруулахад шаардлагатай зардлыг 2026 оны төсвийн төсөлд тусган тооцлоо.

Төрийн албан хаагчдын тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж

Ирэх жил 7.0 мянга орчим төрийн албан хаагчийг тэтгэвэрт гарахаар тооцон, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардалд нийт 352.6 тэрбум төгрөг шаардлагатай байна. Энэ нь 2025 онтой харьцуулахад 111.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

Төсвийн орлогын нөхцөл байдалтай уялдуулан тэтгэмжийн зардлыг төсөвт бүрэн тусгах боломжгүй тул 50 орчим хувь буюу 178.1 тэрбум төгрөгөөр бууруулж 174.4 тэрбум төгрөгийг 2026 оны төсвийн төсөлд тусгалаа. Тэтгэмжийн үлдэх зардлыг 2027 оны төсвийн жилд шилжүүлж бүрэн олгохоор тооцсон болно.

4.2.2. Салбарын урсгал зардал

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН УРСГАЛ ЗАРДАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 158 дугаар тогтоолоор 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан салбарын 2026 оны урсгал зардлыг нийт 3,878.6 тэрбум төгрөгөөр төсөвлөснөөс сургуулийн өмнөх боловсролд 1,115.9 тэрбум төгрөг, ерөнхий боловсролд 2,314.1 тэрбум төгрөг, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад 213.3 тэрбум төгрөг, дээд боловсролд

142.2 тэрбум төгрөг тус тус төсөвлөлөө. Энэ хүрээнд боловсролын чанарт голлох нөлөө үзүүлдэг хүчин зүйлсэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. Тухайлбал, сургууль, цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийг оновчтой болгох, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, цахим боловсролыг хөгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй мэргэжилтний тоог нэмэгдүүлэх, багшийн ур чадвар, ажлын ачаалалд нийцүүлсэн цалин хөлсний бүтцийг бий болгох арга хэмжээг дараах чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд бүх хүүхдийг тэгш хамруулж, шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэх

Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, байгалийн ухааны лаборатори багаж, хэрэгслээр хангах, цэцэрлэг сургуулийн хүүхдийг илчлэг хоол хүнсээр хангах, багшийн хангалтыг нэмэгдүүлж мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зэрэг арга хэмжээнд нийт 373.0 тэрбум төгрөг төсөвлөлөө.

2. Цахим боловсрол

Цахим сургалтын системийг сургалтад ашиглах замаар хүүхэд бүрийг орон зай, цаг хугацаанаас үл хамааран хамгийн сайн багшаар хичээл заалгах боломж бүрдүүлэхийг зорьж байна. Энэ хүрээнд 2023 оноос эхлэн хэрэгжиж байгаа “Мэдлэ” цахим сургуулийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ба нийт 7.0 тэрбум төгрөг төсөвлөлөө. “Мэдлэ” цахим сургуульд 2025-2026 оны хичээлийн жилд ахлах ангид 432 (нийслэл-114, аймгийн төв-102, сум-207, баг-8, Солонгос улс дахь-1) сургуулийн 10 дугаар ангид 17,591, 11 дүгээр ангид 9,951, 12 дугаар ангид 8,959, нийт 36,501 суралцагчийг суралцуулахаар тооцсон ба хөтөлбөр хэрэгжсэнээр сургуулиудын алслагдсан байдлыг ойртуулах, багшийн дутагдлаас болж үүсэх үр дагаврыг бууруулах боломжтой.

3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн хүний нөөц бэлтгэх

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжлийн чиглэлээр сургалт зохион байгуулах, суралцагсдыг онолын мэдлэгээ практиктай хослуулан эзэмших боломжоор хангах зорилгоор хосмог сургалт зохион байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 213.3 тэрбум төгрөгийг төлөвлөлөө. Энэ хүрээнд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагсдыг ажиллангаа суралцах боломжоор хангана.

4. Багшийн ур чадвар, ажлын ачаалалд нийцүүлсэн цалин хөлсний бүтцийг бий болгох

Сүүлийн жилүүдэд нийслэл болон томоохон төв суурин газруудад хүн амын төвлөрөл нэмэгдсэнтэй холбоотойгоор боловсролын байгууллагуудад нэг ангид ногдох сурагчдын тоо өсөж, сургалтын орчны ачаалал нэмэгдэж байна. Тухайлбал, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудад нийт 22,868 анги бүлэг хичээллэж байгаагаас 9,065 бүлэг нь нийслэлд, 5,815 бүлэг нь аймгийн төвд, 7,789 бүлэг нь суманд, 199 бүлэг нь багийн түвшинд хичээллэж байна. Нийт анги, бүлгийн 35 хувь буюу 8,028 нь хэт ачаалалтай ба нэг ангид 35-аас дээш хүүхэдтэй байна.

Иймд нэг ангид суралцах хүүхдийн тоо хэтэрсэн буюу ачаалал ихтэй ажиллаж байгаа багшид хувьсах зардлаар дамжуулан нэмэгдэл хөлс олгох замаар багшийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, багшийн ур чадвар, ажлын ачаалалд нийцүүлсэн цалин хөлсний бүтцийг бий болгоход зориулж 100.0 тэрбум төгрөгийг төсвийн төсөлд нэмж тусгалаа.

Цаашид боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн шинэчлэлийг эрчимжүүлж, хувьсах зардлын тарифыг шинэчлэх хүрээнд цалин хөлсний бүтцийг боловсронгуй болгох, түүнчлэн боловсролын орчин нөхцөлийг сайжруулах, ялангуяа аюулгүй тэгш хүртээмжтэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ, сургууль, цэцэрлэг, дотуур байрны хоолны чанар, илчлэгийг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг цогц байдлаар шийдвэрлэхийг зорьж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УРСГАЛ ЗАРДАЛ

Эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд эрүүл мэндийн салбарт “үр ашгийг сайжруулах, ил тод, хариуцлагатай болгох”-д чиглэсэн санхүүгийн удирдлага, зохицуулалтын багц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

1. Эрүүл мэндийн бодлого, удирдлагын чиглэлээр

Эрүүл мэндийн даатгалын сангийн удирдлага, зохион байгуулалт, төрийн өмчийн эмнэлгүүдийн санхүүгийн сахилга бат сул байгаа зэргээс шалтгаалж үр ашиггүй зардал, өр төлбөр нэмэгдэж, улмаар эрүүл мэндийн даатгалын сангийн тогтвортой байдал алдагдахад хүргэж байна. Иймд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг урт хугацаанд, тогтвортой санхүүжүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор эрүүл мэндийн даатгалын засаглал, хариуцлагын тогтолцоог сайжруулах гурван жилийн (2026-2029) хөгжлийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

Чиг үүргийн шинжилгээ хийсний үндсэн дээр эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, үйл ажиллагааны стандартыг шинэчилж, цомхон, чадварлаг, оновчтой бүтцээр ажиллуулах төлөвлөгөө батлан хэрэгжүүлж эрүүл мэндийн байгууллагуудын зардлын үр ашгийг сайжруулна. Энэ хүрээнд гүйцэтгэлд суурилсан цалин урамшууллын тогтолцоо, гүйцэтгэлийн үнэлгээний ил тод байдлыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах нэр төрлийг нэмэгдүүлж, чанартай, үр нөлөө өндөртэй эмийг илүү хямд үнээр нийлүүлэх бодлогыг хэрэгжүүлж, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын зардлын үр ашгийг сайжруулна.

2. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр

Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх зорилгоор нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийг шинэчлэн байгуулах, эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах ажлыг эрчимжүүлнэ.

Оновчтой бодлого, төлөвлөлтгүйгээр үр дүн нь тодорхойгүй эрүүл мэндийн хөтөлбөр, арга хэмжээнүүдэд төсөв зарцуулж ирсэн байдлыг өөрчилнө. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах чиглэлд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөмж болгосон “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үр ашигтай арга хэмжээнүүд”-ийг баримтлан зөвхөн нотолгоо, судалгаатай үйл ажиллагаанд эрүүл мэндийг дэмжих сан болон бусад нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр, арга хэмжээнд төлөвлөсөн зардлыг зарцуулж, төсвийн үр ашиг, сахилга бат, ил тод байдлыг сайжруулна. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхэд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр 2026 оны төсвийн төсөлд нийт 89.4 тэрбум төгрөгийг тусгалаа.

3.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр

Монгол улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчин эмгэгийн нэр, төрлийг бууруулах хүрээнд эмчилгээний шинэ арга барил, технологийг нутагшуулж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлнэ.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний үр ашиг, үр дүнг нэмэгдүүлэх, тусламж, үйлчилгээний давхардлыг арилгах зорилгоор эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалтыг хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж шинэчилнэ. Энэ хүрээнд анхан шатны тусламж, үйлчилгээг иргэнд ойртуулах, амь нас аврах яаралтай тусламжийн тогтолцоог шинэчлэх, нийслэл рүү чиглэсэн эрэлт ба урсгалыг бууруулах зэрэг бодлогын өөрчлөлтийг хэрэгжүүлнэ.

Лаборатори, дүрс оношилгоо, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, угаалга, ариутгал, гал тогоо зэрэг дэмжих үйлчилгээг нэгтгэж, нөөцийг үр ашигтай удирдах чиглэлд тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Зарим дэмжих үйлчилгээг нь төр хувийн хэвшлийн түншлэлээр харилцан үр ашигтай зохион байгуулах нэгдсэн сүлжээнд оруулж, зардлыг бууруулна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлын үр ашгийг сайжруулах зорилгоор давхардсан тусламж, үйлчилгээг ижил эмнэлгүүдтэй гэрээлэх байдлыг шинэчилж, сонгон шалгаруулалтыг шатлал, чанарын үнэлгээ, байршил зэрэгт үндэслэн хийнэ.

Хэвтэн эмчлүүлэх шаардлагагүй, эмчилгээний үр дүн муутай зарим тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын багцаас хасаж, иргэн өөрөө төлбөрөө төлсний үндсэн дээр авдаг болгох, давхардсан тусламж, үйлчилгээнд дахин санхүүжилт олгохгүй байх зохицуулалтыг бий болгоно.

Эрүүл мэндийн даатгалын нэхэмжлэлийн хяналтын тогтолцоог цахим болон хиймэл оюун ухаанд суурилж, хөндлөнгийн шинжээч болон иргэдийн үнэлгээнд тулгуурлан үнэлдэг хэлбэрт шилжүүлж, хувь хүний нөлөөллөөс арилгах шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдуулан дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ба энэ хүрээнд 2026 оны нэгдсэн төсвийн төсөлд нийт 2,350.9 тэрбум төгрөг төлөвлөлөө.

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН УРСГАЛ ЗАРДАЛ

Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ:

Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэвэр, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэврийн хэмжээг 6.0 хувиар нэмэгдүүлэхээр тооцож нийт 378 тэрбум төгрөг нэмж хуваарилна.

Хүүхэд хамгаалал

Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн төсвийг Засгийн газрын 2024 оны 236 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, норматив”-ын дагуу 2025 оны хүүхэд хамгааллын статистик тоон мэдээнд тулгуурлан 20.1 тэрбум төгрөгөөр төлөвлөв. Хүүхэд хамгааллын төсвийн 11.6 хувийг эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх болон хамтарсан багийн урамшуулал олгоход, 39.1 хувийг хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд, 25.3 хувийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд, 23.9 хувийг хүүхдийн хөгжил оролцоог сайжруулах арга хэмжээнд зарцуулна.

Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих

Монгол улсад 0-18 насны 14.6 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагийн 2.7 мянга нь хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд тэд нийгмийн суурь үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй байна. Эдгээр хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд чиглэсэн арга хэмжээнд зориулж 2025 оноос эхлэн 6.9 тэрбум төгрөг хуваарилан санхүүжүүлж байгаа нь тохируулгат орчинд өөрт шаардлагатай боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг гэртээ ойрхон, эцэг эхэд санхүүгийн дарамтгүй авснаар хүүхдийн хөгжилд болон гэр бүлд томоохон дэмжлэг бүхий үр дүнтэй үйлчилгээ болсон байна. Тиймээс 2026 онд байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэх дэмжих төвүүдийг аймаг дүүргүүдэд нэмэгдүүлэх зорилгоор 9.3 тэрбум төгрөгийг төсвийн төсөлд тусгалаа.

БУСАД САЛБАРЫН УРСГАЛ ЗАРДАЛ

1.Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP17)

Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын Конвенцын 17 дугаар бага хурлыг 2026 онд Монгол Улсад зохион байгуулах болсонтой холбогдуулан хурлын бэлтгэл ажлыг хангах, улс орноо сурталчлан таниулах, мэдээлэл түгээх, дамжуулах, соёл урлагийн арга хэмжээ зохиох, олон улсын зочид төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах, тав тухтай орчныг бүрдүүлэх зэрэг арга хэмжээнд зориулж 39.5 тэрбум төгрөг төлөвлөв.

Энэхүү арга хэмжээний үеэр Монгол Улс “Бэлчээрийн шүхэр санаачилга”, “Ус ба газрын нэгдсэн менежментийг газрын доройтолтой тэмцэх шийдэл болгох нь”, “Газрын нэгдсэн менежментийг тогтвортой дэд бүтцийг хөгжүүлэхэд ашиглах” зэрэг санаачилга гарган хэлэлцүүлэх ба үүний үр дүнд “хөрөнгө оруулалт, санхүүгийн амлалт, хандив,

дэмжлэг”-ийг татаж, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хөгжилд урт хугацааны эерэг нөлөөлөл үзүүлэх боломжтой болох юм.

2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу аймаг, нийслэлийн байгалийн ургамал, ан амьтан, газар, ус, рашаан, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын эх үүсвэрээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах, хяналт тавих арга хэмжээнд зориулсан төсвийг 26.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн төсвийн суурь зарлагыг 61.3 тэрбум төгрөг байхаар төсөвлөсөн.

Энэхүү нэмэгдэж байгаа хөрөнгийг орон нутагт хөрсний доройтол, цөлжилт, ан агнуур, ховордсон амьтад, ойн үржүүлэг, усны нөөц, байгалийн дурсгалт газар, тусгай хамгаалалтын газрыг хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, судалгаа хийх, иргэн аж ахуйн нэгжийн оролцоог дэмжих, урамшуулах, хяналт тавих, нэгдсэн сан бүрдүүлэх зэрэгт зарцуулна.

Хүснэгт 17. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал (сая төгрөг)

| Д/д | Аймаг | 2025 Төсөв | 2026 Төсөл |
|-------------|-------------|-----------------|-----------------|
| 1 | Архангай | 165.5 | 346.5 |
| 2 | Баян-Өлгий | 346.0 | 719.7 |
| 3 | Баянхонгор | 271.7 | 547.3 |
| 4 | Булган | 5,247.7 | 9,974.9 |
| 5 | Говь-Алтай | 205.6 | 817.9 |
| 6 | Дорноговь | 664.8 | 1,178.5 |
| 7 | Дорнод | 1,076.0 | 1,829.6 |
| 8 | Дундговь | 295.7 | 839.8 |
| 9 | Завхан | 292.8 | 688.6 |
| 10 | Өвөрхангай | 393.7 | 636.8 |
| 11 | Өмнөговь | 6,856.5 | 11,790.9 |
| 12 | Сүхбаатар | 438.7 | 480.6 |
| 13 | Сэлэнгэ | 1,937.5 | 2,396.1 |
| 14 | Төв | 1,336.8 | 2,228.9 |
| 15 | Увс | 286.3 | 603.3 |
| 16 | Ховд | 405.9 | 715.9 |
| 17 | Хөвсгөл | 1,227.5 | 1,977.6 |
| 18 | Хэнтий | 514.3 | 1,450.6 |
| 19 | Дархан-уул | 250.3 | 543.5 |
| 20 | Улаанбаатар | 9,138.2 | 16,725.6 |
| 21 | Орхон | 3,014.4 | 4,513.0 |
| 22 | Говь сүмбэр | 167.1 | 262.1 |
| НИЙТ | | 34,532.9 | 61,267.8 |

3. Засгийн газрын болон Засаг даргын нөөц хөрөнгө

Сүүлийн жилүүдэд дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, бүс нутгийн хэт халалт, гандуу нөхцөл, зуд зэрэг байгалийн гамшгийн давтамж, нөлөөлөл нэмэгдэж байгаа нь мал аж ахуй, газар тариалангийн салбарт томоохон эрсдэл учруулж, орон нутгийн хүн амын амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна.

2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндрэх эрсдэлтэй байгаа бөгөөд болзошгүй бусад гамшиг осол зэргийг харгалзан Засгийн газрын нөөц сан, аймаг, сумдын Засаг даргын нөөц хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Иймд төсөвт урьдчилан тооцож, төлөвлөн тусгах боломжгүй, хойшлуулшгүй цаг үеийн шинжтэй арга хэмжээ, байгалийн гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах үйл ажиллагааг шат дараатай зохион байгуулах, өвөлжилтийн бэлтгэлийг хангахтай холбоотойгоор 2026 оны төсвийн төсөлд Засгийн газрын нөөц санг 2025 оны төсвөөс 11.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 159.9 тэрбум төгрөг байхаар, Засаг даргын нөөц хөрөнгийг 9.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 31.2 тэрбум төгрөгөөр байхаар тус тус тооцож төсөвлөлөө.

Хүснэгт 18. Засгийн газрын нөөц сангийн хөрөнгө (сая төгрөг)

| Д/д | Байгууллага | 2025 Төсөв | 2026 Төсөл |
|-----|-------------------------|------------|------------|
| 1 | Засгийн газрын нөөц сан | 148,225.1 | 159,883.7 |

Хүснэгт 19. Засаг даргын нөөц хөрөнгө (сая төгрөг)

| Д/д | Аймаг | 2025 Төсөв | 2026 Төсөл |
|-----|-------------|-----------------|-----------------|
| 1 | Архангай | 450.0 | 882.5 |
| 2 | Баян-Өлгий | 279.0 | 549.7 |
| 3 | Баянхонгор | 405.0 | 1,307.2 |
| 4 | Булган | 333.0 | 656.4 |
| 5 | Говь-Алтай | 369.0 | 727.3 |
| 6 | Дорноговь | 297.0 | 585.4 |
| 7 | Дорнод | 297.0 | 806.5 |
| 8 | Дундговь | 315.0 | 1,088.9 |
| 9 | Завхан | 477.0 | 1,299.8 |
| 10 | Өвөрхангай | 387.0 | 1,315.5 |
| 11 | Өмнөговь | 450.0 | 887.0 |
| 12 | Сүхбаатар | 279.0 | 1,105.6 |
| 13 | Сэлэнгэ | 351.0 | 690.6 |
| 14 | Төв | 531.0 | 1,046.5 |
| 15 | Увс | 387.0 | 762.8 |
| 16 | Ховд | 351.0 | 691.9 |
| 17 | Хөвсгөл | 459.0 | 904.7 |
| 18 | Хэнтий | 369.0 | 881.9 |
| 19 | Дархан-уул | 234.0 | 461.2 |
| 20 | Улаанбаатар | 13,828.4 | 13,560.0 |
| 21 | Орхон | 434.8 | 560.6 |
| 22 | Говь сүмбэр | 198.0 | 390.3 |
| | НИЙТ | 21,481.2 | 31,162.3 |

4.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.1-т Эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 40 хувиас доошгүй хувийг дараагийн жил төсөвт тусгаж, санхүүжүүлэхээр заасан. Энэ хүрээнд урьдчилан тооцоолсноор 2025 оны Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулийн хүрээнд төсөвт төвлөрөх торгуулийн орлогын 40 хувийг орон нутгийн суурь

зарлагад хянаж тусгасан. Ингэснээр 2025 онд тус зориулалтаар 15.8 тэрбум төгрөг батлагдсан бол 2026 онд 44.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 59.8 тэрбум төгрөгт хүргэхээр тооцлоо.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу орлогын 20-оос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-оос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан зарцуулна.

Судалгаа, шинжилгээ, шинжлэх ухаан, техник технологийн орчин үеийн ололтод үндэслэж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг үр өгөөжтэйгөөр зарцуулсны үр дүнд нийгмийн хэв журам сайжирч, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улмаар гэмт хэрэг, зөрчлийн тоо хэмжээ буурах, иргэдийн амар тайван амьдрах орчин бүрдэх ач холбогдолтой юм.

Хүснэгт 20. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал (сая төгрөг)

| Д/д | Аймаг | 2025 Төсөв | 2026 Төсөл |
|-------------|-------------|-----------------|-----------------|
| 1 | Архангай | 216.0 | 509.9 |
| 2 | Баян-Өлгий | 198.0 | 470.7 |
| 3 | Баянхонгор | 396.0 | 862.9 |
| 4 | Булган | 288.0 | 1,074.7 |
| 5 | Говь-Алтай | 198.0 | 538.8 |
| 6 | Дорноговь | 180.0 | 1,019.8 |
| 7 | Дорнод | 288.0 | 627.6 |
| 8 | Дундговь | 141.3 | 509.9 |
| 9 | Завхан | 198.0 | 608.0 |
| 10 | Өвөрхангай | 351.0 | 941.4 |
| 11 | Өмнөговь | 450.0 | 3,137.9 |
| 12 | Сүхбаатар | 147.6 | 392.2 |
| 13 | Сэлэнгэ | 630.0 | 1,490.5 |
| 14 | Төв | 396.0 | 1,765.1 |
| 15 | Увс | 99.0 | 392.2 |
| 16 | Ховд | 180.0 | 537.4 |
| 17 | Хөвсгөл | 116.2 | 549.1 |
| 18 | Хэнтий | 194.4 | 628.4 |
| 19 | Дархан-уул | 252.0 | 999.0 |
| 20 | Улаанбаатар | 10,400.0 | 41,442.9 |
| 21 | Орхон | 252.0 | 823.7 |
| 22 | Говь сүмбэр | 252.0 | 470.7 |
| НИЙТ | | 15,823.5 | 59,792.8 |

5.Геологийн судалгаа, эрлийн ажил

Геологийн салбарыг уул уурхайн салбараас түрүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангах, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтыг татах тааламжтай орчныг бүрдүүлэх, геологи, эрдэс баялгийн судалгааны ажлыг дэвшилтэт техник, технологиор гүйцэтгэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг

арвижуулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг 2025 онтой харьцуулахад 30 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцож төсвийн төсөлд тусгалаа.

Геологийн зураглал, эрэл-үнэлгээ, агаар-сансрын тандан судалгаа, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн болон бусад региональ судалгааны ажлын төсвийг нэмэгдүүлснээр ашигт малтмалын хэтийн төлөв бүхий эрдсийн хуримтлалтай талбайд хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож, дунд хэмжээний ашигт малтмалын ордыг нээн улсын төсөвт орлого төвлөрүүлэх, улмаар хөдөө аж ахуй, байгаль орчин, аялал жуулчлал, эрүүл мэнд, батлан хамгаалах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын салбарт ашиглагдах суурь мэдээллийн санг бүрдүүлэх зэрэг ач холбогдолтой юм.

6. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа

Шүүх байгуулах тухай /шинэчилсэн найруулга/ хууль 2024 оны 06 сарын 05-ны өдөр батлагдаж Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх, Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны дагнасан шүүхийг шинээр байгуулахаар заасантай холбогдуулан 2026 оны төсвийн төсөлд үйл ажиллагааг хагас жилээс эхлэн хэрэгжүүлэхээр тооцон 9.5 тэрбум төгрөгийн зардлыг тусгалаа.

Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүхүүд байгуулагдсанаар гэр бүлийн болон насанд хүрээгүй хүний нас, бие, сэтгэл зүйн онцлогт тохирсон шүүхийн тусгай процесс, орчин бүрдэж гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг буурахад нөлөөлж, шүүхийн ачаалал буурах ач холбогдолтой юм.

7. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага ФАТФ-аас 2027–2029 онд хийх Харилцан үнэлгээнд бэлтгэх хүрээнд Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны хэрэгжилт, үр дүнтэй байдлыг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үр дүнг нэмэгдүүлэх, шинэ технологийн хэрэглээнээс үүдэх эрсдэлийг бууруулах бодлого боловсруулах, олон улсын туршлага, техник хэрэгсэл, программ хангамжийг судлан нэвтрүүлэх, гэмт хэрэг илрүүлэх арга барилыг шинэ түвшинд хүргэх зэрэг ажлууд багтаж байна. Мөн Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэг болон ФАТФ-ын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор тусгай чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг тооцож, 2026 оны улсын төсвийн төсөлд 8.2 тэрбум төгрөг тусгав.

8. Онцгой байдлын албан хаагчдын нийгмийн баталгаа

Сүүлийн жилүүдэд гамшиг ослын тоо эрс нэмэгдэж Улсын хэмжээнд 2025 он гарсаар 15 аймгийн 74 сум, нийслэлийн 3 дүүрэгт, нийт 219 удаагийн ой, хээрийн гал түймэр бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад (ойн 147 буюу 5 дахин, хээрийн 72 буюу 1.2 дахин өссөн) 2.4 дахин өссөн үзүүлэлттэй байна. Мөн үер ус, ган зудын

тохиолдол ихэссээр байна. Иймд гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэдэг онцгой байдлын байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгааг дээшлүүлэх, тус албанд ажиллах хүний нөөцийн бодлогод хөшүүрэг, дэмжлэг болгох зорилгоор алба хаагчдад олгодог онцгой нөхцөлийн нэмэгдлийг 10 хувиар нэмэгдүүлж 40 хувьд хүргэхэд шаардагдах зардлыг 2026 оны төсвийн төсөлд тусгалаа. Ингэснээр албан хаагчдын нийгмийн баталгааг бэхжүүлэх, байгууллагын ажилтнуудын идэвх санаачилга, хариуцлагыг нэмэгдүүлэх, онцгой нөхцөлд шуурхай, үр дүнтэй ажиллах чадамжийг дээшлүүлэх боломж бүрдэнэ.

9. Аялал жуулчлалыг дэмжих зээл

Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх зорилгоор 2023-2028 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулж тус салбарын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор хөнгөлөлттэй зээл олгохоор Засгийн газрын 2025 оны 255 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн.

Тус тогтоолын хүрээнд дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх чиглэлээр аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулж 6 хувийн хүүтэй, 6 хүртэлх жилийн хугацаатай нийт 267.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2026 онд олгохоор тооцоолж, зээлийн хүүгийн дэмжлэгт зориулж 23.1 тэрбум төгрөгийг төрөөс хариуцан төлөхөөр төсвийн төсөлд тусгасан болно.

10. Хөдөө аж ахуйн салбарыг дэмжих арга хэмжээ

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт уламжлалт мал аж ахуй болон эрчимжсэн хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжиж, дотоодын хэрэгцээгээ монголын хөрсөнд ургасан эрүүл хүнсээр бүрэн хангахаар тусгагдсан. Энэ хүрээнд "Эрүүл хүнс үйлдвэрлэгч, экспортлогч бүс" болох зорилтыг дэвшүүлж "Хүнсний хангамж, аюулгүй байдал", "Шинэ хоршоо-чинээлэг малчин", "Цагаан алт" "Атар-4" үндэсний хэмжээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, хөдөө аж ахуйн салбарт хөнгөлөлттэй зээлийг олгож төрөөс зээлийн хүүгийн дэмжлэг олгохоор 2026 оны төсвийн төсөлд тусгалаа. Тодруулбал:

1. Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөн:

Хөнгөлөлттэй зээл: Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, мал аж ахуй, газар тариалангийн салбарыг дэмжих зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолоор батлагдсан Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023, 2024 онд нийт 1.2 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон бөгөөд зээлийн үлдэгдэл 2025 оны 07 дугаар сарын 31-ний байдлаар 667.9 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Тус хөдөлгөөний хүрээнд 2026 онд шинээр зээл олгохгүй бөгөөд өмнө олгогдсон зээлийн хүүгийн дэмжлэгт зориулж 55.3 тэрбум төгрөгийг төрөөс хариуцан төлөхөөр тооцлоо.

Татаас, урамшуулал: Хүнсний болон үрийн улаан буудайн нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, эргэлтийн хөрөнгийн сантай болоход зориулж 23.0 тэрбум төгрөг, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд инновац нэвтрүүлэх, техник, технологийн шинэчлэл хийх зорилгоор тухайн жилд худалдан авсан техникт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх, бордоог хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох, бэлчээрийн ашиглалт, хамгааллыг сайжруулах, отрын нөөц бэлчээр, усан хангамж, өвс, тэжээлийн нөөц, хангамжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд 24.3 тэрбум төгрөг, сүүний урамшуулалд 13.9 тэрбум төгрөг тус тус төлөвлөлөө.

2. Шинэ хоршоо-чинээлэг малчин хөдөлгөөн:

Хөнгөлөлттэй зээл: Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолоор баталсан “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” үндэсний хөдөлгөөний хүрээнд хоршооны гишүүн малчдад зориулж 50.0 сая хүртэл төгрөгийн зээлийг олгож, нийт зээлийн хүүгийн 12 нэгж хувийг төрөөс хариуцан төлж байна. Тус хөдөлгөөний хүрээнд 2024-2025 онд нийт 26,759 хоршооны гишүүн малчинд 841.9 тэрбум төгрөгийн зээлийг олгож, зээлийн үлдэгдэл 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 714.8 тэрбум төгрөг байгаа бол 2026 онд шинээр 500.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгохоор төлөвлөж, зээлийн хүүгийн дэмжлэгт 108.9 тэрбум төгрөгийг төрөөс хариуцан төлөхөөр төсвийн төсөлд тусгав.

3. Атар-4 аян:

Хөнгөлөлттэй зээл: Хүн амын өсөн нэмэгдэж буй хүнсний хэрэглээг хангах зорилгоор Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрт “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ыг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд энэ хүрээнд “Аян өрнүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 47 дугаар тогтоол батлагдсан. Уг тогтоолын дагуу 2025 онд нийт 800.0 тэрбум төгрөгийн зээл олгохоор арилжааны банкнуудтай гэрээ байгуулж, 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 816 иргэн, аж ахуйн нэгжид 424.8 тэрбум төгрөгийг олгоод байна. Тус аяны хүрээнд олгох зээлийн нийт хүүгийн 10 нэгж хувийг төрөөс хариуцан төлөхөөр заасны дагуу 2026 онд зээлийн хүүгийн дэмжлэгт 69.0 тэрбум төгрөгийг олгохоор төсвийн төсөлд тусгасан.

Татаас, урамшуулал: “Атар-4” газар тариалангийн тогтвортой хөгжлийн хүрээнд хүнсний улаан буудайн урамшуулалд 16.0 тэрбум төгрөг, хүнсний ногооны урамшуулалд 11.5 тэрбум төгрөг олгохоор тус тус төлөвлөөд байна.

4. Цагаан алт үндэсний хөдөлгөөн:

Хөнгөлөлттэй зээл: Ноос, ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоол батлагдаж, “Цагаан алт” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд 2024-2026 онд нийт 1,514.6 тэрбум төгрөгийн зээлийг олгохоор банкнуудтай гэрээ байгуулж, 2025 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 432.8

тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 157 зээлдэгчид олгоод байна. Тус хөдөлгөөний хүрээнд олгох зээлийн нийт хүүгийн 10 нэгж хувийг төрөөс хариуцан төлөхөөр зохицуулсан бөгөөд 2026 онд шинээр 495.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгоно. Ирэх онд тус зээлийн хүүгийн дэмжлэгт зориулж 99.5 тэрбум төгрөг олгохоор төсвийн төсөлд тусгасан.

Татаас, урамшуулал: Ноосны урамшуулалд 15.6 тэрбум төгрөг, арьс ширний урамшуулалд 6.2 тэрбум төгрөг, бусад арга хэмжээнд 0.6 тэрбум төгрөг, нийт 22.4 тэрбум төгрөг тусгалаа.

5.Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих

Экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, инновацыг дэмжих, шинээр бизнес эхлүүлэх болон ажлын байр бий болгох, нэмэгдүүлэх зорилгоор жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд хөнгөлөлтэй нөхцөлөөр олгох зээлийн хэмжээг 45.0 тэрбум төгрөг байхаар төсвийн төсөлд тусгав.

11.Цахим шилжилт

Цахим шилжилтийн дунд хугацааны төлөвлөлтийг хийж, төр хувийн хэвшил, иргэн, олон улсын хамтын ажиллагааг уялдуулсан нэгдсэн зорилго, чиглэлийг бий болгож, бодлогын давхардал, төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах замаар цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх дижитал эдийн засаг, инновацыг шилжих шилжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн дараах арга хэмжээнд 5.5 тэрбум төгрөгийн зардал нэмж төлөвлөлөө. Үүнд:

- төрийн “Big data (их өгөгдөл)” суурилан зөвшөөрөл олгох үйл явцыг хялбаршуулах;
- төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх;
- салбар дундын цахим шилжилтийг эрчимжүүлэх зэрэг болно

12.Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн гишүүнчлэлийн хандив

Монгол Улс 1991 онд Дэлхийн банкны 155 дахь гишүүн орноор элсэж, 2024 оныг хүртэл бага болон дунджаас доогуур орлоготой орны ангилалд багтаж ирсэн бөгөөд энэ хугацаанд Дэлхийн банк болон түүний харьяа байгууллагаас нийт 1.2 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл, 168.3 сая ам.долларын буцалтгүй тусламжийг хүлээн авсан байна.

Энэхүү хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн эх үүсвэрийг 1990 оноос хойших шилжилтийн хүнд хэцүү цаг үе болон шилжилтийн дараах үеийн эдийн засгийн өсөлтийг хангах, нийгмийн нэн тэргүүний хэрэгцээ шаардлагатай төсөл хөтөлбөрүүдийг цаг алдалгүй хэрэгжүүлэхэд зориулж ашигласан.

Тухайлбал, Дэлхийн банк болон түүний харьяа байгууллагаас хүлээн авсан нийт буцалтгүй тусламжийн 62 хувийг эрчим хүчний салбарт, 10 хувийг төрийн удирдлага, 9 хувийг зам тээвэр, 9 хувийг хотын хөгжил, 6 хувийг хөдөө аж ахуй, 2 хувийг эрүүл мэнд болон үлдсэн хувийг банк, санхүү болон уул уурхайн салбарт хөрөнгө оруулснаар Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

Дэлхийн банкны аргачлалаар Монгол Улс 2024 оноос дунджаас дээгүүр орлоготой орны ангилалд орж, тус ассоциацийн донор орнуудад гишүүнээр элсэх нөхцөлийг хангаад байгаа бөгөөд донор орон болохтой холбоотойгоор Олон улсын хөгжлийн ассоциацид хандив хэлбэрээр 5.5 тэрбум төгрөгийг олгохоор 2026 оны төсвийн төсөлд тусгасан.

Ингэснээр, Дэлхийн банк болон түүний харьяа бусад байгууллагууд болох Олон улсын санхүүгийн корпорац (IFC), Олон талт хөрөнгө оруулалтын баталгааны агентлаг (MIGA), Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (IBRD)-тай хамтын ажиллагааг бэхжүүлэх нэн чухал ач холбогдолтой юм.

4.2.3. Засгийн газрын тусгай сан

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6.1-т тусгай сангийн төсөв нь улсын төсвийн хөрөнгө, хандив, тусламж, тусгай сангийн үйл ажиллагааны орлого, зээлийн хүүгийн орлогын эх үүсвэрээс бүрдэхээр заасан. Энэ хүрээнд 2026 онд Засгийн газрын тусгай сангуудаар дамжин нийт 12,146.7 тэрбум төгрөгийн зардал санхүүжүүлэх бол үүний 93.1 хувь буюу 11,306.4 тэрбум төгрөг нь Нийгмийн даатгал, Нийгмийн халамж, Эрүүл мэндийн даатгалын сангуудын зарлага, 6.9 хувь буюу 840.3 тэрбум төгрөг нь бусад тусгай сангийн зардалд хамаарч байна.

Хүснэгт 21. Засгийн газрын тусгай сангийн зардлын төсөл (тэрбум төгрөг)

| ЗГ-ын тусгай сан | | 2025 Суурь* | 2026 Төс. | Зөрүү |
|------------------|---|----------------|--------------|-------|
| 1 | Нийгмийн даатгалын сан | 5,869.5 | 6,439.8 | 570.3 |
| 2 | Нийгмийн халамжийн сан | 2,523.4 | 2,593.3 | 69.9 |
| 3 | Эрүүл мэндийн даатгалын сан | 2,242.4 | 2,273.3 | 30.9 |
| 4 | Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сан | 209.1 | 213.3 | 4.2 |
| 5 | Засгийн газрын нөөц сан | 148.2 | 159.9 | 11.7 |
| 6 | Боловсролын зээлийн сан | 157.9 | 155.4 | -2.5 |
| 7 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 129.9 | 117.1 | -12.8 |
| 8 | Улсын авто замын сан | 78.2 | 62.2 | -16.0 |
| 9 | Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан | 44.8 | 44.9 | 0.1 |
| 10 | Зэвсэгт хүчний хөгжлийн сан | 40.0 | 40.0 | - |
| 11 | Хүүхдийн төлөө сан | 8.3 | 17.0 | 8.7 |
| 12 | Эрүүл мэндийг дэмжих сан | 9.7 | 9.5 | -0.2 |
| 13 | Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан | 5.9 | 11.5 | 5.6 |
| 14 | Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан | 8.3 | 8.2 | -0.1 |
| 15 | Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан | 0.6 | 0.6 | - |
| 16 | Хилийн чанадад байгаа Монгол улсын иргэдэд туслах сан | 0.6 | 0.6 | - |

| | | | | |
|-------------|--|-----------------|-----------------|--------------|
| 17 | Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан | 0.1 | 0.1 | - |
| 18 | Кино урлагийг дэмжих сан | 0.5 | - | -0.5 |
| 19 | Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан | - | - | - |
| 20 | Спортыг дэмжих сан | - | - | - |
| 21 | Байгаль орчин, уур амьсгалын сан | - | - | - |
| 22 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан | - | - | - |
| НИЙТ | | 11,477.4 | 12,146.7 | 669.3 |

Боловсролын зээлийн сан

Боловсролын зээлийн сангийн 2026 оны нийт зарлагыг 155.4 тэрбум төгрөгөөр төлөвлөвөө. Боловсролын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтад гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид Засгийн газраас тогтоосон шалгуур, шаардлагыг хангасан тохиолдолд суралцагчийн тэтгэлэг олгох, тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт, тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батлахаар заасан.

Энэ дагуу Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг, Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэг, Засгийн газар хоорондын гэрээгээр суралцагчид олгох тэтгэлэг, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид олгох буцалтгүй тусламж, зарим эрэлттэй мэргэжлээр суралцагчид олгох тэтгэлэг, зорилтод бүлгийн суралцагчид олгох буцалтгүй тусламж, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн сургалтын байгууллагад суралцагчид олгох сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дотоод, гадаадад суралцагчдад олгох зээлтэй холбоотой зардлуудыг тус тус тусгалаа. Мөн Засгийн газрын 2024 оны 103 дугаар тогтоолд туссан багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс үзүүлэх дэмжлэгтэй холбоотой зардлыг тус сангийн 2026 оны төсвийн төсөлд тусгалаа.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлд мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах харилцааг зохицуулсны дагуу холбогдох зардлыг тус сангийн 2026 оны нийт зарлагыг 213.3 тэрбум төгрөгөөр тусгалаа.

Ингэхдээ “Хувьсах зардлын дундаж норматив, итгэлцүүр, журам батлах тухай” Засгийн газрын 2023 оны 466 дугаар тогтоолын дагуу төрийн болон төрийн бус өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын төсвийг төлөвлөж, чанар, үр дүнд үндэслэсэн гүйцэтгэлд суурилсан зарчмаар санхүүжүүлэхээр холбогдох зардлыг тусгалаа.

Нийгмийн халамжийн сан

Монгол Улсад нийгмийн халамжийн чиглэлийн 6 хуулийн хүрээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, алдар цолтой ахмад настан, хүүхэд, эхчүүд болон нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэдэд 12 төрлийн халамжийн хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

Нийгмийн халамжийн сангийн 2026 оны төсвийн саналыг одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, 2025 онд шинэчлэн батлагдсан Ахмад настны тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон Засгийн газрын тогтоол бусад эрх бүхий байгууллагаас баталсан үнэ, тарифын өөрчлөлтүүд, хүн амын ердийн өсөлт, өмнөх 3 жилийн төсвийн гүйцэтгэл зэрэгт үндэслэн төлөвлөв.

Нийгмийн халамжийн сангаас 2026 онд олгох хөнгөлөлт, тусламж, үйлчилгээнд 2,593.3 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон. Нийгмийн халамжийн сангаас олгох нийт хөнгөлөлт, тусламж, үйлчилгээний зардлын 60.7 хувийг хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зардал эзэлж байна.

Хүүхдийн мөнгөн тэтгэмж

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.6-д хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийгмийн халамжийн сангаас олгохоор заасан байдаг. Ирэх онд 0-18 хүртэлх насны нийт 1,332.8 мянган хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгоход 1,575.4 тэрбум төгрөг төсөвлөлөө.

Халамжийн тэтгэвэр

Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан 65 насанд хүрсэн иргэн, 16 насанд хүрсэн одой иргэн, хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд, 18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг нийт 63.8 мянган иргэн нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авч байна. Ирэх онд нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу халамжийн тэтгэвэр авагч иргэд, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж авах 16.4 мянган иргэдийн тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлэн тусгаж нийт тэтгэврийн зардалд 335.1 тэрбум төгрөг тусгалаа.

Асаргааны тэтгэмж

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа, хүүхдийг асарч байгаа асралт гэр бүл, тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэдэд тус тус асаргааны

тэтгэмж олгохоор заасан байдаг. Асаргааны тэтгэмж авдаг нийт 82.8 мянган иргэнд 279.3 тэрбум төгрөг олгохоор тооцож, төсөвт тусгалаа.

Онцгой тохиолдлын болон амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт заасан байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхдэд, байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн нийт 76.4 мянган иргэнд 97.1 тэрбум төгрөг олгохоор тооцсон.

0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж

Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 5.1 дэх хэсэгт заасан жирэмсэн эхийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, ихэр хүүхдийн тэтгэмж, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжийг 172.1 мянган иргэнд олгохоор тооцож 107.0 тэрбум төгрөг тусгасан.

Эхийн алдар одонтой ээжид олгох мөнгөн тусламж

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 4 дүгээр зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.9 дэх хэсэгт заасны дагуу “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одон, “Эхийн алдал” хоёрдугаар зэргийн одонтой 274.0 мянган эхэд 67.6 тэрбум төгрөг олгохоор төсөвт тусгалаа.

Насны хишиг

Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад 65 болон түүнээс дээш настай ахмад настанд “насны хишиг” тэтгэмж олгохоор заасны дагуу 210.3 мянган ахмад настанд нийт 33.6 тэрбум төгрөг олгохоор тооцлоо.

Хүнс тэжээлийн дэмжлэг

Нийгмийн халамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасан энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн-иргэдийн дотроос нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлсон хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэн нийт 129.0 мянган иргэнд нийт 18.8 тэрбум төгрөг олгохоор төсөвт тусгалаа

Асрамжийн үйлчилгээний зардал

Хүүхэд хамгааллын тухай хууль 2024 онд шинэчлэн батлагдсантай холбогдуулан Нийгмийн халамжийн тухай хуулийн 19¹.2. “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлж байгаа гэр бүл, хуулийн этгээдэд олгох хувьсах болон үйлчилгээний зардлыг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ”⁷ гэж заасны дагуу нийт 16 хүүхдийн асрамж, халамжийн төвд амьдарч байгаа 550 хүүхдэд хувцас, эм, хоолны зардлыг баталсан нормативын дагуу олгох 3.4 тэрбум төгрөг нэмж тусгалаа.

⁷ 19¹.1. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу гэр бүлээс нь тусгаарлагдсан хүүхдийг хамруулна.

Нийгмийн даатгалын сан

Нийгмийн даатгалын сангийн орлого: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн орлогыг 6,174.3 тэрбум төгрөг байхаар тооцлоо. Улсын төсвөөс тэтгэврийн даатгалын сангийн 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэр, цэргийн албан хаагчдын тэтгэвэр, Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуульд заасан нэмэгдэл болон бусад зориулалтаар нийт 1,479.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор тооцлоо.

Нийгмийн даатгалын сангийн зарлага: Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагыг 6,439.8 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн. Ирэх онд тэтгэврийг 6.0 хувиар нэмэгдүүлэх болон тэтгэвэр авагчдын тооны өсөлт, итгэлцүүр шинэчлэн баталсантай холбоотой зардлыг тус тус тооцож тусгасан.

Нийгмийн даатгалын сангийн Капитал банкнаас авах 67.2 тэрбум төгрөгийн авлагыг мөн тусгав.

Эрүүл мэндийн даатгалын сан

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн нийт орлогыг 2,551.8 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн. Үүний 1,312.8 тэрбум төгрөгийг төр хариуцах эмнэлгийн тусламж, үйлчилгээ, төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцан төлөх даатгуулагчдын шимтгэлийн орлого, 1,239.0 тэрбум төгрөг нь ажил олгогч, даатгуулагчийн болон бусад даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлогоос тус тус бүрдэхээр байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн нийт зарлагыг 2,273.3 тэрбум төгрөг байхаар төлөвлөлөө. Үүнээс эрүүл мэндийн байгууллагад олгох тусламж, үйлчилгээний санхүүжилтийг 2,090.0 тэрбум төгрөг, төр хариуцах эмийн зардлын хяналт, хүртээмжийг сайжруулах зорилгоор эмийн үнийн хөнгөлөлтөд олгох санхүүжилтийг 169.8 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардлыг 13.5 тэрбум төгрөг байхаар тус тус тооцлоо.

Хүүхдийн төлөө сан:

Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3 дахь заалтад 2021 онд нэмэлт, өөрчлөлт орсноор хүүхдэд зориулсан бүтээн байгуулалт, хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцоог дэмжих зориулалт бүхий “Хүүхдийн төлөө сан” байгуулагдан, сангийн өдөр тутмын үйл ажиллагааг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 139 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журамд сангийн

хөрөнгийн санхүүжилтээр дэмжих хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг илүү тодорхой болгож, сангийн хөрөнгийг дараах зориулалтаар зарцуулахаар тусгасан. Үүнд:

- Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг дэмжих;
 - Хүүхдэд зориулсан барилга байгууламж шинээр барих;
 - Хүүхдэд зориулсан барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх;
 - Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах.
- Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцож амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулах;
- Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх.


Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд зааснаар хүүхдийн төлөө сангийн хөрөнгө нь улсын төсөв, хандив, тусламж, авто тээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлого, хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг дэмжсэн соёл, урлаг, спортын тоглолтын хандив, тусламжийн орлогоос бүрдэнэ гэж заасан. Иймд Хүүхдийн төлөө сангийн өөрийн орлоготой уялдуулж тус сангийн зардлыг 8.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн төсөлд тусгалаа.

4.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламж болон төр, хувийн хэвшлийн түншлэл

4.3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалт нь эдийн засгийн хөгжлийн нэг гол хүчин зүйл юм. Үр өгөөжтэй төсөлд хөрөнгө оруулахын хэрээр үйлдвэрлэл нэмэгдэж, ДНБ өсөн улмаар эдийн засгийн өсөлтийг тэлдэг тул хөрөнгө оруулалт ба эдийн засгийн өсөлт харилцан эерэг хамааралтай байдаг. Төсвийн хөрөнгө оруулалтын хувьд хувийн хөрөнгө оруулалтаас ялгаатай байдал нь эдийн засаг, нийгмийн дэд бүтэц, үйлчилгээг хангахад чиглэсэн урт хугацаанд ашиглах нийтийн буюу төрийн болон орон нутгийн өмчийг бий болгодогт оршино.

Зураг 22. Төлөвлөлтийн цаглавар

| ТӨЛӨВЛӨЛТ 3 САРЫН 1-НЭЭС ЭХЭЛДЭГ | | Сум, дүүрэг, аймаг, нийслэл, ТЭЗ, СЯ гэсэн 4 үе шатаар аргачлал, 10 шалгуур үзүүлэлтээр үнэлж, эрэмбэлдэг |  | Үр ашигтай, ач холбогдолтой, үр нөлөөтэй төслийг төсвийн төсөлд тусгах зорилготой |
|---|---|---|---|--|
| 3 сарын 31 | 4 сарын 30 | 6 сарын 25 | 7 сарын 25 | 8 сарын 25 |
| <i>Иргэдийн саналыг гар утасны апп-р И-монголиа-р дамжуулан 30 хоногийн хугацаанд авдаг</i> | <i>Сум дүүрэг үнэлгээ хийж, эрэмбэлэн сонгож аймаг/нийслэлд хүргүүлэх</i> | <i>Аймаг/нийслэл үнэлгээ хийж, эрэмбэлэн сонгож ТЭЗ нарт хүргүүлэх</i> | <i>ТЭЗ нар үнэлгээ хийж, эрэмбэлэн сонгож Сангийн яаманд хүргүүлэх</i> | <i>СЯ үнэлгээг хянаж, шаардлагатай тохиолдолд засварлан эрэмбэлж, ЗГ-т өргөн барих</i> |


Төлөвлөлтийн хууль, эрх зүйн зохицуулалт: Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Сангийн сайдын 2023 оны А/264 дүгээр тушаалаар батлагдсан журам, аргачлалын хүрээнд төлөвлөж, төлөвлөлтийг улсын хэмжээнд цахим системээр хэрэгжүүлж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх зохистой хэмжээ олон улсын жишиг, судалгаанаас үзэхэд дараах нийтлэг чиг хандлага байна:

- **Хөгжиж буй орнуудын хувьд:** Төсвийн хөрөнгө оруулалт ДНБ-ий 4-8 орчим хувь байх нь зохистой гэж үздэг. Хэт бага байвал дэд бүтэц, нийгмийн салбарын хөгжил удааширч, хэт өндөр байвал төсөвт дарамт учруулж болзошгүй.

- **Хөгжсөн орнуудын хувьд:** ДНБ-ий 2-4 орчим хувь байхад хангалттай гэж үздэг. Эдгээр оронд дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн тул хөрөнгө оруулалтын хэрэгцээ харьцангуй бага байдаг.

Зураг 23. УТХО-ын нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувь, ДНБ-д эзлэх хувь



ОУВС-гийн судалгаанд хөгжиж буй орнууд ДНБ-ийхээ 1 хувьтай тэнцэх хэмжээний төсвийн хөрөнгө оруулалт хийснээр ДНБ урт хугацаанд 1-ээс дээш хувийн өгөөж бий болгодог талаар дурдсан байна.⁸

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зардлын дунджаар 13 хувь, ДНБ-ий дунджаар 4 хувь байгаа нь хөгжиж буй орны хувьд хангалттай үзүүлэлт боловч гол асуудал нь үр ашгийн үзүүлэлт чухал хэвээр байна. Сүүлийн жилүүдэд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг тэргүүлэх чиглэл болгож, энэ хүрээнд 2024-2025 онд боомт, олон улсын чанартай авто зам, эрчим хүчний хөрөнгө оруулалтыг түлхүү хэрэгжүүлж байна. Барилга, байгууламж, зам гүүр, эрчим хүчний салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалтын 43 орчим хувь нь материалын зардалд зарцуулагдах бөгөөд барилгын материалын 33.8 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, 66.2 хувийг импортоор хангадаг байна.

Төсвийн хөрөнгө оруулалт нь үр ашиг, ач холбогдол, эрэлт хэрэгцээг харгалзан үзэж эрэмбэлэн хэрэгжүүлэх үндсэн зарчимтай.

Энэхүү зарчмыг төсөл бүрд хэрэгжүүлэхийн тулд төсвийн хөрөнгө оруулалтын цаглавар, хугацаанд өөрчлөлт оруулж жил бүрийн 03 дугаар сарын 01-ээс дараах үе шатаар хэрэгжүүлсэн бөгөөд 2026 оны төсвийн төсөлд нийт 29.0 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий, 14.4 их наяд төгрөгийн санхүүжилт шаардлагатай 1,712 төсөл, арга хэмжээний саналыг төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн.

⁸ IMF, “Well Spent How Strong Infrastructure Governance Can End Waste In Public Investment”, 2020, pg 20

Зураг 24. УТХО-аар хэрэгжүүлэхээр ирүүлсэн төсөл, арга хэмжээний санал, цаглавар

| Сангийн сайдын 295, А/264-р тушаал: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох журам болон аргачлалууд | | | |
|--|---|---|--|
| 04 сарын 30 | 04 сарын 30 | 06 сарын 25 | 07 сарын 25 |
| 17,000+ иргэн | Сум/дүүргээс аймаг/нийслэлд хүргүүлсэн | Аймаг/нийслэл/агентлаг төлөвлөж ТЕЗ нарт хүргүүлсэн | Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн |
| 1,068 төсөл санаачилсан | 273 төсөл | 1,089 Төсөл | 1,712 төсөл |
| | төсөвт өртөг: 1.6 их наяд ₮ 2026 онд САНХҮҮЖИХ: 764.0 тэрбум ₮ | төсөвт өртөг: 12.3 их наяд ₮ 2026 онд САНХҮҮЖИХ: 6.5 их наяд ₮ | төсөвт өртөг: 29.0 их наяд ₮ 2026 онд САНХҮҮЖИХ: 14.4 их наяд ₮ |

Ирсэн саналуудын 78.5 хувь нь ирэх онд шинээр хэрэгжүүлэх төслийн санал бөгөөд эдгээрийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд шалгуур үзүүлэлтээр хянасны үр дүнд, хуулийн зөрчилгүйгээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх боломжтой 9.6 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 913 төслийг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журам, аргачлалын дагуу эрэмбэлэв.

Зураг 25. Шалгуур үзүүлэлт, эрэмбэлэлт

| ИРҮҮЛСЭН САНАЛ /шинэ/ | 1 | 2 | 3 | 4 | ХЯНАХ ТӨСӨЛ |
|-----------------------|---|--|--|---|---|
| | Бодлогын баримт бичигт “ТХХТ” гэж эх үүсвэрийг баталсан төслүүд | Төрийн хэмнэлт, МУЗЗНДНТУ тухай хуулиар УТХО хийхгүй төслүүд | ТЭЗҮ, зураг төсвийг ЭЗХЯ рүү шилжүүлэх | Цахим систем хийх төслүүдийг ЦХИХХЯ руу шилжүүлэх |  |
| 11.3 их наяд ₮ | -378.8 тэрбум ₮ | -927.9 тэрбум ₮ | -927.9 тэрбум ₮ | -20.5 тэрбум ₮ | 9.6 их наяд ₮ |
| 1232 төсөл | 11 төсөл | 149 төсөл | 145 төсөл | 7 төсөл | 913 төсөл |

ХӨГЖЛИЙН БОДЛОГО БА ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль нь 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан бөгөөд хөгжлийн бодлогыг боловсруулах, батлах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг бөгөөд урт, дунд болон богино хугацааны зорилго, зорилт бүхий бодлогын баримт бичгийг Улсын Их Хурлаас тухай бүр баталж түүнд чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэхээр заасан.

Тухайлбал тус хуулийн 6.10.3-т “улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж, Төсвийн тухай хуулийн 5.1-д “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 6.2.7-д “төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх” гэж заасан.


“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Хүний хөгжлийн бодлого”, “Эдийн засгийн бодлого”, “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн бодлогын 4 тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд нийт 317 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 126 нь улсын төсвийн хөрөнгө оруулалтад хамаарч, үүнд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ 3.5 их наяд төгрөгөөр тооцогдож байна.

Тус төлөвлөгөөнд багтсан 43 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих бөгөөд эдгээрт 1.6 их наяд төгрөгийн санхүүжилт, харин 1.9 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 83 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан. Түүнчлэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний 65.8 хувь буюу 83 төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгахаар төсвийн ерөнхийлөн захирагчдаас санал ирүүлсэн байна.

Өмнө жилүүдэд батлагдаж байсан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний тухайн жилийн төсвийн тухай хуультай уялдаа холбоог харахад 2022 онд уялдах байдал 36.1 хувь, 2023 онд 47.1 хувь, 2024 онд 71.0 хувь, 2025 онд 92 хувь уялаатай байна гэж Эдийн засаг хөгжлийн яамнаас тооцоолсон байна.

Зураг 26. УХЖТ болон УТХО-ын уялдаа



Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй холбоотой хууль, эрх зүйн зохицуулалт, аргачлал, цаглавар, судалгаа, статистик мэдээлэл, хөгжлийн бодлого, мөн эдгээрт тулгуурласан ирэх онд баримтлах бодлого, чиглэлийг тусгав.

Дээрх судалгаа, мэдээлэлд үндэслэн 2026 онд “ТОГТВОРТОЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ХӨГЖИЛД ЧИГЛЭСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ” гэснийг баримталж энэ хүрээнд дараах 3 чиглэлийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

| ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ | ЭРЧИМ ХҮЧ, СУУРЬ ДЭД БҮТЦЭЭР ХУВИЙН ХЭВШЛИЙГ ДЭМЖИХ | ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ |
|---|--|---|
| ҮНДСЭН ЗАРЧИМ: Үр ашиг, ач холбогдол, эрэлт хэрэгцээнд суурилан эрэмбэлж төлөвлөх | | |
| 1. Боловсрол салбарын эхэлсэн төслүүдийг дуусгана 2. Ачаалал өндөр байршлуудад бэлэн зураг төсөвтэй төслүүдийг шинээр эхлүүлнэ 3. Тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлнэ. 4. Хавдрын эмнэлгийн барилгыг эхлүүлнэ 5. Тоног төхөөрөмжийн санхүүжилтийг шийдвэрлэнэ. | 1. Дэд бүтцийн салбарт хэрэгжиж байгаа төслүүдийг үргэлжлүүлнэ. 2. Эрчим хүчний салбарт шинэ хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. 3. Зам тээврийн салбарт ач холбогдолтой томоохон замуудыг эхлүүлнэ. 4. ХАА-н салбарын үйлдвэрлэл паркуудын дэд бүтэц 5. Цахим шилжилт, инновац, дэд бүтэц 6. Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолборыг ашиглалтад оруулна. 7. Шинжлэх ухааны лабораторийн тоног төхөөрөмжийг шийдвэрлэнэ | 1. СОР-17 хурлын барилга байгууламж, тоног төхөөрөмж 2. Онцгой байдлын салбарын барилга байгууламж, тоног төхөөрөмж 3. Батлах хамгаалах, хууль зүй, дотоод хэрэгтэй холбоотой хөрөнгө оруулалт 4. Бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө оруулалт |

Баримтлах зарчим: Төсвийн хөрөнгө оруулалтын 2026 оны бодлогыг тодорхойлоход дээрх хүчин зүйлсийг харгалзаж тооцож, доорх зарчимд үндэслэсэн болно. Үүнд:

- I. Бодлогын баримт бичиг, зорилтууд
- II. Олон улсын судалгаа, чиг хандлага
- III. Төсвийн хөрөнгө оруулалтын судалгаа, статистик
- IV. Нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлага

Үүнээс гадна 2023-2025 онд дараах бодлогыг баримталж төлөвлөж, хэрэгжүүлснийг дор орууллаа. Үүнд:

| 2023 он | 2024 он | 2025 он | 2026 он |
|---|---|---|---|
| I. ЭХЛҮҮЛСЭН ТӨСЛҮҮДИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ, АШИГЛАЛТАД ОРУУЛАХ | | | |
| II. Ковидоос үүдэлтэй барилгын материалын үнийн өсөлт шийдвэрлэсэн III. Шинэ хөрөнгө оруулалт тусгаагүй IV. ТЭЗҮ, зураг төсвийн санхүүжилт тусгасан | II. УАГ-аас магадлалд хийсэн төсөвт өртгийн нэмэгдлийг шийдвэрлэсэн III. Орон нутагт шаардлагатай хөрөнгө оруулалтыг иргэдийн эрэмбэлснээр тусгасан IV. Бүх салбарт шаардлагатай хөрөнгө оруулалт шинэ хөрөнгө оруулалт эхлүүлсэн V. ТЭЗҮ, зураг төсвийн санхүүжилт тусгасан | II. Бүсчилсэн хөгжлийг бодлогыг эхлүүлж, авто зам, эрчим хүч, дэд бүтцийн салбарт шинэ хөрөнгө оруулалт эхлүүлсэн III. Бүх салбарт тоног төхөөрөмж, их засвар, ТЭЗҮ, зураг төсвийн санхүүжилт тусгасан | II. “Хүний хөгжил – Мега төсөл”-ийг бүх салбарт хэрэгжүүлэх III. Эрчим хүч, дэд бүтцийн салбар IV. Бусад салбарт нэн шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх |

Үргэлжлэн хэрэгжих төсөлд:

- ✓ Гэрээ байгуулсан, гүйцэтгэлтэй уялдуулан үлдэгдэл санхүүжилтийг тусгах
- ✓ Нэмэлт санхүүжилтийг УАГ-ын дүгнэлтэд үндэслэх /одоогоор 193 төслийн 609.1 тэрбум төгрөгийн хүсэлт хүргүүлсэн, 08 сарын 31-ний өдрийн байдлаар 100 төслийн 194.5 тэрбум төгрөгийн мэдээлэл ирсэн байна./
- ✓ Тарифт цалингийн нэмэгдэлд 35.3 тэрбум төгрөгийн санал ирсэн /ХББОСС-д шинжээчийн дүгнэлт гаргуулах албан бичиг хүргүүлсэн, дүгнэлт санал ирээгүй/

Шинээр хэрэгжих төсөлд:

- ✓ *Цахим системээр үнэлгээ хийж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор эрэмбэлсэн байх*
- ✓ *Бүрэн /сүүлийн 2 жилийн хугацаанд хийсэн/ зураг төсөвтэй байх*
- ✓ *Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд туссан байх*
- ✓ *ЗГҮАХ-ийн зорилттой уялдсан байх зарчмыг баримталсан.*

Түүнчлэн Сангийн яамны “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем”-ийн нээлттэй вэб сайт болон “Төсвийн хөрөнгө оруулалт”, “Public Investment” гэсэн гар утасны аппликэйшнээр дамжуулж, 2025 оны 03-р сарын 01-ээс 2025 оны 03 сарын 31-ийг дуустал хугацаанд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд орон нутгийн 17,000 иргэн, нийт 1,068-н төслийн саналыг гаргаж, тухайн сум, дүүрэг, аймаг, нийслэлд илгээсэн байна.

Мөн төсвийн төслийг боловсруулах үйл явцад олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулахаар дээрх хуульд заасны дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн хэлэлцүүлгийг цахимаар зохион байгуулж, Сангийн яамны цахим хуудас, Emongolia, 11-

11 төв, яамдын цахим хуудсаар болон “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем”-ээр 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 14-ний өдрүүдэд санал авсан. Уг санал асуулга, хэлэлцүүлгийн үр дүнд дараах төслүүдийг шинээр эхлүүлэхгүй, хойшлуулах зарчмыг баримталлаа.

- Соёлын төвийн барилга
- Баг, хороо, сум, дүүрэг, аймгийн тамгын газрын барилга
- Сум, аймгийн төвийн доторх авто зам
- Тусгай чиг үүргийн байгууллагуудаас бусад чиглэлийн албан конторын барилга
- Зуслан, амралт цогцолбор
- Ахмад, залуучууд, хүүхдийн хөгжлийн төв
- Кино, театрын барилга
- Үр ашиг, ач холбогдолгүй бусад төслүүд

Дээрх зарчмын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслүүдийг боловсрол, эрүүл мэндийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох, төрийн үйлчилгээг цахимжуулах, онцгой байдлын чадавхыг бэхжүүлэхэд түлхүү чиглүүлсэн бөгөөд мөн байгаль орчин, хүнсний аюулгүй байдал, шинжлэх ухаан, батлан хамгаалах зэрэг бусад салбарт шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэхээр төсвийн төсөлд тусгасан.

Зураг 28. Шинэ хөрөнгө оруулалт

| | | | | |
|--|--------------------------------|---|-----------------------------|---------------------------------------|
| "СОР 17" хурал зохион байгуулахтай холбоотой хөрөнгө оруулалт | Боловсрол | Батлан хамгаалах, гадаад харилцаа | | Эрүүл МЭНД |
| | 9% 98.9 | 8% 85.6 | | 6% 68.6 |
| 20% 217.1 | Хууль зүй, дотоод хэрэг | Төрийн байгууллагуудын их засвар, тоног төхөөрөмж | Эрчим хүч | ТЭЗҮ, зураг төсөв |
| | 6% 68.3 | 5% 53.4 | 5% 51.7 | 4% 43.6 |
| Авто зам, засвар, шинэчлэл | Цахим шинэчлэл | Хавдар судлалын үндэсний төв 2 | Инженерийн дэд бүтэц | Байгаль орчин |
| | | 4% 40.5 | 3% 37.6 | 3% 29.3 |
| 10% 108.0 | 6% 67.9 | Онцгой байдал | Шинжлэх ухаан | Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуй |
| | | 4% 39.3 | 3% 32.5 | 2% 22.2 |

Нийгмийн хариуцлагын хүрээнд нийгмийн салбарт хийсэн хөрөнгө оруулалтыг татварын бодлогоор дэмжинэ.

Аж ахуйн нэгжүүд байгаль орчин, эрүүл мэнд, боловсрол, соёл, спорт зэрэг салбаруудын нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор хөрөнгө оруулалт хийж, санхүүгийн дэмжлэг үзүүлбэл тухайн аж ахуйн нэгж **борлуулалтын орлогынхоо 1 хувь хүртэлх хэмжээгээр орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх боломж** бүрдсэн.

Жишээ: Жилийн 300.0 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого, 30.0 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж төсөвт 6.6 тэрбум төгрөгийн татвар төлдөг компанийн хувьд Боловсролын яамнаас баталсан шаардлага, стандартад нийцсэн ерөнхий боловсролын 320 хүүхдийн сургуулийг 6 тэрбум төгрөгөөр барьж байгуулан, улсад ишлэжүүлсэн тохиолдолд борлуулалтын орлогын 1 хувь хүртэлх буюу төлбөл зохих 6.6 тэрбум төгрөгийн татвараас **3 тэрбум төгрөгийг хөнгөлж, төсөвт 3.6 тэрбум төгрөг төлнө.**

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2026 ОНД ХҮНИЙ ХӨГЖИЛ-МЕГА ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ДАРААХ ОНЦЛОХ ТӨСЛҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.

1. Боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах

Боловсрол бол аливаа улсын хөгжлийн суурь байдаг. Боловсрол эдийн засгийн өсөлт, инновацыг удирдаж, хөдөлмөр эрхлэлт, бүтээмжийг нэмэгдүүлж, хувь хүний болон улсын хөгжил, дэвшлийг түүчээлдэг.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр боловсролын хөрөнгө оруулалтыг 2021 оноос хойш 40 хувиар нэмэгдүүлж, 2020 оноос хойш 277 цэцэрлэг, 200 сургуулийг ашиглалтад оруулаад байна. 2026 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 53 цэцэрлэг, 76 сургууль, 32 дотуур байрын төсөл, гадаад зээл, тусламжаар 20 цэцэрлэг, 41 сургуулийн төсөл хэрэгжих бөгөөд 7700 хүүхдийн ортой 52 цэцэрлэг, 22,636 суудалтай 54 сургууль, 3,665 ор бүхий 25 дотуур байр тус тус ашиглалтад орохоор байна.

Зураг 29. Онцлох хөрөнгө оруулалт, боловсрол

| ОНЦЛОХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: 2026 | | | |
|---|--|-----------------|------------------------------|
|  <p>Хүний хөгжлийг дэмжих БОЛОВСРОЛЫН ЖИЛ</p> | <p>НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ</p> <p>1,948.9</p> <p>ТЭРБУМ ТӨГРӨГ</p> | Сургууль | 117 |
| |  <p>ҮҮНЭЭС 2026 ОНД САНХҮҮЖИХ:</p> <p>1,041.6</p> <p>ТЭРБУМ ТӨГРӨГ</p> | Цэцэрлэг | 73 |
| | | Дотуур Байр | 32 |
| | | Тоног төхөөрөмж | 58.9 ТЭРБУМ ТӨГРӨГ |

Сургуулийн өмнөх боловсролд бүх хүүхэд тэгш хамрагдаж, чанартай үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийн суурийг бий болгох боломжийг бүрдүүлж, энэ хүрээнд улсын хэмжээнд ээлжийн коэффициент 1.5-с дээш байгаа байршлуудыг их өгөгдөлд суурилан тооцоолж 81.3 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 53 цэцэрлэгийн барилгыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, шинээр 2 цэцэрлэгийн барилгыг эхлүүлэхэд нийт 4.8 тэрбум төгрөгийг тусгав.

Ерөнхий боловсролыг тэгш хүртээмжтэй олгох, чанарыг сайжруулах зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд улсын хэмжээнд ээлжийн коэффициент 2.0-с дээш байгаа байршлуудыг их өгөгдөлд суурилан тооцоолж, сургууль дүүргэлтийг зохистой түвшинд хүргэх, ээлжийн коэффициентийг бууруулж, аймаг, сумын сургуулийн дэд бүтэц, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 76 сургууль, 32 дотуур байрны барилгыг төлөвлөв. (275.1 тэрбум төгрөг)

Мөн боловсролын хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори байгуулах, хоол үйлдвэрлэл, номын сан, урлагийн заалыг тохижуулах, дуу хөгжмийн хичээлийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хичээлийн хэрэглэгдэхүүн, сургуулиудын биеийн тамирын техник хэрэгсэл, цэвэрлэгээний тоног төхөөрөмжийг хангах, боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын онцлогт тохирсон хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг сайжруулахад 66.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Зураг 30. Онцлох хөрөнгө оруулалт, боловсролын тоног төхөөрөмж



ШИГТГЭЭ-3 ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРУУДЫН ТӨСВИЙН ҮРЖҮҮЛЭГЧ

Боловсролын салбарын зардал сүүлийн 10 жилийн хугацаанд жилд дунджаар 13 хувиар өсөж 2024 оны байдлаар 3.7 их наяд төгрөгт хүрснээр нэгдсэн төсвийн зардлын 13.1 хувийг эзэлж байна. Тус салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг хэмжих зорилгоор төсвийн зардлын үржүүлэгчийг тооцооллоо.⁹

Боловсролын салбарын шууд үржүүлэгч 0.43, хуримтлагдсан нөлөө 0.85-тай байна. Өөрөөр хэлбэл тус салбарын зардлыг 1 тэрбум төгрөгөөр өсгөхөд дотоодын нийт бүтээгдэхүүнийг 3 жилийн дотор 850 сая төгрөгөөр нэмэгдүүлнэ.



Тус салбарын үржүүлэгч нь олон улсын судалгаанууд дахь боловсролын салбарын 0.76-1.14 гэсэн үр дүнтэй ойролцоо байна.¹⁰ Боловсролын салбарын зардлыг нэмэгдүүлэх нь урт хугацаанд хүмүүн капиталын чанарыг сайжруулж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлснээр эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад нөлөөлнө.

Эдийн засгийн бусад салбаруудын хувьд эрчим хүч, дулаан хангамж, тээвэр холбооны салбаруудын үржүүлэгчид нь ДНБ-д хамгийн өндөр эерэг нөлөө үзүүлдэг. Тухайлбал эрчим хүч, дулаан хангамжийн салбарын зардлыг 1 тэрбум төгрөгөөр өсгөхөд ДНБ-ийг 3 жилийн дотор 2.2 тэрбум төгрөгөөр, тээвэр холбооны салбарын зардлыг 1 тэрбум төгрөгөөр өсгөхөд ДНБ-ийг 3 жилийн дотор 2.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлнэ.



2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх

Монгол Улсын газар нутаг, хүн ам зүйн онцлогт нийцүүлж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр онцгой анхаарч байна.

Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчин эмгэгийг эмчлэх, гадаадад эмчлүүлэгсдийн хувь, хэмжээг бууруулж эх орондоо үйлчлүүлэх боломжийг нэмэгдүүлэх, аймаг орон нутгаас Улаанбаатар хот руу чиглэх эмчлүүлэгчдийн урсгалыг бууруулах зорилгоор Булган аймгийн Нэгдсэн эмнэлэг, "Хавдар судлалын Үндэсний төв-II" цогцолборын А, С блокийн барилга, гадна шугам сүлжээ, Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, Зүрх, судасны үндэсний төв, Нийслэлийн хүүхдийн сэргээн засах "Эрүүл үрс" төвийн барилга, Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн барилгын хүчитгэл зэрэг лавлагаа шатлалын эмнэлгүүд болон орон нутагт анхан болон дунд шатны эрүүл мэндийн төвүүдийн барилгын төслүүдийг шинээр хэрэгжүүлэх болон үргэлжлүүлэн хэрэгжүүлж

⁹Төсвийн үржүүлэгчийн олон улсад түгээмэл ашиглагддаг Blanchard & Perotti (2002) судалгааны ажилд үндэслэн бүтцийн Вектор Авторегрессив загварыг ашиглан тооцоолов.

¹⁰ Roll & бусад (2023). The Multiplier Effect of Education Expenditures

Reeves et al (2013). Does investment in the health sector promote or inhibit economic growth?

ашиглалтад оруулах, урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг, эрт оношилгоог оновчтой хийх зорилгоор тоног төхөөрөмжийн санхүүжилтийг шийдвэрлэлээ.

Зураг 31. Онцлох хөрөнгө оруулалт, Эрүүл мэндийн салбар

| ОНЦЛОХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: 2026 | | | |
|--|---|--|---------------------------------|
|  <p>Хүний хөгжлийг дэмжих ЭРҮҮЛ МЭНДИЙН ХҮРТЭЭМЖ</p> | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ 1,742.7 ТЭРБУМ ТӨГРӨГ | <i>Хавдар судлалын үндэсний төв 2</i> | 40.5 ТЭРБУМ ТӨГРӨГ |
| |  <p>ҮҮНЭЭС 2026 ОНД САНХҮҮЖИХ:</p> 1,301.1 ТЭРБУМ ТӨГРӨГ | <i>Эс, эд, эрхтэн шилжүүлэх төв</i> | 43.1 ТЭРБУМ ТӨГРӨГ |
| | | <i>Эх нялхас /ЭХЭМҮТ/</i> | 13.9 ТЭРБУМ ТӨГРӨГ |
| | | <i>Зүрх судасны үндэсний төв</i> | 182.9 ТЭРБУМ ТӨГРӨГ |
| | | <i>Аймгуудын эмнэлэг, яаралтай тусламж</i> | 1,386.5 ТЭРБУМ ТӨГРӨГ |

Анхан шатны эрүүл мэндийн байгууллага: Алслагдсан хөдөө орон нутгийн иргэдийн халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, анхан шатны тусламж, үйлчилгээний хүртээмжийг чанартай, цаг алдалгүй хүргэх, чадавхыг дээшлүүлэх, зорилгоор сумын эрүүл мэндийн төвд лабораторийн цус, шээсний шинжилгээний аппарат тоног төхөөрөмж, яаралтай тусламж, сэргээн засах, рентген оношилгооны аппаратаар нэн шаардлагатай эмнэлгийн тоног, төхөөрөмж, хэрэгслээр хангахад 7.3 тэрбум төгрөгийг санхүүжүүлнэ.

Нийслэл, орон нутгийн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага: Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэгт амьсгалын эрхтэн тогтолцоо, хоол боловсруулах эрхтэн тогтолцоо, ялгаруулах эрхтэн тогтолцооны оношилгоог хийхэд шаардлагатай төрөлжсөн мэргэшлийн тоног төхөөрөмжийг сайжруулахад 15.1 тэрбум төгрөгийг санхүүжүүлнэ.

Эрүүл мэндийн салбарт шинээр ашиглалтад орж буй эмнэлгүүдийг тоног төхөөрөмж: Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/182 дугаар тушаал, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 34 дүгээр тогтоол, Сумын эрүүл мэндийн төвийн стандарт MNS 5081:2013, Нэгдсэн эмнэлгийн стандарт MNS 5095:2017, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн стандарт MNS 6330:2017-д тус тус заасны дагуу үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн сэтгэлд нийцсэн ээлтэй орчин бүрдэх, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тасралтгүй, чирэгдэлгүй, чанартай, аюулгүй хүргэх нөхцөл боломж бүрдүүлэх үүднээс орчин үеийн шаардлагад нийцсэн, эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангахад 4.2 тэрбум төгрөгийг санхүүжүүлнэ.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв: Эрхтэн шилжүүлэн суулгах чиглэлээр төрөлжсөн нарийн мэргэжил эзэмшсэн боловсон хүчнийг чадавхжуулах, хүүхдэд элэг, бөөр шилжүүлэн суулгахад шаардлагатай шинэ технологи нэвтрүүлэхэд шаардлагатай багаж төхөөрөмжийг шийдвэрлэхэд 9.3 тэрбум төгрөгийг тусгасан бөгөөд ингэснээр элэг шилжүүлэн суулгах мэс засал, бөөр шилжүүлэн суулгах мэс засалд хүлээгдэж байгаа хүлээгдлийг 20-25 хувиар бууруулах боломж бүрдэнэ.

Хавдар судлалын үндэсний төв: Орчин үеийн анагаах ухааны хөгжил нь бага инвазив мэс заслын аргууд, тэр дундаа робот мэс заслыг эрчимтэй нэвтрүүлж байна. Робот мэс засал нь уламжлалт мэс заслын аргуудтай харьцуулахад олон давуу талтай болох нь дэлхий нийтэд батлагдсан. Робот мэс заслын системийг нэвсрүүлснээр нээлттэй хагалгаанд шилжих хувийг 26.5 хувиар буулгаж, хагалгааны дараах хүндрэлийг 15 хувиар буулгах, дундаж ор хоногийг 1.5 дахин буулгах бөгөөд 5.2 тэрбум төгрөгийг тусгалаа.

Эмгэг судлалын үндэсний төв: Мэс ажилбар, мэс заслаар авсан эдэд онош тогтоох, хортой хавдрын онош тавих, эмчилгээний төлөвлөгөө гаргах, амьд сорьцын шинжилгээ, онош тодруулах зэрэг оношлоход төвөгтэй тохиолдлуудад эмгэг судлалын заслан шинжилгээ хийх зориулалт бүхий лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх чиглэлээр 2.1 тэрбум төгрөгийг тусгалаа. Ингэснээр үзүүлэх тусламж, үйлчилгээний цар хүрээ 2.5–3 дахин нэмэгдэх боломжтой бөгөөд слайд сканер ашигласнаар гадаадын өндөр хөгжилтэй орны эмч, мэргэжилтнүүдээс цахим зөвлөгөө авах нөхцөл бүрдэх юм.

Гэмтэл согог судлалын үндэсний төв: Тус төвд одоо ашиглагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийн 10 орчим хувь нь 10-аас дээш жилийн насжилтай тоног төхөөрөмжүүд бөгөөд хэвийн үйл ажиллагааг дэмжих, тоног төхөөрөмжийг сайжруулахад 6.4 тэрбум төгрөгийг төсвийн төсөлд тусгалаа. Уг тоног төхөөрөмжүүдийг шинэчилж сайжруулснаар мэс заслын хүлээгдэл 10-15 хувиар буурч, эмнэлгийн орны хүлээгдэл 0-10 хоног болж буурах, мэс заслын тусламж үйлчилгээг хурдан шуурхай авах боломжийг нэмэгдүүлнэ.

Хавдар судлалын үндэсний төв II: Орчин үеийн өргөн цар хүрээтэй дэлхийн жишигт нийцсэн Хавдар судлалын Үндэсний төв-II цогцолборын эхний үе шат болох А, С блокийн барилга болон гадна шугам сүлжээний санхүүжилтэд нийт 234.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 40.5 тэрбум төгрөгийг төсвийн төсөлд тусгалаа.



Тус эмнэлэг нь Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 34 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Баянголын аманд байгуулах бөгөөд мэс засал, туяа эмчилгээ, эрчимт эмчилгээ, оношилгоо, нөхөн сэргээх болон амбулаторийн үйлчилгээний хэсгийг агуулна. Түүнчлэн эмнэлгийн барилга байгууламж баригдах бөгөөд 614 орны хүчин чадал бүхий орчин үеийн өндөр хүчин чадалтай эмнэлгийн тоног төхөөрөмж суурилуулалт хангагдсан 1500 хүртэл эмч, ажилтан, туслах ажилтан ажиллах боломжтой томоохон бүтээн байгуулалт болно.

3. Хувийн хэвшлийг дэмжиж эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн өсөлт, байгаль орчны хамгаалал зэргийг тэргүүлэх чиглэл болгон өөрийн орны эрчим хүчний анхдагч нөөц болох нүүрс, нар, салхины баялаг нөөц, эдгээр нөөцийг үр ашигтай ашиглахад чиглэж байгаа бөгөөд **бодлогын гол зорилтууд нь:**

- I. Эрчим хүчний хангамжийг тогтвортой, найдвартай хүртээмжтэй болгох, үүний тулд дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- II. Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, хэрэглээний бүх үе шатуудад шинэ технологи, инновацыг нэвтрүүлж, үр ашгийг сайжруулах;
- III. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг хөгжүүлэх;
- IV. Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, технологи, мэдлэгийг шилжүүлэн авахад хамтын ажиллагааг сайжруулахад оршиж байна.

| ОНЦЛОХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: 2026 | | | |
|--|--|---------------------------------|---------------------------------|
|  <p>Хувийн хэвшлийг дэмжих ЭРЧИМ ХҮЧ</p> | <p>НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ</p> <p>5,332.9 ТЭРБУМ ТӨГРӨГ</p>  <p>ҮҮНЭЭС 2026 ОНД САНХҮҮЖИХ:</p> <p>3,937.6 ТЭРБУМ ТӨГРӨГ</p> | <i>Улсын төсөв</i> | 347.4 ТЭРБУМ ТӨГРӨГ |
| | | <i>Гадаад зээл, тусламж</i> | 522.1 ТЭРБУМ ТӨГРӨГ |
| | | <i>ТХХТ</i> | 351.8 ТЭРБУМ ТӨГРӨГ |
| | | <i>Бонд</i> | 150.0 ТЭРБУМ ТӨГРӨГ |
| | | <i>Хувийн хэвшил</i> | 2,566.3 ТЭРБУМ ТӨГРӨГ |

Өнөөдрийн байдлаар баруун, төв, өмнөд болон дорнод бүс, Алтай–Улиастайн гэсэн 5 эрчим хүчний системд нийт 330 гаруй сум, суурин газруудыг төвлөрсөн эрчим хүчний системээс хангаж байна.

Эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг эх үүсвэрийн бүтцээр нь авч үзвэл 90.5 хувийг дулааны цахилгаан станцууд, 5.98 хувийг салхин цахилгаан станцууд, 2.7 хувийг нарны цахилгаан станцууд, 0.85 хувийг усан цахилгаан станцууд, 0.0016 хувийг дизель станцууд тус тус үйлдвэрлэсэн бол нийт импортолсон цахилгаан эрчим хүчний 1.3 тэрбум кВт.ц буюу 46.1 хувийг ОХУ-аас, 1.5 тэрбум кВт.ц буюу 53.9 хувийг БНХАУ-аас тус тус импортолсон.

Сүүлийн жилүүдийн дунджаар ЦЭХ-ний нийт хэрэглээ 8-10 хувиар өсөж, өвлийн улиралд системийн оргил ачаалал дунджаар 11 хувийн өсөлттэй байна. Түүнчлэн, төвийн бүсийн нэгдсэн сүлжээний ачаалал 2024 онд 1655 МВт хүрсэн бөгөөд үүнээс Улаанбаатар хотын ачаалал 1073 МВт хүрсэн нь нийт ачааллын 64.8 хувийг эзэлж байна.

Эрчим хүчний системийн суурилагдсан хүчин чадлын 81 хувийг дулааны цахилгаан станцууд эзэлж байгаа ба цахилгаан эрчим хүчний хэрэглээний хоногийн графикаар их бага ачааллын зөрүү 280-350 МВт-д хүрч байна. Ачааллын зөрүүний дийлэнх хувийг импорт, экспортын эрчим хүчээр зохицуулж байгаа ба 2023, 2024 онд ашиглалтад орсон батарей хуримтлуурын станцууд горимын тохируулгад зохих хэмжээний дэмжлэг үзүүлж байна.

Улсын хэмжээнд арилжааны үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн 155 МВт-ын салхин цахилгаан станц, 181 МВт-ын нарны эрчим хүчний эх үүсвэрүүд ажиллаж байна. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн суурилагдсан хүчин чадал системийн нийт

суурилагдсан хүчин чадлын 18.6 хувь байгаа ба нийт эрчим хүч үйлдвэрлэлийн 9.53 хувийг үйлдвэрлэж байна.


Нар, салхины эх үүсвэрүүдийн үр ашигтай үйлдвэрлэлийн горим нь эх газрын эрс тэс уур амьсгалтай Монгол улсын эрчим хүчний хэрэглээний оргил ачааллын цагаас зөрүүтэй байгаагаас эдгээр станцууд өөрийн суурилагдсан хүчин чадлын хэмжээгээр системд тогтвортой эрчим хүчнийг нийлүүлэх боломжгүй байна. Иймээс сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг хөгжүүлэхэд эрчим хүчний нэгдсэн сүлжээний горимын зохицуулалт хийх чадвартай эх үүсвэр шаардлагатай байгаа юм.

Хөрш орнуудын туршлагаас харахад эрчим хүчний нэгдсэн сүлжээний горимын зохицуулалтад оролцох боломжтой усан цахилгаан станц БНХАУ-д суурилагдсан хүчин чадлын 19.2 хувь, ОХУ-д 20.24 хувийг эзэлж байгаа бол манай улсын хувьд ердөө 1.7 хувийг эзэлж байна.

Эрчим хүчний салбарт суурь горимд ажиллах том чадлын ДЦС, оргил ачааллын үед горим тохируулга хийх, нөөц чадлыг богино хугацаанд гаргах маневрлах чадвартай их чадлын усан цахилгаан станц, усан цэнэгт, цэнэгт хураагуур болон хийн станцуудыг эхний ээлжид барих, тэдгээрийн горим ажиллагааны оновчтой байрлалд нар, салхины эх үүсвэрүүдийг үе шаттайгаар барьж байгуулснаар эрчим хүчний эх үүсвэрийн бүтэц оновчтой болж импортын эрчим хүч буурах, системийн тогтворжилт дээшилж, улмаар эрчим хүч экспортлох боломж бүрдэх юм.

Зураг 34. Эрчим хүчний хөрөнгө оруулалт

Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалт:



Түүнчлэн, эрчим хүчний тогтвортой, найдвартай байдал болон цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангах чиглэлээр эрчим хүчний том чадлын суурь горимд ажиллах эх үүсвэрүүд болох томоохон нүүрсний нөөц бүхий Төв аймгийн Баян,

Баянжаргалан сумдын нутаг дэвсгэрт цайдам нуурын нүүрсний ордод түшиглэн Бөөрөлжүүтийн 300 МВт, Баянгийн 660 МВт, Шивээ-овоо 660 МВт-ын цахилгаан станцууд, Завхан аймгийн Тосонцэнгэл суманд 30 МВт-ын, Сэлэнгэ аймгийн төвд 70 МВт-ын станцуудыг барьж, эхний ээлжийг 2024 оноос ашиглалтад орж эхлээд байна.

Эдгээр эх үүсвэрүүдийн барихын зэрэгцээ эх үүсвэрүүдийг хооронд нь болон үйлдвэрлэсэн эрчим хүчийг хэрэглэгчдэд нь хүргэх цахилгаан дамжуулах шугам сүлжээний төслүүдийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бөгөөд 2026 онд цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг 3,515 мянган МВт.ц-аар, төвлөрсөн дулаан хангамжийн хүчин чадлыг 112 МВт-аар тус тус нэмэгдүүлнэ. Ингэснээр цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын хувь 99.7 хувьд хүрч нэмэгдэх ба импортын цахилгаан эрчим хүчийг 663.4 мянган МВт.ц- аар бууруулахаар тооцоолов.

4. Гамшгийн эсрэг бэлэн байдлыг сайжруулж онцгой байдлын байгууллагын чадавхыг нэмэгдүүлнэ.

Онцгой байдлын байгууллагын нэгжийг баруун (бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газар), зүүн (бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар), хойд (бүсийн төв Орхон аймгийн Онцгой байдлын газар), өмнөд (бүсийн төв Өмнөговь аймгийн Онцгой байдлын газар), Улаанбаатарын (бүсийн төв нийслэлийн Онцгой байдлын газар) гэсэн 5 бүсэд хувааж, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг бүсчилсэн хэлбэрт шилжүүлж бүсийн төвүүдийг байгуулан гамшгаас хамгаалах арга хэмжээг авч байна.

“Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжид тавих шаардлага” MNS 6412-2013: стандартад зааснаар улсын хэмжээнд 169 гал түймэр унтраах, аврах анги байхаас 77, “Онцгой байдлын байгууллагын эрэн хайх, аврах нэгжид тавих шаардлага” MNS 6740:2018: улсын стандартад зааснаар улсын хэмжээнд 108 эрэн хайх, аврах нэгж байхаас 48 эрэн хайх, аврах анги, салбар, бүлэг байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Онцгой байдлын байгууллагын техник, тоног төхөөрөмжийн хангалт дунджаар 63 хувьтай байна. Үүнээс аврах ажиллагааны тоног төхөөрөмжийн хангалт 66.2 хувь, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хангалт 71.4 хувь, гал унтраах чиглэлийн тоног төхөөрөмжийн хангалт 61.8 хувь, холбоо, зарлан мэдээллийн тоног төхөөрөмжийн хангалт 32.0 хувь, богино долгионы радио станц 36.6 хувь (суурин 69.5 хувь, үүргэвчийн 21 хувь, машины 27.7 хувь), хэт богино долгионы радио станц 32 хувь (суурин 82 хувь, үүргэвчийн 25 хувь, машины 34 хувь, гар станц 29 хувь, дахин дамжуулах станц 57 хувь)-тай байна.

Мөн гамшиг, аюулт үзэгдлийн нөхцөл байдлын хувьд жилд тохиолдох гамшгийн тоо 2015 онд 400 орчим байсан бол 2030 он гэхэд 560 болж, гамшгийн тоо 40 хувиар өсөх хандлагатай байна. Хүн амын хэт төвлөрөл, нөөцийн тэгш бус хуваарилалт, ядуурал, стандарт мөрдөөгүй төлөвлөлт, хотжилт зэрэг гамшгийн эрсдэлийг бүрдүүлэх далд хүчин зүйл улам бүр нэмэгдэж байгаа нь онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа иргэдэд түргэн шуурхай хүрэх нөхцөлийг хязгаарлаж байна.

Иймд дэвшилтэт технологи, инновацад суурилсан гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх, эрт сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай авах, эрсдэлийг бууруулахад чиглэсэн техник, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх, эрэн хайх, аврах нэгжийн хүчин чадлыг сайжруулах, гал түймэр унтраах тусгай зориулалтын техник хэрэгслийн бэлэн байдлыг хангахад 39.3 тэрбум төгрөг тусгалаа.

Зураг 35. Онцлох хөрөнгө оруулалт, Онцгой байдлын салбар

| ОНЦЛОХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: 2026 | | | |
|--|--|--|--|
|  <p>Гамшгийн эсрэг бэлэн байдлыг сайжруулах ОНЦГОЙ БАЙДАЛ</p> | <p>НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ</p> <p>594.7</p> <p>ТЭРБУМ ТӨГРӨГ</p>  <p>ҮҮНЭЭС 2026 ОНД САНХҮҮЖИХ:</p> <p>573.9</p> <p>ТЭРБУМ ТӨГРӨГ</p> | <p><i>Завхан, Тосонцэнгэл, гал унтраах ангийн барилга</i></p> | <p>2.9</p> <p>ТЭРБУМ ТӨГРӨГ</p> |
| | | <p><i>Хөвсгөл, Тариалан, гал унтраах ангийн барилга</i></p> | <p>2.6</p> <p>ТЭРБУМ ТӨГРӨГ</p> |
| | | <p><i>Баянхонгор, Баянхонгор, гал унтраах ангийн барилга</i></p> | <p>2.4</p> <p>ТЭРБУМ ТӨГРӨГ</p> |
| | | <p><i>Өвөрхангай, Арвайхээр, гал унтраах ангийн барилга</i></p> | <p>2.4</p> <p>ТЭРБУМ ТӨГРӨГ</p> |
| | | <p><i>Тоног төхөөрөмж</i></p> | <p>39.3</p> <p>ТЭРБУМ ТӨГРӨГ</p> |
| | | <p><i>Гадаад зээл, тусламжийн төсөл</i></p> | <p>523.8</p> <p>ТЭРБУМ ТӨГРӨГ</p> |

5. Төрийн цахим үйлчилгээг сайжруулж хүний хөгжлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Монгол Улсад төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, цахимаар үзүүлэх бодлого хэрэгжиж байгаа ч орон нутгийн нэгжүүд болон төв байгууллагуудад дэд бүтцийн чадавх, техник хэрэгслийн хомсдол, хуучирсан тоног төхөөрөмжийн асуудал байсаар байна.

Төрийн мэдээлэл солилцооны “ХУР”, “ДАН”, “e-Mongolia”, “Mcloud” зэрэг үндсэн, дэмжих системүүдийн хэрэгцээ өсөн нэмэгдэж, системүүдийн найдвартай байдал, аюулгүй ажиллагаа, эрчим хүчний хангамж, галын хамгаалалтыг шинэчлэх шаардлага үүссэн.

Үүрэн холбооны сүлжээний өргөтгөх, шилэн кабель, 4G сүлжээний өргөтгөл зэрэг алслагдсан сум, баг, орон нутгийн иргэд өндөр хурдны интернэт болон мобайл сүлжээгээр хангах, мэдээлэл авах, боловсрол эзэмших, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх боломжийг нэмэгдүүлэх, кибер аюулгүй байдлыг хангах, дижитал эдийн засгийг

хөгжүүлэх, хөгжлийн индексийг дээшлүүлж, нийгмийн тэгш байдлыг дэмжиж, төрийн цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр төсвийн төсөлд 67.9 тэрбум төгрөгийг тусгалаа.

Ингэснээр төрийн үйлчилгээг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, найдвартай, тасралтгүй хүргэх суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

Зураг 36. Онцлох хөрөнгө оруулалт, Цахим хөгжил

| ОНЦЛОХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: 2026 | | | |
|--|--|----------------------------------|------------------------------|
|  <p>Хүний хөгжлийг дэмжих ЦАХИМ ХӨГЖИЛ</p> | <p>2026 ОНД САНХҮҮЖИХ: ҮҮНЭЭС 2026 ОНД САНХҮҮЖИХ:</p> <p>97.5 ТЭРБУМ ТӨГРӨГ</p> | Үүрэн холбооны сүлжээ нэвтрүүлэх | 4.3 ТЭРБУМ ТӨГРӨГ |
| | | Цахим систем | 11.4 ТЭРБУМ ТӨГРӨГ |
| | | Хатуу дэд бүтэц | 52.2 ТЭРБУМ ТӨГРӨГ |
| | | Гадаад зээл, тусламж | 29.6 ТЭРБУМ ТӨГРӨГ |

6. Бусад салбарт нэн шаардлагатай хөрөнгө оруулалтыг санхүүжүүлнэ.

Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх, салбарт нэн тэргүүний болон тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх төсөл, арга хэмжээг бэлэн байдлаар эрэмбэлэн төсвийн төсөлд тусгалаа.

Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын Конвенцын 17 дугаар бага хурлыг 2026 онд Монгол Улсад зохион байгуулахтай холбоотойгоор хурлын бэлтгэл ажлыг хангах, олон улсын зочид төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах, тав тухтай орчныг бүрдүүлэх зэрэгт зориулж 217.1 тэрбум төгрөгийг санхүүжүүлнэ.

Зураг 37. COP17 бүтээн байгуулалт




Шинжлэх ухаан: Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор нь үндсэн 7 хэсэг барилга, байгууламжаас бүрдэж байгаа бөгөөд олон улсын стандартад нийцсэн нээлттэй, салбар дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториуд, жишиг үйлдвэрлэлийн цех, оффис, номын сан, хурлын заал, спорт заал, олдвор, дээж хадгалах агуулах, палеонтологи, археологи, одон орон судлалын музей байрлах юм.

Түүнчлэн ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд болон бусад их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын 3300 орчим эрдэмтэн судлаач, албан хаагчид ажиллах хүчин чадалтай шинжлэх ухаан, технологи, инновац, танин мэдэхүйн төв болох бөгөөд барилгыг 2026 онд бүрэн ашиглалтад оруулахад шаардагдах 40.4 тэрбум төгрөг болон лабораториудын эхний ээлжид шаардлагатай тоног төхөөрөмжид 32.5 тэрбум төгрөгийг тусгалаа.

Зам, тээврийн салбарт: Шинэ сэргэлтийн бодлого, Бүсчилсэн хөгжлийн зорилтын хүрээнд хилийн боомтыг холбох авто зам, аялал жуулчлалын чиглэлийн авто зам барих, авто замын засвар арчлалтын хугацааг уртасгах, чанарыг сайжруулах, хөрөнгийн эх үүсвэрийг үе шаттай нэмэгдүүлэх, олон улс болон улсын чанартай нийт 500 орчим километр авто замд их засвар, шинэчлэлт, ээлжит засварын ажил хийгдэнэ.

Зураг 38. Зам тээврийн салбарын хөрөнгө оруулалт

Зам, тээврийн салбарт шинээр төлөвлөсөн төслүүд:



Инженерийн дэд бүтэц: Хотын хүртээмжтэй байдал, инженерийн дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлэх замаар амьдралын чанарыг сайжруулах, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй, өндөр чанартай болгох, иргэдийн аюулгүй байдал, амьдралын таатай орчныг бүрдүүлэх, түгжрэлийг бууруулах, дагуул хотуудын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, бэлтгэл ажлыг хангах чиглэлээр хөрөнгө оруулалтын төслүүдийг үргэлжлүүлнэ. (220.7 тэрбум төгрөг)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах чиглэлээр буюу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэг болон Өнөр бүл-Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төрөлжсөн асрамжийн газрыг барьж дуусгах, тоног төхөөрөмжөөр хангах, мөн гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд Улаанбаатар, Архангай, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Завхан, Ховд, Хөвсгөл аймгуудад Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн

төвийн барилга барьж ашиглалтад оруулснаар 30.0 мянган иргэнд тогтмол дэмжлэг үзүүлэх, 210 ажлын байрыг орон нутагт хангах боломжтой болно. (26.4 тэрбум төгрөг)

Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.6-д төсвөөс санхүүжих бүх байгууллагын төсвийг аль нэг төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд хамруулсан байх гэж заасны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нэгдсэн дүнг төсвийн ерөнхийлөн захирагчаар нь харвал:

Хүснэгт 22. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, салбараар

| Төсвийн ерөнхийлөн захирагч | Төслийн тоо | Төсөвт өртөг | Санхүүжих дүн |
|---|-------------|--------------------|--------------------|
| Монгол Улсын Ерөнхийлөгч | 1 | 500.0 | 500.0 |
| Монгол Улсын Их Хурлын дарга | 1 | 3,637.5 | 3,637.5 |
| Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд | 3 | 227,036.1 | 112,905.3 |
| Монгол Улсын Шадар сайд | 7 | 70,925.4 | 50,072.6 |
| Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга | 12 | 72,366.8 | 26,146.5 |
| Гадаад харилцааны сайд | 1 | 19,867.9 | 19,867.9 |
| Сангийн сайд | 5 | 576,534.7 | 151,699.7 |
| Хууль зүй, дотоод хэргийн сайд | 30 | 189,481.6 | 93,115.1 |
| Батлан хамгаалахын сайд | 8 | 115,083.8 | 67,849.4 |
| Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд | 14 | 257,206.8 | 249,643.6 |
| Боловсролын сайд | 198 | 1,355,322.4 | 448,020.6 |
| Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | 17 | 101,764.6 | 37,443.4 |
| Зам, тээврийн сайд | 69 | 3,342,637.3 | 902,813.5 |
| Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд | 62 | 514,852.9 | 169,418.3 |
| Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд | 44 | 772,072.7 | 220,728.5 |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд | 14 | 104,778.5 | 47,830.3 |
| Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд | 6 | 39,754.5 | 26,310.2 |
| Эрчим хүчний сайд | 32 | 974,356.1 | 322,422.8 |
| Эрүүл мэндийн сайд | 37 | 653,182.0 | 211,643.9 |
| Авлигатай тэмцэх газрын дарга | 2 | 1,697.9 | 1,697.9 |
| Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч | 2 | 3,919.8 | 3,358.0 |
| Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга | 8 | 124,885.9 | 60,525.8 |
| Улсын Ерөнхий Прокурор | 3 | 65,364.4 | 24,220.9 |
| Монгол Улсын Ерөнхий аудитор | 1 | 2,494.7 | 2,494.7 |
| Сонгуулийн ерөнхий хорооны дарга | 1 | 41,720.4 | 12,516.1 |
| Төрийн албаны зөвлөлийн дарга | 1 | 435.1 | 435.1 |
| НИЙТ | 579 | 9,631,879.8 | 3,267,317.6 |

Төсөлд тусгасан төслүүдийг эдийн засгийн ангиллаар нь авч үзвэл дийлэнх нь буюу 78 хувь нь барилга байгууламж, дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслүүд бол үлдсэн 22 хувь нь их засвар, тоног төхөөрөмж, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах, цахим систем боловсруулах зориулалт бүхий төсөл, арга хэмжээ байна.

Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын 27.6 хувь нь зам тээврийн салбарт буюу 902.8 тэрбум төгрөг, 13.7 хувь нь боловсролын салбарт буюу 448.0 тэрбум төгрөг, 9.8 хувь нь эрчим хүчний салбарт буюу 322.4 тэрбум төгрөг, 6.5 хувь нь эрүүл мэндийн салбарт буюу 211.6 тэрбум төгрөг, 5.2 хувь нь соёл, спорт, аялал жуулчлалын салбарт буюу 169.4 тэрбум төгрөг санхүүжих бөгөөд нийт төслүүдийн 60 хувь нь 2026 онд, 24 хувь нь 2027 онд, 16 хувь нь 2028 онд хэрэгжиж тус тус дуусах буюу ашиглалтад орохоор байна.

Хүснэгт 23. Төслийн төрөл, ангилал (сая төгрөг)

| Төслийн төрөл | Төслийн тоо | Төсөвт өртөг | Санхүүжих дүн |
|------------------------------|-------------|--------------------|--------------------|
| Зам, гүүр | 60 | 3,071,144.7 | 818,627.6 |
| Цахилгаан, дулаан хангамж | 33 | 964,251.1 | 310,941.5 |
| Сургууль | 76 | 812,146.4 | 221,914.3 |
| Инженерийн дэд бүтэц | 36 | 706,075.9 | 216,055.6 |
| Эмнэлэг | 25 | 587,255.2 | 136,509.2 |
| Соёлын төв, музей, театр | 33 | 322,332.0 | 108,241.6 |
| Цэцэрлэг | 53 | 198,293.5 | 81,314.0 |
| Спорт заал, цогцолбор, ордон | 37 | 200,779.1 | 57,040.9 |
| Дотуур байр | 32 | 158,528.4 | 53,200.8 |
| ТЭЗҮ, зураг төсөв | 5 | 63,609.5 | 45,616.8 |
| Их засвар, тоног төхөөрөмж | 81 | 854,899.8 | 604,029.3 |
| Бусад | 108 | 1,692,564.2 | 613,826.0 |
| Нийт | 579 | 9,631,879.8 | 3,267,317.6 |

Үр дүн, үр нөлөө: 2026 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 3,267.3 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэх бөгөөд байна. Энэхүү хөрөнгө оруулалт нь дотоодын нийт бүтээгдэхүүний 5.8 хувийг бүрдүүлэх эдийн засгийн ач холбогдолтой бөгөөд макро эдийн засгийн өсөлтийг дэмжих, үйлдвэрлэл үйлчилгээний хэмжээг нэмэгдүүлэх, хэрэглээ, эргэлтийн хөрөнгийг идэвхжүүлэх чухал нөлөө үзүүлнэ.

Мөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх явцад зөвхөн барилга угсралт, дэд бүтцийн бүтээн байгуулалтын салбарт төдийгүй түүнтэй холбоотой ханган нийлүүлэлт, үйлчилгээний салбарт ч шууд болон шууд бусаар нийт 109.6 мянган ажлын байр шинээр бий болох тооцоо гарч байна. Ингэснээр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, өрхийн орлогыг өсгөх, улмаар нийгмийн тогтвортой байдлыг хангахад эерэг үр нөлөө үзүүлнэ.

Нөлөөллийг хугацааны хувьд авч үзвэл:

Дүнд хугацаанд. Нийгмийн үйлчилгээний хүртээмж сайжирч, сургуулийн болон цэцэрлэгийн багтаамж нэмэгдсэнээр боловсролын чанар дээшлэх, эрүүл мэндийн байгууллагын хүчин чадал өргөжсөнөөр иргэд чанартай эмчилгээ, үйлчилгээ авах боломж нэмэгдэх ач холбогдолтой.

Үүний зэрэгцээ зам, цахилгаан, дулаан зэрэг суурь дэд бүтэц сайжирснаар хувийн хэвшлийн бизнесийн орчин илүү таатай болж, шинэ үйлдвэр, үйлчилгээ шинээр байгуулах нөхцөл бүрдэнэ. Мөн хөдөө орон нутагт ажлын байр, орлогын эх үүсвэр бий болохын хэрээр нийслэлийн хэт төвлөрөл аажмаар буурч, бүс нутгийн хөгжлийн тэнцвэр хангагдана.

Урт хугацаанд. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эдийн засагт үзүүлэх нөлөө нь дунд хугацаанд тогтворжиж, урт хугацаандаа дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг 1–2 хувиар нэмэгдүүлэх боломжтой. Энэ нь макро эдийн засгийн тогтвортой өсөлтийн чухал эх үүсвэр болж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд түлхэц өгнө.

Нөгөө талаар боловсрол, эрүүл мэндийн чанартай үйлчилгээний хүртээмж нэмэгдсэнээр хүний хөгжил дэмжигдэж, иргэдийн амьдралын чанар дээшлэхийн зэрэгцээ шинэ технологи, инновацыг нутагшуулах нөхцөл бүрдэнэ. Ингэснээр хөдөлмөрийн зах зээлд шинэ ур чадвар төлөвшиж, технологийн дэвшлийг үр өгөөжтэй ашиглах боломж нэмэгдэнэ.

Мөн төрийн үйлчилгээний хүртээмж, чанар шинэчлэгдэж, цахим засаглал, дата төв, төрийн үйлчилгээний дижитал шинэчлэл хийгдвэл иргэдэд хүрэх үйлчилгээний ил тод байдал сайжирна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үялдаа: Монгол Улсын 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд эдийн засаг, нийгэм, дэд бүтэц болон байгаль орчин, эрүүл мэнд, боловсрол зэрэг салбар бүрд хүрэх тодорхой зорилтууд, хэмжигдэхүйц үр дүн, зорилтот түвшин тодорхойлсон байна.

Эдгээр зорилт, үр дүнг бодитоор хэрэгжүүлэхийн тулд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн бүх төсөл, арга хэмжээг хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулсан байх шаардлагыг тавьж цахим системээр хэрэгжүүлэв. Ийнхүү цахим системд суурилсан, хөгжлийн жилийн төлөвлөгөөнд бүрэн нийцүүлсэн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үр дүнд хөгжлийн жилийн төлөвлөгөөний 60 хувь буюу нийт 76-н төсөл, арга хэмжээ төсвийн тухай хуулийн төсөлд туссан саналтай уялдав.

Түүнчлэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын хүрээнд хүний хөгжлийг дэмжих чиглэлд боловсрол, эрүүл мэндийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд нийт 252 төсөл арга хэмжээнд 705.1 тэрбум төгрөг, эрчим хүч, дэд бүтцийг сайжруулах замаар хувийн хэвшлийг дэмжих чиглэлд нийт 145 төсөл, арга хэмжээнд 1.4 их наяд төгрөг, бусад салбарт 1.1 их наяд төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгагдаагүй төсөл, арга хэмжээний хувьд төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн зарчмын дагуу хэрэгжилтийн бэлэн байдал хангагдаагүй, "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох журам болон аргачлал"-ын дагуу үнэлгээгээр хангалттай оноо аваагүй, мөн иргэд, олон нийт, аймаг, нийслэл, төсвийн ерөнхийлөн захирагчдаас санал ирээгүй төсөл, арга хэмжээнүүд болно.

"Засгийн газарт чиглэл өгөх тухай" Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын хэрэгжилт

Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын 1.3 дах хэсэгт “улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нь нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт магадлал хийх, аудитын дүгнэлт гаргуулах ажлыг

холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, саналаа 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах” гэж заасан.

Уг тогтоолын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчдаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй 315 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэх саналыг ирүүлсэн.

Мөн төслүүдийн хувьд тарифт цалин, материалын үнийн өсөлт, анх төлөвлөсөн зураг төсвийн алдаатай байдал, захиалагч, гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр төсөвт өртөг нэмэгдэж байна. Тухайлбал, 2025 онд эхэлсэн авто замын томоохон төслүүдийн өртөг 634.7 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт шаардлагатай байгаа талаар Зам, тээврийн яамнаас судалгаа ирүүлсэн байна.

Дээрх төслүүдээс магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан 249 төсөл, арга хэмжээний 644.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий мэдээллийг 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн Монгол Улсын Ерөнхий аудиторт үндэслэлтэй эсэхийг нягтлан шалгуулахаар холбогдох мэдээллийг 8 удаагийн албан бичгээр хүргүүлсэн.

Үндэсний аудитын газраас эдгээр төслүүдийн магадлалын ерөнхий дүгнэлт үндэслэлтэй эсэхэд хяналт шалгалт хийж 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 6 удаагийн албан бичгээр 100 төслийн 194.5 тэрбум төгрөгийг хянаж ирүүлснийг төсвийн төсөлд тусгаад байна.

Харин “Тарифт цалингийн жишиг шинэчлэн батлах тухай” 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 95 дугаар тушаалын 3 дахь заалтын дагуу 69 /улсын төсвийн хөрөнгө оруулалтаар-59, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар-7, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар-3/ төсөл, арга хэмжээнд тарифт цалингийн өөрчлөлтийг тооцож, магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан ирүүлснийг Монгол Улсын Ерөнхий аудиторт хүргүүлсэн.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар 04-ний өдрийн 05 дугаар тогтоолоор Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийг баталсан бөгөөд тарифт цалингийн өөрчлөлтийг тооцсон төсөвт өртгийн нэмэгдэлд аудит хийх боломжгүй талаар 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 1840 тоот албан бичгээр ирүүлсэн тул төсвийн төсөлд тусгаагүй болно.

Түүнчлэн, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх гурван төсөл тутмын нэгд нь нэмэлт санхүүжилт үүсэж, зарим төслүүд төлөвлөсөн хугацаанаас нэгээс дээш жилээр хойшилж ашиглалтад орж байна. Тухайлбал, зөвхөн сүүлийн 2 жил буюу 2023 онд барилгын материалын үнийн өсөлтөд 303.4 тэрбум төгрөг, 2024 онд аудитын дүгнэлтээр 660.6 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон байдаг. Улмаар төсөвт нэмэлт ачаалал үүсгэж, барилга байгууламж, дэд бүтэц хугацаандаа ашиглалтад ороогүйн улмаас боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээний хүртээмж саарч, төсвийн хөрөнгө оруулалтын өгөөж буурах сөрөг үр дагаварт хүргэж байх тул барилгын салбарын хууль тогтоомж, норм, дүрэм стандартыг зайлшгүй шинэчлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Иймд 2026 оны төсвийн төсөлд нэг маяг, жишиг зураг төсвөөр шинэ төсөл, арга хэмжээ төлөвлөгөөгүй, харин сүүлийн 2 жилд батлагдсан бүрэн зураг төсөвтэй төслүүдийг төлөвлөсөн, цаашид ч энэ шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлнэ.

Мөн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага талаас нь зохицуулах бодлогын хүрээнд Сангийн яамнаас “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль”-ийн төслийг боловсруулан, УИХ-д өргөн барихаар бэлтгэж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын хэмнэлтийн арга хэмжээ: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь хэсэгт заасны дагуу төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх зохицуулалтын хүрээнд 132 төслийн төсөвт өртгийг 58.7 тэрбум төгрөгөөр бууруулснаар 2026 онд санхүүжих дүнд 11.2 тэрбум төгрөгийн хэмнэлт бий болсон байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр хэрэгжүүлж буй шинэчлэлийн арга хэмжээ:

Нэг. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийг боловсруулж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын асуудлыг зохицуулсан бие даасан хууль байхгүй бөгөөд суурь харилцааг Төсвийн тухай хуулиар голчлон зохицуулж, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

Түүнчлэн, төслийн төлөвлөлт, төслийн хэрэгжилт, санхүүжилт, гүйцэтгэл, хяналт, тайлагналттай холбоотой зарчмын шинжтэй чухал асуудлууд Засгийн газар, Сангийн сайдын баталсан журам, аргачлалуудаар зохицуулагдаж буй нь төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын бодлого, зохицуулалт нэгдмэл бус, хууль, эрх зүйн орчин хангалтгүй байгааг илтгэх бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай болгох, эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор Төсвийн тухай хуулийн төсвийн хөрөнгө оруулалтад хамаарах зүйл, хэсэг, заалтад давхардсан тоогоор 44 удаа нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 161.5.4-г заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай багц хуулийн төсөлд өгсөн дүгнэлтдээ “Хөрөнгө оруулалтын төслийг сонгох, эрэмбэлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай” гэж, “Хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц хууль эрх зүйн орчин хэрэгтэй” гэж онцлон тэмдэглэсэн бөгөөд энэ хүрээнд “... хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинээр боловсруулан гаргах шаардлагатай” гэж, мөн “Төсвийн хөрөнгө оруулалтыг сонгох, эрэмбэлэх, үр ашгийг тооцоход журмын зохицуулалт хангалтгүй бөгөөд хөрөнгө оруулалтын эрх зүйн цогц орчин бий болгохын тулд бусад орнуудын сайн туршлагын дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинээр боловсруулах шаардлагатай” болохыг чухалчлан зөвлөсөн. Үүнээс гадна, “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Ерөнхий сайдын 2025 оны 02 тоот албан даалгаврын 3.5-д “Төсвийн хөрөнгө оруулалт, томоохон төсөл, хөтөлбөрийн

санхүүжилтийг шийдвэрлэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хуулийн төсөл боловсруулж, Улсын их хуралд өргөн мэдүүлэхийг” даалгасан байна.

Энэ хүрээнд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 204 дүгээр тушаалаар байгуулсан бөгөөд хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны тайлан, олон улсын харьцуулсан судалгааны тайлан болон холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж хуулийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр батлаад байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан анхдагч хуулийн төслийн төрлөөр боловсруулахаар төлөвлөж 8 бүлэг бүхий гадаадын зээл, тусламж, орон нутгийн хөгжлийн сангийн бодлого, зохицуулалтыг сайжруулах, төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд эдгээрийг давхардалгүй, харилцан уялдаатай, үр ашигтай, оновчтой төлөвлөж, хуваарилах, ач холбогдлын эрэмбэ, үнэлгээнд үндэслэдэг байх, шаардлагагүй тохиолдолд зээлийн хөрөнгө оруулалт авахгүй байх, төсөл, арга хэмжээг үр ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн байгууллагууд болон бусад оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, санхүүжилт, зарцуулалт, бүртгэл, тайлагналт, ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхийг зорьж байна.


Хоёр. Төсвийн хөрөнгө оруулалтын цахим шинэчлэлийг хэрэгжүүлж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтыг ил тод, үр ашигтай, бүрэн цахимд шилжүүлэх зорилгоор 2019 оноос цахим шинэчлэлийг эхлүүлж, Төсвийн Хөрөнгө Оруулалтын Удирдлагын Цахим Систем /PIMIS/ болох “publicinvestment.gov.mn” веб сайт болон “publicinvestment” гар утасны аппликэйшн хөгжүүлэн, холбогдох хууль, тогтоол, журам, аргачлалын дагуу төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, тайлагналт, болон өмчийн бүртгэл, ашиглалт зэрэг бүхий л үйл ажиллагааг цахим системээр хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулсаар байна.



- Цахим шинэчлэлийн хүрээнд улсын төсөв, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, орон нутгийн төсвийн болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, гадаадын зээл, тусламжийн үйл ажиллагааны эхний үе шатыг цахим системд нэгтгэв.
- Их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилсан, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг оновчтой, үр ашигтай хэрэгжүүлэхэд чиглэсэн дэд системийг хөгжүүлэв. Монгол улсын газрын зурагт суурилсан уг систем нь улсын болон бүс нутгийн хэмжээнд шаардлагатай хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг тооцоолон, санал болгох, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилготой. Их өгөгдөл бүрдүүлэлт, мэдээллийн үнэн зөв, давхардалгүй байдлыг хангах үүднээс төрийн 14-н байгууллагын 24-н системтэй холбогдсон, realtime мэдээлэл солилцооны платформ хөгжүүлэв.
- Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үйл ажиллагаанд хүний оролцоог багасгах зорилтын хүрээнд 2026 онд боловсролын салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилан тооцоолов.

Зураг 40. Төсвийн хөрөнгө оруулалтын цахим системийн цар хүрээ



Цаашид, их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилсан, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх дэд системийг бүх салбарт үе шаттайгаар нэвтрүүлэх, мөн Монгол улсын хэмжээнд хөрөнгө оруулалтын бүх эх үүсвэрийг нэгтгэж, хөрөнгө оруулалтын их өгөгдөлд суурилсан мэдээллийн сан үүсгэж, уялдаа холбоотой, үр ашигтай хөрөнгө оруулалтын нэгдсэн платформ хөгжүүлэх зорилго тавин ажиллаж байна.

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ:

1. Төсвийн хөрөнгө оруулалтыг эрчим хүчний хэмнэлттэй, ногоон болон тогтвортой хөгжлийн шаардлагад нийцүүлэх;
2. Хөрөнгө оруулалтын бодлогод уур амьсгалын өөрчлөлт болон гамшгийн эрсдэлийн удирдлагын зарчмыг нэвтрүүлж, хэрэгжилтийг хангах;
3. Нийгмийн тэгш байдлыг хангах үүднээс жендерийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах;
4. Цахим шинэчлэлийг үргэлжлүүлэн хөгжүүлж, их өгөгдөл болон хиймэл оюун ухаанд суурилсан, хөрөнгө оруулалтын бүх эх үүсвэрийг нэгтгэсэн үндэсний нэгдсэн мэдээллийн платформ болгон өргөжүүлэх.

4.3.2. Гадаад зээл, тусламж

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд гадаадын зээл, тусламжийн санхүүжилт нь чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр хязгаарлагдмал нөхцөлд Засгийн газрын гадаад зээл, тусламж нь томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх санхүүгийн гол эх үүсвэр болж, хөгжлийн

бодлогын баримт бичгийн зорилтыг хангах, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж ирсэн.

Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газар 1991–2025 оны хугацаанд хөгжлийн түнш орнууд болон олон улсын байгууллагуудаас нийт **27.9 их наяд төгрөг**ийн гадаад зээл, тусламж авч, шаардлагатай төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. Энэ хугацаанд **нийт 392 төсөл** хэрэгжсэн бөгөөд тэдгээрээс **300 төсөл амжилттай хэрэгжиж дууссан** бол **92 төсөл 2026 онд үргэлжлэн хэрэгжинэ**. Үүнээс гадна **6 төсөл хэлэлцээрийн шатанд** байгаа бөгөөд **нийт 98 төслийг 2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна**.

2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 98 төсөл, хөтөлбөр нь боловсрол, эрүүл мэнд, орон сууц, дэд бүтэц, тээвэр, нийгмийн хамгаалал зэрэг олон салбарт хэрэгжиж, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд бодит үр нөлөө үзүүлнэ.

Иймд гадаад зээл, тусламж нь Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай, үр өгөөжтэй, стратегийн ач холбогдолтой бодлого, санхүүгийн хэрэгсэл юм.

ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН БОДЛОГО, ЗАРЧИМ

Нэг. Төслүүдийг хугацаанд нь хэрэгжүүлэх. 2026 онд хугацаа нь дуусах гэрээ, хэлэлцээр бүхий төслүүдийн санхүүжилтийг бүрэн тусгаж, төлөвлөсөн хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх бодлого барьж, цаашид төслийн хугацааг сунгахгүй, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахгүй байх зарчим баримтална.

Хоёр. Эдийн засаг, нийгмийн ач холбогдлоор эрэмбэлэх. Төсвийн зардлын хязгаарлалттай уялдуулж гадаад зээл, тусламжийн төсөл, хөтөлбөрүүдийг эдийн засаг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлнэ. Үүнд:

- Эдийн засгийн бодит өсөлтийг дэмжих, бүтээмж, экспортыг нэмэгдүүлэх төслүүдийг тэргүүн ээлжид санхүүжүүлэх,
- Иргэдийн амьдралын чанар, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах төсөл, хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх,
- Бүс нутгийн хөгжил, байгаль орчны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төслүүдийг оновчтой эрэмбэлж, хэрэгжүүлэх.

Ингэснээр хязгаарлагдмал төсвийн хүрээнд хамгийн өндөр үр өгөөжтэй, нийгэм-эдийн засгийн ач холбогдол бүхий төслүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Гурав. Хэрэгжилтийг эрчимжүүлэх. Хэрэгжилт нь удааширсан зээл, тусламжийн төслүүдийн гүйцэтгэлийг богино хугацаанд сайжруулах арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд хэрэгжилтийн төлөвлөгөөг дахин оновчлох зохицуулалт хийнэ.

Дөрөв. Урсгал зардлыг оновчтой удирдах. Гадаад зээл, тусламжийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор төсөл хэрэгжүүлэх нэгжийн урсгал зардлыг оновчтой түвшинд барих бодлого баримтална. Зөвлөх үйлчилгээ, захиргааны зардал зэрэг урсгал зардлыг бууруулах, зардлын бүтцэд үр ашгийн тооцоо хийх, шаардлагагүй зардлыг хасах замаар төсвийн хэмнэлт, бүтээмжийг сайжруулна.

Тав. Үүрэг, хариуцлагын уялдаа холбоог сайжруулах. Төслийн хэрэгжилтэд оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, зохион байгуулалтын давхардлыг арилгах, шийдвэр гаргалтын шат дамжлагыг бууруулж, оновчтой болгох замаар төслүүдийн хэрэгжилтийн үр дүнг сайжруулна.

ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулахдаа гадаад зээл, тусламжийн дээрх бодлого, зарчмыг удирдлага болгон дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

Нэгдүгээрт, Улсын Их Хурал (УИХ)-аар соёрхон батлагдсан, Засгийн газраас хэрэгжүүлж буй гадаад зээл, тусламжийн төслийн хүрээнд, Төсвийн ерөнхийлөн захирагчдаас нийт 719 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5.8 их наяд төгрөгийн санал ирүүлснийг УИХ-ын 2024 оны 54, 81 дүгээр тогтоолын дагуу шаардлагагүй шинэ худалдан авалт, зөвлөх үйлчилгээний санхүүжилтийг хойшлуулж, хэмнэлтийн зарчмыг баримтлан нийт 2.9 их наяд төгрөгийн 214 бараа, ажил, зөвлөх үйлчилгээнд зохицуулалт хийж, төслүүдийг ач холбогдол, үр ашгаар нь эрэмбэлсэн.

Хоёрдугаарт, Засгийн газрын 2025 оны **24 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд,** гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслийн **нэгжүүдийн чиг үүргийн давхардлыг арилгах,** ажлын ачааллыг нягтруулах, **бүтээмжийг дээшлүүлэх** зорилгоор төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төслийн нэгжүүдийг **нэгтгэн, нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж** болгон өөрчлөн байгуулах ажлыг хийж байна.

Гуравдугаарт, Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн удирдлагыг бүрэн цахимжуулах зорилгоор **Төсвийн Хөрөнгө Оруулалтын Удирдлагын Цахим Систем (PIMIS)-д** холбогдох үйл ажиллагааг үе шаттайгаар шилжүүлж байна. Энэхүү шилжилт нь зөвхөн техник шинэчлэл бус, төсвийн хөрөнгө оруулалтын олон эх үүсвэрийг уялдуулан удирдах, ил тод байдлыг нэмэгдүүлэх нэн чухал алхам юм.

Дээрх зохицуулалтыг хийснээр 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд гадаад зээл, тусламжийн ашиглалтыг өмнөх оныхтой адил хэмжээнд буюу гадаад зээлийн 74 төслийн 1,542.4 тэрбум төгрөг, тусламжийн 24 төслийн 365.0 тэрбум төгрөг, нийт 1,907.4 тэрбум төгрөгийн зээл, тусламжийн ашиглалтыг тусгалаа.

Төсөөлөл: Дээрх бодлогын хүрээнд 2026 онд гадаад зээл, тусламжийн ашиглалт нь ДНБ-ний 4.3 хувь орчим байхаар төлөвлөөд байна.

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн 2026 оны нийт ашиглалтын 51 хувийг олон улсын байгууллага, 49 хувийг хөгжлийн түнш улс орнуудын эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд өмнөх жилүүдийн адил Азийн хөгжлийн банк (АХБ)-ны санхүүжилт хамгийн өндөр хувь эзэлж, нийт зээл, тусламжийн ашиглалтад 29 хувийг бүрдүүлж байгаа бол Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) 13 хувь, Дэлхийн банк (ДБ) 8 хувь байна. Хөгжлийн түнш орнуудын дунд Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын санхүүжилт нийт зээл, тусламжийн ашиглалтын 13 хувийг эзэлж, Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, 1008 айлын орон сууцны хороолол зэрэг томоохон төслүүдийг санхүүжүүлнэ. Түүнчлэн, Бүгд Найрамдах Энэтхэг Улс (БНЭУ)-ын зээлээр хэрэгжүүлж буй Газрын тосны үйлдвэр барих төсөл нийт зээл, тусламжийн ашиглалтын 11 хувийг, Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын тусламжаар хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл нь 5 хувийг тус тус эзлэхээр байна.

Хүснэгт 24. Гадаад зээл, тусламжийн төсөл хөтөлбөр, хөгжлийн түншиэр (тэрбум төгрөг)

| Д/д | Хөгжлийн түнш | Төслийн тоо | 2026 оны төсвийн төсөл | Хувь |
|-------------|--|-------------|------------------------|-------------|
| 1 | Азийн Хөгжлийн Банк | 47 | 556.76 | 29.2% |
| 2 | Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банк | 12 | 254.35 | 13.3% |
| 3 | Бүгд Найрамдах Хятад Ард Улс | 6 | 251.78 | 13.2% |
| 4 | Бүгд Найрамдах Энэтхэг Улс | 2 | 228.99 | 12.0% |
| 5 | Бүгд Найрамдах Солонгос Улс | 6 | 163.28 | 8.6% |
| 6 | Дэлхийн Банк | 10 | 147.84 | 7.8% |
| 7 | Америкийн Нэгдсэн Улс | 1 | 87.58 | 4.6% |
| 8 | Холбооны Бүгд Найрамдах Герман Улс | 3 | 75.07 | 3.9% |
| 9 | Бүгд Найрамдах Франц Улс | 3 | 58.38 | 3.1% |
| 10 | Бүгд Найрамдах Польш Улс | 2 | 52.09 | 2.7% |
| 11 | Европын Хөрөнгө Оруулалтын банк | 4 | 22.53 | 1.2% |
| 12 | Япон Улс | 1 | 6.47 | 0.3% |
| 13 | Люксембүргийн Их Гүнт Улс | 1 | 2.30 | 0.1% |
| НИЙТ | | 98 | 1,907.4 | 100% |

Засгийн газрын 2026 оны гадаад зээл, тусламжийн ашиглалтыг бүтцийн хувьд авч үзвэл 1,514.4 тэрбум төгрөг буюу 79 хувийг хөрөнгө оруулалтын зардалд, 272.7 тэрбум төгрөг буюу 14 хувийг дамжуулан зээлдүүлэх зардалд ашиглахаар тус тус төлөвлөсөн бол 120.4 тэрбум төгрөг буюу 6 хувийг урсгал зардлын санхүүжилтэд төлөвлөсөн нь 2025 оныхтой харьцуулахад урсгал зардал хоёр дахин буурсан үзүүлэлт юм.

ХЭРЭГЖИЖ БУЙ ТОМООХОН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 2026 онд **дэд бүтцийн салбарт** хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, хөтөлбөрүүд нь эдийн засгийн суурь нөхцөлийг бэхжүүлэх, эрчим хүчний найдвартай хангамжийг бүрдүүлэх, тээвэр, логикийн чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна. Төслүүдийн хэрэгжилт нь үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагааг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах, иргэдийн амьдрах орчныг сайжруулахад бодит хувь нэмэр оруулах стратегийн ач холбогдолтой. Тухайлбал:

1. ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАРИХ ТӨСӨЛ

Хүснэгт 25. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн мэдээлэл







| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | | | |
|---|---|---|-----------------------------------|-----------------------------------|--------------|
|  | АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ |  | БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС | | |
| ЭХЛЭХ | 2017 | ДУУСАХ | 2028 | | |
|  | | | | | |
|  | ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: Дорноговь, Алтанширээ | | | | |
|  | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: | | USD 1,700.0 | | |
| | БНЭУ-ын 1,700.0 сая ам.долларын зээл | | | | |
|  | НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: | | USD 300.2 (18%) | | |
| Зээлийн хүү | 0.28% | Зээлийн хугацаа | 20 жил | Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 5 жил |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | 2026 ОНД САНХҮҮЖИХ | ТӨСЛИЙН ЯВЦ | | | |
| 4,983,283.6 сая ₮ | 207,745.3 сая ₮ | 29% | | | |

Газрын тос боловсруулах үйлдвэр нь жилд 1.5 сая тонн түүхий тос боловсруулах хүчин чадалтай бөгөөд дотоодын газрын тосны бүтээгдэхүүний нийт хэрэглээний 55 орчим хувийг хангана. Үйлдвэр ашиглалтад орсноор Евро-4 болон Евро-5 стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэх бөгөөд 339.0 мянган тонн автобензин,

824.0 мянган тонн дизель түлш, 80.0 мянган тонн онгоцны түлш, 43.0 мянган тонн шингэрүүлсэн шатдаг хий болон бусад дагалдах бүтээгдэхүүн үүнд багтаж байна. Эдгээр бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд нийлүүлснээр жил бүр дунджаар 1.0 тэрбум ам.долларын импортын валютын урсгалыг дотооддоо үлдээснээр Монгол Улсын төлбөрийн тэнцэл, валютын нөөцөд эерэг нөлөө үзүүлэх юм.

2. ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ БАРИХ ТӨСӨЛ







Хүснэгт 26. Эрдэнэбүрэнгийн УЦС барих төслийн мэдээлэл

| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | | | |
|---|---|---|-------------------------------------|--|--------------|
|  | ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ |  | БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС | | |
| ЭХЛЭХ | 2024 | ДУУСАХ | 2030 | | |
|  | | | | | |
|  | ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: Ховд, Эрдэнэбүрэн | | | | |
|  | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: | | USD 271.4 | | |
| | БНХАУ-ын 253.1 сая ам.долларын зээл, МУЗГ хариуцах 18.3 сая ам.доллар | | | | |
|  | НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: | | USD 79.9 (30%) | | |
| Зээлийн хүү | 2.0% | Зээлийн хугацаа | 20 жил | Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 7 жил |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | | 2026 ОНД САНХҮҮЖИХ | | ТӨСЛИЙН ЯВЦ | |
| 635,618.5 сая ₮ | | 99,375.8 сая ₮ | | 18% | |

Баруун бүсийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах зорилготой энэхүү төсөл нь тогтвортой, сэргээгдэх эх үүсвэрээр хангах боломжийг бүрдүүлж, импортын цахилгаан эрчим хүчний хамаарлаас гарах стратегийн ач холбогдолтой юм. Төсөл хэрэгжсэнээр жил бүр ОХУ-аас авч буй эрчим хүчний төлбөрт төлдөг 17.5 тэрбум төгрөгийг дотооддоо үлдээх боломжтой болж, эрчим хүчний салбарын эдийн засгийн үр ашиг нэмэгдэнэ. Мөн оргил ачаалал болон аваарын үед горим тохируулга хийх боломжтой болно. Ховд гол дээр 1,140 тэрбум м³ багтаамжтай хиймэл нуур бий болж, байгаль орчны тогтвортой байдалд онцгой ач холбогдолтой. Уур амьсгалын өөрчлөлт, эрс тэс цаг агаарын нөлөөгөөр ширгэж буй гол, горхийг хамгаалахаас гадна үерийн эрсдэлээс сэргийлэх, усыг нөөцлөн оновчтой ашиглах боломжийг бүрдүүлнэ.

3. ЧОЙР-САЙНШАНДЫН 220 КВТ-ЫН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ, ДЭД СТАНЦ БАРИХ ТӨСӨЛ

Хүснэгт 27. Чойр-сайншандын 220 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийн мэдээлэл

| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | | | |
|---|--|---|--|-----------------------------------|--------------|
|  | ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ |  | ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНК | | |
| ЭХЛЭХ | 2022 | ДУУСАХ | 2027 | | |
|  | | | | | |
|  | ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: Говьсүмбэр, Дорноговь | | | | |
|  | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: | | USD 77.9 | | |
| | ЕСБХБ-ны 62.8 сая ам.долларын зээл, 13.0 сая ам.долларын тусламж | | | | |
|  | НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: | | USD 0.0 (0%) | | |
| Зээлийн хүү | SOFR+1 | Зээлийн хугацаа | 18 жил | Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 4 жил |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | | 2026 ОНД САНХҮҮЖИХ | | ТӨСЛИЙН ЯВЦ | |
| 243,966.8 сая ₮ | | 80,346.0 сая ₮ | | 5% | |

Оюутолгой уурхайг цахилгаан эрчим хүчээр найдвартай хангахад чухал үүрэгтэй бөгөөд жил бүр 100-120 сая ам.долларын Оюутолгойн төлбөрийн мөнгөн урсгал, валютыг дотооддоо үлдээх боломжтой болно. Нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалтыг хэмжээг жилд 125,793.66 тн-оор бууруулна. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээс үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг Төвийн болон Өмнөд бүсийн цахилгаан эрчим хүчний сүлжээнд дамжуулахаас гадна уг төсөл хэрэгжих аймгуудын 9,733 айл өрх, 12,234 аж ахуйн нэгжийн нийт 22,000 орчим хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хангамж, найдвартай ажиллагаа сайжирч шинээр хэрэглэгч холбох боломж бүрдэх юм.

4. СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ




Хүснэгт 28. Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн мэдээлэл

| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | | | |
|---|--|---|-------------------------|-----------------------------------|--------------|
|  | ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ |  | АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК | | |
| ЭХЛЭХ | 2019 | ДУУСАХ | 2027 | | |
|  | | | | | |
|  | ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: Говь-Алтай, Завхан, Хөвсгөл, Ховд, Увс, Баянхонгор | | | | |
|  | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: | | USD 60.6 | | |
| | АХБ-ны хөнгөлөлттэй зээл 40.0 сая \$, Буцалтгүй тусламж 20.6 сая \$ | | | | |
|  | НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: | | USD 32.7 (53.9%) | | |
| Зээлийн хүү | SOFR 5.3+0.5 | Зээлийн хугацаа | 25 жил | Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 5 жил |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | | 2026 ОНД САНХҮҮЖИХ | | ТӨСЛИЙН ЯВЦ | |
| 105,995.3 сая ₮ | | 43,356.4 сая ₮ | | 76% | |

Төслийн хүрээнд төвийн эрчим хүчний системээс алслагдсан аймгуудад Сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийг бий болгоно. Тухайлбал, Говь-Алтай аймгийн Алтай хотод 10 МВт нарны станц, Алтай суманд 0.5 МВт хосолмол систем, Завхан аймгийн Улиастай хотод 10 МВт нарны станцыг барьж ашиглалтад оруулсан бол хөрсний дулааны төслийг Ховд аймгийн Жаргалант сум, Завхан аймгийн Улиастай суманд амжилттай хэрэгжүүлээд байна. Түүнчлэн, Хөвсгөл аймгийн Мөрөн хотод 10 МВт нарны станц барих төсөл, Говь-Алтай аймгийн Алтай сум, Увс аймгийн Улаангом сум, Баянхонгорын Өлзийн суманд хөрсний дулааны төслийг тус тус хэрэгжүүлж байна.

5. МОНГОЛ УЛСЫН ТЭЭВРИЙН ХОЛБОЛТ БА ЛОГИСТИКИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

Хүснэгт 29. Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн мэдээлэл

| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | | | |
|--|-----------------|---|---------------|-----------------------------------|--------------|
|  ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ | |  ДЭЛХИЙН БАНК | | | |
| ЭХЛЭХ | 2023 | ДУУСАХ | 2028 | | |
|  | | | | | |
| ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: | | | | | |
| Хэнтий, Сүхбаатар, Архангай, Төв, Өвөрхангай, Увс, Булган, Хөвсгөл | | | | | |
| НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: | | USD 110.0 | | | |
| ДБ-ны 110.0 сая ам.долларын зээл | | | | | |
| НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: | | USD 7.8 (7%) | | | |
| Зээлийн хүү | SOFR+1.3 | Зээлийн хугацаа | 25 жил | Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 5 жил |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | | 2026 ОНД САНХҮҮЖИХ | | ТӨСЛИЙН ЯВЦ | |
| 358,893.4 сая ₮ | | 50,956.6 сая ₮ | | 7% | |

Төслийн хүрээнд хэрэгжих авто замын их засвар, шинээр барих авто замын сүлжээ нь хөдөлгөөний эрчим ихтэй үед хоногт дунджаар 1272-6424 тээврийн хэрэгсэл, оргил ачааллын үед буюу цагаан сар, зуны баяр наадмын өдрүүдээр 4,610-15,721 тээврийн хэрэгсэл зорчдог бөгөөд авто замын ашиглалтын нөхцөл сайжирснаар зорчих хугацаа 30 хувиар буурах, тээвэр логистикийн үйлчилгээний зардал 8.0 орчим ам.доллараар буурах зэрэг үр дүн гарна. Мөн төсөл хэрэгжсэнээр замын нөхцөл сайжирч, орон нутагт аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний салбар хөгжих боломж нэмэгдэх ба малчид, оршин суугчид, жуулчид, дотоодын хүн тээвэр, ачаа тээврийн цаг хугацаа хэмнэх, тээврийн зардал буурах, тухайн орон нутгийг бусад газартай холбох, тээвэр, логистикийг сайжруулах ач холбогдолтой юм. Төсөл хэрэгжих 8 аймагт оршин суух 146,711 малчин (98,400 малчин өрх) шууд ашиг шимийг хүртэнэ.

6. УЛААНБААТАР ХОТЫН ТОГТВОРТОЙ АВТО ЗАМ, ТЭЭВЭР ТӨСӨЛ

Хүснэгт 30. Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн мэдээлэл

| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | | | |
|--|-----------------|---|---------------|-----------------------------------|--------------|
|  НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР | |  ДЭЛХИЙН БАНК | | | |
| ЭХЛЭХ | 2022 | ДУУСАХ | 2026 | | |
|  | |  | | | |
|  | |  | | | |
|  ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: Улаанбаатар, Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх | | | | | |
|  НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: | | USD 102.7 | | | |
| | | ДБ-ны 100.0 сая ам.долларын зээл, 2.7 сая ам.долларын тусламж | | | |
|  НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: | | USD 16.6 (16%) | | | |
| Зээлийн хүү | SOFR+1.3 | Зээлийн хугацаа | 25 жил | Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 5 жил |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | | 2026 ОНД САНХҮҮЖИХ | | ТӨСЛИЙН ЯВЦ | |
| 308,479.6 сая ₮ | | 46,850.8 сая ₮ | | 57% | |

Төслийн хүрээнд Өнөр хорооллын гудамжны 2.3 км авто зам, Үйлдвэрчний эвлэлийн гудамжны 5.6 км авто замыг шинэчлэн засварлах бол Нарны замын зүүн өргөтгөлийн 4.0 км авто зам, Сэлбэ голын баруун талын 2.5 км шинэ зам, Яармагийн 8.0 км авто зам, Улаанхуарангийн өргөтгөлийн 4.0 км авто замыг тус тус шинээр барина. Эдгээр бүтээн байгуулалт дууссанаар авто замаар зорчих хугацаа 15 хувиар буурч, зам тээврийн осол, аваар мөн 15 хувиар багасна. Замын хөдөлгөөний аюулгүй байдал сайжирч, иргэдийн зорчих боломж нэмэгдсэнээр явган зорчигчдын хөдөлгөөн 20 хувиар нэмэгдэх тооцоо гарсан нь хотын иргэдийн өдөр тутмын амьдралд эерэг өөрчлөлт бий болгоно.

7. НҮХЭН ГАРЦ БАРИХ ТӨСӨЛ




Хүснэгт 31. Нүхэн гарц барих төслийн мэдээлэл

| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | | | |
|--|-------------|---|---------------|-----------------------------------|--------------|
|  НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР | |  БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС | | | |
| ЭХЛЭХ | 2022 | ДУУСАХ | 2026 | | |
|  | |  | | | |
|  | |  | | | |
|  ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: Улаанбаатар, Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх | | | | | |
|  НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: USD 30.1 БНХАУ-ын 29.4 сая ам.долларын зээл, МУЗГ хариуцах 0.7 сая ам.доллар | | | | | |
|  НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: USD 14.3 (46%) | | | | | |
| Зээлийн хүү | 2% | Зээлийн хугацаа | 20 жил | Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 7 жил |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | | 2026 ОНД САНХҮҮЖИХ | | ТӨСЛИЙН ЯВЦ | |
| 56,830.4 сая ₮ | | 30,913.6 сая ₮ | | 33% | |

Улаанбаатар хотын хүн ам болон авто тээврийн хэрэгслийн тоо сүүлийн жилүүдэд эрчимтэй өссөнтэй холбоотойгоор замын хөдөлгөөний ачааллыг бууруулах зорилготой төмөр замтай огтлолцдог автозамын дөрвөн байршилд нүхэн гарц барьж байгуулахаар төлөвлөсөн. Уг бүтээн байгуулалт хэрэгжсэнээр тухайн байршлуудад авто замын түгжрэл 9.1 хувиар буурч, тээврийн хэрэгслийн осол, аваар гарах эрсдэл багасах юм. Мөн хоногт нийт 124,700 тээврийн хэрэгсэл саадгүй нэвтрэх боломж бүрдэж, хотын авто замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдалд эерэг нөлөө үзүүлнэ.

8. НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВЭРТ ДҮҮЖИН ЗАМЫН ТЭЭВЭР НЭВТРҮҮЛЭХ ТӨСӨЛ

Хүснэгт 32. Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төслийн мэдээлэл

| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | | | |
|---|--|---|-------------------------------------|-----------------------------------|---------------|
|  | НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР |  | БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛС | | |
| ЭХЛЭХ | 2020 | ДУУСАХ | 2027 | | |
|  | | | | | |
|  | ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: Улаанбаатар, Хан-Уул, Баянзүрх | | | | |
|  | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: | | EUR 60.7 | | |
| | БНФУ-ын 60.7 сая еврогийн зээл | | | | |
|  | НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: | | USD 17.1 (28%) | | |
| Зээлийн хүү | 0.01% | Зээлийн хугацаа | 40 жил | Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 12 жил |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | | 2026 ОНД САНХҮҮЖИХ | | ТӨСЛИЙН ЯВЦ | |
| 180,948.6 сая ₮ | | 27,484.8 сая ₮ | | 33% | |

Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, олон төрлийн нийтийн тээврийн үйлчилгээ болон Улаанбаатар хотын дэд төвүүдийг хооронд нь холбох, авто замын түгжрэлийг бууруулах, агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулна. Төслийн барилга угсралтын явцад 200 хүн, ашиглалт хариуцсан 57 ажлын байр шинээр бий болно. Яармаг орчмын авто замын түгжрэлийг 15 хувиар бууруулна. Түүнчлэн төсөл хэрэгжсэнээр нийтийн тээврийн шинэ төрлийг нэвтрүүлж, иргэдийн нийтийн тээврийн сонголтыг өргөжүүлэхэд чиглэж байна.

9. ХИЛИЙН ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТОГТВОРТОЙ ХУДАЛДААГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

Хүснэгт 33. Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдааг дэмжих төслийн мэдээлэл

| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | | | |
|--|---------------------------|--|---------------|-----------------------------------|--------------|
|  САНГИЙН ЯАМ | |  АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК | | | |
| ЭХЛЭХ | 2023 | ДУУСАХ | 2030 | | |
|  | | | | | |
| ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: | | | | | |
|  Дорнод аймаг Хавирга боомт Баян-Өлгий аймаг Цагааннуур боомт Ховд аймаг Булган боомт | | | | | |
| НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: USD 100.0 | | | | | |
| АХБ-ны 95.0 сая ам.долларын зээл, 5.0 сая ам.долларын тусламж | | | | | |
| НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: USD 0.3 (0.3%) | | | | | |
| Зээлийн хүү | SOFR+0.6 2.00% | Зээлийн хугацаа | 25 жил | Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 5 жил |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | | 2026 ОНД САНХҮҮЖИХ | | ТӨСЛИЙН ЯВЦ | |
| 356,220.2 сая ₮ | | 28,331.0 сая ₮ | | 5 % | |

Монгол Улсын экспортын бүтэц төрөлжиж, боомтуудын нэвтрүүлэх хүчин чадал нэмэгдсэнээр гадаад худалдааны хэмжээ өсөх боломж бүрдэнэ. Төсөл нь Хавирга, Цагааннуур, Булган хилийн боомтуудад хэрэгжсэнээр эдгээр боомтын хүчин чадлыг одоогийн түвшнээс 3–4 дахин нэмэгдүүлэх бөгөөд экспортын урсгалыг эрчимжүүлэх чухал үр дүнтэй юм. Түүнчлэн боомт орчмын жижиг худалдаа, үйлдвэрлэл, аялал жуулчлал, логистик, агуулах, үйлчилгээний салбарууд хөгжих таатай нөхцөл бүрдэж, бүс нутгийн иргэдийн амьжиргаанд эергээр нөлөөлнө. Үүний зэрэгцээ, Үндэсний цахим нэг цонхны систем гадаад худалдааны үйл явцыг хялбаршуулж, шинэ салбаруудын экспортын боломжийг нэмэгдүүлж байна.

10. ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

Хүснэгт 34. Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн мэдээлэл

| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | | | |
|---|---|---|------------------------|-----------------------------------|--------------|
|  | СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ |  | АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК | | |
| ЭХЛЭХ | 2019 | ДУУСАХ | 2026 | | |
|  | | | | | |
|  | ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: | | | | |
| | Хөвсгөл, Хэнтий | | | | |
|  | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: | | USD 38.4 | | |
| | АХБ-ны 38.4 сая ам.долларын зээл | | | | |
|  | НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: | | USD 16.8 (44%) | | |
| Зээлийн хүү | SOFR 5.3+0.5 | Зээлийн хугацаа | 21 жил | Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 5 жил |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | | 2026 ОНД САНХҮҮЖИХ | | ТӨСЛИЙН ЯВЦ | |
| 77,292.9 сая ₮ | | 38,905.4 сая ₮ | | 77 % | |

Төслийн хүрээнд Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх сум, Хэнтий аймгийн Дадал суманд ландшафт байгууламжууд баригдсан бөгөөд хуучин хогийн цэгүүдэд нөхөн сэргээлт хийж, бохир ус болон ариун цэврийн байгууламжууд ашиглалтад орсон. Мөн “Чингис хаан” аялал жуулчлалын цогцолборын мэдээллийн төв, авто зам, зогсоол, худалдаа, үйлчилгээний төвүүд, ариун цэврийн байгууламж, Хөвсгөлийн Улсын Тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа, жуулчдын мэдээллийн төв, Хөвсгөлийн Хатгал-Жанхайн даваа-Тойлогт чиглэлийн 30.7 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажил үргэлжилж байна.







Дээрх томоохон төслүүд нь үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлж, бүс нутгийн тэнцвэртэй хөгжил, эдийн засгийн бодит өсөлтийг дэмжих суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

Харин гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 2026 онд **нийгмийн салбарт** хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн төсөл, хөтөлбөрүүд нь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн суурь үйлчилгээний орчныг сайжруулахад чиглэгдэж байна. Төслүүдийн хэрэгжилт нь нийгмийн хамгаалал, амьдрах орчны нөхцөлийг сайжруулах, хот байгуулалт, дэд бүтцийн шинэчлэлийг дэмжихэд бодит хувь нэмэр оруулах зорилготой. Тухайлбал:

ГЭР ХОРООЛЛЫГ ОРОН СУУЦЖУУЛАХ, ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН СУУЦНЫ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСЛҮҮД

11. УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 35. Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн мэдээлэл

| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | | | |
|--|--|---|------------------------|-----------------------------------|--------------|
|  | НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР |  | АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК | | |
| ЭХЛЭХ | 2018 | ДУУСАХ | 2026 | | |
|  | | | | | |
|  | ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: Улаанбаатар, Сүхбаатар, Сонгинохайрхан | | | | |
|  | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: | | USD 148.3 | | |
| | АХБ-ны 110.0 сая, ЕХОБ-ны 38.3 сая ам.долларын зээл | | | | |
|  | НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: | | USD 122.3 (82%) | | |
| Зээлийн хүү | SOFR5.3 2.00% | Зээлийн хугацаа | 25 жил | Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 5 жил |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | | 2026 ОНД САНХҮҮЖИХ | | ТӨСЛИЙН ЯВЦ | |
| 125,196.4 сая ₮ | | 70,085.8 сая ₮ | | 60% | |

Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, гэр хорооллын бүсийн хөгжлийг дэмжих зорилготой уг хөтөлбөрийн хүрээнд 6 дэд төвийг шинээр байгуулж, нийт 33,400 өрхийн орон сууц барина. Дэд төвүүдийн бүтээн байгуулалт нь инженерийн болон нийгмийн дэд бүтцийг цогц шийдлээр хэрэгжүүлж байна. Тухайлбал, инженерийн дэд бүтцийн хүрээнд авто зам, ус хангамж, ариутгах татуурга, дулаан, цахилгаан, холбоо, шилэн кабель, үерийн хамгаалалт, хөрсний ус зайлуулах суваг зэрэг нийт 280 гаруй км шугам сүлжээ баригдаж, усан сан, насос станц, дулааны станц, дэд өртөө, мэдээлэл холбооны төв зэрэг чухал байгууламжууд ашиглалтад орсон. Нийгмийн дэд бүтцийн хүрээнд 9.59 га талбайд тохижилт хийж, 4 цэцэрлэг, 2 бизнес инкубатор төв, 1 олон нийтийн хөгжлийн төв, 1 спорт цогцолбор, 1 гал хамгаалах ангийн байр, 640 хүүхдийн багтаамжтай сургуулийн барилга, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах төв зэрэг баригдаж байна. Эдгээр нь орон сууцны хороолол дагасан төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн өдөр тутмын хэрэгцээг хангах боломжийг бүрдүүлж байна. Мөн нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдийг дэд төвүүдэд байгуулснаар хотын хойд бүсийн 160 мянган иргэн хотын төв рүү зорчихгүйгээр төрийн үйлчилгээг оршин суугаа газартаа авах нөхцөл бүрдэж, цаг хугацаа, зардал хэмнэх, амьдралын чанарыг дээшлүүлэх боломжийг олгож байна.

12. УЛААНБААТАР ХОТЫН ОРЛОГОД НИЙЦСЭН НОГООН ОРОН СУУЦ БА ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАР БҮХИЙ ХОТЫН ШИНЭЧЛЭЛ САЛБАРЫН ТӨСӨЛ

Хүснэгт 36. Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төслийн мэдээлэл

| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | | | |
|---|---|---|-----------------------|-----------------------------------|-----------------|
|  | НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР |  | АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК | | |
| ЭХЛЭХ | | 2018 | ДУУСАХ | | 2026 |
|  | |  | | | |
|  | |  | | | |
|  | ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: Улаанбаатар, Сонгинохайрхан, Баянзүрх | | | | |
|  | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: | | USD 228.3 | | |
| | АХБ-ны 175.0 сая ам.долларын зээл, 53.0 сая ам.долларын тусламж | | | | |
|  | НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: | | USD 30.5 (14%) | | |
| Зээлийн хүү | SOFR5.3+0.6 CC 0.15 | Зээлийн хугацаа | 25-40 жил | Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 5-10 жил |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | | 2026 ОНД САНХҮҮЖИХ | | ТӨСЛИЙН ЯВЦ | |
| 708,407.4 сая ₮ | | 65,592.2 сая ₮ | | 53% | |

Төслийн хүрээнд Улаанбаатар хотын гэр хорооллын 30.8 га талбайд 5,000 өрхийн орлогод нийцсэн ногоон орон сууц бүхий эко хороолол байгуулагдаж, барилга байгууламжид сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, шинэлэг технологи, шийдлүүдийг анх удаа нэвтрүүлэхээр төлөвлөгдсөн. Энэхүү хороолол нь агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчний үр ашигтай хэрэглээг дэмжих, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах үндсэн зорилготой. Төслийн үр дүнд 8,000 өрхийн яндан, 5,000 өрхийн нүхэн жорлонг байхгүй болгож, жилд 2.4 сая кВт.ц эрчим хүч, 5.4 сая литр ус хэмнэх боломж бүрдэнэ. Мөн 120,000 м² ногоон байгууламж, 16.4 км дугуйн зам, 39.2 км явган хүний зам, 3,800 автомашины зогсоол шинээр байгуулагдаж, иргэдийн амьдрах орчны чанар сайжирна. Түүнчлэн “Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан”

байгуулагдаж, ногоон зээлийн хэмжээг нэмэгдүүлснээр илүү олон иргэд орон сууцны зээлд хамрагдах боломж бүрдэж байна.

13. СОЛОНГО 1, 2 ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛ БАРИХ ТӨСӨЛ

Хүснэгт 37. Солонго 1, 2 орон сууцны хороолол барих төслийн мэдээлэл

| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | | | |
|--|--------------|--|---------------|-----------------------------------|---------------|
|  ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ | |  БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС | | | |
| ЭХЛЭХ | 2020 | ДУУСАХ | 2027 | | |
|  | | | | | |
| ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: | | | | | |
| Улаанбаатар, Хан-Уул | | | | | |
| НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: USD 266.8 | | | | | |
| БНСУ-ын 266.8 сая ам.долларын зээл | | | | | |
| НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: USD 141.2 (58%) | | | | | |
| Зээлийн хүү | 0.20% | Зээлийн хугацаа | 30 жил | Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 10 жил |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | | 2026 ОНД САНХҮҮЖИХ | | ТӨСЛИЙН ЯВЦ | |
| 455,870.9 сая ₮ | | 70,860.2 сая ₮ | | 48% | |

Төслийн хүрээнд нийт 5,002 айлын 66 блок орон сууц, 2,706 автомашины зогсоол, гадна талбайн тохижилт зэрэг бүтээн байгуулалт хийгдэж, иргэдийг орлогод нийцсэн, аюулгүй, тав тухтай орон сууцаар хангах нөхцөл бүрдэнэ. Энэхүү бүтээн байгуулалт нь хот орчмын бүсийн хөгжилд түлхэц өгч, одоогийн гэр хорооллыг үе шаттайгаар дахин төлөвлөх, орон сууцжуулах боломжийг нэмэгдүүлнэ. Үүний үр дүнд Улаанбаатар хотын хөрс болон агаарын бохирдол буурч, нийтийн үйлчилгээний хүртээмж сайжирч, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бодитоор бүрдэнэ. Гэр хорооллын бага орлоготой иргэдийн амьдрах орчныг сайжруулах зорилготой энэхүү төсөл нь орон сууц, дэд бүтэц, автомашины зогсоол, боловсролын байгууллага зэрэг иж бүрэн шийдлээр хэрэгжиж байна.

14. БАЯНГОЛЫН АМНЫ 2007 АЙЛЫН ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН СУУЦ БАРИХ ТӨСӨЛ

Хүснэгт 38. Баянголын амны 2007 айлын орлогод нийцсэн орон сууц барих төслийн мэдээлэл







| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | | | |
|---|--|---|--|-----------------------------------|---------------|
|  | ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ |  | БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС | | |
| ЭХЛЭХ | 2020 | ДУУСАХ | 2028 | | |
|  | | | | | |
|  | ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: Улаанбаатар, Сонгинохайрхан | | | | |
|  | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: | | USD 114.7 | | |
| | БНСУ-ын 114.7 сая ам.долларын зээл | | | | |
|  | НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: | | USD 38.0 (35%) | | |
| Зээлийн хүү | 0.20% | Зээлийн хугацаа | 30 жил | Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 10 жил |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | | 2026 ОНД САНХҮҮЖИХ | | ТӨСЛИЙН ЯВЦ | |
| 277,542.2 сая ₮ | | 48,547.4 сая ₮ | | 35% | |

Улаанбаатар хотын төвийн төвлөрлийг сааруулах, шинэ суурьшлын бүсийг хөгжүүлэх, зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах, Улаанбаатар хотын агаар, хөрсний бохирдлыг бууруулах, иргэдийг орлогод нийцсэн орон сууцаар хангах хүрээнд 2,007 айлын орон сууцны цогцолбор жишиг хорооллыг Баянголын аманд байгуулна.

НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСЛҮҮД

15. ЭМЗЭГ БҮЛГИЙН ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР

Хүснэгт 39. Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн мэдээлэл

| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | | | |
|---|--|---|-----------------------|-----------------------------------|-------|
|  | ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ |  | АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК | | |
| ЭХЛЭХ | 2019 | ДУУСАХ | 2026 | | |
|  | | | | | |
|  | ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: Улаанбаатар, Увс, Хөвсгөл, Өвөрхангай, Булган, Дорноговь | | | | |
|  | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: | | USD 80.4 | | |
| | АХБ-ны 76.1 сая ам.долларын зээл, 3.5 сая ам.долларын тусламж, МУЗГ хариуцах 0.8 сая ам.доллар | | | | |
|  | НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: | | USD 19.6 (24%) | | |
| Зээлийн хүү | 2.63% | Зээлийн хугацаа | 25 жил | Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 5 жил |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | | 2026 ОНД САНХҮҮЖИХ | | ТӨСЛИЙН ЯВЦ | |
| 207,870.9 сая ₮ | | 60,384.8 сая ₮ | | 82% | |

Хөтөлбөрийн хүрээнд Хан-Уул дүүрэг, Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн шинэ өргөтгөл, Булган аймгийн Дашинчилэн, Өвөрхангай аймгийн Баян-Өндөр, Дорноговь аймгийн Эрдэнэ, Хөвсгөл аймгийн Тариалан, Архангай аймгийн Өлзийт сумдад болон Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэгт эрүүл мэндийн төв, Түргэн тусламжийн үндэсний төвийг тус тус шинээр барьж, 610 нэр төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг суурилуулснаар тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг мэдэгдэхүйц сайжруулна. Эдгээр шинэчлэлийн үр дүнд жил бүр 45,500 иргэн анхан шатны

тусламжийг илүү ойр, үйлчлүүлэгчид ээлтэй орчинд авах боломжтой болж, 97,500 иргэн дүүрэг болон аймгийн нэгдсэн эмнэлгийн сайжруулсан тусламж, тэр дундаа эх барих, эмэгтэйчүүдийн эмчилгээ болон мэс заслын тусламжийг хүртэх боломжтой болно.

16. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

Хүснэгт 40. Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн мэдээлэл

| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | | | |
|---|--|--|----------------------------|--|--------------|
|  | БОЛОВСРОЛЫН ЯАМ |  | АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК | | |
| ЭХЛЭХ | 2018 | ДУУСАХ | 2027 | | |
|  | |  | | | |
|  | ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: Улаанбаатар хотын 9 дүүрэг, Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай | | | | |
|  | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: | | USD 65.0 | | |
| | АХБ-ны 65.0 сая ам.долларын зээл | | | | |
|  | НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: | | USD 50.2 (77%) | | |
| Зээлийн хүү | SOFR 5.3+0.5 | Зээлийн хугацаа | 26 жил | Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 5 жил |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | | 2026 ОНД САНХҮҮЖИХ | | ТӨСЛИЙН ЯВЦ | |
| 52,728.7 сая ₮ | | 19,592.2 сая ₮ | | 80% | |

Төслийн хүрээнд Нийслэлийн 9 дүүрэг болон Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай аймгийн төвд нийт 7 сургууль, 14 цэцэрлэгийг шинээр барьж, өргөтгөн ашиглалтад оруулснаар 3,400 суудал, 2,325 ор бүхий хүчин чадал нэмэгдсэн. 3 ээлжээр хичээллэх эрсдэлийг бууруулах зорилгоор цахим болон танхим хосолсон сургалтын орчныг бүрдүүлж, 135 цахим анги, 590 энгийн ангийн тоног төхөөрөмжийг нийслэлийн зорилтот сургуулиудад хүлээлгэн өгсөн. Мөн багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих зорилгоор

Bagsh.edu.mn цахим сургалтын платформыг хөгжүүлж, 2023 оноос эхлэн сургалтад ашиглаж эхэлсэн.

Дээрх нийгмийн салбарт хэрэгжиж төсөл, хөтөлбөрүүд нь Улаанбаатар хот болон бүс нутгийн хэмжээнд нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн амьдрах орчны тав тухтай, аюулгүй орчныг бүрдүүлэхэд чиглэж байна. Мөн хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих, суурь дэд бүтцийн шинэчлэлийг хийх замаар нийгмийн тогтвортой хөгжлийн суурийг бий болгоход чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн, **2026 онд** Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл, Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төсөл, Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах зэрэг төсөл, хөтөлбөр хэрэгжиж дуусна:

17. УЛААНБААТАР ХОТЫН НИЙТ УС ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ

Хүснэгт 41. Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн мэдээлэл

| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | |
|---|---|---|--|
|  | САНГИЙН ЯАМ |  | АНУ-ЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН КОРПОРАЦИ |
| ЭХЛЭХ | 2021 | ДУУСАХ | 2026 |
|  | |  | |
|  | |  | |
|  | ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: Улаанбаатар, Сонгинохайрхан | | |
|  | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: | USD 461.8 АНУ-ын МСС-ийн 350.0 сая ам.долларын тусламж, МУЗГ хариуцах 111.8 сая ам.доллар | |
|  | НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: | USD 304.7 (66%) | |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | 2026 ОНД САНХҮҮЖИХ | ТӨСЛИЙН ЯВЦ | |
| 320,234.9 сая ₮ | 87,583.9 сая ₮ | 86% | |

Улаанбаатар хотын ундны усны шинэ эх үүсвэрийг бий болгох зорилготой энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр ирэх 30 жилийн хугацаанд хотын нэгдсэн сүлжээнд жилд 50 сая м³ хүртэл гүн цэвэршүүлсэн ус нийлүүлж, 2.4 сая гаруй иргэнийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, тогтвортой усаар хангах, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг усны хомстолд орохоос урьдчилан сэргийлнэ. Мөн хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр баригдсанаар дахин боловсруулсан хаягдал усыг эрчим хүчний үйлдвэрлэлд анх удаа нэвтрүүлж, жилд 14-18 сая м³ гүний цэнгэг усыг хэмнэж, дахин боловсруулсан хаягдал усаар орлуулах боломж бүрдэнэ. Хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын ундны усны шинэ эх үүсвэрийг бий болгож, баруун тийш тэлэх, дагуул хот, шинэ суурьшлын бүсүүдийг байгуулах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

18. УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЭР БАРИХ

Хүснэгт 42. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн мэдээлэл

| ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | | ХӨГЖЛИЙН ТҮНШ | | | |
|--|--|---|---------------------------------|-----------------------------------|-------|
|  | ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ |  | БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС | | |
| ЭХЛЭХ | 2019 | ДУУСАХ | 2026 | | |
|  | | | | | |
|  | ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ: Улаанбаатар, Сонгинохайрхан | | | | |
|  | НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ /сая валют/: USD 262.7 БНХАУ-ын 1,700.0 сая ам.долларын зээл, МУЗГ хариуцах 13.1 сая ам.доллар | | | | |
|  | НИЙТ АШИГЛАЛТ /сая валют/: USD 221.7 (85%) | | | | |
| Зээлийн хүү | 2.00% | Зээлийн хугацаа | 20 жил | Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа | 7 жил |
| АШИГЛААГҮЙ ҮЛДЭГДЭЛ | | 2026 ОНД САНХҮҮЖИХ | | ТӨСЛИЙН ЯВЦ | |
| 135,567.7 сая ₮ | | 44,683.9 сая ₮ | | 95% | |

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барьснаар хоногт 250,000 м³ бохир ус цэвэрлэх хүчин чадалтай, MNS:4943-2015 стандартын шаардлага хангасан байгууламж ашиглалтад орно. Энэхүү төсөл нь Туул голын бохирдлыг бууруулах, хөрс, агаарын чанарыг сайжруулах, лаг боловсруулах орчин үеийн технологи нэвтрүүлэх, мөн нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Боомтын шинэчлэл:

Монгол Улсын Засгийн газар эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, экспортын боломжийг нэмэгдүүлэх, аялал жуулчлал, худалдааг дэмжих зорилгоор **Боомтын сэргэлтийн бодлогыг** хэрэгжүүлж байна.

Энэхүү бодлогын хүрээнд:

- **Гашуунсухайт, Шивээхүрэн, Замын-Үүд** боомтуудад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх дэд бүтцийн шинэчлэл,
- **Ханги, Бичигт, Цагаандэл уул** боомтуудад ашигт малтмалын экспортын шинэ гарц нээх бүтээн байгуулалт,
- **Боршоо, Булган, Сүмбэр, Ульхан, Ханх, Хавирга, Цагааннуур, Алтанбулаг** боомтуудад аялал жуулчлал, худалдааны дэд бүтцийг хөгжүүлэх ажлууд хийгдэж байна.

Хүснэгт 43. Зам тээврийн салбарын хөрөнгө оруулалт



Бодлогын хэрэгжилтийн хүрээнд хэд хэдэн боомтод бүтээн байгуулалт, зураг төсөл, судалгааны ажлууд амжилттай хэрэгжиж байна. Тухайлбал, Замын-Үүд, Гашуунсухайт, Боршоо, Сүхбаатар болон Алтанбулаг хилийн боомтын барилга байгууламжийг өргөтгөж, шинэчлэн сайжруулсан нь тухайн боомтуудын хүчин чадлыг 2-3 дахин нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмж, зохион байгуулалтыг илүү оновчтой болгожээ. Ингэснээр тээвэр,

худалдааны урсгалыг илүү үр ашигтай, шуурхай зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Мөн Бичигт, Цагаандэл-Уул хилийн боомтод өргөтгөл, шинэчлэлийн барилга угсралтын ажил үргэлжилж байгаа бөгөөд Цагааннуур, Булган, Хавирга хилийн боомтуудын барилга, угсралтын ажлыг Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр эхлүүлнэ. Үүнээс гадна 8 боомтын шинэчлэлтийн зураг төсөл бүрэн боловсруулагдаж, өргөтгөл, шинэчлэл хийгдэхэд бэлэн болсон.

Түүнчлэн Бага-Илэнх, Эрэнцав хилийн боомтын зураг төсөл боловсруулах ажил үргэлжилж байгаа бөгөөд инженерийн шийдэл, техникийн тооцооллыг нарийвчлан гаргаж байна. Бусад боомтуудад суурь судалгаа хийгдэж, газар зүйн байршил, эдийн засгийн ач холбогдол, тээвэр логистикийн урсгал зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэж, хөгжлийн төлөвлөлт боловсруулагдаж байна.

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 2026 онд дараах ажлууд хийгдэнэ. Үүнд:

- Азийн Хөгжлийн Банкны санхүүжилттэй “Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх, тогтвортой худалдааг дэмжих төсөл” 2026 онд үргэлжлэн хэрэгжинэ. Төсөл хэрэгжсэнээр Хавирга, Цагааннуур, Булган боомтуудын хүчин чадлыг 3–4 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. Энэ нь экспортын урсгалыг эрчимжүүлж, боомт орчмын худалдаа, үйлдвэрлэл, аялал жуулчлал, логистикийн салбаруудыг хөгжүүлэх боломж бүрдүүлнэ. Төслийн нийт өртөг 100.0 сая ам.доллар бөгөөд 2026 оны төсвийн төсөлд 28.3 тэрбум төгрөгийн зээлийн ашиглалыг тусгалаа.
- Азийн Хөгжлийн Банкны санхүүжилттэй “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл” нь 2026 онд үргэлжлэн хэрэгжих бөгөөд хилийн боомтуудын үйл ажиллагааг сайжруулах, гаалийн болон хил дамнасан үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэх зорилготой. Төслийн хүрээнд 2026 онд Бичигт хилийн боомтын дэд бүтцийг шинэчлэх, хяналтын системийг сайжруулах, цахим үйлчилгээ нэвтрүүлэх зэрэг ажлууд хийгдэнэ. Энэхүү төслийн нийт өртөг 54.0 сая ам.доллар бөгөөд 2026 оны төсвийн төсөлд 22.6 тэрбум төгрөгийн зээлийн ашиглалыг тусгалаа.

Харин **2026 онд шинээр** “Аймгуудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, эрчимжүүлэх төсөл”, “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл - 2”, “Монгол Улсын гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төсөл” зэрэг 6 төсөл, хөтөлбөр гадаад зээлийн хөрөнгөөр эхлэхээр төлөвлөж байна. Үүнд:

Хүснэгт 44. Гадаад зээлийн хөрөнгөөр 2026 онд шинээр эхлэх төсөл, хөтөлбөрүүд, хэлэлцээрт

| № | Хөгжлийн түнш | Төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүчин чадал | Төсөвт өртөг | Хэрэгжих хугацаа |
|---|---------------|--|---------------------|------------------|
| 1 | АХБ | Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл – 2 (Боловсролын салбарт нэн шаардлагатай 31 сургууль, 9 цэцэрлэг шинээр барих.) /хэлэлцээрт/ | 150.0 сая ам.доллар | 2016-2031 |
| 2 | АХБ | Аймгуудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, эрчимжүүлэх төсөл (17 аймгийн нэгдсэн | 225.0 сая ам.доллар | 2026-2036 |

| | | | | |
|-------------|-------|---|--------------------------------------|-----------|
| | | эмнэлгийг сайжруулах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасаг, мэс заслын барилгыг шинэчлэх, өргөтгөх.) /хэлэлцээрт/ | | |
| 3 | ЕСБХБ | Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл (УБ хотод зүрх судасны өвчлөлийн оношилгоо, эмчилгээ, судалгаа, сургалтын цогц төвийг байгуулах.) /хэлэлцээрт/ | 34.9 сая ам.доллар | 2026-2029 |
| 4 | АХБ | Монгол Улсын гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төсөл (ОБЕГ-ын чадавхыг сайжруулахад шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг худалдаж авах.) /хэлэлцээрт/ | 100.0 сая ам.доллар | 2026-2031 |
| 5 | АХБ | Монгол Улсын гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх төсөл (Аналогоос тоон системд шилжих зорилгоор онцгой байдлын холбооны системийг шинэчлэх.) /хэлэлцээрт/ | 30.0 сая ам.доллар | 2026-2031 |
| 6 | ДБ | Мандалговь-Арвайхээр чиглэлийн 220 кВт-ын 2 хэлхээт 287 км урт ЦДАШ (ЦДАШ-ын хүчин чадлыг нэмэгдүүлэх, түүний найдвартай байдлыг сайжруулах.) /хэлэлцээрт/ | 78.0 сая ам.доллар | 2026-2030 |
| НИЙТ | | | 617.9 сая ам.доллар | |

ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ АНХААРАХ АСУУДЛУУД

Өнөөдрийн байдлаар Улсын Их Хурлаар холбогдох зээлийн хэлэлцээрүүдийг соёрхон баталж, Засгийн газраас хэрэгжүүлж буй зээлийн 68 төсөл, хөтөлбөр болон тусламжийн 24, хэлэлцээрийн шатанд буй 6 нийт 98¹¹ гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээ байгаагаас нийт амлалтын дүнгийн 68 хувь буюу 15.9 их наяд төгрөг нь ашиглагдаагүй, хүлээгдэж байна. Эдгээр төслүүдийн 82 хувь нь 2025–2028 онд хэрэгжиж дуусах гэрээ, хэлэлцээртэй тул ирэх жилүүдэд зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэх, эсвэл бодлогын томоохон өөрчлөлт хийх зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна. Тухайлбал:

Төслийн хэрэгжилтийн хугацаа сунгагдах эрсдэл: Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт нь тухайн жилийн төсвийн зарлагын хязгаарлалтын нөлөөгөөр санхүүжилт удааширч, хөрөнгийн ашиглалт тогтмол саатаж байгаа нь бодитоор илэрч байгаа бөгөөд энэ нь олон төсөл төлөвлөсөн хугацаандаа дуусахгүй байх эрсдэлтэй тулгарч байна.

Төслийн үр дүн буурах эрсдэл: Хугацаа хэтэрснээр зөвхөн хэрэгжилт удааширах бус, төсвийн дарамт нэмэгдэх, нэмэлт санхүүжилт шаардагдах зэрэг санхүү, зохион байгуулалтын хүндрэл үүсч байна. Үүний зэрэгцээ, хэрэгжилтийн хугацаа сунгагдсанаар

¹¹ Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 2026 оны төсвийн төсөлд нийт 98 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгасан. Тухайлбал гадаад тусламжийн хөрөнгөөр 24 төсөл, арга хэмжээ санхүүжих бол гадаад зээлийн хөрөнгөөр 74 төсөл, хэмжээ санхүүжин, үүнээс 6 төсөл хэлэлцээрийн шатанд байгаа бол 68 төслийн зээлийн хэлэлцээрийг УИХ-аар соёрхон баталсан.

төслийн зорилтот үр дүн буурах эрсдэл бодитоор илэрч байна. Цаг хугацааны хэтрэлт нь төслийн анхны зорилго, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг сааруулж, үр дүнг хоцроох, улмаар иргэд, аж ахуйн нэгжид хүрэх үр ашиг багасах нөхцөл бүрдүүлж байна.

4.3.3. Төр, хувийн хэвшлийн түншлэл

Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.21-д “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагуу түншлэлээр хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан төслүүдийн танилцуулга, мэдээлэл, хэрэгжилт, үр дүн, төсөвтэй уялдсан байдал болон төсвөөс санхүүжүүлэх төрлөөр гэрээ байгуулсан төслүүдийн төсвөөс төлөх төлбөрийн хуваарь, төсвийн төсөлд тусгах саналыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлснээр хянаж тусгасан мэдээлэл”-ийг төсвийн төслийн танилцуулгад дараах байдлаар орууллаа.

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг баталж, 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль нь 9 бүлэг, 60 зүйлтэй бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулсан байдаг. Энэ хуулийн зорилт нь нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих, төр, хувийн хэвшил эрсдэлийн оновчтой удирдлагад суурилан түншлэлийн гэрээний дагуу урт хугацаанд үр ашигтай хамтран ажиллах болон санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд эрчим хүчний салбарын 3, зам, тээврийн салбарын 7, байгаль орчны салбарын 1, чөлөөт бүсийн хөгжлийн 1 гэсэн нийт 12 төслийн санал Эдийн засаг, хөгжлийн яаманд ирсэн бөгөөд эдгээрээс баримт бичгийн бүрдэл, судалгаа тооцоолол дутуу 2 төсөл захиалагч байгууллагууд руу буцаагдсан, урьдчилсан үнэлгээний шатанд түншлэлээр хэрэгжүүлэх шаардлагагүй 5 төсөл, түншлэлээр хэрэгжих боломжтой, бүрэн шинжилгээ хийгдэх 5 төслөөс 1 төсөл бүрэн шинжилгээ хийгдэж, уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах Засгийн газрын шийдвэр гараад байна.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас ирүүлсэн мэдээллээр 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар түншлэлээр хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээ байхгүй болно.

4.4. Орон нутгийн төсөв

Орон нутгийн төсвийн суурь орлого, зарлагыг төлөвлөж, аймгуудад олгох санхүүгийн дэмжлэг 2026 онд 297.5 тэрбум төгрөг, дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ 2026 онд 1.4 их наяд төгрөг байхаар тооцлоо.

Хүснэгт 45. Аймгуудын санхүүгийн дэмжлэг (сая төгрөг)

| Д/д | САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ | 2025 Төсөв | 2026 Төсөл | Зөрүү |
|-------------|-----------------------|------------------|------------------|-----------------|
| 1 | Архангай | 33,894.6 | 32,646.8 | -1,247.8 |
| 2 | Баян-Өлгий | 19,361.5 | 16,555.4 | -2,806.1 |
| 3 | Баянхонгор | 28,978.1 | 31,392.2 | 2,414.1 |
| 4 | Булган | 0.0 | 6,041.2 | 6,041.2 |
| 5 | Говь-Алтай | 19,659.6 | 16,068.5 | -3,591.0 |
| 6 | Дундговь | 0.0 | 2,986.1 | 2,986.1 |
| 7 | Завхан | 35,900.6 | 39,258.2 | 3,357.6 |
| 8 | Өвөрхангай | 21,883.1 | 26,267.2 | 4,384.1 |
| 9 | Сүхбаатар | 9,349.9 | 8,684.1 | -665.9 |
| 10 | Увс | 28,342.1 | 37,831.0 | 9,489.0 |
| 11 | Ховд | 4,875.8 | 3,992.7 | -883.1 |
| 12 | Хөвсгөл | 38,599.9 | 40,718.6 | 2,118.7 |
| 13 | Хэнтий | 27,305.8 | 28,664.6 | 1,358.8 |
| 14 | Говь-Сүмбэр | 5,119.7 | 6,421.6 | 1,301.9 |
| НИЙТ | | 273,270.7 | 297,528.2 | 24,257.5 |

Хүснэгт 46. Дээд шатны төсөвт төвлөрүүлэх дүн (сая төгрөг)

| Д/д | ТӨВЛӨРҮҮЛЭХ | 2025 төсөв | 2026 төсөл | Зөрүү |
|-------------|-------------|---------------------|--------------------|-------------------|
| 1 | Дорноговь | 10,754.9 | 10,425.1 | -329.8 |
| 2 | Дорнод | 3,042.3 | 1,192.1 | -1,850.2 |
| 3 | Өмнөговь | 1,530,918.5 | 1,136,829.9 | -394,088.6 |
| 4 | Сэлэнгэ | 8,665.2 | 9,385.6 | 720.4 |
| 5 | Төв | 2,370.0 | 3,053.3 | 683.3 |
| 6 | Дархан-Уул | 6,781.2 | 9,854.7 | 3,073.5 |
| 7 | Улаанбаатар | 130,762.8 | 173,579.1 | 42,816.3 |
| 8 | Орхон | 108,420.3 | 86,377.7 | -22,042.6 |
| НИЙТ | | 1,801,715.06 | 1,430,697.4 | -372,769.7 |

Орон нутгийн хөгжлийн сан

Аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлдэг орлогын шилжүүлгийн эх үүсвэр нь Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэр болох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, газрын тосны нөөц ашигласны төлбөр болон улсын төсвийн эх үүсвэр болох хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрөөс бүрддэг.

Иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулахад чиглэсэн, уул уурхайн орлогоос бүрдэж, тухайн орон нутгийн иргэдийн санал, санаачилга дээр тулгуурлан зарцуулагддаг ОНХС-гийн хуваарилалтаас уул уурхайн олборлолт хийгдэж буй аймаг, сумдад түлхүү хуваарилах бодлогыг баримталж байна.

Хүснэгт 47. Орон нутгийн хөгжлийн сан (сая төгрөг)

| | Аймаг | 2025 | 2026 | Зөрүү |
|----|-------------|------------------|------------------|-----------------|
| 1 | Архангай | 9,698.4 | 9,414.2 | -284.2 |
| 2 | Баян-Өлгий | 9,395.6 | 10,828.9 | 1,433.3 |
| 3 | Баянхонгор | 18,124.8 | 21,974.4 | 3,849.7 |
| 4 | Булган | 11,079.8 | 10,666.9 | -412.9 |
| 5 | Говь-Алтай | 18,303.7 | 19,801.8 | 1,498.1 |
| 6 | Дорноговь | 33,362.2 | 34,920.2 | 1,557.9 |
| 7 | Дорнод | 22,933.7 | 27,807.2 | 4,873.5 |
| 8 | Дундговь | 13,039.8 | 13,480.7 | 440.9 |
| 9 | Завхан | 12,419.4 | 11,862.2 | -557.2 |
| 10 | Өвөрхангай | 12,182.2 | 12,661.4 | 479.2 |
| 11 | Өмнөговь | 43,789.7 | 42,558.7 | -1,231.0 |
| 12 | Сүхбаатар | 19,709.5 | 20,827.5 | 1,118.0 |
| 13 | Сэлэнгэ | 23,056.1 | 24,972.6 | 1,916.5 |
| 14 | Төв | 24,987.5 | 22,891.4 | -2,096.2 |
| 15 | Увс | 10,770.9 | 12,455.4 | 1,684.6 |
| 16 | Ховд | 18,010.8 | 18,950.1 | 939.3 |
| 17 | Хөвсгөл | 14,457.7 | 14,593.2 | 135.5 |
| 18 | Хэнтий | 16,234.2 | 19,238.7 | 3,004.5 |
| 19 | Дархан-Уул | 13,203.6 | 12,586.4 | -617.2 |
| 20 | Улаанбаатар | 39,536.7 | 42,639.9 | 3,103.2 |
| 21 | Орхон | 26,251.7 | 30,640.9 | 4,389.2 |
| 22 | Говьсүмбэр | 5,829.7 | 5,118.2 | -711.5 |
| | НИЙТ | 416,377.6 | 440,891.0 | 24,513.4 |

4.5. Орон сууцны санхүүжилтийн банк

Засгийн газар, Монголбанктай байгуулсан санамж бичгийн хүрээнд “Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийг 2013 оноос хэрэгжүүлсэн бөгөөд тус хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд нийт 9.9 их наяд төгрөгийн орон сууцны хөнгөлөлттэй зээлийг нийт 137 мянга гаруй иргэнд олгоод байна.

Уг хөтөлбөрийн зорилго нь иргэдийг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдах суурь нөхцөл боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ орон сууцжуулах замаар амьдралын чанарыг сайжруулах, агаар орчны бохирдлыг богино хугацаанд бууруулах үндсэн зорилгыг агуулсан болно.

Дээрх үндсэн зорилгын хүрээнд арилжааны банкны богино хугацаат эх үүсвэрээр олгосон орон сууцны зээлийг үнэт цаасжуулан Монголбанканд эзэмшүүлэх замаар тус

хөтөлбөрийн санхүүжилтийг шийдвэрлэж ирсэн бөгөөд энэхүү “Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” нь түүхэн үүргээ гүйцэтгэж, өнөөдрийг хүртэл хугацаанд нийт 137 мянган иргэнийг орон сууцтай болгох, цаашлаад аятай тухтай орчинд амьдрах боломжийг бүрдүүлж байгаа хэдий ч тус хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байсаар байна.

Тухайлбал, сүүлийн жилүүдэд арилжааны банкнуудын өөрийн эх үүсвэрээр буюу зах зээлийн хүүтэй олгосон орон сууцны зээлийн хэмжээ нэмэгдэж хөтөлбөрийн зээлтэй харьцуулбал 1.5 дахин өндөр байгаа нь энэхүү зах зээл цаашид хөгжих орон зай байгааг илтгэж байна.

Түүнчлэн, нийслэл Улаанбаатар хотын нийт өрхийн 50-иас дээш хувь, аймгийн төвүүдэд амьдарч буй өрхүүдийн 70 орчим хувь нь орчин үеийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээнд холбогдоогүй гэр, байшин хороололд амьдарч байна. Тиймээс дан ганц хөтөлбөрийн санхүүжилтэд анхаарах бус, орон сууцны урт хугацааны тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бий болгох чиглэлд хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, нэгдсэн бодлогоор хангах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Дэлхийн бусад улс орнууд ч мөн адил иргэдээ орон сууцжуулах чиглэлээр олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлж ирсэн бөгөөд үүний дотроос орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлэх нэг түгээмэл хувилбар нь орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банк байгуулах замаар санхүүжүүлэх явдал юм.

Төрийн оролцоотой орон сууцны төрөлжсөн банк байгуулсан улс орнуудын дотроос ХБНГУ, БНСУ, Казакстан, Тайланд, Аргентин зэрэг улсуудын орон сууцны банкнууд урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд үүний үндсэн шалтгаан нь банкны үйл ажиллагааг улс төрөөс хараат бус, бие даан шийдвэр гаргах байдлаар зохион байгуулж, засаглалын оновчтой бүтцийг бий болгосонд оршиж байна.

Мөн Дэлхийн банкнаас Монгол Улсын орон сууцны санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр замын зураглалыг боловсруулж, санхүүжилтийн тогтолцоог сайжруулах талаар өгсөн зөвлөмжөөс үзэхэд орон сууцны санхүүжилтийн тогтолцоог зах зээлийн зарчимд тулгуурлан боловсронгуй болгох, ипотекийн зээлийг дахин санхүүжүүлэх тогтолцоог бэхжүүлэх, түүнчлэн ипотекийн зээлийн батлан даалтын тогтолцоог нэвтрүүлэх, урт хугацааны орон сууцны хуримтлалын тогтолцоо бий болгох, цаашлаад орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн үйл ажиллагааг Монголбанкнаас Засгийн газар руу шилжүүлж орлогод нийцсэн орон сууцны шийдлүүдийг зорилтот бүлэгт чиглүүлэх шаардлагатай байна.

Орон сууцны зээл олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрөлжсөн банктай улс орнуудын туршлага болон Дэлхийн банкнаас Монгол Улсын орон сууцны санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар дэвшүүлсэн санал, зөвлөмж, мөн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн орчныг судалсны үндсэн дээр орон сууцны

санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

Нэгдүгээрт, Орон сууцны санхүүжилтийн банкийг төр, хувийн хэвшил болон олон улсын санхүүгийн байгууллагын хамтын оролцооны хүрээнд засаглалын оновчтой бүтэцтэйгээр байгуулж, хууль, эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх;

Хоёрдугаарт, Олон улсын туршлагыг судлан банкны сайн засаглалыг бүрдүүлж төрийн хувь оролцоог олон улсын байгууллага болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдад үе шаттайгаар санал болгох;

Гуравдугаарт, Санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын бодлоготой уялдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, дотоод болон гадаадын хөрөнгийн зах зээлд үнэт цаас гаргах замаар нэмэлт эх үүсвэр төвлөрүүлэх;

Дөрөвдүгээрт, Улаанбаатар хотын хөгжлийн төлөвлөгөөтэй нийцүүлэн, төрөөс авч хэрэгжүүлж буй гэр хорооллын дахин төлөвлөлт, агаар орчны бохирдлыг бууруулах бодлогуудтай уялдуулж орон сууцны эрэлт, нийлүүлэлтийг зохистой түвшинд ханган хэрэгжүүлэх зэрэг болно.

Иймд орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банк байгуулах энэхүү бодлогын арга хэмжээг 2026 оны төсвийн жилд хэрэгжүүлснээр Монгол Улсад орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоо бодитоор бүрдэж, улмаар орон сууцны зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, цаашлаад иргэдийн амьдрах орчны чанар бодитойгоор сайжрах боломж бүрдэнэ.

4.6. Засгийн газрын өр

Засгийн газрын өрийн удирдлагын хүрээнд 2026 онд баримтлах арга хэмжээ

Өрийн удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн баримт бичгийг боловсруулж, тухайн төсвийн жилийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хамт гурван жилд нэг удаа Төсвийн тухай хуулийн 8.1-д заасан цаглабрын дагуу батлуулна.” гэж заасны дагуу Засгийн газрын зүгээс 2015 оноос хойш 3 жил тутам “Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичиг”-ийг Улсын Их Хурлаар батлуулан, мөрдөж байна.

Засгийн газраас стратегийн баримт бичгийн хүрээнд дэвшүүлсэн зорилт арга, хэмжээг өрийн удирдлагын үйл ажиллагааны үндсэн чиглэл болгон хэрэгжүүлж ирсэн бөгөөд стратегийн баримт бичгийн хүрээнд шаардлагатай эх үүсвэрийг татан төвлөрүүлэх, гадаад, дотоод төлбөрүүдийг хугацаанд нь төлж барагдуулах, олон улсын зах зээлийн таатай үеийг ашиглан өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

өрийн дарамтыг багасгаж дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн, хэрэгжилтийг тухай бүр Улсын Их Хуралд тайлагнаж ирсэн.

Тухайлбал, Улсын Их Хурлын баталсан Засгийн газрын өрийн удирдлагын 2016-2018, 2019-2022, 2023-2025 оны стратегийн баримт бичгүүдийг мөрдөж ажилласны үр дүнд 2016 онд ДНБ-ий 93.1 хувьд хүрээд байсан Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 41.8 хувьд, 2017 онд төсвийн нийт зардлын 12.8 хувьтай тэнцэж байсан Засгийн газрын өрийн хүүгийн зардал 2024 оны жилийн эцсийн байдлаар 3.8 хувьд тус тус хүрээд байна. Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Эс энд Пи, Фитч, Мүүдиз зэрэг агентлагууд Монгол улсын зээлжих зэрэглэлийг 2024 онд нэмэгдүүлж, В+, В2 түвшинд хүргэсний нэг шалтгаан нь Засгийн газрын өрийн оновчтой удирдлага, өрийн дарамт буурч байгаатай холбоотой болохыг онцолсон.

Улсын Их Хурлын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг”-ийг баталсан. Тус стратегийн баримт бичгийн хүрээнд гадаад валютын нөөц болон төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүйгээр гадаад төлбөрийг төлөх, гадаад зээлийн хөрөнгөөр хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан, эдийн засгийн бодит өгөөжтэй, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжид хэрэгжүүлэх, үнэт цаасны арилжааг тогтмолжуулж дотоод болон гадаад үнэт цаасны зах зээлийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэх, мөн болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг хязгаарлахаар зорилт, арга хэмжээг тусгасан болно.

Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигт дараах 4 зорилтыг тусгасан. Үүнд:

- Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан, эдийн засгийн бодит өгөөжтэй, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжид хэрэгжүүлэх бодлогыг баримтална.
- Засгийн газрын өрийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлж, дунд болон урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Болзошгүй өр төлбөрийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн үнэт цаас болон Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлийг хязгаарлах;
- Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаасны арилжааг тогтмолжуулан зах зээлийн суурь хүүг тогтоох замаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт татах боломжийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдын бааз суурийг тэлэх зэрэг болно.

Дээрх зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтоосон. Үүнд:

Хүснэгт 48. Засгийн газрын өрийн багцын зорилтот бүтэц

| Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Түвшин | Зорилтот түвшинг | | |
|---|-------------|--------|------------------|------|------|
| | | | 2026 | 2027 | 2028 |
| Хөгжлийн бодлогын баримт бичигт туссан, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн томоохон инженерийн дэд бүтцийн төслийг санхүүжүүлэх зорилгоор байгуулсан гадаад зээлийн гэрээний дүнг тухайн жилд байгуулсан гадаад төслийн зээлийн нийт хэмжээнд харьцуулсан харьцаа | хувь | доод | 70.0 | 70.0 | 70.0 |
| Зорилтын хүрээнд гэрээ байгуулсан санхүүгийн бүтээгдэхүүн болон хэрэгжүүлсэн өрийн зохицуулалтын арга хэмжээний тоо | нэгж | доод | 2 | 2 | 2 |
| Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл/ДНБ | хувь | дээд | 10.0 | 10.0 | 10.0 |
| Тухайн аймаг, нийслэлийн гаргасан үнэт цаасны нэрлэсэн үлдэгдэл/ тухайн аймаг, нийслэлийн тухайн жилийн төсвийн орлого | хувь | дээд | 70.0 | 60.0 | 50.0 |
| Арилжаа зохион байгуулах давтамж | нэгж | доод | Сард 2 удаа | | |
| Дахин санхүүжилтийн зориулалтаар гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны тоо | нэгж | дээд | 2 | 2 | 2 |

Өрийн удирдлагын стратегийн баримт бичгийг чанд сахиж, мөрдсөний үр дүнд олон улсын хөрөнгө оруулагчид, зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагуудын итгэл нэмэгдэж Монгол Улсын зээлжих зэрэглэл тогтворжих, цаашид сайжрах боломжтой. Мөн дотоод болон олон улсын зах зээлд Монгол Улсын суурь хүүг тогтоож, өгөөжийн муруйг тогтмол шинэчилснээр хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн зах зээлээс хөрөнгө оруулалт хямд эх үүсвэр татах боломжийг нэмэгдүүлэх бөгөөд гадаад зээлээр дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлтийг дэмжих зэрэг томоохон ач холбогдолтой байна.

V БҮЛЭГ: ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

5.1. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд

Төсвийн төсөлд Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 31.6 их наяд төгрөг буюу ДНБ-ий 30.9 хувь, нийт зарлагын хэмжээг 33.0 их наяд төгрөг буюу 32.2 хувь, төсвийн суурь тэнцлийг 2.0 их наяд төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувьтай тэнцэх ашигтай байхаар төлөвлөлөө.

Хүснэгт 49. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

| ҮЗҮҮЛЭЛТ | 2025 ТОД | 2026 ТӨСӨЛ | Зөрүү |
|----------------------------------|-----------------|-----------------|----------------|
| НИЙТ ОРЛОГО | 32,540.2 | 34,923.8 | 2,383.6 |
| Тогтворжуулалтын сан | 429.1 | 367.7 | -61.4 |
| Үндэсний баялгийн сан | 1,901.2 | 2,956.1 | 1,054.9 |
| ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО | 30,209.9 | 31,600.0 | 1,390.1 |
| НИЙТ ЗАРЛАГА | 31,573.9 | 32,980.0 | 1,406.1 |
| Урсгал зардал | 23,964.1 | 24,549.9 | 585.8 |
| Хөрөнгийн зардал | 7,881.6 | 8,885.5 | 1,003.9 |
| Эргэж төлөгдөх цэвэр зээл | -271.8 | -455.4 | -183.6 |
| ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ | -1,364.0 | -1,380.0 | -16.0 |
| ДНБ-д эзлэх хувь | -1.5 | -1.3 | 0.2 |
| СУУРЬ ЗАРЛАГА | 28,400.5 | 29,552.0 | 1,151.5 |
| ДНБ-д эзлэх хувь | 31.6 | 28.9 | -2.7 |
| СУУРЬ ТЭНЦЭЛ | 1,809.4 | 2,048.0 | 238.6 |
| ДНБ-д эзлэх хувь | 2.0 | 2.0 | 0.0 |

5.2. Төсвийн тусгай шаардлага

Монгол Улсын 2026 төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан тусгай шаардлагад бүрэн нийцүүлж боловсрууллаа.

Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2026 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 8,341.8 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 133.7 ам.доллар байхаар тооцлоо.

Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасны дагуу нэгдсэн төсвийн суурь тэнцэл ДНБ-ий 2 хувиас дээш ашигтай байхаар төлөвлөлөө.

Хүснэгт 50. Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн ДНБ-д эзлэх хувь

| | 2026 |
|-----------------|------|
| Хуулийн хязгаар | 2.0% |
| Төсөөлөл | 2.0% |

Тухайн жилийн нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т заасны дагуу урсгал зарлагыг ДНБ-ий 30.0 хувиас хэтрэхгүй байхаар төлөвлөлөө.

Хүснэгт 51. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын ДНБ-д эзлэх хувь

| | 2026 |
|-----------------|-------|
| Хуулийн хязгаар | 30.0% |
| Төсөөлөл | 24.0% |

Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасны дагуу Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2026 онд хуульд заасан хязгаарт байхаар байна.

Хүснэгт 52. Засгийн газрын өрийн төсөөлөл, нэрлэсэн дүнгээр (ДНБ-д эзлэх хувь)

| | 2026 |
|-----------------|-------|
| Хуулийн хязгаар | 60.0% |
| Төсөөлөл | 43.8% |

5.3. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,380.0 тэрбум төгрөгийн алдагдалтай байгаа бөгөөд үүнийг Засгийн газрын гадаад хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр бүрэн санхүүжүүлэхээр байна.

VI БҮЛЭГ: ТӨСВИЙН ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Төсвийн эрсдэлийн шинжилгээ нь гадаад, дотоод нөхцөлөөс шалтгаалах төсвийн гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй хүчин зүйлсийг тодорхойлж, тохиолдох магадлалд шинжилгээ хийж, төсөвт үзүүлэх нөлөөг тооцох замаар төрийн санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалахад чиглэсэн байдаг. Олон улсад уг тайланг тухайн улс орны эдийн засгийн онцлог, бүтцэд тулгуурлан боловсруулдаг бөгөөд энэхүү шинжилгээ нь төсвийн орлогыг бууруулах, зардлыг нэмэгдүүлэх магадлалтай эрсдэлүүдийг тодорхойлж, бодлогын хариу арга хэмжээг авах үндэс болдог байна.

Монгол Улсын Төсвийн тухай хууль 2011 онд батлагдсанаас хойш тус хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.4 дэх хэсэгт “төсвийн гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй эрсдэлийн шинжилгээ”-г төсвийн танилцуулгад тусгана гэж заасны дагуу төсвийн баримт бичигт эрсдэлийн талаар тусгаж ирсэн. Харин 2026 оны төсвийн баримт бичигт анх удаа Олон Улсын Валютын Сангийн техник туслалцааны дэмжлэгтэйгээр төсвийн эрсдэлийг системтэй, тоон загварт үндэслэн тодорхойлж, тохиолдох магадлал болон төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцож, олон нийтэд ил тод мэдээлж байна.

Цаашид энэхүү шинжилгээг жил бүр боловсруулж, олон улсын жишигт нийцүүлж, улам боловсронгуй болгон, төсвийн сахилга бат, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхээр зорьж байна.

6.1. Товч агуулга

Төсвийн эрсдэлийн шинжилгээг олон улсын туршлагад үндэслэн, эрсдэлийг системтэй тодорхойлж, шинжлэх зорилгоор үндсэн дөрвөн бүлэгтэй боловсрууллаа. Төсөвт нөлөөлөх гадаад орчны эрсдэлийг голлох түүхий эдийн үнэ болон биет хэмжээний хэлбэлзэл, Засгийн газрын өрийн эрсдэлээр үнэлж, нөлөөллийг тооцсон бол дотоод хүчин зүйлсийг төрийн өмчит аж ахуйн нэгжийн эрсдэл, мөн байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлийн нөлөөг зудын эрсдэлээр тооцооллоо.

1. Макро эдийн засгийн эрсдэл

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбараас өндөр хамааралтай, гадаад орчны эрсдэлийн нөлөө өндөр байна. Сүүлийн 20 жилд Монгол улсын эдийн засгийн бүтэц уул уурхайн салбарт улам төвлөрч төсвийн орлогоо бүрдүүлж ирсэн. Тухайлбал, 2000-2009 онд уул уурхайн салбарын шууд болон шууд бус нөлөө¹² дотоодын нийт бүтээгдэхүүний дунджаар 21 хувийг эзэлж байсан бол сүүлийн таван жилд 30 хувьд хүрлээ. Энэ нь төсвийн нийт орлогын 30 орчим хувийг бүрдүүлж байна. Энэхүү бүтэц нь түүхий эдийн үнэ болон экспортын биет хэмжээний хэлбэлзэл, худалдааны түнш орнуудын эдийн засгийн идэвхжилд мэдрэг байдлыг нэмэгдүүлж байна.

Гадаад орчны тогтворгүй байдал манай улсын эдийн засагт түүхий эдийн зах зээлээр дамжиж нөлөөлж байна. Гадаад эдийн засгийн сорилт, тодорхой бус байдал дунд

¹²Тээвэр, худалдаа, боловсруулах салбар тус бүрийн хувьд уул уурхайн салбараас авч буй завсрын хэрэглээний нийт завсрын хэрэглээнд эзлэх жинг тооцоолж, эдгээр салбаруудын ДНБ-ийг тус жингээр үржүүлэн нэмж шууд бус нөлөөг тооцсон.

хугацаанд үргэлжлэх төлөвтэй байгааг ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагууд онцолж байна. Эдгээр хүчин зүйлс нь гол түнш орнуудын худалдааны тэнцэл, хөрөнгө оруулалтыг бууруулж, аж үйлдвэрийн салбарын өсөлтийг сааруулах бөгөөд Монгол улсын хувьд гол экспортын бүтээгдэхүүний үнэ, эрэлт болон валютын ханшаар дамжин төсвийн орлого, Засгийн газрын өрийн тогтвортой байдалд эрсдэл үүсгэдэг. Иймд 2026 онд нүүрс, зэсийн үнэ буурах, нүүрсний экспортын биет хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх хувилбаруудаар мэдрэмжийн шинжилгээг хийж, экспортын орлого болон төсвийн орлогод үзүүлэх нөлөөг үнэллээ.

Шинжилгээний үр дүн:

Шинжилгээний үр дүнд экспортын орлого болон төсвийн нийт орлогод нүүрсний экспортын биет хэмжээний бууралт хамгийн өндөр нөлөө үзүүлэхээр байна. Тухайлбал, биет хэмжээ суурь төсөөллөөс 1 сая тонноор буурахад экспортын орлого ДНБ-ий 0.2 хувь, төсвийн тэнцвэржүүлсэн орлого ДНБ-ий 0.06 хувьтай тэнцэх хэмжээгээр буурахаар байна. Харин зэсийн үнэ 1 хувиар буурахад төсвийн тэнцвэржүүлсэн орлого ДНБ-ий 0.02 хувиар буурах бол нүүрсний үнийн бууралтын нөлөө харьцангуй өндөр буюу ДНБ-ий 0.05 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 53. Төсвийн эрсдэлийн матриц

| | | | | |
|------------------|--------------------------------|---|-----------------------------|-------|
| Төсвийн нөлөө | Өндөр (500 тб.₮ дээш) | Нүүрсний үнэ 10 хувиар буурах | | |
| | Дунд (150-500 тб.₮ хүртэлх) | Нүүрсний экспортын биет хэмжээ 5 сая тонноор буурах | Зэсийн үнэ 10 хувиар буурах | |
| | Бага (150 тб.₮ хүртэлх) | | Зудын эрсдэл | |
| | | Бага | Дунд | Өндөр |
| Тохихоо магадлал | | | | |

2. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд хийсэн эрсдэлийн шинжилгээ

Төсвийн эрсдэлийг макро эдийн засгийн түвшинд үнэлэхээс гадна салбар, байгууллагын түвшинд системтэй тодорхойлох нь чухал юм. Төрийн өмчит аж ахуйн нэгж нь Монгол улсын эдийн засагт, ялангуяа уул уурхай, эрчим хүч, тээвэр зэрэг стратегийн салбаруудад чухал үүрэг гүйцэтгэдэг ба борлуулалтын орлогоос гадна нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэх, үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх зэрэг хосолсон үүрэг хүлээдэг.

Энэхүү бүлэгт олон улсын шинжилгээний загварыг ашиглан Монгол Улсын төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн эрсдэлийн шинжилгээг хийв. Ингэхдээ Олон Улсын Валютын Сангийн боловсруулсан ТӨААН-ийн санхүүгийн тогтвортой байдал, үйл ажиллагааны үр ашиг, төсөвт үзүүлэх эрсдэлийг үнэлдэг SOE Health check tool загварыг ашигласан болно. Энэхүү загвар нь санхүүгийн бус ашгийн төлөөх ТӨААН-үүдийн санхүүгийн тоон мэдээлэлд суурилж шинжилгээ хийдэг бөгөөд эдгээр аж ахуй

нэгжүүдийн алдагдал, өр төлбөр зэрэг нь төсөвт шууд нөлөө үзүүлдэг учир эрсдэл үүсгэх гол эх үүсвэр гэж үздэг байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны статистикийн мэдээгээр Монгол Улсад 9 өөр салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт 87 ТӨААН бүртгэлтэй байна. Үүнээс хөрөнгийн хэмжээ, ашигт ажиллагаа, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн зохистой харьцааг харгалзан, санхүүгийн бус, ашгийн төлөөх хамгийн том 13 ТӨААН-ийг сонгон авч нарийвчилсан шинжилгээ хийлээ.

Шинжилгээний үр дүнд:

- Уул уурхайн бүтээгдэхүүнээ экспортолдог ТӨҮГ-ийн санхүүгийн эрсдэл доогуур, ашигт ажиллагаа өндөр байгаа бол дотоодын зах зээлд нүүрс борлуулдаг ТӨААН ашигт ажиллагаа, хөрвөх чадвар сул, эрсдэл өндөр байна.
- Санхүүгийн бус, ашгийн төлөөх ТӨААН-үүдийн хөрөнгийн өгөөж сүүлийн 5 жилд 0-ээс 9.6 хувь болж өссөн ч өсөлт нь цөөн уул уурхайн аж ахуйн нэгжид төвлөрсөн нь салбарын эмзэг байдлыг нэмэгдүүлжээ.

3. Засгийн газрын өрийн эрсдэл

Засгийн газрын өрийн эрсдэл болон Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн талаар шаардлагатай тооцооллыг хийж гүйцэтгэлээ. Ингэхдээ Засгийн газрын өрийн багцын зардал эрсдэлийн үзүүлэлтүүд, өрийн тогтвортой байдлын шинжилгээг холбогдох аргачлалын дагуу тооцоолж тайлбарласан бол Засгийн газрын болзошгүй өр төлбөрт Засгийн газрын өрийн баталгаа болон орон нутгийн өр төлбөрийг авч үзлээ.

Шинжилгээний үр дүнд:

Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн үзүүлэлтүүдийн хувьд дахин санхүүжилтийн эрсдэл бага, хугацаа тулсан томоохон өр төлбөргүй, хүүгийн зардлын төсвийн орлого, ДНБ-д эзлэх хувь буурч байгаа бөгөөд Засгийн газрын хүүгийн түвшин шинэчлэгдэх дундаж хугацаа өмнөх онуудтай ижил түвшинд буюу 6.3 жилтэй тэнцэж байна. Засгийн газрын өрийн эрсдэлийг өрийн тогтвортой байдлын шинжилгээгээр богино болон дунд хугацаанд авч үзэхэд “хэвийн эрсдэл”-тэй гарсан байна. Тухайлбал:

Богино хугацааны эрсдэл: Засгийн газарт богино хугацаанд стресс тохиох магадлал 13.8 хувьтай тэнцэхээр байгаа нь Олон Улсын Валютын сангаас тогтоосон хязгаараар “хэвийн эрсдэлтэй” түвшинд байна.

Дунд хугацааны эрсдэл: Засгийн газрын өрийн төсөөллийн тархалт хэвийн эрсдэлтэй, Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ бага эрсдэлтэй, ингэснээр дунд хугацаанд “хэвийн эрсдэлтэй” гарсан байна.

4. Байгалийн гамшгийн эрсдэл: Зудын эрсдэл

Сүүлийн хоёр жилд зудын эрсдэлийн улмаас хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурч, эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлт болон өрхийн орлогын түвшинд сөргөөр нөлөөлөв. Улмаар хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдах, инфляц нэмэгдэх зэрэг эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг үр дагавар эрс нэмэгдсэн бөгөөд ийнхүү эрсдэлийн

эдийн засаг, төсөвт үзүүлэх нөлөөг бууруулах бодлогын хариу арга хэмжээ шаардлагатай болсон.

Сүүлийн 25 жилд 2001-2003 он, 2009-2010 он, 2023-2024 онуудад нийтдээ 7 удаа зудын эрсдэл тохиолдож, дунджаар том малын зүй бус хорогдлын оны эхний нийт малд эзлэх хувь 10 хувьд хүрч энгийн жилүүдээс 8.0 нэгж хувиар өссөн бол бойжуулсан төлийн оны эхний нийт малд эзлэх хувь 27 орчим хувьд хүрч энгийн жилүүдээс 9 орчим нэгж хувиар буурсан байна.¹³ Ирэх онд зудын эрсдэл бий болсон тохиолдолд дээрх тооцооллоор малын хорогдол 6 орчим саяд, бойжуулсан төлийн тоо өмнөх жилээс 4.8 саяар буурах хувилбарыг тооцлоо.


Шинжилгээний үр дүнд:

Хөдөө аж ахуйн салбарын өсөлт 9.5 хувиар буурч, эдийн засгийн өсөлт 4.0 хувь болж суурь төсөөллөөс 1.7 нэгж хувиар буурахаар байна.¹⁴

6.2. Макро эдийн засгийн эрсдэл

6.2.1. Макро эдийн засгийн орчин болон эрсдэлийн тойм

Уул уурхайн цөөн нэр төрлийн бүтээгдэхүүнээс ихээхэн хамааралтай манай улсын хувьд төсвийн орлогын төлөвлөлтөд макро эдийн засаг болон гадаад худалдааны үзүүлэлтийн төсөөллийг оновчтой гаргах нь онцгой ач холбогдолтой байдаг. Ялангуяа уул уурхайн салбарын дам нөлөө жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа нь манай улсын гадаад худалдаа, эдийн засаг, төсөв, санхүүгийн гүйцэтгэл гадаад орчноос хамаарах хамаарлыг улам нэмэгдүүлж байна.



Эх сурвалж: ҮСХ

Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тогтмол өсөж, сүүлийн таван жилийн дунджаар нийт экспортын 92 хувийг дангаар бүрдүүлж байна. Экспортын бүтцийн түүхэн хандлагыг авч үзвэл, 2000–2009 онд уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 68 орчим хувийг бүрдүүлж байсан бол дараагийн 10 жилд түүхий эдийн зах зээлийн таатай нөхцөл болон Оюутолгойн төсөл эхэлж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр 89 хувь болж нэмэгдсэн. Харин 2020 оноос хойш БНХАУ-ын зах зээлд


¹³ Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

¹⁴ Сангийн яамны тооцоо

нүүрсний үнэ түүхэн өндөр түвшинд хүрч, үүний зэрэгцээ Засгийн газраас экспортын гол боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, төрийн өмчит уул уурхайн компаниудад менежментийн шинэчлэл хийж, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тогтолцоог нэвтрүүлснээр экспортын хэмжээг түүхэн дээд хэмжээнд хүрч нэмэгдүүлсэн билээ.

Цаашлаад зөвхөн экспортоос гадна эдийн засаг дахь уул уурхайн салбарын дам нөлөө нэмэгдэж байна. Эдийн засгийн бүтцийг салбараар нь задлан харвал, уул уурхай болон түүнээс өндөр хамаарал бүхий тээвэр, худалдаа, боловсруулах зэрэг салбаруудын ДНБ-д эзлэх нийлбэр жин тогтмол өсөх хандлагатай байна. Тухайлбал, 2000–2009 онд уул уурхайн салбарын шууд болон шууд бус нөлөө¹⁵ нийт дотоодын нийт бүтээгдэхүүний дунджаар 21 хувийг эзэлж байсан бол дараагийн 10 жилд 25 хувь болж нэмэгдэж, сүүлийн таван жилд 30 хувьд хүрч өссөн. Энэхүү бүтэц нь түүхий эдийн үнэ болон экспортын биет хэмжээний хэлбэлзэл, дэлхийн зах зээл дэх үнийн савлагаа, худалдааны түнш орнуудын эдийн засгийн идэвхжилд мэдрэг байдлыг нэмэгдүүлж байна.

Уул уурхайн орлогын төсвийн нийт орлогод эзлэх хувь 20 жилийн өмнөхөөс 2 дахин өссөн байна. 2005–2012 онд уул уурхайн орлого нэгдсэн төсвийн нийт төсвийн орлогын 16 орчим хувийг бүрдүүлж байсан бол 2013–2019 онд 22 хувь, сүүлийн 5 жилд 31 хувьд хүрч нэмэгдсэн.



Эх сурвалж: ҮСХ, Сангийн яам

Нүүрс, зэсийн үнийн хэлбэлзэл төсвийн орлогод хамгийн хүчтэй нөлөө үзүүлж байна. “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-д тухайн жилийн нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа тухайн төрлийн эрдэс баялгийг “гол нэр төрлийн эрдэс баялаг” гэж үзэх бөгөөд үүнд одоогоор нүүрс болон зэсийн баяжмал хамаарч байна. Иймд нүүрс болон зэсийн баяжмалын экспортын үнэ, биет хэмжээний төсөөлөлд үүсэх зөрүү нь төсвийн нийт орлого, гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл, эдийн засгийн өсөлтийн тооцоонд нөлөөлдөг тул энэхүү бүлэгт эдгээр эрсдэлүүдийн мэдрэмжийг тооцоолох, хувилбарт шинжилгээ хийлээ.

¹⁵ Тээвэр, худалдаа, боловсруулах салбар тус бүрийн хувьд уул уурхайн салбараас авч буй завсрын хэрэглээний нийт завсрын хэрэглээнд эзлэх жинг тооцоолж, эдгээр салбаруудын ДНБ-ийг тус жингээр үржүүлэн хооронд нь нэмж шууд бус нөлөөг тооцсон.

“Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-ийн 4.1.5-д заасны дагуу төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцохдоо гол нэр төрлийн эрдэс баялаг болох нүүрс, зэсийн үнийг тэнцвэржүүлсэн аргачлалаар тооцдог тул дээрх бүтээгдэхүүнүүдийн үнийн хэлбэлзэл нь тэнцвэржүүлсэн орлогод үзүүлэх шууд нөлөө бага байдаг. Харин биет хэмжээний бууралт тэнцвэржүүлсэн орлогыг бууруулах хүчин зүйл болдог.


6.2.2. Гадаад эдийн засгийн орчны төлөв ба эрсдэл

Гадаад эдийн засгийн орчны тогтворгүй байдал 2026 онд үргэлжилнэ. Дэлхий дахин сүүлийн жилүүдэд геополитик, гео-стратегийн хурцадмал нөхцөл байдал, худалдаа, тарифын дайн зэрэг томоохон сорилтуудтай нүүр тулж байна. Эдгээр сорилт, тодорхой бус байдал богино хугацаанд арилахгүй, дунд хугацаанд үргэлжлэх төлөвтэй байгааг ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагууд онцолжээ.

Тухайлбал, АНУ-ын “America First” бодлогын хүрээнд хэрэгжиж буй тарифын өөрчлөлтүүд дэлхийн нийлүүлэлтийн сүлжээ, үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж, БНХАУ-тай хийх худалдааны хэлэлцээрийн тодорхойгүй байдал гадаад орчны эрсдэлийг улам нэмэгдүүлэв.

Түүнчлэн, Ойрх Дорнодын геополитикийн нөхцөл байдал ширүүсэж, дайны байдалд шилжвэл газрын тосны үнэ 2022 оны дээд түвшин буюу 120 ам.долларт хүрэх, бусад аж үйлдвэрийн түүхий эдийн үнийн хэлбэлзэл эрс нэмэгдэх эрсдэлтэй гэж зарим олон улсын байгууллагууд анхааруулж байна. Сүүлийн 3 жилд гадаад орчны тодорхой бус байдал, сорилтууд манай эдийн засагт нөлөөлж ирсэн гол 3 сувгийг дараах схемээр харууллаа.

Зураг 45. Гадаад орчны эрсдэлийн суваг



6.2.3. Мэдрэмжийн шинжилгээ

Монгол Улсын хувьд гадаад орчны эрсдэл нь экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрс, зэсийн баяжмалын үнэ, эрэлтийг бууруулж, улмаар төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх эрсдэлийг үүсгэдэг. Иймд бусад хүчин зүйлс тогтмол үед 2026 онд нүүрс, зэсийн үнэ буурах, нүүрсний экспортын биет хэмжээ буурах хувилбаруудаар мэдрэмжийн шинжилгээг хийж, экспортын орлого болон төсвийн орлогод үзүүлэх нөлөөг үнэллээ.

Шинжилгээний үр дүнд экспортын орлого болон төсвийн нийт орлогод нүүрсний биет хэмжээний бууралт хамгийн өндөр нөлөө үзүүлэхээр байна. Тухайлбал, нүүрсний биет хэмжээ суурь төсөөллөөс 1 сая тонноор буурахад экспортын орлого ДНБ-ий 0.2 хувь, төсвийн тэнцвэржүүлсэн орлого ДНБ-ий 0.06 хувьтай тэнцэх хэмжээгээр буурахаар байна. Харин зэсийн үнэ 1 хувиар буурахад төсвийн орлого ДНБ-ий 0.02 хувиар буурах бол нүүрсний үнийн бууралтын нөлөө харьцангуй өндөр буюу ДНБ-ий 0.05 хувьтай тэнцэж байна.¹⁶

Хүснэгт 54. Төсвийн үндсэн үзүүлэлтийн мэдрэмжийн шинжилгээ

| Хувилбар | Төсөвт тооцсон дүн | Экспортын орлого | | Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн | |
|--|--------------------|------------------|-------------|---|--------------|
| | | ДНБ % | Их наяд ₮ | ДНБ % | Их наяд ₮ |
| Нүүрсний биет хэмжээ 1 сая тонноор буурахад | | | | | |
| Суурь утга | 90.0 сая тн | 62.5 | 63.9 | 30.9 | 31.6 |
| Нүүрсний биет хэмжээ буурах хувилбар | 89.0 сая тн | 62.2 | 63.6 | 30.8 | 31.5 |
| Суурь хувилбараас зөрүү | -1.0 сая тн | -0.3 | -0.3 | -0.06 | -0.06 |
| Нүүрсний үнэ 1 хувиар буурахад | | | | | |
| Суурь утга | 70.0 \$/тн | 62.5 | 63.9 | 30.9 | 31.6 |
| Нүүрсний үнэ буурах хувилбар | 63.0 \$/тн | 62.3 | 63.7 | 30.8 | 31.5 |
| Суурь хувилбараас зөрүү | -7.0 \$/тн | -0.2 | -0.2 | -0.05 | -0.05 |
| Зэсийн баяжмалын үнэ 1 хувиар буурахад | | | | | |
| Суурь утга | 9,700 \$/тн | 62.5 | 63.9 | 30.9 | 31.6 |
| Зэсийн баяжмалын үнэ буурах хувилбар | 9,603 \$/тн | 62.3 | 63.7 | 30.9 | 31.6 |
| Суурь хувилбараас зөрүү | 97.0 \$/тн | -0.2 | -0.2 | -0.02 | -0.02 |

Эх сурвалж: Сангийн яамны тооцоолол

ХУВИЛБАР 1. НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭ СУУРЬ ТӨСӨӨЛЛӨӨС 5 САЯ ТОННООР БУУРАХ

АНУ-БНХАУ-ын худалдааны дайн гүнзгийрэх, БНХАУ-ын гангийн экспортод улс орнуудын тавих гаалийн татварын хоригийн цар хүрээ нэмэгдэх, геополитикийн хурцадмал байдлын улмаас “Тэг-Ковид”-той төстэй арга хэмжээ авах нөхцөл байдал үүсэх зэрэг онцгой тохиолдолд манай улсын нүүрсний экспортын биет хэмжээ буурч болзошгүй.

¹⁶ Сангийн яамны тооцоо

Иймд дээрх эрэлт талын эрсдэлийг харгалзан үзэж 2026 онд нүүрсний биет хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс 5 сая тонноор буурах хувилбарыг тооцооллоо. Нүүрсний экспортын биет хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс 5 сая тонноор буурсан тохиолдолд экспортын орлого 1.3 их наяд, төсвийн орлого 0.3 их наяд төгрөгөөр буурахаар байна.

Хүснэгт 55. Нүүрсний биет хэмжээний бууралтын төсөвт үзүүлэх нөлөө

| Хувилбар №1 | Биет хэмжээ, сая тн | Экспортын нөлөө | | Төсвийн нөлөө | |
|--|---------------------|-----------------|-----------|---------------|-----------|
| | | ДНБ % | Их наяд ₮ | ДНБ % | Их наяд ₮ |
| Суурь төсөөлөл | 90.0 | 62.5 | 63.9 | 30.9 | 31.6 |
| Нүүрсний экспортын биет хэмжээ 5 сая тонноор буурснаар | 85.0 | 61.2 | 62.6 | 30.6 | 31.3 |
| Зөрүү | -5.0 | -1.3 | -1.3 | -0.3 | -0.3 |

Эх сурвалж: Сангийн яамны тооцоолол

ЭРСДЭЛ ТОХИОХ МАГАДЛАЛ: БАГА

Олон улсад худалдааны зөрчил, өндөр татварын бодлого, геополитикийн хурцадмал байдал болон БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр эдийн засгийн тодорхойгүй байдал давамгайлж байна. Гэсэн хэдий ч 2026 оноос хэрэгжиж эхлэх БНХАУ-ын эдийн засгийн шинэ загвар нь шинжлэх ухаан, дэвшилтэт техник, технологид суурилсан бүтцийг цогцлоож, өндөр чанартай гангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэхээр байгаа нь коксжих нүүрсний эрэлтийг тогтвортой хадгалах боломжтой гэж шинжээчид үзэж байна.¹⁷

Монгол Улсын Засгийн газраас боомтын нэвтрүүлэх хүчин чадал болон тээврийн гарцыг нэмэгдүүлэх бодлогыг баримталж, арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлж байгаа нь нүүрсний экспортын тогтвортой байдлыг хангах чухал нөхцөл болж байна. Энэ хүрээнд Гацуунсухайт–Ганцмодын төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлсэн бол Ханги, Шивээхүрэн боомтын төмөр замын төслийг эхлүүлэхээр төлөвлөсөн нь экспортын гарцыг төрөлжүүлж, тээврийн саатал, тасалдлын эрсдэлийг бууруулах стратегийн чухал ач холбогдолтой болж байна.

Түүнчлэн Засгийн газраас төмөр замын тээврийн тарифыг авто тээврийн тарифтай өрсөлдөхүйц хэмжээнд бууруулж, аж ахуйн нэгжүүдийн зардлыг мэдэгдэхүйц багасгаж, зах зээлд нийлүүлэх хэмжээг тогтвортой хадгалах боломжийг бүрдүүлэв. Мөн гаалийн бүрдүүлэлтийг үе шаттай сайжруулж, цахим системийг нэвтрүүлснээр ачилт, хяналт, нэвтрэлтийн хугацаа багасгаж, экспортын урсгал саадгүй үргэлжлэх нөхцөл хангагдаж байна.

¹⁷ Дэлхийн эдийн засгийн форум, WEF

НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Манай улс нүүрсний бүртгэгдсэн 30-35 тэрбум тонн гаруй нөөцтэй ба дэлхийн нийт нөөцийн 3 орчим хувийг эзэлдэг. Монгол Улсын орд газрууд нутгийн өмнөд хэсгээр буюу БНХАУ-ын Баяннуур, Жинин, Шаньси, Гансу зэрэг аж үйлдвэрийн томоохон цогцолбор бүхий мужуудтай ойр байршилтай, мөн үнийн хувьд өрсөлдөх чадвар өндөр тул сүүлийн 10 хүрэхгүй жилийн хугацаанд БНХАУ-ын чулуун нүүрсний зах зээлд томоохон тоглогч болж чаджээ.

Зураг 46. Нүүрсний экспортын гүйцэтгэл




Эх сурвалж: ҮСХ, ГЕГ

Монгол Улс 2005-2009 оны хооронд жилд дунджаар 4 сая тонн нүүрс экспортолдог байсан бол БНХАУ-ын гангийн эрэлт, хэрэгцээ нэмэгдэж, манай нүүрсний салбарт орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэний нөлөөгөөр 2010 оноос 2021 оны хооронд жилд дунджаар 24 сая тонн болж нэмэгдэн, сүүлийн 3 жилд Боомтын сэргэлтийн хүрээнд хийгдсэн дэд бүтцийн шинэчлэлийн үр дүнд нүүрсний экспортыг 2024 онд түүхэн дээд буюу 84 сая тонн хүргэж өсгөж чадсан. Ойрын жилүүдэд Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын үр дүнд 30 сая тонн, бусад экспортын боомтуудын төмөр замын холболтын төслүүдийн үр дүнд 80-100 сая тонноор нэмэгдэх боломжтой гэж шинжээчид үзэж байна.

ХУВИЛБАР 2. НҮҮРСНИЙ ХИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ СУУРЬ ТӨСӨӨЛЛӨӨС 10 ХУВИАР БУУРАХ

Зураг 47. Ганцмод боомтын коксжих нүүрсний үнийн хөдөлгөөн, тонн/юань



Эх сурвалж: Sxcoal

Олон улсын гангийн зах зээл болон БНХАУ-ын аж үйлдвэрийн идэвхжил 2025 оны эхний хагаст сулран, нүүрсний дотоодын болон боомтын агуулахын нөөц нэмэгдсэнээр Ганцмод боомт дахь коксжих нүүрсний үнэ огцом унаж, 6 дугаар сард 700 юань/тонн болж сүүлийн 15 жилийн доод түвшинд хүрэв. Харин 7 дугаар сараас нийлүүлэлтийн илүүдэл

харьцангуй багасаж, худалдан авалт нэмэгдсэнээр үнэ сэргэж, 8 дугаар сарын 12-ны байдлаар 1,010 юань/тонн-д хүрсэн байна.¹⁸

Нүүрсний үнийн төсөөлөлд онцолж буй голлох эрсдэлүүдийг дурдвал:

- БНХАУ-ын гангийн эрэлт буурах;
- БНХАУ-ын дотоодын нүүрсний олборлолт, нийлүүлэлт нэмэгдэх;
- Эрчим хүчний бодлого, байгаль орчны хязгаарлалт нэмэгдэх;
- Олон улсын зах зээлд Австрали, ОХУ болон бусад нийлүүлэгчдийн экспорт нэмэгдэж, Монголын нүүрсний өрсөлдөх чадвар буурах зэрэг болно.

Дээрх эрсдэлүүдийн магадлал харьцангуй бага боловч тохиолдсон нөхцөлд 2026 онд нүүрсний үнэ суурь түвшнээс 10 хувиар буурах хувилбарыг тооцлоо. Нүүрсний үнийн 10 хувийн бууралт ойролцоогоор экспортын орлогыг 2.3 их наяд төгрөгөөр, төсвийн орлогыг 0.5 их наяд төгрөгөөр бууруулахаар байна.

ЭРСДЭЛ ТОХИОХ МАГАДЛАЛ: БАГА

Ганцмод боомтын коксжих нүүрсний үнэ 2025 оны 6 сард хамгийн бага түвшиндээ хүрсэн нь сүүлийн 15 жилийн доод буюу олборлох өртөгт ойртсон тул, 2026-2027 онуудад энэ онтой адил огцом бууралт ажиглагдахгүй гэж шинжээчид үзэж байна.¹⁹ “Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд 2026 онд нүүрсний хилийн дундаж үнийг тонн тутамд 70 ам.доллар байхаар тооцсон тул үнэ цаашид буурах магадлал бага гэж үзэж байна.

Хүснэгт 56. Нүүрсний үнийн бууралтын төсөвт үзүүлэх нөлөө

| Хувилбар №2 | Үнэ | Экспортын нөлөө | | Төсвийн нөлөө | |
|--|------|-----------------|-----------|---------------|-----------|
| | | ДНБ % | Их наяд ₮ | ДНБ % | Их наяд ₮ |
| Суурь төсөөлөл | 70.0 | 62.5 | 63.9 | 30.9 | 31.6 |
| Нүүрсний хилийн дундаж үнэ 10 хувиар буурснаар | 63.0 | 60.3 | 61.6 | 30.4 | 31.1 |
| Зөрүү | -7.0 | -2.2 | -2.3 | -0.5 | -0.5 |

ХУВИЛБАР 3. ЗЭСИЙН ҮНЭ 10 ХУВИАР БУУРАХ

ОУВС болон Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагууд 2026 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 0.3 нэгж хувиар бууруулсан бөгөөд энэ нь дэлхийн зэсийн эрэлтийг бууруулах эрсдэл болж байна. Зэсийн үнийн төсөөлөлд онцолж буй голлох эрсдэлүүдийг дурдвал:

- Дэлхийн болон БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт удааширах;
- Зэсийн олборлолт, нийлүүлэлтийн тасалдлыг бий болгох;
- Геополитикийн тодорхойгүй байдал, хөрөнгө оруулагчдын болгоомжлолыг нэмэгдүүлэх;

¹⁸ Эх сурвалж: Sxcoal

¹⁹ Fitch

- Худалдааны дайн болон АНУ-ын зэсийн тариф нь зэсийн арилжааны урсгал, эрэлтийн бүтцийг өөрчлөх зэрэг болно.

Дэлхийн эдийн засагт дээрх эрсдэлүүдийн магадлал харьцангуй бага боловч тохиолдсон нөхцөлд 2026 онд зэсийн үнэ суурь түвшнээс 10 хувиар буурах хувилбарыг тооцлоо. Зэсийн баяжмалын үнийн 10 хувийн бууралт экспортын орлогыг 2.1 их наяд, төсвийн нийт орлогыг 0.2 их наяд төгрөгөөр бууруулахаар байна.

Хүснэгт 57. Зэсийн үнийн бууралтын төсөвт үзүүлэх нөлөө

| Хувилбар №3 | Үнэ | Экспортын нөлөө | | Төсвийн нөлөө | |
|--------------------------------|---------|-----------------|-----------|---------------|-----------|
| | | ДНБ % | Их наяд ₮ | ДНБ % | Их наяд ₮ |
| Суурь төсөөлөл | 9,700.0 | 62.5 | 63.9 | 30.9 | 31.6 |
| Зэсийн үнэ 10 хувиар буурснаар | 8,730.0 | 60.4 | 61.8 | 30.6 | 31.4 |
| Зөрүү | 970.0 | -2.1 | -2.1 | -0.2 | -0.2 |

Эх сурвалж: Сангийн яамны тооцоолол

ЭРСДЭЛ ТОХИОХ МАГАДЛАЛ: ДУНД

Дэлхийн эдийн засгийн өсөлт саарах, зэсийн баяжмалын эрэлт буурах эрсдэл байгаа хэдий ч нүүрстөрөгчийг бууруулах олон улсын санаачилга, цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээ, технологийн дэвшил зэрэг хүчин зүйл зэсийн үнэд эергээр нөлөөлөх төлөвтэй байна. Тухайлбал, ANZ Research-ийн тооцоогоор зэсийн эрэлт 2030 он хүртэл жилд 4–5 хувиар өсөж 38.5 сая тоннд хүрнэ гэж таамаглажээ. ВМІ-ийн тооцоогоор нийлүүлэлтийн өсөлт ирэх 10 жилд жилд дунджаар 2.9 хувь байх төлөвтэй бөгөөд энэ нь үнийг дэмжих суурь нөхцөл болж, хөрөнгө оруулалтын банкнууд 2025 онд дундаж үнийг 9,700 ам.доллар, 2026 онд 9,990 ам.долларт хүрнэ гэж үзэж байна.²⁰

ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛД ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

1. Төсөв, санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой эрсдэлийг бууруулах арга хэмжээ:

“Төсвийн тогтворжуулалтын сан”: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16.1-д үндэслэн байгуулсан Төсвийн тогтворжуулалтын сан нь нэгдсэн төсвийн дунд болон урт хугацааны тогтвортой байдлыг хангах чухал хэрэгсэл юм. Төсвийн тогтворжуулалтын сан болон Ирээдүйн өв сангийн үлдэгдэл 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 2.0 их наяд төгрөг байна.

Түлш, шатахууны урт хугацаат гэрээ: ОХУ-Украины дайн эхэлсэн 2022 онд дэлхий дахин газрын тос, эрчим хүчний үнийн томоохон сорилттой нүүр тулсан. Улмаар Монгол Улсын Засгийн газар үнийн хэлбэлзлийн эрсдэлийг бууруулах зорилгоор гол нийлүүлэгч “Роснефть” компанитай гэрээ байгуулж, шатахууны үнийг 2027 он хүртэл зах зээлийн үнээс хямд, хөнгөлөлттэй үнээр нийлүүлж байна.

²⁰ Эх сурвалж: Bloomberg

2. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, бүтцийг төрөлжүүлэхтэй холбоотой эрсдэлийг бууруулах арга хэмжээ:

Экспортыг нэмэгдүүлэх, худалдааг дэмжих Засгийн газрын Ажлын хэсэг: Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх Ажлын хэсгийг байгуулсан. Энэ хүрээнд экспортын дэд бүтцийг сайжруулж, тээврийн өртгийг бууруулах, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулах, уул уурхайн биржийн арилжааг идэвхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлээд байна.

Хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх: Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Боомтын сэргэлт хэрэгжиж эхэлснээр томоохон боомтуудын бүрэн шинэчлэлийг үе шаттай эхлүүлсэн. Үүний үр дүнд хилийн нэвтрүүлэх хүчин чадал 3-4 дахин нэмэгдэж, Монгол Улс түүхэндээ хамгийн өндөр буюу 2023 онд 70 сая тонн, 2024 онд 84 сая тонн нүүрс экспортолж чадсан.

Уул уурхайн бүтээгдэхүүний бирж: 2023 оноос эхлэн уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль батлагдаж, ТӨААН-үүд бүтээгдэхүүнээ экспортод гаргахад шууд гэрээгээр бус биржээр арилжиж эхэлсэн. Цаашлаад уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг уян хатан болгох, форвард гэрээний нөхцөлийг хүргэлттэй уялдуулан тодорхой хугацааны мөчлөгтэй шинэчлэх боломжийг бүрдүүлж, биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэн ажиллаж байна.

Эдийн засгийг төрөлжүүлэх: Засгийн газар эдийн засгийн төрөлжилтийг дэмжих хүрээнд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэх бодлого хэрэгжүүлж байна. Тухайлбал, бүх төрлийн боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас хөнгөлөх, үйлдвэрлэл, технологийн паркт үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад шаардлагатай барилгын материал, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөх, нэмэгдсэн өртгийн албан татварын төлөлтийг хойшлуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байгаа нь дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэхэд чиглэж байгаа болно.

6.3. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд хийсэн эрсдэлийн шинжилгээ

6.3.1. ТӨААН-үүдийн санхүүгийн нөхцөл байдал

Төрийн өмчит аж ахуй нэгж нь Монгол улсын эдийн засагт, ялангуяа уул уурхай, эрчим хүч, тээвэр зэрэг стратегийн салбаруудад чухал үүрэг гүйцэтгэдэг ба борлуулалтын орлогоос гадна нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэх, үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх зэрэг хосолсон үүрэг хүлээдэг.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны статистикийн мэдээнд дурдсанаар, Монгол Улсад 9 өөр салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт 87 ТӨААН бүртгэлтэй байгаа бөгөөд эдгээр нь дотоодын нийт бүтээгдэхүүний 74 хувь, нийт ажиллах хүчний 4.1 хувийг эзэлж байна. Үүнд “Эрдэнэс Монгол” нэгдлийн дор 21 охин компаниуд мөн багтсан болно. Монгол улсын нийт 87 ТӨААН-үүдийг шинжилгээний хүрээнд дараах байдлаар ангилсан:

- Санхүүгийн бус ашгийн төлөөх ТӨААН
- Санхүүгийн ТӨААН
- Ашгийн бус ТӨААН

Хүснэгт 58. Шинжилгээний үндсэн ангиллаар ангилсан ТӨААН-үүдийн санхүүгийн үзүүлэлт, их наяд төгрөгөөр

| Ангилал | ТӨААН | Нийт орлого | Үйл ажиллагааны ашиг/алдагдал | Өр төлбөр | Хөрөнгө | Ажиллагчид |
|------------------------|-----------|-------------|-------------------------------|-------------|-------------|---------------|
| Санхүүгийн бус, ашгийн | 38 | 22.0 | 8.2 | 18.2 | 58.5 | 45,468 |
| Санхүүгийн | 7 | 1.1 | 0.1 | 8.4 | 9.6 | 3,737 |
| Ашгийн бус | 42 | 6.5 | 0.7 | 3.2 | 10.7 | 10,473 |
| Нийт | 87 | 29.9 | 5.7 | 22.8 | 59.4 | 59,678 |
| ДНБ-д эзлэх хувь | - | 37% | 7% | 29% | 74% | 4.1%* |

/*Нийт ажиллагчдад эзлэх хувь/ Эх сурвалж: ТӨБЗГ

6.3.2. “ТӨААН-үүдийн санхүү, үйл ажиллагааны байдлын шинжилгээ” /SOE Health check tool/-ийн үр дүн

ТӨААН-ийн санхүүгийн тогтвортой байдал, үйл ажиллагааны үр ашиг, төсөвт үзүүлэх эрсдэлийг үнэлдэг SOE Health checktool загвар нь санхүүгийн бус ашгийн төлөөх ТӨААН-үүд дээр тохируулсан шинжилгээний арга зүй бөгөөд ТӨААН-үүдийг (1) санхүүгийн ашгийн төлөөх, (2) санхүүгийн бус ашгийн төлөөх болон (3) ашгийн бус гэж 3 ангилдаг. Монгол Улсад 2024 оны байдлаар нийт 87 ТӨААН бүртгэлтэй байгаагаас 38 нь санхүүгийн бус ашгийн төлөөх, 7 нь санхүүгийн салбарт, 42 нь ашгийн бус гэх ангилалд тус тус хамаарагдаж байна. Иймд ашигт ажиллагаа, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн зохистой харьцаанд тулгуурлан хөрөнгийн хэмжээгээр хамгийн том санхүүгийн бус ашгийн төлөөх 13 ТӨААН-ийг сонгон авч шинжилгээг хийж гүйцэтгэлээ.

Сонгосон ТӨААН-ийн санхүүгийн эрсдэл, төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлж, шинжилгээний үр дүнг ашгийн чадвар, хөрвөх чадвар, өр төлбөрийн тогтвортой байдлын голлох үзүүлэлтүүдийн эрсдэлийн зэрэг бүхий өнгөөр ялгасан хүснэгтээр илэрхийлсэн ба багаас их рүү шилжих тусам эрсдэлийн зэрэг өндөр болохыг илтгэнэ.

Хүснэгт 59. Сонгосон ТӨААН-үүдийн салбарын ангилал

| Салбар | ААН тоо | ТӨААН |
|---------------------------|---------|---|
| Эрчим Хүч | 3 | ДЦС-4 |
| | | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ Диспетчерийн Үндэсний Төв Эрдэнэс Тавантолгой |
| Уул уурхай Ба Олборлох | 5 | Эрдэнэт үйлдвэр |
| | | Эрдэнэс Критикал Минералс |
| | | Багануур Шивээ Овоо |
| Тээвэр, Логистик | 3 | Монголын төмөр зам Монголын иргэний агаарын тээвэр |
| | | Улаанбаатар төмөрзам |
| Түлш, шатахууны | 2 | Тавантолгой түлш |
| | | Монгол газрын тос боловсруулах үйлдвэр |

АШИГТ АЖИЛЛАГАА:

ТӨААН-үүдийн ашигт ажиллагааны шинжилгээгээр хөрөнгийн өгөөж, эздийн өмчийн өгөөж, үйл ажиллагааны зардлаа нөхөх чадвар зэрэг үзүүлэлтүүдээр эрсдэлийг тодорхойллоо.

Ашгийн үзүүлэлтээр “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ эрсдэл багатай ангилалд байгаа бол “Тавантолгой түлш” ХХК, “Шивээ-Овоо” ХК, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК хувьд эрсдэл өндөр, бусад аж ахуйн нэгжийн хувьд эрсдэл “дундаж” байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн сүүлийн 5 жилийн орлогын тайлангийн шинжилгээг задалж үзвэл үйл ажиллагааны орлого 2020 онд 1.5 их наяд төгрөгөөс 10.3 их наяд төгрөг, цэвэр ашиг 2020 онд 149 тэрбум төгрөгөөс 4.5 их наяд төгрөг болж өссөн нь ашигт ажиллагаанд голлон нөлөөлжээ.

Хүснэгт 60. Сонгосон ТӨААН-үүдийн ашигт ажиллагааны эрсдэлийн шинжилгээ

*Эрсдэлийн зэрэг 1-5 руу өсөхөөр, (1-эрсдэл бага, 5-эрсдэл өндөр)

| АШИГТ АЖИЛЛАГАА | | Хөрөнгийн өгөөж | Эздийн өмчийн өгөөж | Зардал нөхөх чадвар |
|------------------|--|-----------------|---------------------|---------------------|
| Эрчим Хүч | ДЦС-4 | 4 | 3 | 4 |
| | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ | 3 | 3 | 4 |
| | Диспетчерийн Үндэсний Төв | 3 | 3 | 4 |
| | Эрдэнэс Тавантолгой | 1 | 1 | 1 |
| УУ Ба Олборлох | Эрдэнэт үйлдвэр | 1 | 2 | 2 |
| | Эрдэнэс Критикал Минералс | 2 | 2 | 3 |
| | Багануур | 3 | 1 | 3 |
| | Шивээ Овоо | 1 | 5 | 4 |
| Тээвэр, Логистик | Монголын төмөр зам | 3 | 3 | 2 |
| | Монголын иргэний агаарын тээвэр | 3 | 3 | 3 |
| | Улаанбаатар төмөрзам | 3 | 3 | 3 |
| | Тавантолгой түлш | 5 | 5 | 5 |
| Түлш | Монгол газрын тос боловсруулах үйлдвэр | 3 | 5 | 2 |

SOE-НСТ загварын үр дүн

ХӨРВӨХ ЧАДВАР БУЮУ БЭЛЭН МӨНГӨНИЙ ХҮРЭЛЦЭЭ:

Энэхүү шинжилгээгээр тухайн ТӨААН-үүдийн санхүүгийн байдлын тайланд өр төлбөрөө цаг хугацаанд нь барагдуулахад хангалттай эргэлтийн болон мөнгөн хөрөнгө байгаа эсэхийг үнэлдэг.

Хөрвөх чадварын эхний 2 үзүүлэлт хоёул богино хугацаат өр төлбөрийг барагдуулахад эргэлтийн хөрөнгө хангалттай эсэхийг хэмжих ба “Эргэлтийн хөрөнгө ба өр төлөх чадварын харьцаа”-нд нийт эргэлтийн хөрөнгийг, “түргэн хөрвөх чадварын харьцаа”-нд эргэлтийн хөрөнгөөс бараа материал хассан дүн нь тухайн өр төлбөрийг барагдуулахад хүрэлцээтэй эсэхийг шинжилсэн болно.

Ихэнх аж ахуйн нэгжүүдэд хөрвөх чадвар буюу бэлэн мөнгөний хүрэлцээ гол асуудал хэвээр байгаа нь өдөр тутмын үйл ажиллагаагаа санхүүжүүлэх, төлбөрийг хугацаанд нь гүйцэтгэхэд хүндрэл үүсэж байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь бэлэн мөнгөний дутагдлыг нөхөх арга хэмжээ авах эсвэл өрийн зохицуулалт хийх шаардлагатайг илтгэж байна.

*Эрсдэлийн зэрэг 1-5 руу өсөхөөр, (1-эрсдэл бага, 5-эрсдэл өндөр)

| | | ХӨРВӨХ ЧАДВАР | | | |
|------------------|--|--------------------------------------|--------------------------------|--------------------------------|----------------------------------|
| | | Эргэлтийн хөрөнгө ба өр төлөх чадвар | Түргэн хөрвөх чадварын харьцаа | Авлага төлөгдөх дундаж хугацаа | Өглөг барагдуулах дундаж хугацаа |
| Эрчим Хүч | ДЦС-4 | 5 | 4 | 1 | 1 |
| | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ | 4 | 2 | 1 | 1 |
| | Диспетчерийн Үндэсний Төв | 5 | 2 | 1 | 1 |
| УУ Ба Олборлох | Эрдэнэс Тавантолгой | 4 | 2 | 1 | 2 |
| | Эрдэнэт үйлдвэр | 5 | 5 | 1 | 2 |
| | Эрдэнэс Критикал Минералс | 5 | 5 | 1 | 5 |
| | Багануур | 5 | 5 | 1 | 4 |
| | Шивээ Овоо | 5 | 5 | 2 | 5 |
| Тээвэр, Логистик | Монголын төмөр зам | 1 | 1 | 5 | 1 |
| | Монголын иргэний агаарын тээвэр | 5 | 5 | 1 | 2 |
| | Улаанбаатар төмөрзам | 5 | 5 | 1 | 2 |
| Түлш | Тавантолгой түлш | 1 | 1 | 1 | 1 |
| | Монгол газрын тос боловсруулах үйлдвэр | 5 | 5 | 5 | 5 |

SOE-НСТ загварын үр дүн

ӨР ТӨЛБӨР ТӨЛӨХ ЧАДВАР:

Өр төлбөрийн зохистой байдлын харьцаа нь тухайн аж ахуйн нэгж урт хугацаанд бүх өр, төлбөрийн үүргээ биелүүлэх боломжтой эсэх, мөн үүнд өөрийн хөрөнгө, эздийн өмч хэр жин эзэлж байгааг харуулдаг.

Эрсдэлийн зэрэг бага байх тусам үйл ажиллагааны орлого, ашгаараа урт хугацаанд өр төлбөрөө барагдуулах боломжтойг илтгэж байгаа бол өндөр эрсдэлтэй ТӨААН-үүдийн хувьд хөрөнгөө зарах эсхүл нэмэлт хөрөнгө оруулалт татах, өр төлбөрийг дахин санхүүжүүлэх замаар өр төлбөр төлөх чадвараа сайжруулах шаардлагатай байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас бусад аж ахуйн нэгжийн хувьд өр, EBITDA харьцаа өндөр эрсдэлтэй зэрэгт байгаа нь ашиг багасаж, мөнгөн урсгал суларсан үед өрийн дарамт өндөр болохоор байна.

*Эрсдэлийн зэрэг 1-5 руу өсөхөөр, (1-эрсдэл бага, 5-эрсдэл өндөр)

| | | ӨР ТӨЛБӨР ТӨЛӨХ ЧАДВАР | | | | | НИЙТ ЭРСДЭЛИЙН ЗЭРЭГ |
|----------------|-------|-------------------------------|--------------------|----------------------------|-------------------------------------|----------------------------|-----------------------------|
| | | Өр, эздийн өмчийн харьцаа | Өр, EBITDA харьцаа | Хүү төлөх чадварын харьцаа | Мөнгөн хүүгийн үйлчилгээний харьцаа | Өрийн үйлчилгээний харьцаа | |
| Эрчим Хүч | ДЦС-4 | 2 | 5 | | | 5 | 3 |
| | УБЦТС | 1 | 5 | 3 | 4 | 5 | 3 |
| | ДҮТ | 5 | 5 | 1 | 1 | 2 | 3 |
| УУ Ба Олборлох | ЭТТ | 1 | 1 | 1 | 1 | | 2 |
| | ЭҮ | 1 | 1 | 1 | 1 | 1 | 2 |
| | ЭКМ | 3 | 5 | 1 | 1 | 1 | 3 |
| | БГН | 5 | 5 | 4 | 5 | 5 | 4 |
| | ШО | 5 | 5 | 5 | 5 | 5 | 4 |

| | | | | | | | |
|---------------------|-------|---|---|---|---|---|---|
| Тээвэр, Логистик | МТЗ | 5 | 5 | 1 | 1 | 4 | 3 |
| | МИАТ | 5 | 5 | 3 | 5 | 1 | 3 |
| | УБТЗ | 1 | 5 | 3 | 5 | 3 | 3 |
| Түлш | ТТТ | 5 | 5 | | | | 3 |
| | МГТБҮ | 5 | 5 | 1 | 1 | 5 | 4 |

SOE-НСТ загварын үр дүн

ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮНД:

Нийт эрсдэлийн зэрэг: ТӨААН-үүдийн санхүүгийн эрсдэлийн төлөв байдал нь харилцан адилгүй ба нийт эрсдэлийн шинжилгээгээр санхүүгийн эрүүл мэндийн харьцааг дараах гурван түвшинд хувааж авч үзэж болохоор байна.

Нэгдүгээрт, Уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхэлж, бүтээгдэхүүнээ экспортод гаргадаг “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ зэрэг аж ахуйн нэгжийн хувьд санхүүгийн эрсдэл бага, ашигт ажиллагаа өндөр, хөрвөх чадвар сайн буюу нийт эрсдэл доогуур байгаа бол бүтээгдэхүүнээ дотоодын цахилгаан станц, өрхөд борлуулдаг "Багануур" ХК, "Шивээ-Овоо" ХК хувьд хэдий нээлттэй компани ч үнийн хүчтэй зохицуулалтын нөлөөгөөр ашигт ажиллагаа, хөрвөх чадвар, өр төлбөр барагдуулах чадвар аль аль нь сул, санхүүгийн эрсдэл өндөр байна.

Хоёрдугаарт, Санхүүгийн бус, ашгийн төлөөх ТӨААН-үүд сүүлийн 5 жилд хөрөнгийн өгөөж 0 хувиас 9.6 хувь болж эрс нэмэгдсэн боловч, үүнд цөөн тооны, тэр дундаа гадаад орчноос өндөр хамааралтай уул уурхайн аж ахуйн нэгжүүд өндөр жин эзэлж байгаа нь эмзэг байдлыг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна.

Гуравдугаарт, үйл ажиллагаа нь бүрэн эхлээгүй, бүтээн байгуулалтын шатанд байгаа ТӨААН-үүдийн хувьд үйл ажиллагаа нь жигдэртэл төсөв, санхүүгийн эрсдэл өндөр гарах төлөвтэй байна.

ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛД ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ:

ТӨААН-үүдэд хамаарах төсөв, санхүүгийн эрсдэлийг бууруулахад засаглалын тогтолцоо, өмчлөгчийн болон үйл ажиллагааны үүргийн зааг, бие даасан, хүчтэй төлөөлөн удирдах зөвлөл, ил тод тайлагнал зэрэг чухал ач холбогдолтой байдаг. Энэхүү зарчмын дагуу Монгол Улсын Засгийн газраас Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, хариуцлагатай байдлыг сайжруулах зорилго бүхий хуулийн төслийг танилцуулж, Монгол Улсын Их Хуралд өргөн барьсан.

Хуулийн төсөлд туссан томоохон шинэчлэлүүдийг дурдвал төрийн өмчлөлийн төвлөрсөн хяналтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хэрэгжүүлэх, Удирдах зөвлөлийн гишүүдийг шатлан дэвших шалгуурт суурилан томилох, гүйцэтгэлд суурилсан удирдлагын гэрээг нэвтрүүлэх, ногдол ашгийн бодлого, зээллэгийн хязгаар зэрэг санхүүгийн хяналтуудыг бий болгох зэрэг болно.

Засгийн газар стратегийн ТӨААН-уудад бүрэн эрхт төлөөлөгч томилж ирсэн туршлагатай бөгөөд энэ нь бодлогын уялдаа, ил тод байдал, стратегийн хяналтыг бэхжүүлэх ач холбогдолтой. Тухайлбал, 2025 оны 7 дугаар сард “Эрдэнэс Тавантолгой” ХК-д компанийн засаглалыг сайжруулах, олборлолт, борлуулалт, тээвэрлэлтийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг 50 хувиар бууруулах зорилго бүхий Онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн багийг томилоод байна.

6.4. Засгийн газрын өрийн эрсдэл

6.4.1. Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн үзүүлэлтүүд

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцааг 60 хувь байхаар заасан. Өрийн удирдлагын тухай хууль 2015 онд батлагдсанаар Засгийн газрын өрийн **өнөөгийн үнэ цэнээр** илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцааг 2015 оны төсвийн жилд 58.3 хувиас, 2016 оны төсвийн жилд 88 хувиас, 2017 оны төсвийн жилд 85 хувиас, 2018 оны төсвийн жилд 80 хувиас, 2019 оны төсвийн жилд 75 хувиас, 2020 оны төсвийн жилд 70 хувиас, 2021 болон 2022 оны төсвийн жилд 70 хувиас, 2023 оны төсвийн жилд 65 хувиас, 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас хэтрүүлэхгүй байхаар тус тус заасан байдаг.


Харин дээрх хуульд 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг **нэрлэсэн дүнгээр** илэрхийлдэг болгон өөрчилсөн бөгөөд энэ нь өрийн харьцаа тооцох аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэх ач холбогдолтой.

Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 2016 оноос хойш 2.2 дахин буураад байна. Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 2016 онд 93.1 хувьтай тэнцэж байсан бөгөөд 2020 онд цар тахлын нөлөөнөөс шалтгаалан 75.5 хувь болсон бол үүнээс бусад жилүүдэд

тогтмол буурч, 2024 оны жилийн эцсийн байдлаар 33.4 их наяд төгрөгтэй, ДНБ-ний 41.8 хувьтай тэнцэж байна. Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаартай нийцэж байна.

Засгийн газрын өрийн төсөөллийн хувьд төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцтэй буюу дунд хугацаанд ДНБ-ний 45 хувь орчимд тогтворжихоор байна. Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөлөлд Засгийн газрын гадаад хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг түлхүү ашиглах, мөн Засгийн газрын өрийн баталгааг боломжит түвшинд гаргах тооцооллыг Засгийн газрын өрийн төсөөлөлд ашигласан.

Зураг 48. Засгийн газрын өрийн динамик



Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийг өрийн зардал, дахин санхүүжилтийн эрсдэл, хүүгийн түвшний эрсдэл болон ханшийн эрсдэлийн үзүүлэлтүүдээр хэмждэг. Дэлхийн банк болон Олон Улсын Валютын сангаас хамтран боловсруулсан өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн (MTDS) загварыг ашиглан тооцсоноор Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн үзүүлэлтүүд 2024 оны жилийн эцсийн байдлаар дараах байдалтай байна.

Хүснэгт 63. Засгийн газрын өрийн зардал, эрсдэлийн үзүүлэлтүүд, 2024 он

| Эрсдэлийн үзүүлэлт | | ЗГ-ын өр (ЗГӨБ* ороогүй) | ЗГ-ын өр (ЗГӨБ* орсон) |
|----------------------------|--|-----------------------------|---------------------------|
| Өрийн багцын зардал | Хүүгийн зардлын ДНБ-д эзлэх хувь | 1.5 | 1.5 |
| | Жигнэсэн дундаж хүү (хувь) | 4.3 | 4.6 |
| Дахин санхүүжилтийн эрсдэл | АТМ ²¹ (жил)- эргэн төлөгдөх дундаж хугацаа | 7.5 | 7.2 |
| Хүүгийн түвшний эрсдэл | АТР ²² (жил)- хүүгийн түвшин шинэчлэгдэх дундаж хугацаа | 6.5 | 6.3 |
| Ханшийн эрсдэл | Гадаад валютаарх өр (нийт өрд эзлэх хувь) | 96.1 | 96.3 |

*Засгийн газрын өрийн баталгаа

Засгийн газрын өрийн хүүгийн зардлын ДНБ-д харьцуулсан харьцаа тогтвортой буурч байна. Засгийн газрын хүүгийн зардал 2017 онд 1,156.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ны 4.3 хувь, төсвийн орлогын 14.5 хувьтай тэнцэж байсан бол 2024 онд 1,165.9

²¹ Average time to Maturity

²² Average time to Re-fixing

тэрбум төгрөг буюу ДНБ-ны 1.5 хувь, төсвийн орлогын 3.9 хувьтай тэнцүү болж тус тус буураад байна.

Засгийн газрын өрийн жигнэсэн дундаж хүүгийн түвшин сүүлийн жилүүдэд олон улсын зах зээлд хувьсах хүүгийн хувь өссөнтэй холбоотойгоор нэмэгдэж байна. Засгийн газрын өрийн багцын жигнэсэн дундаж хүүгийн түвшин 2017 онд 4.8 хувь байсан бол 2024 онд 4.2 хувьд хүрч буурсан байна.

Засгийн газрын өрийн багцын зардлын үзүүлэлтүүд 2025 болон 2026 онд тогтвортой түвшинд хадгалагдахаар байна. Хүүгийн зардал 2025 онд 1,292.9 тэрбум төгрөг, 2026 онд 1,299.2 тэрбум төгрөг буюу харгалзан ДНБ-ны 1.4 хувь, 1.3 хувьтай тэнцэхээр байна.

Засгийн газрын өрийн дахин санхүүжилтийн эрсдэл бага түвшинд хадгалагдаж байна. Засгийн газраас дунд хугацааны стратегийн баримт бичгийн дагуу арилжааны нөхцөлтэй гадаад үнэт цаасны хэмжээг үе шаттай бууруулж хугацаа тулсан томоохон гадаад төлбөрийг шийдвэрлэж ирсэн. Тухайлбал, 2021-2024 онд нийт 2.9 тэрбум ам.долларыг Сенчири-1, Сенчири-2, Сенчири-3 бондын хүрээнд төлсөн бөгөөд Сенчири-1 бондын хувьд түүхэн хамгийн бага хүүтэйгээр гарсан, Сенчири-2 бондыг цар тахлын дараах олон улсын санхүүгийн хямралын үед амжилттай гаргасан бол Сенчири-3 бондыг хамгийн бага эрсдэлийн нэмэгдэлтэйгээр гаргаж, үлдэгдэл хэсгийг мөнгөн хөрөнгийн эх үүсвэрээр төлсөн. Ингэснээр Засгийн газрын өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа 2024 оны жилийн эцсийн байдлаар 7.5 жилтэй тэнцэж байна.

Хүүгийн түвшин шинэчлэгдэх хугацаа 6.3 жил байгаа бөгөөд Засгийн газрын өрийн үлдэгдлийн 80.2 хувийг тогтмол хүүтэй үнэт цаас, зээл эзэлж байна. Засгийн өрийн 19.8 хувийг хувьсах хүүтэй гадаад зээл эзэлж байгаа бөгөөд энэ нь нийт гадаад зээлийн 29.8 хувийг эзэлж байна. Түүнчлэн, 2024 оны жилийн эцсийн байдлаар хүүгийн түвшин шинэчлэгдэх дундаж хугацаа 6.3 жил байгаа нь өмнөх онуудтай ойролцоо түвшинд байна.

Засгийн газрын өрийн 96.1 хувийг гадаад өр эзэлж байна. Үүнээс 2024 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын нийт гадаад өрийн 64.8 хувийг хөнгөлөлттэй нөхцөлтэй гадаад зээл, 25.9 хувийг гадаад үнэт цаас эзэлж байна. Гадаад өрийн нийт өрд эзлэх хувь нэмэгдсэн нь Засгийн газрын өрийн зардлыг бууруулах зорилгоор Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг бага хүүтэй гадаад хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаатай холбоотой.

Монгол Улс Дэлхийн банкны ангиллаар дунджаас дээгүүр орлоготой орон болсноор гадаад зээлийн өртөг нэмэгдэж байна. Монгол Улс Дэлхийн банкны орлогын ангиллаар 2011 онд дунджаас доогуур орлоготой (lower-middle income) орны ангилалд орсон бол 2024 онд дунджаас дээгүүр орлоготой (upper-middle income) орны ангилалд шилжсэн. Үүний үр дүнд олон улсын байгууллага болон хөгжлийн түнш орнуудаас Монгол Улсад олгох зээлийн нөхцөл өөрчлөгдөж, нэн хөнгөлөлттэй зээлийн хөнгөлөлттэй эх үүсвэр холимог буюу энгийн нөхцөлтэй зээлийн эх үүсвэр рүү шилжиж байна.

Засгийн газрын зүгээс дотоод үнэт цаасны нээлттэй арилжааг эхлүүлээд байна. Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 он болон 2026-2028 оны стратегийн баримт

бичгүүдэд Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг тогтмолжуулахаар тусгасан. Үүний дагуу хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, дотоод аж ахуйн нэгжүүдэд төгрөгийн өгөөжийн суурь хүүг тогтоож, хямд эх үүсвэр татах боломжийг бүрдүүлэх зорилгоор 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс дотоод үнэт цаасны нээлттэй арилжааг бага хэмжээтэйгээр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан эхлүүлээд байна.

6.4.2. Өрийн тогтвортой байдлын шинжилгээ

Өрийн тогтвортой байдлын шинжилгээгээр Засгийн газрын өр богино, дунд хугацаанд хэвийн эрсдэлтэй байхаар гарсан нь Олон улсын валютын сангаас гарсан үр дүнтэй ижил байна. Засгийн газрын өрийн эрсдэлийг тооцох зорилгоор Олон Улсын Валютын сан /цаашид ОУВС/-аас гишүүн орнуудын өрийн тогтвортой байдлын шинжилгээг боловсруулж олон нийтэд мэдээлдэг. Ингэснээр хөрөнгө оруулагчид болон олон улсын санхүүгийн байгууллагууд тухайн улс оронд санхүүжилт олгох болон эрсдэлийн үзүүлэлт тооцохдоо ашигладаг байна.

Засгийн газрын өрийн тогтвортой байдал гэдэг нь Засгийн газар зээлдэгчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, санхүүгийн хямралд өртөхгүйгээр урт хугацаанд өрийн харьцаа үзүүлэлтийг зохистой түвшинд байлгах чадварыг хэлнэ. Тогтвортой байдлыг үнэлэхэд төсвийн тэнцэл, эдийн засгийн өсөлтийн хэтийн төлөв, төсвийн бодлого зэргээс шалтгаалан өрийн эргэн төлөлтийг шийдвэрлэх боломжийг үнэлдэг.

ОУВС-аас Засгийн газрын өрийн тогтвортой байдлын шинжилгээг үндсэн 2 загварчлалаар боловсруулдаг. Үүнд:

- Бага орлоготой орнуудын өрийн тогтвортой байдлыг үнэлэх загвар (LICDSF²³)
- Улсын эрсдэл, өрийн тогтвортой байдлын шинжилгээний загвар (SRDSF²⁴)

Монгол Улсын хувьд 2011 оноос “бага орлоготой” орон ангиллаас гарч “дундаж орлоготой” ангилалд шилжсэн бөгөөд 2023 оноос хойш SRDSF загварыг ашиглан Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг үнэлж ирсэн.

БОГИНО ХУГАЦАА:

ОУВС-аас Засгийн газрын өрийн богино хугацааны эрсдэлийг стресс²⁵ тохиох магадлал 19.5 хувиас их үед эрсдэл өндөр, стресс тохиох магадлал 6.3 хувиас бага үед эрсдэл бага, бусад үед эрсдэл хэвийн байх тооцооллыг гаргасан байна. Тус загварт Монгол Улсын 2024 оны өгөгдлийг оруулж тооцоход 2025-2026 онд стресс тохиох магадлал 13.8 хувь буюу хэвийн эрсдэлтэй гэж үнэлэгдэж байна. Тус стресс тохиох магадлал

Зураг 49. Богино хугацааны загварын үр дүн



²³ Debt Sustainability Framework for Low-Income Countries

²⁴ Sovereign Risk, Debt Sustainability Framework

²⁵ Улс дефолтод орох, зээлжих зэрэглэл муудах, олон улсын зах зээлд нэвтрэх боломжгүй болох зэрэг

өссөн гол шалтгаан нь 2024 онд олон улсын нөхцөл байдал²⁶ муудсантай холбоотой байна.

ДУНД ХУГАЦАА:

Засгийн газрын өрийн дунд хугацааны эрсдэлийг Өрийн төсөөллийн тархалт болон санхүүжилтийн хэрэгцээний түвшнээс тооцдог. Шинжилгээний үр дүнд Өрийн төсөөллийг тархалт хэвийн эрсдэлтэй байгаа бөгөөд хамгийн том нөлөө нь тархалтын өргөн эзэлж байна. Энэ нь сүүлийн 20 жилийн Засгийн газрын өрийн мэдээллээс ирээдүйн 5 жилд өрийн хэлбэлзлийн эрсдэлийн түвшин хэвийн түвшинд байгааг илтгэж байна.

Хүснэгт 64. Дунд хугацааны загварын үр дүн

| Загвар | Үзүүлэлт | Хэмжээ | Эрсдэлийн түвшин | Эрсдэлийн сэрэмжлүүлэг |
|--------------------------|---|--------|------------------|------------------------|
| Өрийн төсөөллийн тархалт | Тархалтын өргөн (5 жилийн дараах тархалтын Хамгийн өндөр-Хамгийн бага хэмжээ) | 94.6% | 1.4 | ... |
| | Өр тогтворжихгүй байх магадлал (2024 оны түвшнээс өсөх магадлал) | 28.2% | 0.2 | ... |
| | Өрийн түвшин х Институтын индекс ²⁷ | 21.0% | 0.5 | ... |
| | Өрийн төсөөллийн тархалтын индекс | ... | 2.1 | Хэвийн |
| Санхүүжилтийн хэрэгцээ | Засгийн газрын Санхүүжилтийн хэрэгцээний ДНБ-д эзлэх хэмжээний дундаж (5 жил) | 2.8% | 1.0 | ... |
| | Банкуудын ЗГ-аас авах авлагын нийт хөрөнгөд эзлэх хувь | 3.9% | 1.3 | ... |
| | Стрессийн үед Банкны ЗГ-аас авах авлагын өөрчлөлт | 2.6% | 0.9 | ... |
| | Санхүүжилтийн хэрэгцээний индекс | ... | 3.1 | Бага |

Харин Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээний эрсдэлийг тооцохдоо дараагийн 5 жилд санхүүжилтийн хэрэгцээний дундаж түвшин, арилжааны банкнуудын Засгийн газраас авах авлагын хэмжээний нийт нөөцөд эзлэх хувь болон стрессийн үед Засгийн газраас авах авлагын хэмжээ хэрхэн өсөх төсөөллийг тооцдог бөгөөд шинжилгээгээр бага эрсдэлтэй гарсан байна. Энэ нь 2026 он хүртэл томоохон өр төлбөрийг төлж барагдуулснаар санхүүжилтийн хэрэгцээний дундаж түвшнийг бууруулсантай холбоотой байна.

²⁶ Загварт олон улсын нөхцөл байдлыг VIX индексээр тооцсон

²⁷ Дэлхийн банкаас тогтоодог институтын чанарын индекс



Ингэснээр доор харуулж буй хүснэгтээр тус 2 эрсдэлийн үзүүлэлтийг индексжүүлж авч үзэхэд дунд хугацаанд Засгийн газрын өрийн эрсдэл хэвийн түвшинд байна.

Хүснэгт 65. Дунд хугацааны эрсдэлийн индекс

| | Бага эрсдэлийн жишиг | Өндөр эрсдэлийн жишиг | Эрсдэлийн түвшин | Индексжүүлсэн хэмжээ |
|--------------------------|-------------------------|--------------------------|---------------------|-------------------------|
| Өрийн төсөөллийн тархалт | 1.1 | 2.1 | 2.1 | 0.5 |
| Санхүүжилтийн хэрэгцээ | 7.6 | 17.9 | 3.1 | 0.1 |
| Дунд хугацааны индекс | 0.3 | 0.4 | | 0.3, Хэвийн |

ОУВС-аас 2022 онд хийсэн өрийн тогтвортой байдлын шинжилгээгээр өндөр эрсдэлтэй гарч байсан. Шинжилгээний үр дүнд Засгийн газрын өрийн эрсдэл богино хугацаанд хэвийн түвшинд байсан бол дунд хугацаанд өндөр эрсдэлийн түвшинтэй байсан. Энэ нь хугацаа тулсан МУХБ-ны бондууд, Монголбанкны своп, Засгийн газраас Хуралдай бонд, Гэрэгэ бондыг төлөхөөр хүлээж байсантай холбоотой.

Дээрх эргэн төлөлтүүдийг хуваарийн дагуу 2023 онд бүрэн төлж барагдуулсан бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хэмжээ 60.5 хувьтай тэнцэж байснаас 41.8 хувь болж 18.7 нэгж хувиар буурсан, эдийн засгийн өсөлт 5-7 хувьтай тэнцэж, гадаад валютын албан нөөцийн хэмжээ 3.4 тэрбум ам.доллараас 5.5 тэрбум ам.доллар болж өссөн зэрэг эдийн засгийн эерэг үзүүлэлтүүдтэй холбоотойгоор эрсдэлийн түвшин буурч хэвийн түвшинтэй гараад байна.

Хүснэгт 66. Өрийн тогтвортой байдлын шинжилгээний дүгнэлт

| Хугацаа | Механик дохио |
|--------------------------|---------------|
| Богино хугацаа | Хэвийн |
| Дунд хугацаа | Хэвийн |
| Өрийн төсөөллийн тархалт | Хэвийн |
| Санхүүжилтийн хэрэгцээ | Бага |

6.4.3. Засгийн газрын болзошгүй өр төлбөр

Засгийн газрын өрийн баталгаа нь баталгаа гаргуулагч зээллэгийн төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд төлбөрийг баталгаа гаргуулагчийн өмнөөс төлж барагдуулахаар Засгийн газрын хүлээсэн үүрэг бөгөөд Засгийн газрын болзошгүй өр төлбөрт хамаарна. Засгийн газар 2011 оноос хойш нийт 11 удаа Засгийн газрын өрийн баталгаа гаргасан. Үүнээс 9 зээллэгийн төлбөр бүрэн төлөгдөж дууссан бол 2 зээлийн төлбөрийг хуваарийн дагуу төлж байгаа бөгөөд өмнө нь баталгаа дуудагдаж байгаагүй байна.

Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2025 оны хагас жилийн байдлаар 176.2 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Энэ нь Монгол Улсын Хөгжлийн банкны “Чойбалсан ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төсөл”-ийг санхүүжүүлэх зорилгоор БНХАУ-ын хөгжлийн банкнаас ашигласан 352.7 сая юанийн зээлийн үлдэгдэл юм.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас олон улсын зах зээлд гаргасан 500 сая ам.долларын үнэт цаас нь Засгийн газрын өрийн баталгаатайгаар гарсан бөгөөд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу орон нутгийн өрд бүртгэгдэж байна.

Засгийн газрын өрийн баталгаатай зээллэгийн хуваарьт үндсэн төлбөр 2026 онд 28.4 тэрбум төгрөг байгаа бөгөөд төлбөрийн дүн харьцангуй бага, Монгол Улсын Хөгжлийн банкны зүгээс зээлийн төлбөрийг хугацаанд нь тогтмол төлж барагдуулж байгаа тул төсөвт учруулах эрсдэлгүй байна.

Аймаг, нийслэл үнэт цаас гаргах эрхтэй болж, санхүүгийн шинэ хэрэгсэл ашиглаж эхэлсэн. Өрийн удирдлагын тухай хуульд 2021 онд нэмэлт өөрчлөлт орж аймаг, нийслэлийн үнэт цаасыг дотоодын зах зээлд, мөн Өрийн удирдлагын тухай хуульд 2024 онд өөрчлөлт орсноор нийслэлийн үнэт цаасыг олон улсын зах зээлд гаргах эрхтэй болсон.

Үүний дагуу НЗДТГ-аас 2024 онд нийт 798.0 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаасыг “Бөөрөлжүүтийн ДЦС-ыг барих төсөл”, “Батарей хуримтлуурын төсөл” болон Улаанбаатар хотын авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлийн төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор гаргасан бол 500.0 сая ам.долларын гадаад үнэт цаасыг “Сэлбэ дэд төвийг орон сууцжуулах төсөл”-д зориулж гаргаад байна. Ингэснээр орон нутгийн өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 2025 оны хагас жилийн байдлаар 2,575.2 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Үүнээс 2,611.5 тэрбум төгрөгийн төлбөрийг 2025-2027 оны хооронд төлөхөөр байгаа бөгөөд үүнээс 2027 онд 2,319.5 тэрбум төгрөгийг төлөхөөр байгаа нь нийслэлийн зүгээс өрийн удирдлага болон эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх шаардлагатай болохыг харуулж байна.

ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛД ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ:

Засгийн газраас өрийн эрсдэлийг бууруулахаар Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигт дурдсан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:


Болзошгүй өр төлбөрийн хэмжээг хязгаарлаж байна. Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн хэмжээг хязгаарлах зорилтыг дунд хугацаанд дэвшүүлсэн нь Засгийн газрын өрийн баталгааны ДНБ-д эзлэх хэмжээг 10 хувиас хэтрүүлэхгүй байх, мөн орон нутгийн өр төлбөрийн хэмжээний тухайн орон нутгийн төсвийн орлогод эзлэх хэмжээг 2026 онд 70 хувиас, 2027 онд 60 хувиас, 2028 онд 50 хувиас тус тус хэтрүүлэхгүй байхаар хязгаарлаж, орон нутаг нь улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг аваагүй байх шалгуурыг тогтоосон болно. Ингэснээр Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн эрсдэл болон төсөвт үзүүлэх дарамт буурахаар байна.

Олон улсын зах зээлд тогтмол үнэт цаас арилжаалж хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж байна. Олон улсын зах зээлд тогтмол үнэт цаас арилжаалах нь олон улсын зах зээл дэх суурь хүүд нөлөөлөхгүй боловч үүн дээр нэмэгдэх эрсдэлийн нэмэгдэл буурах давуу талтай. Ингэснээр хүүгийн нэмэгдлийг бууруулж, олон улсын зах зээл дэх суурь хүүгийн түвшин нэмэгдсэн ч суурь хүүгийн зөрүүнээс болон Засгийн газрын гадаад үнэт цаасны хүүгийн хэмжээний нэмэгдэл бага байх боломж бүрдэнэ. Түүнчлэн, өрийн зохицуулалтын арга хэмжээ тогтмол авч хэрэгжүүлэх нь үнэт цаасны томоохон төлбөрийг эдийн засаг, гадаад валютын албан нөөц, төлбөрийн тэнцэлд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр шийдвэрлэхээс гадна олон улсын зах зээлд Монгол Улсын ам.долларын өгөөжийн муруйг тогтоож, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг олон улсын зах зээлээс харьцангуй хямд эх үүсвэрийг татан төвлөрүүлэх боломжийг бүрдүүлдэг.

Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг тогтмолжуулж, дотоодын хөрөнгийн зах зээлийг дэмжиж байна.

Засгийн газраас 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дотоод үнэт цаасны арилжааг эхлүүлсэн бөгөөд 2 долоо хоног тутам тогтмол арилжаалж байна. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль 2024 оны 12 дугаар сард батлагдаж 2025 оны 07 дугаар сард өөрчлөлт орсон бөгөөд дотоод үнэт цаас гаргах шаардлага гараагүй боловч дотоодын зах зээлийг дэмжих зорилгоор 300 тэрбум төгрөгийн үнэт цаас гаргахаар тусгасан байна. Энэ хүрээнд 2 долоо хоног тутам бага хэмжээгээр дотоод үнэт цаас арилжаалж байна.

Зураг 53. Засгийн газрын үнэт цаас



Эх сурвалж: Сангийн яам

Ийнхүү дотоод үнэт цаас арилжаалах нь дотоод валютаар илэрхийлэгдсэн өрийн нийт өрд эзлэх хэмжээг өсгөх бөгөөд тогтмол хүүтэй арилжаалагдах тул хөвөгч хүүгийн эрсдэлийг мөн бууруулахаар байна. Түүнчлэн, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд Засгийн газрын дотоод үнэт цаас гаргах хэмжээг 562.2 тэрбум төгрөгөөр тусгаж, дотоод үнэт цаасны арилжааг үргэлжлүүлэн тогтмол зохион байгуулахаар тусгасан.

Зураг 54. Дотоод үнэт цаасны өгөөжийн муруй




Эх сурвалж: Сангийн яам

6.5. Байгалийн гамшиг, зудын эрсдэл

Монгол Улс хойд, төв Азийн өндөрлөгт оршдог, эрс тэс уур амьсгалтай, хуурай, богино зуны улирал, урт, хүйтэн өвлийн улиралтай орон бөгөөд сүүлийн 80 жилийн хугацаанд байгалийн гамшгийн давтамж болон нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө хоёр дахин нэмэгдсэн байна.

Зураг 55. Зудтай жилүүдийн том малын зүй бус хорогдол, ХАА-ын салбарын ажилт



Эх сурвалж: ҮСХ


Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас зудын эрсдэл нэмэгдэж байна. Хүйтний эрч чангарч, их хэмжээний цас орсноор зудын хүндрэл тогтмол нэмэгдэж байгаа бөгөөд 2023, 2024 онд дараалан тохиосон зуд нийт 14.3 сая толгой мал хорогдуулсан нь сүүлийн жилүүдийн хамгийн хүнд хохиролтой тохиолдлуудын нэг боллоо.

Дэлхийн банкны “Уур амьсгал ба хөгжил” тайланд дурдсанаар Монголд 2000 оноос хойш дунджаар таван жил тутамд нэг удаа зуд тохиолдож ирсэн бол энэ зууны дунд үе гэхэд гурван жил тутамд нэг удаа тохиох хандлагатай байна. Малын тоог өнөөгийн түвшинд хадгалж, дасан зохицох арга хэмжээ аваагүй тохиолдолд 2050 он гэхэд зудын улмаас жилд дунджаар 4.1 сая, 2100 он гэхэд 6.8 сая толгой мал хорогдох эрсдэлтэй гэж тооцжээ.

Малын хорогдол эдийн засагт шууд нөлөөлдөг. Хөдөө аж ахуйн салбар нь ДНБ-ий 15 орчим хувийг бүрдүүлдэг бөгөөд үүний 90 гаруй хувийг мал аж ахуй эзэлдэг. Зудын улмаас малын зүй бус хорогдол салбарын үйлдвэрлэл болон түүнд ажиллагсад, 190 мянга гаруй өрхийн амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлж байна.

Зудын хүндрэлтэй холбогдуулан НҮБ, ХХАА-н байгууллагаас 2023 онд танилцуулсан “Малчин өрхийн гамшгийн эрсдэл даах чадварын дүн шинжилгээ” тайланд дурдсанаар судалгаанд хамрагдсан нийт малчин өрхийн ердөө 10 хувь нь эрсдэл даах босго утгыг давсан, 20 гаруй хувь нь маш эмзэг гэсэн үр дүн гарсан байна.

Зураг 56. Эрсдэл даах чадварын индекс, аймгаар



Эх сурвалж: ХХААБ, НҮБ

МАЛЫН ХОРОГДЛЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ:

Сүүлийн 25 жилд 2001-2003 он, 2009-2010 он, 2023-2024 онуудад нийтдээ 7 удаа зудын эрсдэл тохиолдож, дунджаар том малын зүй бус хорогдлын оны эхний нийт малд эзлэх хувь 10 хувьд хүрч энгийн жилүүдээс 8.0 нэгж хувиар өссөн бол бойжуулсан төлийн оны эхний нийт малд эзлэх хувь 27 орчим хувьд хүрч энгийн жилүүдээс 9 орчим нэгж хувиар буурсан байна.²⁸ Ирэх онд зудын эрсдэл бий болсон тохиолдолд дээрх тооцооллоор малын хорогдол 6 орчим саяд, бойжуулсан төлийн тоо өмнөх жилээс 4.8 саяар буурах хувилбарыг тооцлоо. Шинжилгээний үр дүнд хөдөө аж ахуйн салбар 9.5 хувиар буурч, эдийн засгийн өсөлт 4.0 хувь болж суурь төсөөллөөс 1.7 нэгж хувиар буурахаар байна.

ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛД ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ:

Орон нутгийн удирдлагуудын эрсдэлийн төлөвлөлт: Орон нутгийн засаг захиргаа зудын эрсдэлд урьдчилан бэлтгэх, техникийн бэлэн байдал, хангамж болон бусад эрсдэлийн төлөвлөлтийг сайжруулах тодорхой алхмууд авч эхэлсэн. Тухайлбал, аймгуудын төсөв, малын тоо толгойн албан татвар, Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, гамшгаас хамгаалах анги нэгжийн бэлэн байдлыг хангах, өвөлжилтийн нөхцөлийг сайжруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Малын индексжүүлсэн даатгалын шинэчлэл: Засгийн газраас Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025 оны 1 дүгээр сард Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Хуулийн төсөлд дараах ерөнхий шинэчлэлүүдийг агуулсан байхаар төлөвлөн боловсруулсан. Үүнд:

1. Уур амьсгалын өөрчлөлт, зудын гамшигт үзэгдэл нэмэгдэхийн хэрээр нөхөн төлбөр олгох босго үзүүлэлтийг бууруулж, шинэчлэн тогтоох;

²⁸ Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2. Үргэлжлэн бий болох зудын хүнд нөхцөлийг даван туулах хүрээнд даатгуулагч малчин болон даатгалын компани хооронд байгуулсан тухайн жилийн гэрээний дүнг үндэслэн нөхөн төлбөрийн тодорхой хэмжээг нэг удаа урьдчилсан байдлаар олгох зэрэг зохицуулалтыг тусган боловсруулаад байна.

VII БҮЛЭГ: ТӨСВИЙН ТӨСЛИЙН ХАВСРАЛТ

7.1. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн тайлбар

1 дүгээр бүлэг – Нийтлэг үндэслэл

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн зорилт болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг дурдсан. Хуулийн зорилтын талаар тус танилцуулгын I болон IV бүлэгт дэлгэрэнгүй тусгасан.

2 дугаар бүлэг – Монгол Улсын 2026 оны төсвийн орлого, зарлага болон хөрөнгө, өрийн удирдлага

Монгол Улсын 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төсөвт төвлөрүүлэх дүн, 2026 оны төсвийн жилд төвлөрүүлэх нийт тэнцвэржүүлсэн орлогын дүнг тусгасан. Орлогын дэлгэрэнгүй тайлбарыг IV бүлэг “Төсвийн орлого, татварын бодлого” хэсэгт тусгасан.

Монгол Улсын 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч нарын эргэн төлөх үндсэн төлбөрийн дүн болон зарцуулах төсвийн дүнг тусгасан бөгөөд урсгал зардлын дэлгэрэнгүй тайлбарыг IV бүлэг “Төсвийн урсгал зардал” хэсэгт тусгасан.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсвийн дүнг тусгасан бөгөөд үүний талаар дэлгэрэнгүй тайлбарыг IV бүлэг “Төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл тусламж болон төр, хувийн хэвшлийн түншлэл” хэсэгт оруулсан.

Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах дүнг тусгасан бөгөөд үүний дэлгэрэнгүй тайлбарыг IV бүлэг “Төсвийн орлого, татварын бодлого” хэсэгт оруулсан.

Түүнчлэн, Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2026 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ, Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээг тус тус тусгасан. Дэлгэрэнгүй тайлбарыг IV бүлэг “Засгийн газрын өр” хэсэгт оруулсан.

3 дугаар бүлэг – Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг

Орон нутагт 2026 оны төсвийн жилд олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ болон 2026 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд

олгох орлогын шилжүүлгийн хэмжээг тусгасан. Дэлгэрэнгүй тайлбарыг IV бүлэг “Орон нутгийн төсөв” хэсэгт оруулсан.

4 дүгээр бүлэг – Бусад зүйл

Хуулийн төслийн хавсралтаар батлах “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”, “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг тус тус тусгасан болно. Түүнчлэн хуулийн дагаж мөрдөх хугацааг тусгалаа.

7.2. Хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан 2 хуулийн төсөл, 2 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл:

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Агуулга: Иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалах, орлогын тэгш бус байдлыг бууруулах, бизнесийн идэвхжилийг дэмжих, татварын хамрагдалтыг сайжруулах, далд эдийн засгийг бууруулах зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно. Иргэдийн төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлтийг шаталсан хэлбэрээр үе шаттай нэмэгдүүлэх хүрээнд 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал иргэн бүрийн сарын 1 сая төгрөг хүртэлх худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг 50 хувиар хөнгөлж, түүнээс дээш хэсэгт 20 хувиар хөнгөлж, буцаан олгох зохицуулалтыг тусгаж, 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн иргэн бүрийн сарын 500,000 төгрөг хүртэлх худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг 100 хувиар хөнгөлж, 500,000-1,000,000 төгрөг хүртэлх худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг 50 хувиар хөнгөлж, 1,000,001 төгрөгөөс дээш хэсэгт 20 хувиар хөнгөлж буцаан олгох зохицуулалтыг тусгасан.

Төсөвт үзүүлэх нөлөөлөл: Нийт иргэдийн 75 хүртэл хувь нь нэмэгдсэн өртгийн албан татвараас 50-100 хувь хөнгөлөгдөх ба энэ нь 2 026 оны төсөвт 375 орчим тэрбум төгрөгөөр нөлөөлөхөөр байна.

2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Агуулга: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд бүх аймагт түншлэлээр төсөл хэрэгжүүлэх боломжийг нээх, хувийн хэвшлийн

түншлэгч төслийн саналаа түншлэлийн төвд шууд гаргаж урьдчилсан үнэлгээ хийлгэх, төрийн үйлчилгээний зарим төсөлд техник, эдийн засгийн үндэслэлийг төслийн онцлогоос хамааруулан шаардахгүй байх, төсөл санаачлагч өөрийн санхүүжилтээр техник, эдийн засгийн үндэслэл боловсруулсан бол төслийн баг ТЭЗҮ-г хүлээн авах, төрийн болон орон нутгийн өмчид хамаарах оюуны өмчийг түншлэлийн төсөлд нэвтрүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах, олсон орлогоо инновац, судалгаа хөгжүүлэлтэд зарцуулах боломжийг нээх, урьдчилсан болон уралдаант шалгаруулалтыг нэгтгэж нэг үе шаттай болгох, шат дамжлагыг багасгах, төсөлд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагуудыг багасгах асуудлуудыг тусгасан.

Төсөвт үзүүлэх нөлөөлөл: Монгол Улсыг 2026 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд нийт 317 төсөл, арга хэмжээ батлагдсанаас төр, хувийн хэвшлийн түншлэлээр 4.4 их наяд төгрөгийн 12 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 120 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгаснаас 42.5 хувь буюу 51 төсөл арга хэмжээг 2026 оны төсвийн төсөлд тусгасан бол 69 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй зарим төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татаж, түншлэлээр хэрэгжүүлэх, төсвийн дарамтыг бууруулах эерэг нөлөөтэй.

Улсын Их Хурлын тогтоолын төсөл:

1. Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай

Агуулга: Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаасыг арилжаалан, өрийн зохицуулалтын арга хэмжээ тогтмол авч хэрэгжүүлэх нь зах зээлд өгөөжийн муруйг тогтоож үнэт цаасны томоохон төлбөрийг эдийн засаг, төсөв, төлбөрийн тэнцэлд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр шийдвэрлэхээс гадна, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг зах зээлээс харьцангуй хямд эх үүсвэрийг татан төвлөрүүлэх боломжийг бүрдүүлдэг.

Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийн 4 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх арга зам, шалгуур үзүүлэлтэд дахин санхүүжилтийн зорилгоор ЗГГҮЦ-ны арилжааг жилд 2-оос дээшгүй удаа, Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг сар бүр 2-оос доошгүй удаа явуулахаар тогтмол зохион байгуулахаар заасан. Иймд Засгийн газрын зүгээс зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан 2026 онд 1.0 тэрбум ам.доллар хүртэлх ЗГГҮЦ-ыг, 562.2 тэрбум төгрөг хүртэлх ЗГДҮЦ-ыг арилжаалахаар Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгалаа.

Төсөвт үзүүлэх нөлөөлөл: Засгийн газраас 2020 онд гаргасан “Номад” бондын 174.3 сая ам.доллар буюу 656.6 тэрбум төгрөгийн төлбөр 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр төлөгдөх хуваарьтай байгаа бөгөөд 2026-2028 оны хооронд нийт 1,130.1 сая ам.долларын төлбөр хугацаа тулсан байна. Энэ нь төрийн сангийн мөнгөн хөрөнгө болон гадаад валютын албан нөөц, төсөв, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах эрсдэлтэй байна. Дээрх

үндэслэлүүдийг харгалзан 2026 онд 1.0 тэрбум ам.доллар хүртэлх ЗГГҮЦ-ыг, 562.2 тэрбум төгрөг хүртэлх ЗГДҮЦ-ыг арилжаалахаар Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгалаа.

2. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор тус Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

7.3. Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний танилцуулга

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн “22.6.4.төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах;”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн “6.2.7.төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх.” гэсэн заалт болон холбогдох Төсвийн Ерөнхийлөн Захирагч /ТӨЗ/ бүрийн ирүүлсэн санал дээр үндэслэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн хавсралт 1-ийг нэгтгэн боловсрууллаа.

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн дагуу нийт 36 ТӨЗ байгаа бөгөөд үүнээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга-2, Улсын Их Хурлын дарга-1, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга-14, Ерөнхий сайд-3, Монгол Улсын тэргүүн шадар сайд-3, Монгол Улсын шадар сайд нар нийт-10, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга-2, салбар хариуцсан сайд нар нийт-65, нийт 97 хөтөлбөрийн хүрээнд зорилт, хүрэх үр дүнг дэвшүүлсэн бөгөөд түүнтэй уялдсан үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг нэгтгэн боловсруулсан болно.

Тус хавсралтаар Төсвийн Ерөнхийлөн захирагч бүрийн хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, түүний шалгуур үзүүлэлтийг суурь он болон суурь түвшин, 2026 онд хүрэх зорилтот түвшнийг батлуулахаар өргөн барьсан бөгөөд Төсвийн Ерөнхийлөн захирагч бүрээр авч үзвэл төсвийн хөтөлбөр 97, хөтөлбөрийн үр дүн 215, үр дүнд хүрэх 397 шалгуур үзүүлэлт болон 2026 онд хүрэх 397 зорилтот түвшнийг тодорхойллоо.

Хүснэгт 67. ТӨЗ-ийн хөтөлбөр, үр дүн, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшний тоо

| № | ТӨСЛИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАР | Хөтөлбөр | Үр дүн | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин |
|---|---|----------|--------|------------------|-----------------|
| 1 | МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА | 2 | 4 | 5 | 5 |

| | | | | | |
|------|--|-----------|------------|------------|------------|
| 2 | МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА | 1 | 5 | 5 | 5 |
| 3 | МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА | 1 | 1 | 3 | 3 |
| 4 | УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ | 1 | 1 | 1 | 1 |
| 5 | ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА | 1 | 1 | 1 | 1 |
| 6 | ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДАРГА | 1 | 1 | 1 | 1 |
| 7 | ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДСНИЙ КОМИССЫН ДАРГА | 1 | 8 | 8 | 8 |
| 8 | УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР | 1 | 3 | 3 | 3 |
| 9 | МОНГОЛ УЛСЫН ҮНДСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА | 1 | 1 | 3 | 3 |
| 10 | МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР | 1 | 2 | 11 | 11 |
| 11 | АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА | 1 | 4 | 8 | 8 |
| 12 | САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА | 1 | 7 | 7 | 7 |
| 13 | ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА | 1 | 8 | 17 | 17 |
| 14 | ҮНДСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА | 1 | 6 | 11 | 11 |
| 15 | СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА | 1 | 4 | 8 | 8 |
| 16 | ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА | 1 | 3 | 6 | 6 |
| 17 | МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД | 3 | 14 | 21 | 21 |
| 18 | МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД | 3 | 3 | 7 | 7 |
| 19 | МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД /ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБА ХАРИУЦСАН/ | 4 | 4 | 14 | 14 |
| 20 | МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД /ХА, ХО, ӨРСӨЛДӨӨН ХАРИУЦСАН/ | 3 | 5 | 8 | 8 |
| 21 | ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА | 2 | 2 | 2 | 2 |
| 22 | БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД | 7 | 12 | 24 | 24 |
| 23 | ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД | 4 | 6 | 9 | 9 |
| 24 | САНГИЙН САЙД | 1 | 2 | 10 | 10 |
| 25 | ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД | 14 | 27 | 60 | 60 |
| 26 | ЗАМ ТЭЭВРИЙН САЙД | 4 | 10 | 18 | 18 |
| 27 | БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД | 1 | 1 | 1 | 1 |
| 28 | БОЛОВСРОЛЫН САЙД | 6 | 6 | 20 | 20 |
| 29 | АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД | 1 | 7 | 15 | 15 |
| 30 | ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД | 7 | 10 | 25 | 25 |
| 31 | ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД | 6 | 7 | 13 | 13 |
| 32 | ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД | 4 | 10 | 14 | 14 |
| 33 | ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД | 1 | 5 | 5 | 5 |
| 34 | ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД | 3 | 13 | 14 | 14 |
| 35 | СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД | 5 | 8 | 10 | 10 |
| 36 | ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД | 1 | 4 | 9 | 9 |
| НИЙТ | | 97 | 215 | 397 | 397 |

7.4. Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт

Хүснэгт 68. Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт (сая төгрөг)

| № | Хөгжлийн түнш | Эх үүсвэр | Төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүчин чадал | 2026 оны ашиглалт |
|----|---------------|-----------|---|-------------------|
| 1 | БНЭУ | Зээл | Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл | 207,745.3 |
| 2 | АНУ | Тусламж | Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл | 87,583.9 |
| 3 | БНХАУ | Зээл | Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл | 99,375.8 |
| 4 | БНСУ | Зээл | Солонго 1 орон сууцны хороолол барих төсөл | 39,024.2 |
| 5 | БНСУ | Зээл | Солонго 2 орон сууцны хороолол барих төсөл | 31,836.0 |
| 6 | БНСУ | Зээл | Баянголын амны 2007 айлын орлогод нийцсэн орон сууц барих төсөл | 48,547.4 |
| 7 | БНХАУ | Зээл | Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих | 44,683.9 |
| 8 | ДБ | Зээл | Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл | 46,414.7 |
| 9 | ДБ | Тусламж | Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл-тусламж | 436.1 |
| 10 | АХБ | Тусламж | Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1 дахь үе шатны төсөл | 9,258.4 |
| 11 | АХБ | Зээл | Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны төсөл (COL) | 6,541.4 |
| 12 | АХБ | Зээл | Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны төсөл (OCR) | 44,585.1 |
| 13 | АХБ | Зээл | Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл - 3 /4343/ | 24,685.3 |
| 14 | АХБ | Зээл | Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл - 3 /4342/ | 32,413.5 |
| 15 | БНСУ | Зээл | 10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл | 24,300.0 |
| 16 | ДБ | Зээл | Ухаалаг засаг төсөл-II | 13,452.2 |
| 17 | ЕСБХБ | Зээл | Улаанбаатар-Дарханы чиглэлд нэмэлт 2 эгнээ зам барих төсөл | 90,219.8 |
| 18 | ЕСБХБ | Зээл | Чойр-Сайншандын 220 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл | 27,909.7 |
| 19 | ЕСБХБ | Тусламж | Чойр-Сайншандын 220 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл /тусламж/ | 52,436.2 |
| 20 | АХБ | Зээл | Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл | 30,400.0 |
| 21 | АХБ | Зээл | Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл (OCR) | 13,047.3 |
| 22 | АХБ | Зээл | Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл (COL) | 5,455.7 |
| 23 | АХБ | Тусламж | Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл (АХБ Уур амьсгалын ногоон сан) | 7,374.2 |

| № | Хөгжлийн түнш | Эх үүсвэр | Төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүчин чадал | 2026 оны ашиглалт |
|----|---------------|-----------|--|-------------------|
| 24 | АХБ | Тусламж | Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл (Өндөр технологийн сан) | 9,315.0 |
| 25 | ХБНГУ | Зээл | Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл | 29,498.1 |
| 26 | ДБ | Зээл | Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл | 50,956.6 |
| 27 | БНХАУ | Зээл | Нүхэн гарц барих төсөл | 30,913.6 |
| 28 | ЕСБХБ | Зээл | Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг барих төсөл | 20,938.2 |
| 29 | ЕСБХБ | Тусламж | Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг барих төсөл Тусламж | 861.0 |
| 30 | ЕХОБ | Зээл | Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл 83097-EIB | 1,100.0 |
| 31 | ЕХОБ | Зээл | Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл 83873-EIB | 4,546.5 |
| 32 | АХБ | Зээл | Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл-2 MON-3526 | 1,931.9 |
| 33 | АХБ | Зээл | Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл-2 MON-3525 | 33,924.6 |
| 34 | АХБ | Зээл | Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн 3 дугаар үе шатны төсөл /COL | 5,626.6 |
| 35 | АХБ | Зээл | Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн 3 дугаар үе шатны төсөл /OCR | 22,956.2 |
| 36 | АХБ | Зээл | Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл - /3787/ | 34,966.9 |
| 37 | АХБ | Зээл | Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл - /3788/ | 3,938.5 |
| 38 | БНХАУ | Тусламж | 1008 айлын түр суурьшуулах орон сууцын төсөл | 16,392.1 |
| 39 | АХБ | Зээл | Аймаг, сумын бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр -I шат /4306/ | 10,505.3 |
| 40 | АХБ | Зээл | Аймаг, сумын бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр -I шат /4307/ | 5,879.6 |
| 41 | АХБ | Зээл | Аймаг, сумын бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр -I шат /8441/ | 17,011.3 |
| 42 | АХБ | Тусламж | Аймаг, сумын бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр -I шат /0885-тусламж/ | 820.0 |
| 43 | АХБ | Тусламж | Аймаг, сумын бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр -I шат /0886-тусламж/ | 15,474.0 |
| 44 | ДБ | Зээл | Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл | 10,723.4 |
| 45 | БНФУ | Зээл | Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл | 9,609.2 |
| 46 | АХБ | Зээл | Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл-1 | 4,178.0 |
| 47 | АХБ | Зээл | Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл-нэмэлт санхүүжилт | 18,390.2 |
| 48 | АХБ | Зээл | Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл (COL болон OCR) | 3,724.0 |
| 49 | АХБ | Тусламж | Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл | 5,179.7 |
| 50 | БНФУ | Зээл | Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төсөл | 27,484.8 |
| 51 | ЕСБХБ | Зээл | Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал төсөл | 19,206.5 |
| 52 | ЕСБХБ | Тусламж | Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал төсөл Тусламж | 19,206.5 |

| № | Хөгжлийн түнш | Эх үүсвэр | Төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүчин чадал | 2026 оны ашиглалт |
|----|---------------|-----------|--|-------------------|
| 53 | Япон Улс | Зээл | Инженер технологийн дээд боловсрол төсөл | 6,474.9 |
| 54 | АХБ | Зээл | Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл /3708-MON/ | 23,034.7 |
| 55 | АХБ | Тусламж | Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл /0611,0610/ | 18,435.9 |
| 56 | АХБ | Тусламж | Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төсөл | 1,885.9 |
| 57 | БНПУ | Зээл | Аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл | 48,286.5 |
| 58 | БНХАУ | Зээл | Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл | 16,200.0 |
| 59 | ХБНГУ | Тусламж | Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох төсөл II, III шат | 38,432.3 |
| 60 | БНСУ | Зээл | Шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах | 10,930.5 |
| 61 | ХБНГУ | Зээл | Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал технологийн их сургууль | 7,137.1 |
| 62 | АХБ | Зээл | Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл | 11,289.0 |
| 63 | АХБ | Зээл | Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл- нэмэлт санхүүжилт | 8,303.2 |
| 64 | БНСУ | Зээл | Байгаль орчны төв лабораторийн чадавхыг сайжруулах төсөл | 8,640.0 |
| 65 | ЕСБХБ | Зээл | Ногоон-Улаанбаатар орон сууц төсөл | 5,940.0 |
| 66 | ЕСБХБ | Тусламж | Ногоон-Улаанбаатар орон сууц төсөл Тусламж | 9,847.6 |
| 67 | АХБ | Зээл | Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл | 613.5 |
| 68 | АХБ | Зээл | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл /3605/ | 16,780.7 |
| 69 | АХБ | Тусламж | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл /9191/ | 183.4 |
| 70 | БНЭУ | Зээл | Монгол-Энэтхэгийн хамтарсан мэдээллийн технологийн боловсрол болон аутсорсингийн төвийг байгуулах төсөл | 21,247.0 |
| 71 | БНФУ | Зээл | Монгол Улсын Онцгой байдлын байгууллагад гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөл | 21,287.9 |
| 72 | АХБ | Зээл | Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдлыг дэмжих төсөл | 3,609.1 |
| 73 | ДБ | Зээл | Мал аж ахуйн салбарын эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл | 8,048.0 |
| 74 | АХБ | Зээл | Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл -2 /3679/ | 10,317.0 |
| 75 | АХБ | Зээл | Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл-2 /3786/ | 7,444.7 |
| 76 | ЕСБХБ | Зээл | Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл | 1,322.5 |
| 77 | ЕСБХБ | Тусламж | Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл Тусламж | 5,462.5 |
| 78 | АХБ | Тусламж | Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл-2 /нэмэлт санхүүжилт/ | 2,868.3 |
| 79 | Люксембург | Тусламж | Монгол Улсын Зүрх Судлал, Зүрхний мэс засал ба Телемедицин | 2,297.8 |
| 80 | БНПУ | Зээл | Эрдэнэт хотын хатуу хог хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл | 3,798.8 |

| № | Хөгжлийн түнш | Эх үүсвэр | Төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүчин чадал | 2026 оны ашиглалт |
|-------------|---------------|-----------|---|--------------------|
| 81 | АХБ | Зээл | Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдааг дэмжих төсөл /4419/ | 25,844.0 |
| 82 | АХБ | Тусламж | Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдааг дэмжих төсөл /0929/ | 2,486.9 |
| 83 | АХБ | Зээл | “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөл”-ийн 2 дахь шат | 14,133.0 |
| 84 | ДБ | Зээл | Багануур-Чойрын 220 кВ-ын 188 км урттай 2 хэлхээт ЦДАШ, 220/110/35 кВ-ын Багануур, Чойр дэд станцуудын өргөтгөл | 2,700.0 |
| 85 | БНХАУ | Тусламж | Ерөнхийлөгч нарын спорт цогцолбор | 44,211.4 |
| 86 | ДБ | Зээл | Мандалговь-Арвайхээр чиглэлийн 220 кВт-ын 2 хэлхээт 287км урт ЦДАШ /хэлэлцээрт/ | 1,000.0 |
| 87 | АХБ | Зээл | Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл | 24,571.7 |
| 88 | ДБ | Зээл | Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл | 8,000.0 |
| 89 | АХБ | Зээл | Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төсөл | 513.4 |
| 90 | АХБ | Зээл | Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2 дугаар үе шатны төсөл (OCR) | 11,865.9 |
| 91 | ЕСБХБ | Зээл | Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл /хэлэлцээрт/ | 1,000.0 |
| 92 | ДБ | Тусламж | Цахим хоршоо төсөл | 6,111.7 |
| 93 | ЕХОБ | Зээл | Аймаг, сумын бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр -I шат /L91068/ | 8,448.0 |
| 94 | ЕХОБ | Тусламж | Аймаг, сумын бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр -I шат /G91068-тусламж/ | 8,439.2 |
| 95 | АХБ | Зээл | Монгол Улсын гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх төсөл /хэлэлцээрт/ | 1,000.0 |
| 96 | АХБ | Зээл | Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төсөл - 2 дугаар нэмэлт санхүүжилт /хэлэлцээрт/ | 1,000.0 |
| 97 | АХБ | Зээл | Аймгуудын лавлагаа шатлалын эмнэлэг барих, яаралтай тусламжийг сайжруулах төсөл /хэлэлцээрт/ | 2,000.0 |
| 98 | АХБ | Зээл | Онцгой байдлын байгууллагын техник, тоног төхөөрөмжийг сайжруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх төсөл /хэлэлцээрт/ | 1,000.0 |
| НИЙТ | | | | 1,907,428.4 |

7.5. Санхүүжилтийг нь зогсоох болон багасгах хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт, түүний төсөвт үзүүлэх нөлөөлөл, тайлбар

7.5.1. Урсгал зардал

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд урсгал зардлын санхүүжилтийг зогсоох болон багасгах хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд нийт 615.6 тэрбум төгрөг бууруулахаар тусгалаа. Үүнд:

Хүснэгт 69. Санхүүжилтийг зогсоох болон багасгах хөтөлбөр, арга хэмжээний тайлбар (тэрбум төгрөг)

| Д/д | АРГА ХЭМЖЭЭ | 2026 төсөл | ТАЙЛБАР |
|-----|---|---------------|--|
| 1 | Салбаруудын зээлийн хүүгийн хөнгөлөлт, татаас, урамшуулал | -128.8 | Засгийн газрын 2024 оны 106 дугаар тогтоолын хүрээнд 2023-2024 онд өвөлжилт, хаваржилт хүндэрч, зудын гамшигт нэрвэгдсэн малчдын зээл төлөх хугацааг нэг жилээр хойшлуулж, зээлийн хүүгийн 6 нэгж хувиас давсан хэсгийг төрөөс хариуцан төлөхөөр шийдвэрлэсэн. Тус арга хэмжээнд зориулж зөвхөн 2025 оны төсөвт 66.3 тэрбум төгрөгийг тусгаж санхүүжүүлсэн тул 2026 онд уг арга хэмжээний дагуу төсвөөс санхүүжилт олгохгүй. Түүнчлэн, "Хүнсний хувьсгал" үндэсний хөдөлгөөний хүрээнд нэмж шинээр зээл олгохгүй бөгөөд 2023-2024 онд олгосон зээлийн үлдэгдэл буурсантай холбогдуулан төрөөс хариуцан төлөх зээлийн хүүгийн дэмжлэгийг тус тус бууруулан тусгалаа. |
| 2 | Төсөвт байгууллагын үйл ажиллагааны зардал /Цалин, байгууллагын хэвийн үйл ажиллагааны зардал | -113.0 | 2025 оны төсвийн тодотголоор ЗГ-аас авч хэрэгжүүлсэн төрийн албан хаагчдын орон тоог бууруулах бодлогын арга хэмжээ болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд төсөвт байгууллагын цалин хөлс, үндсэн үйл ажиллагааны урсгал зардал буурсан. |
| 3 | Салбаруудын хөтөлбөр арга хэмжээний зардал | -103.4 | Төсвийн урсгал зардлыг 2025 оны түвшинд хадгалж, ДНБ-ий 24 хувиас хэтрүүлэхгүй байхаар тооцож, 2026 оны төсвийн жилд эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж, хувийн хэвшилд суурилсан өсөлтийн загварыг дэмжих замаар макро тогтвортой байдлыг хадгалах, иргэн төвтэй, хүний хөгжил, бизнесийн орчныг дэмжсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн, соёл урлаг, спорт, аялал жуулчлалын, бүсчилсэн хөгжлийн бодлого, удирдлага, мал аж ахуйг хөгжүүлэх, агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, стандарт хэмжил зүй, залуучууд болон оюутнууд зэрэг салбаруудын хөтөлбөр, арга хэмжээний зардлыг төсвийн хязгаарт багтаан бууруулахаар тооцлоо. Эдгээр хөтөлбөрүүдийн зардлын дахин хуваарилалтыг иргэн төвтэй, хүний хөгжил, бизнесийн орчныг дэмжсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн болно |
| 4 | Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх ажил, үйлчилгээ | -99.9 | Улсын Их Хурлын 2024 оны 54, 81 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хүрээнд хэрэгжих төсөл, арга хэмжээг дахин үнэлж, төсвийн үр ашиг, ач холбогдлыг харгалзан |

| | | | |
|---|--|-------|---|
| | | | зохицуулалт хийсэн болно. Энэ хүрээнд шаардлагагүй худалдан авалт болон зөвлөх үйлчилгээний санхүүжилтийг хойшлуулж, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлснээр нийт 2.9 их наяд төгрөгийн өртөг бүхий 214 арга хэмжээнд санхүүгийн зохицуулалт хийсэн. Зохицуулалтын үр дүнд 120.4 тэрбум төгрөг буюу 2026 оны төсвийн тухай хуульд тусгасан нийт ашиглалтын зардлын 6 хувь нь урсгал зардлын санхүүжилтэд төлөвлөгдсөн бөгөөд энэ нь өмнөх оны түвшнээс хоёр дахин буурсан үзүүлэлт юм. |
| 5 | Хөдөө орон нутгийн тэтгэмж, тэтгэвэрт гарах тэтгэмжийг хойшлуулах болон ажил олгогчоос олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | -84.7 | Хөдөө орон нутгийн тэтгэмж, тэтгэвэрт гарахад олгох мөнгөн тэтгэмж болон ажил олгогчоос олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг өмнөх оноос цэвэр дүнгээр 89.8 тэрбум төгрөгөөр бууруулахаар тооцлоо. /2026 онд тэтгэвэрт гарах төрийн албан хаагчдад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 2027 онд олгохоор тооцож хугацааг хойшлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөнтэй холбогдуулан 174.7 тэрбум төгрөг буурч байна./ |
| 6 | Нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардал | -31.4 | 2025 онд хэрэгжсэн нэг удаагийн арга хэмжээний зардлыг бууруулж тооцсон үүнд Хавдрын эмнэлгийн зориулалтаар ашиглах объектыг лизингээр авах зардал, хүн амын тооллогын зардал зэрэг зардлууд багтсан байна. |
| 7 | Бусад зардал | -27.0 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор бусад хөтөлбөр арга хэмжээний зардлыг буурууллаа. |
| 8 | Төр, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | -20.0 | 2024 онд санд хуримтлагдсан хөрөнгийг орон сууцны хөнгөлөлттэй зээлийг санхүүжүүлэхэд хөрөнгө оруулж, хүүгийн өгөөжийн зөрүүг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны төсөвт тусгасан. Засгийн газрын 2025 оны 228 дугаар тогтоолын дагуу Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах гэрээг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариуцан Монголбанктай 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр байгуулсны дагуу бодлогын хүү болон хөрөнгө оруулалтын өгөөжийн зөрүү Гэр, бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны төсвийн багцад шилжүүлж, төсвийн төсөлд “Хуримтлалын сангийн өгөөжийн зөрүү” -ээр тусгалаа. |
| 9 | Олон улсын байгууллагад төлөх төлбөр, хураамж | -7.4 | Монгол Улсад 2026 онд COP17 бага хурлыг зохион байгуулахтай холбогдуулан Конвенцын Нарийн бичгийн дарга нарын газарт төлөх төлбөрийг 2025 оны төсөвт ГХСайдын багцад тусгасан. Төлбөр төлсөн тул 2026 оны төсөлд зардлыг бууруулан тусгалаа. |

7.5.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлагыг зохицуулсан. Тухайлбал, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилж, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарт

багтаан төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байхаар заасан.

Энэ хүрээнд Сангийн сайдын "Журам болон аргачлалд өөрчлөлт оруулах тухай" 2023 оны А/264 дүгээр тушаалаар батлагдсан аргачлалын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй төслүүдийг дахин үнэлж төсөвт өртгийн нэмэгдэлтэй төслүүдийг Үндэсний аудитын газраар магадлалын ерөнхий дүгнэлтийг үндэслэлтэй эсэхэд дүгнэлт гаргуулах, санхүүжилтийн хүндрэлтэй төслүүдийн хэрэгжилттэй уялдуулах, хэрэгжилт удааширсан буюу хэрэгжих хугацаа 1-ээс дээш жил хойшилсон төслүүдийг дахин эрэмбэлэх ажлыг зохион байгуулсан.

Тухайлбал, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаврын дагуу 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар өмнөх онуудад төсөвт тусгагдсан үргэлжлэн хэрэгжүүлэх 3.1 их наяд төгрөгийн санхүүжүүлэхээр санал ирүүлсэн.

Дээрх аргачлалын дагуу үргэлжлэн хэрэгжүүлэхээр ирүүлсэн төслүүдээс төсөвт өртгийн нэмэгдлийг Үндэсний аудитын газраар хянуулж буй 449.9 тэрбум төгрөг, тарифт цалингийн өөрчлөлт тооцуулсан 35.3 тэрбум төгрөг болон гэрээ цуцалсан, 2026 онд санхүүжих шаардлагагүй, санхүүжилтийн тооцоолол алдаж ирүүлсэн 378.4 тэрбум төгрөгийн саналыг төсвийн төсөлд тусгаагүй болно.

7.6. Сангийн үлдэгдлүүд

Төсвийн тогтворжуулалтын сан болон Ирээдүйн өв сангийн үлдэгдэл 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар:

- Төсвийн тогтворжуулалтын сан: 2,049,595.7 сая төгрөг;
- Ирээдүйн өв сан: 4,706,102.4 сая төгрөг байна.

7.7. Олон нийтийн хэлэлцүүлэг

7.7.1. E-Монголиа системээр авсан иргэдийн санал асуулгын үр дүн

Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл боловсруулахдаа Засгийн газар анх удаа иргэдийн санал асуулгыг E-Mongolia системээр өргөн цар хүрээтэй зохион байгуулсан бөгөөд нийт 188,016 иргэн (насанд хүрсэн иргэдийн 8.2 хувь) оролцсон нь Монгол Улсад төсөв боловсруулахад иргэдийн оролцоог анх удаа системтэйгээр, өргөн хүрээнд хангаж чадсан томоохон өөрчлөлт боллоо. Цаашид төсвийн төслийг олон нийтээр нээлттэй хэлэлцүүлж хэвших нь авлигыг бууруулах, хөрөнгө оруулалтыг зөв хуваарилах, хүний хөгжлийг дэмжихэд бодитой ахиц гарах болно.

Санал асуулгад оролцогчдын 55.5 хувь нь эмэгтэй, 44.5 хувь нь эрэгтэй бол насны бүтцийн хувьд 50 хувь нь 18-34 насны, 45.7 хувь нь 35-54 насны, 4.5 хувь нь 55-аас дээш насныхан байна. Санал асуулгын үр дүнг <https://2026tusuw.netlify.app/> хаягаар хандаж харна уу.

Иргэдийн саналын үр дүнг тоймлон дүгнэвэл, эрүүл мэнд, боловсрол, эрчим хүчний чанар-хүртээмжид төвлөрөх, түүнчлэн төрийн захиргаа, төрийн өмчит компаниудын зарцуулалт, сахилга батыг эрс сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Тиймээс төсвийн бодлого-үр ашгийг сайжруулахын тулд 1)эрүүл мэнд, боловсрол, эрчим хүчний салбарын төсвийг гүйцэтгэл-үр дүнд суурилан эрэмбэлэх; 2) төсвийн байгууллагын захиргааны зардал бууруулах болон төрийн өмчит компаниудын шинэчлэлийг бодит төлөвлөгөө, хугацаатай хэрэгжүүлэх; 3)халамжийн бодлогыг зорилтот бүлэгт чиглүүлэх, өгөөж багатай зардлыг үе шаттай бууруулах; 4)татварын бодлогын өөрчлөлтийг өрхийн орлогын нөлөөлөлтэй уялдуулах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай байна.

Иргэдийн санал асуулгын үр дүнг тоймлон харуулбал:

2026 онд аль салбарт төсвийг түлхүү чиглүүлэх нь зүйтэй гэж иргэд үзэв?

Хүснэгт 70. Санал асуулгын дүн

| Чиглэл | Хувь | Анхаарах асуудал |
|-------------------|------|---|
| Эрүүл мэнд | 26.4 | Хүртээмж, чанар, хүний нөөц, урьдчилан сэргийлэлтэд чиглэсэн хөрөнгө оруулалт. |
| Боловсрол | 21.4 | Цэцэрлэг, сургууль, багшийн чанарын асуудал; Хот ба хөдөөгийн ялгааг бууруулах. |
| Цахилгаан, дулаан | 17.9 | Эрчим хүчний найдвартай байдал, дулааны хангамж, шинэчлэл. |
| Зам | 7.2 | Аюулгүй байдал, засвар шинэчлэл. |

2026 онд аль салбарын төсөвт хэмнэлт хийх шаардлагатай гэж үзэв?

Хүснэгт 71. Санал асуулгын дүн

| Чиглэл | Хувь | Анхаарах асуудал |
|-----------------------------|------|---|
| Нийгмийн халамж | 17.0 | Зорилтот бүлэгт чиглүүлэх, давхардлыг арилгах; Хамрагдах шалгуурыг чангатгах. |
| Соёл, спорт, аялал жуулчлал | 16.3 | Шинэ барилга, арга хэмжээний зардлыг эрэмбэлж танах. |
| Зам барилга | 13.9 | Үр өгөөж багатай төсөл, давхардсан хөрөнгө оруулалтыг танах. |
| Хууль зүй | 12.7 | Зардлын бүтцийг оновчлох, давхардлыг арилгах. |

Төсвийн үр ашгийг сайжруулах хүрээнд ямар бодлого хэрэгжүүлэх шаардлагатай вэ?

Хүснэгт 72. Санал асуулгын дүн

| Чиглэл | Хувь | Анхаарах асуудал |
|--|------|---|
| Төрийн захиргааны зардал бууруулах | 27.6 | Захиргааны зардлыг танах, худалдан авалтыг нэгтгэх, дижитал шилжилтийг эрчимжүүлэх. |
| ТӨК-ийн зардлыг бууруулах, тоог цөөлөх | 23.2 | Алдагдалтай, давхардсан чиг үүргийг нэгтгэх/татан буулгах, засаглалыг сайжруулах. |

| | | |
|--|------|--|
| Халамжийн зардлыг танах | 16.7 | Шаардлагагүй халамжийг цомхотгож, зорилтот бүлэгт чиглүүлэх. |
| Төрийн албан хаагчдын орон тоог хязгаарлах | 15.2 | Илүүдэл орон тоо, бүтэц зохион байгуулалтыг оновчлох. |

2026 онд шинээр эхлүүлэхгүй, тэвчиж болох хөрөнгө оруулалт юу байх вэ?

Хүснэгт 73. Санал асуулгын дүн

| Чиглэл | Хувь | Анхаарах асуудал |
|----------------------|------|--|
| Соёлын төв | 35.5 | Шинэ байгууламжийг түр хойшлуулж, ашиглалтыг сайжруулах/эрэмбэлэх. |
| Дотуур байр | 19.4 | Шинэ барилгаас илүү ашиглалтыг нэмэгдүүлэх, эрэлтэд үнэлгээ хийх. |
| Инженерийн дэд бүтэц | 12.0 | Шинэ төсөл эхлүүлэхийг үе шаттай хэрэгжүүлж, засвар шинэчлэлд тэргүүлэх ач холбогдол өгөх. |
| Сургууль | 8.4 | Хэрэгцээ, ачаалалд тулгуурлан үе шаттай хэрэгжүүлэх. |

Татварын ямар бодлого хэрэгжүүлэх нь зүйтэй вэ?

Хүснэгт 74. Санал асуулгын дүн

| Чиглэл | Хувь | Анхаарах асуудал |
|------------------------------------|------|--|
| Татварын хувь хэмжээг бууруулах | 33.6 | Өрхийн орлого болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд эерэг нөлөөтэй байх. |
| Буцаан олголт, хөнгөлөлт | 19.0 | Эдийн засгийн идэвх, хөрөнгө оруулалтыг дэмжих. |
| Хугацааг уян хатан болгох | 16.0 | Мөнгөний урсгалд нийцсэн хуваарь, хойшлуулах зэрэг зохицуулалт хийх. |
| Татварын орчныг сайжруулах | 12.9 | Энгийн, тогтвортой, шударга татварын орчин бүрдүүлэх. |

7.7.2. Төсвийн Ерөнхийлөн захирагч нарын зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлэг

Төсвийн тухай хуулийн 28¹ дүгээр зүйлд төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангаж, салбар бүрээр хэлэлцүүлэг зохион байгуулахаар заасан. Энэ дагуу төсвийн төслийг боловсруулах үйл явцад иргэдийг оролцуулж, ТЕЗ нарын танхимын хэлэлцүүлгийг 2025 оны 8 дугаар сарын 4-14-ны хооронд ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулсан.

Танхимын хэлэлцүүлэгт иргэд, иргэний нийгмийн байгууллага, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Үндэсний аудитын газар, Сангийн яам болон хэлэлцүүлгийн асуудалтай холбоотой салбарын асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагч нар, холбогдох агентлаг, албан тушаалтнууд оролцож, санал, дүгнэлт өгч, асуулт асууж, хариулт авсан.

Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан талаар ТЕЗ нараас ирүүлсэн тайланг нэгтгэж үзвэл танхимаар нийт 1390 хүн, бусад хэлбэрээр (вэбсайт болон утсаар) 238,388 хүн нийт 239,788 хүн оролцсон байна. Гаргасан саналыг нэгтгэж үзвэл танхимаар нийт 332 санал, бусад хэлбэрээр (вэбсайт болон утсаар) 8,478 санал буюу нийт 8,810 санал

өгсөн байна. Эдгээр үзүүлэлт нь цахим суваг давамгай оролцоотой (99%) байсныг, харин танхимын хэлэлцүүлэг нь бодлогын түвшний асуулт-хариулт, тайлбар-солилцооны чанараараа ач холбогдолтой байсныг харуулж байна.

Хүснэгт 75. Олон нийтийн хэлэлцүүлэг (ТЭЗ нараар)

| | Тухайн салбарын хэлэлцүүлгийг зохион байгуулагч /ТЭЗ-аар/ | Оролцогчдын тоо | | | Нийт санал | | |
|----|--|-----------------|----------------|----------------|------------|--------------|--------------|
| | | Танхим | Бусад | Нийт | Танхим | Бусад | Нийт |
| 1 | Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд | 40 | 28,001 | 28,041 | 8 | 1 | 9 |
| 2 | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд | 68 | 20,108 | 20,176 | 10 | 29 | 39 |
| 3 | Боловсролын сайд | 60 | 50,000 | 50,060 | 14 | 2,221 | 2,235 |
| 4 | Гадаад харилцааны сайд | 30 | | 30 | 4 | | 4 |
| 5 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | 94 | 29,150 | 29,244 | 35 | 150 | 185 |
| 6 | Зам, тээврийн сайд | 40 | 15,001 | 15,041 | 15 | 1 | 16 |
| 7 | Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд, эдийн засаг, хөгжлийн сайд | 120 | 21,900 | 22,020 | 16 | | 16 |
| 8 | Сангийн сайд | | | | 3 | | 3 |
| 9 | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд | 80 | 19 | 99 | 33 | 19 | 52 |
| 10 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд | 38 | 11,419 | 11,457 | 28 | 419 | 447 |
| 11 | Хууль зүй, дотоод хэргийн сайд | 150 | 38,171 | 38,321 | 22 | 3,717 | 3,739 |
| 12 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд | 36 | 23 | 59 | 9 | 125 | 134 |
| 13 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд | 40 | 13,000 | 13,040 | 30 | | 30 |
| 14 | Эрүүл мэндийн сайд | 99 | 3,077 | 3,176 | 24 | 5 | 29 |
| 15 | Эрчим хүчний сайд | 35 | 13 | 48 | 5 | 13 | 18 |
| 16 | Монгол Улсын шадар сайд /хөрөнгө оруулалт/ | 17 | | 17 | 6 | | 6 |
| 17 | Монгол Улсын шадар сайд /онцгой байдал/ | 90 | 1,377 | 1,467 | 4 | 1,377 | 1,381 |
| 18 | Монгол Улсын ерөнхий аудитор | 12 | 195 | 207 | 4 | 195 | 199 |
| 19 | Төрийн албаны зөвлөлийн дарга | 40 | | 40 | 8 | 1 | 9 |
| 20 | Сонгуулийн ерөнхий хорооны дарга | 17 | | 17 | 7 | | 7 |
| 21 | Монгол Улсын үндсэн хуулийн цэцийн дарга | 12 | | 12 | 7 | | 7 |
| 22 | Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч | 64 | 4,062 | 4,126 | 8 | 64 | 72 |
| 23 | Шүүхийн сахилгын хорооны дарга | | | | | | |
| 24 | Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга | | | | | | |
| 25 | Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга | 3 | | 3 | 2 | | 2 |
| 26 | Хүний эрхийн үндэсний комиссын дарга | 36 | 2,800 | 2,836 | 10 | 139 | 149 |
| 27 | Үндэсний статистикийн хорооны дарга | 61 | 12 | 73 | 1 | 1 | 2 |
| 28 | Санхүүгийн зохицуулах хорооны дарга | 21 | | 21 | 2 | | 2 |
| 29 | Улсын ерөнхий прокурор | 39 | 60 | 99 | 5 | 1 | 6 |
| | НИЙТ | 1,390 | 238,388 | 239,778 | 332 | 8,478 | 8,810 |

Иргэдийн гаргасан 8,810 саналын давхардлыг цэвэрлэж үзэхэд нийт 417 саналд багцлагдаж байна. Эдгээр саналын 151 нь ТЕЗ нар өөрсдөө эрэмбэлсний үндсэн дээр төсвийн төсөлд тусгах шаардлагагүй гэж үзсэн бөгөөд эдгээр нь голдуу одоогоор хэрэгжиж байгаа буюу нэгэнт төсөвт тусгагдсан, эсхүл он дамжин хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээтэй холбоотой байна.

Үлдэх 264 саналыг жилийн төсвийн төсөлд тусгуулах боломжтой гэж ТЕЗ нар санал болгосныг хянаж үзвэл 84 санал нь тодорхой хэмжээгээр төсвийн төсөлд туссан байна. Төсөвт тусгагдсан арга хэмжээний нийтлэг шинж нь тухайн салбарын бодлого, үргэлжлэн хэрэгжиж байгаа хөтөлбөр, арга хэмжээ, жил тутам давтагддаг урсгал шинжтэй зардалтай холбоотой байна. Ийм саналууд жил бүрийн төсөвт тусгагддаг бөгөөд мөнгөн дүнгээр илэрхийлбэл 2,365 тэрбум төгрөг болж байна.

Хүснэгт 76. Төсөвт туссан саналын товчоо (тэрбум төгрөгөөр)

| № | Салбар | саналын тоо | Төсөв | үүнээс: | |
|----|-----------------------------|-------------|--------------|--------------|------------------|
| | | | | урсгал | хөрөнгө оруулалт |
| 1 | Эрүүл мэнд | 13 | 799.9 | 799.9 | 0 |
| 2 | Боловсрол | 4 | 227.6 | 227.6 | 0 |
| 3 | Нийгмийн хамгаалал | 11 | 575.2 | 575.2 | 0 |
| 4 | Эрчим хүч | 3 | 133.9 | 40.5 | 934 |
| 5 | Уул уурхай аж үйлдвэр | 1 | 50 | 50 | 0 |
| 6 | Барилга, орон сууц | 8 | 213.5 | 0.2 | 213.1 |
| 7 | Хүнс, хөдөө аж ахуй | 8 | 92.8 | 92.8 | 0 |
| 8 | Байгаль орчин | 1 | 3.7 | 0 | 3.7 |
| 9 | Соёл, спорт, аялал жуулчлал | 2 | 53.9 | 0 | 53.9 |
| 10 | Шүүх | 4 | 9.8 | 9.5 | 0.3 |
| 11 | Хууль зүй | 8 | 21.7 | 7.4 | 14.3 |
| 12 | Шинжлэх ухаан | 1 | 32.5 | 0 | 32.5 |
| 13 | Онцгой байдал | 4 | 84.4 | 35.3 | 49.1 |
| 14 | Төрийн бусад чиг үүрэг | 16 | 65.9 | 53.1 | 12.8 |
| | НИЙТ | 84 | 2,365 | 1,892 | 1,314 |

Түүнчлэн дээрх 264 саналаас төсөвт тусгах боломжгүй 180 санал байгаагийн 61 нь “давхардсан” гэдэг шалтгаанаар хасагдсан байна. Төсөвт тусгагдаагүй шалтгаан нь санал болгосон арга хэмжээнүүд нь 2026 оны төсвийн хязгаарт багтаагүй, хөрөнгө оруулалтын шинжтэй, эсхүл бодлогын өөрчлөлт шаардах шинэчлэл шаардлагатай саналууд зонхилж байна.

**Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт
заасан зүйлс төсвийн төслийн танилцуулгад туссан талаар**

| № | Заалтууд | Туссан байдал |
|----------|--|--|
| 32.2.1. | Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдлын үнэлгээ, ирээдүйн чиг хандлагын төсөөлөл, тооцоо; | 2.4.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн таамаглал |
| 32.2.2. | макро эдийн засаг, төсвийн тогтвортой байдлыг хангах талаар Засгийн газраас тухайн жилд баримтлах бодлого, тэргүүлэх чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх асуудлыг төсвийн төсөлд тусгасан байдал; | I бүлэг: Монгол Улсын 2026 оны төсвийн онцлог, баримтлах бодлого, тэргүүлэх чиглэл II бүлэг: Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага |
| 32.2.3. | төсвийн тэнцлийн зорилтот үзүүлэлтийг тооцсон байдал; | 5.1.Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд |
| 32.2.4. | төсвийн гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй эрсдэлийн үнэлгээ; | VI бүлэг. Төсвийн эрсдэлийн шинжилгээ |
| 32.2.5. | төсвийн жилийн татварын зардлын тооцоог татварын орлогын нэр төрөл бүрээр, өмнөх хоёр жилийн гүйцэтгэл, дараагийн хоёр жилийн төсөөлөл; | 4.1.4.Татварын зарлага |
| 32.2.6. | хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалт /нэр төрөл, санхүүжилтийн эх үүсвэрээр/; | 4.3.1.Улсын төсвийн хөрөнгө оруулалт -Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралт |
| 32.2.7. | санхүүжилтийг нь зогсоох болон багасгах хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт, түүний төсөвт үзүүлэх нөлөөлөл, тайлбар; | 7.5.Санхүүжилтийг нь зогсоох болон багасгах хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт, түүний төсөвт үзүүлэх нөлөөлөл, тайлбар |
| 32.2.8. | гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт /нэр төрөл, объект, үнийн дүнгээр/; | 7.4.Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт |
| 32.2.9. | тусгай сангийн орлого, зарлагын тооцоо; | 4.2.3.Засгийн газрын тусгай сан |
| 32.2.10. | төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсөвт төлөх ногдол ашгийн хэмжээ; | 4.1.3.Татварын бус орлого /Хувьцааны ногдол ашиг/ |
| 32.2.11. | төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, тэдгээртэй холбогдсон тайлбар, танилцуулга; | 7.3.Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний танилцуулга -Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралт |
| 32.2.12. | төсвийн тусгай шаардлагад болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцэж байгаа талаарх тайлбар; | 5.1.Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд 5.2.Төсвийн тусгай шаардлага |
| 32.2.13. | <i>төсвийн тусгай шаардлагыг түр баримтлахгүй тохиолдолд түүний үндэслэл, санал;</i> | <i>Төсвийн тусгай шаардлагыг баримталж байна</i> |
| 32.2.14. | нэгдсэн төсвийн орлого, зарлагын үзүүлэлтийн хураангуй тайлбар; | 4.1.Төсвийн орлого, татварын бодлого 4.2.Төсвийн урсгал зардал 5.1.Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд |
| 32.2.15. | төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон байдал; | 4.1.Төсвийн орлого, татварын бодлого 5.2.Төсвийн тусгай шаардлага |
| 32.2.16. | төсөв алдагдалтай төлөвлөгдсөн бол уг алдагдлыг санхүүжүүлэх тухай санал; | 5.3.Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр |

| | | |
|----------|---|--|
| 32.2.17. | Засгийн газрын өрийн үлдэгдэл, төслийн зээлийн дотоод эх үүсвэрийн хэмжээ, Засгийн газраас гаргасан баталгаа, түүний дүн; | 4.6.Засгийн газрын өр |
| 32.2.18. | нэгдсэн төсвийн орлогын нэг хувиас хэтэрсэн дүнтэй тэнцэх болзошгүй өр төлбөр, түүнээс учирч болзошгүй эрсдэлийн тооцоо; | 6.4.3.Засгийн газрын болзошгүй өр төлбөр |
| 32.2.19. | <i>Энэ заалтыг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон</i> | - |
| 32.2.20. | төсвийн төсөлтэй холбогдуулан шийдвэрлүүлэх хууль тогтоомжийн төсөл. | 7.2.Хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл |
| 32.2.21. | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагуу түншлэлээр хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан төслүүдийн танилцуулга, мэдээлэл, хэрэгжилт, үр дүн, төсөвтэй уялдсан байдал болон төсвөөс санхүүжүүлэх төрлөөр гэрээ байгуулсан төслүүдийн төсвөөс төлөх төлбөрийн хуваарь, төсвийн төсөлд тусгах саналыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлснээр хянаж тусгасан мэдээлэл. | 4.3.3.Төр, хувийн хэвшлийн түншлэл |
| 32.2.22. | энэ хуулийн 28 ¹ .2.3-т заасны дагуу хэлэлцүүлгээс гарсан саналыг тухайн жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөлд хэрхэн тусгасан талаарх мэдээлэл. | 7.7.Олон нийтийн хэлэлцүүлэг |

---ооо---